

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



ӨСӨЛТИЙН
ЦУВААНД
ХАМТДАА

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР:



ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР:



2023-06-14

СЭХ
ОН 2023.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч

Монложистикс Холдинг ХХК



✉ info@mlholding.mn
☎ + 976-7701 5454
📍 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Нью Хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

Үндсэн андеррайтер

Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК



✉ info@mandal.capital
☎ + 976-7575 3399
📍 Улаанбаатар хот, Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо,
Жамъян Гүний Гудамж 18-2, Меру Тауэр, 6
давхар, 602 тоот

Аудитын компани

Грант Торнтон Аудит ХХК



✉ info@mn.gt.com
☎ + 976-7011 0799
📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Юнескогийн гудамж-31, Далай Тауэр, 9-р
давхар

Хуулийн фирм

Хаанлекс Партнерс ХХН



✉ info@khanlex.mn
☎ +976-7747 1122
📍 Улаанбаатар 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Олимпын гудамж-5, Аюуд Тауэр, 14
давхар 1404 тоот

Үнэлгээний Компани

Гэрэгэ Эстимэйт ХХК



✉ info@geregepartners.mn
☎ +976-7000 5000
📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Сүхбаатарын талбай, Эрдмийн ордон, 1004
тоот

Туслах андеррайтер

Инвескор Капитал ҮЦК ХХК



✉ info@icapital.mn
☎ +976-7755 0077
📍 Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 1 дүгээр хороо, Жамъян Гүний гудамж
18/1, Даун Таун барилга, 6 давхар, 601 тоот



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмуудын дагуу өөрийн хувьцаанаас анх удаа олон нийтэд санал болгож байна.

Энэхүү үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас 10,985,082,070 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 59,378,822 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн болон зөвхөн одоогийн цаг хугацааны шинж чанартай зарим мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч Монлогистикс Холдинг ХХК болон Үндсэн андеррайтер Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.



2023-06-14

БҮРТГЭВ-03



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын тээвэр ложистикийн салбарт хөрөнгө оруулагчийн нэг болох гэж буй танд баяр хүргэж, таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Үйлдвэрлэгч ба худалдаа борлуулалт, түгээлтийн сүлжээний тогтвортой үйл ажиллагааг бараа материалын хадгалалт, тээвэрлэлтийн үйлчилгээгээр ханган ажилладаг дэлхийн эдийн засгийн гол судас нь тээвэр ложистик юм. Дэлхийн банкны тайлан мэдээгээр тээвэр ложистик нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнд 13 хувийг эзэлдэг том салбар төдийгүй хэрэглэгчдэд цогц үйлчилгээг үзүүлдэг, санхүүгийн зах зээлд олны анхаарлын төвд байж, хөрөнгө оруулалтыг татан хиймэл оюун ухаан, инновацлаг системүүдийг хөгжүүлдэг гол талбар болоод байна.

Ази тивийн эх газрын төвд оршдог, далайд гарцгүй Монгол Улсын хувьд тээвэр ложистик нь газар зүйн байршлаас шалтгаалж, хөрш орнуудаас шууд хамааралтай байдаг бөгөөд өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд тээврийн зардлыг хямд бөгөөд хурдан болгоход шаардагдах дэд бүтцийг бий болгож чадаагүй нь нийгэмд ямар сөрөг үр дагавар учруулж болохыг сүүлийн жилүүдэд тохиолдсон ачаа эргэлтийн удаашрал, саатал хэн бүхэнд тод харууллаа.

Энэ байдлыг сайжруулах гарц хайх, газар зүйн түгжигдмэл байрлалаа давуу тал болгох шинэ санаачлага гаргах, тээврийн өртөгийг бууруулахад чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэх үйл хэрэгт манай хамт олон "Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд" эрхэм зорилгын хүрээнд 18 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Дэлхий дээр хүн төрөлхтөний амьдрал эхэлснээс хойш уламжлагдан хийгдэж ирсэн, цаашид аль ч шатны хөгжлийн явцад усталгүй үлдэх нь тодорхой ажил хөдөлмөрийн нэг нь ачаа тээвэр, хүргэлтийн үйлчилгээ юм. Энэ үзэл баримтлал нь нэгэн цагт тус компанийг байгуулах гол шалтгаан болсон түүхтэй.

Байгуулагдсан өдрөөс хойш манай хамт олны бий болгосон үнэт зүйлсийг тодорхойлбол:

- Урт хугацааны тогтвортой хөгжлийн үндсэн тулгуур болох олон улсын хөрөнгө оруулагч нарын шаардлагад нийцэх засаглалын тогтолцоо
- Урт хугацааны хөгжлийн стратегийг дэлхийн жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх чадвартай менежментийн баг
- Орчин үеийн техник, технологийн хөгжил болон тээвэр ложистикийн дэд бүтцэд хийсэн хөрөнгө оруулалт

Бид цаашид эдгээр үнэт зүйлсээ улам баталгаажуулж сайжруулахын зэрэгцээ компанийн бүхий л хөрөнгө оруулагчдын өмнө хүлээх үүрэг хариуцлага, байгаль орчинд сөрөг нөлөөгүй ажиллах шаардлагын тэнцвэртэй харьцааг нэн тэргүүнд баримтлан, олон улс руу гарахын тулд энэ цаг үед нэгэн түүхэн шийдвэр гаргаж байна.

Засаглалын тогтолцоог улам бүр төгөлдөржүүлж, үеийн үед цэцэглэн хөгжиж, дэлхийн түүхэнд алтан үсгээр бичигдсэн компаниудын замналыг Монгол Улсад нутагшуулах, үнэ цэн нь үргэлж өсөн нэмэгдэх, тээврийн салбарын тэргүүлэгч хамт олон хөрөнгө оруулагч хүн бүрийн өмнө үүдээ нээн урьж байна.

Үе дамжигдах үнэт өвийг бүтээж, эх орныхоо өсөлтийн цуваанд хамтдаа хувь нэмрээ оруулцгаая.



ТУЗ-ИЙН ДАРГА

Л.ГАНЗОРИГТ



АГУУЛГА

СЭХ
ОН 2023 ООр 23 өдөр
БҮРТГЭВ

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ	17
1.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга	17
1.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн мэдээлэл	18
1.3 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээд	19
1.4 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	22
1.5 Монложистикс Группийн түүхэн замнал	23
1.6 Үнэт цаас гаргагчийн засаглал, бүтэц зохион байгуулалт	24
1.7 Эрх бүхий албан тушаалтан	37
1.8 Үнэт цаас гаргагчийн хэлцлүүд	38
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ	42
2.1 Үнэт цаас гаргагч, охин компани тус бүрийн үйл ажиллагаа,	42
тэдгээрийн онцлог	42
2.2 Үнэт цаас гаргагчийн охин компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ	51
2.3 Хүний нөөцийн бодлого	55
2.4 Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд	57
2.5 Эрсдэлийн удирдлагын бодлого	59
2.6 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ	64
3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ	86
3.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал	86
3.2 Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал	92
3.3 Олон улсын тээвэр ложистикийн зах зээлийн нөхцөл байдал	93
3.4 Олон улсын тээвэр ложистикийн салбарын цаашдын төлөв	95
3.5 Дотоодын тээвэр ложистикийн зах зээлийн нөхцөл байдал	96
3.6 Дотоодын тээвэр ложистикийн салбарын цаашдын төлөв байдал	105
3.7 Үнэт цаас гаргагчийн богино болон дунд хугацааны стратеги	112
3.8 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь	116
3.9 Санхүүгийн төлөвлөгөө	119
4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ	133
4.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай	133
4.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт	133
4.3 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл	134
4.4 Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	137
4.5 Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг	139




2023-06-14

БҮРТГЭВ-03

СЭХ
ОН: 2023, сар: 06, өдөр: 23
БҮРТГЭВ
N. 1

4.6 Ногдол ашгийн бодлогын төсөл.....	140
4.7 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө.....	141
4.8 Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр.....	144
5. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД	147
5.1 Хөндлөнгийн үнэлгээний байгууллага танилцуулга, гэрээ	147
5.2 Хөндлөнгийн аудитын компанийн танилцуулга, гэрээ	148
5.3 Хуулийн фирмийн танилцуулга, гэрээ	149
5.4 Үндсэн андеррайтерийн танилцуулга, гэрээ.....	151
5.5 Туслах андеррайтерийн танилцуулга.....	152





ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ



Үнэт цаас гаргагч Монложистикс Холдинг ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 17-ны өдрийн 23/ТУЗ/10/01 тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 сарын 10-ны өдрийн 23/ХЭХ/13 тоот тогтоолыг үндэслэн олон нийтэд санал болгосны дараах нийт хувьцааны 15 хувь буюу 59,378,822 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анх удаа нийтэд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагч	Монложистикс Холдинг ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо ширхэг	336,480,000
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	59,378,822
Нийтэд санал болгох хувь	15%
Үүнээс:	
Стратегийн хөрөнгө оруулагчдад	70% буюу 41,565,175 ширхэг
Олон нийтэд	30% буюу 17,813,647 ширхэг
Нийтэд санал болгох үнэ	185 төгрөг
Татан төвлөрүүлэх дүн	10,985,082,070 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	-Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт -Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга
Үнэт цаасны бүртгэл	Монголын хөрөнгийн биржийн I ангилал



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

СЗХ
2023 Овар 23 өдөр
БҮРТГЭЭГ


2023-07-23
БҮРТГЭЭГ 03

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл	18
Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн холбоо барих мэдээлэл	18
Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн охин компаниудын мэдээлэл	21
Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниудын мэдээлэл	21
Хүснэгт 5. Хувьцаа эзэмшлийн бүтэц, хувь болон үнийн дүн (төгрөгөөр)	22
Хүснэгт 6. ТУЗ-ийн бүрэлдэхүүн	24
Хүснэгт 7. ТУЗ-ын гишүүдийн танилцуулга	25
Хүснэгт 8. ТУЗ-ийн хороодын гишүүд, тэдгээрийн чиг үүрэг	29
Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагуудын танилцуулга	31
Хүснэгт 10. Охин компаниудын гүйцэтгэх удирдлага	34
Хүснэгт 11. Охин компаниудын гүйцэтгэх удирдлагын танилцуулга	35
Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд	37
Хүснэгт 13. Монложистикс Группийн тээврийн төрөл, тээврийн хэлбэрээр	51
Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн матриц	60
Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн орлогын нэгтгэсэн тайлан сая төгрөгөөр	65
Хүснэгт 16. Монложистикс Группийн нэгтгэсэн орлогын тайлангийн задаргаа, сая төгрөгөөр	73
Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүү байдлын тайлан, сая төгрөгөөр ...	76
Хүснэгт 18. Хувь эрхгүй оролцоонд ногдох эздийн өмч, цэвэр ашиг, сая төгрөгөөр	78
Хүснэгт 19. Монложистикс Группийн санхүү байдлын тайлангийн задаргаа, сая төгрөгөөр	79
Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	80
Хүснэгт 21. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд, охин компани тус бүрээр	83
Хүснэгт 22. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	86
Хүснэгт 23. Инфляцын төсөөлөл	89
Хүснэгт 24. Индексүүд	92
Хүснэгт 25. Авто замын тээврийн үзүүлэлт	99
Хүснэгт 26. Авто тээвэр ачааны төрлөөр, мянган тонноор	100
Хүснэгт 27. Төмөр замын тээврийн үзүүлэлтүүд	100
Хүснэгт 28. Төмөр замын тээвэр ачааны төрлөөр, мянган тонноор	101
Хүснэгт 29. Агаарын тээврийн үзүүлэлт	101
Хүснэгт 30. Агаарын тээвэр, тээвэрлэгчийн төрлөөр, сая тонноор	101
Хүснэгт 31. Экспортын голлох боомтуудын хүчин чадал, сая тонноор	107
Хүснэгт 32. Эдийн засгийн өсөлтөд үндэслэсэн борлуулалтын орлогын төсөөлөл ...	111
Хүснэгт 33. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь, тээврийн төрлөөр	116
Хүснэгт 34. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр	119
Хүснэгт 35. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр	128
Хүснэгт 36. Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр	131
Хүснэгт 37. Нийтэд санал болгох үнэт цаасны тухай	133
Хүснэгт 38. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	134
Хүснэгт 39. Монложистикс Группын нийт үнэлгээ ба Монложистикс Холдинг ХХК-ийн эзэмшлийн үнэ цэнэ	136
Хүснэгт 40. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, сая төгрөгөөр	137
Хүснэгт 41. Вагон худалдан авах өртөгийн задаргаа	138
Хүснэгт 42. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө	141
Хүснэгт 43. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцоход авах алхмууд	142
Хүснэгт 44. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт	143

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
ML

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
monlogistics
HOLDING
ATAS 99 634251
9021031063

HOLDING



Хүснэгт 45. Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэх худалдан авах нөхцөл	144
Хүснэгт 46. Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын улсын бүртгэлийн мэдээлэл	147
Хүснэгт 47. Хөндлөнгийн аудитын байгууллагын улсын бүртгэлийн ба холбоо мэдээлэл	148
Хүснэгт 48. Хуулийн фирмийн улсын бүртгэлийн ба холбоо барих мэдээлэл	149
Хүснэгт 49. Үндсэн андеррайтерийн улсын бүртгэлийн мэдээлэл ба холбоо барих мэдээлэл	151

БҮРТГЭЭ-03



ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

БҮРТГЭЭ-03

График 1. Үнэт цаас гаргагчийн нийт тээврийн тоо ширхэг	66
График 2. Үнэт цаас гаргагчийн нэгж тээврийн дундаж үнэ, ам.доллаароор	67
График 3. Монголбанкнаас зарласан ам.долларын жилийн дундаж ханш.....	68
График 4. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр	68
График 5. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, түүний өсөлтийн хувийн задаргаа.....	69
График 6. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөг, борлуулалтад эзлэх хувь, тэрбум төгрөгөөр.....	69
График 7. Ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалтад эзлэх хувь, сая төгрөгөөр ...	70
График 8. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ашиг, борлуулалтад эзлэх хувь, сая төгрөгөөр.....	71
График 9. Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашиг, түүний бүтэц, сая төгрөгөөр	72
График 10. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого ба цэвэр ашгийн задаргаа, сая төгрөгөөр.....	74
График 11. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, сая төгрөгөөр	77
График 12. Өр төлбөр ба эзний өмчийн дүн, сая төгрөгөөр	77
График 13. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, бизнесийн чиглэлээр, сая төгрөгөөр ..	80
График 14. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны харьцаа, үзүүлэлтүүд.....	81
График 15. Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа, үзүүлэлтүүд.....	81
График 16. Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн харьцаа үзүүлэлтүүд.....	82
График 17. Үнэт цаас гаргагчийн ашгийн маржин	82
График 18. Үнэт цаас гаргагчийн өгөөжийн харьцаа, үзүүлэлт	83
График 19. Монгол Улсын ДНБ, их наяд төгрөгөөр.....	86
График 20. Экспортын голлох бүтээгдэхүүн, сая доллароор.....	87
График 21. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөгөөр	88
График 22. Инфляцын түвшин, хувиар.....	88
График 23. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, хувиар	90
График 24. Төлбөрийн тэнцэл, сая доллароор.....	91
График 25. Гадаад валютын албан нөөц, сая доллароор	91
График 26. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөгөөр болон ДНБ-д эзлэх хувь.....	92
График 27. Хувьцааны арилжаа, тэрбум төгрөгөөр	93
График 28. Тээвэр ложистикийн зах зээлийн бүтэц.....	94
График 29. Цахим худалдааны зах зээл, тэрбум ам.доллаароор.....	95
График 30. Ложистикийн Гүйцэтгэлийн Индекс 2018 -Монгол Улс.....	96
График 31. Тээврийн нийт орлого, тэрбум төгрөгөөр.....	97
График 32. Тээврийн салбарын ДНБ-д эзлэх хувь, ДНБ үйлвэрлэлийн аргаар оны үнээр, их наяд төгрөгөөр	98
График 33. Тээврийн нийт орлого тээврийн хэлбэрээр, тэрбум төгрөгөөр	99
График 34. Нийт тээсэн ачаа тээврийн хэлбэрээр, сая тонноор.....	99
График 35. Нийт тээсэн ачаа тээврийн төрлөөр, сая тонноор.....	102
График 36. Импортын тээврийн хэмжээ, сая тонноор	102
График 37. Транзит тээврийн хэмжээ, сая тонноор	103
График 38. Экспортын тээвэр бүтээгдэхүүнээр, сая тонноор	103
График 39. Экспортын тээврийн хэмжээ тээврийн хэлбэрээр, сая тонноор	104
График 40. Дотоод тээврийн хэмжээ, сая тонноор	104
График 41. Тээврийн тоо хэмжээ ба тээврийн орлогын өсөлт	106
График 42. Нийт экспортын хэмжээний төсөөлөл, сая тонноор.....	106



График 43. БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ, сая тонноор	106
График 44. Импортын тээврийн хэмжээний төсөөлөл, сая тонноор	107
График 45. Транзит тээврийн хэмжээний төсөөлөл, сая тонноор	108
График 46. БНХАУ- ОХУ, БНХАУ- Европын улсууд хоорондын нийт ачаа эргэлт, сая тонноор	108
График 47. Дотоод тээврийн тоо хэмжээний төсөөлөл, сая тонноор	109
График 48. Нийт тээврийн тоо хэмжээний төсөөлөл, сая тонноор	110
График 49. Тээврийн тоо хэмжээ болон тээврийн орлогын өсөлтийн регресс	110
График 50. Тээврийн салбарын орлогын төсөөлөл, тэрбум төгрөгөөр	111
График 51. Бизнесийн амьдралын мөчлөг	112
График 52. Монложистикс Группийн зах зээлд эзлэх хувь, тэрбум төгрөгөөр	116
График 53. Чингэлэг тээврийн хэмжээ, сая тонноор	117
График 54. Нүүрсний экспортын тээврийн хэмжээ, сая тонноор	118
График 55. Транзит тээврийн хэмжээ, сая тонноор	118
График 56. Тээврийн тоо төсөөлөл, ширхэгээр	120
График 57. Тээврийн дундаж үнийн төсөөлөл, ам. доллароор	121
График 58. Төгрөгийн ам доллартой харьцах ханшийн төсөөлөл	121
График 59. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөлөл ба түүний өсөлтийн хувь, тэрбум төгрөгөөр	122
График 60. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөгийн төсөөлөл, тэрбум төгрөгөөр	123
График 61. Татварын дараах цэвэр ашиг, сая төгрөгөөр	123
График 62. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөлөл, тээврийн төрлөөр, тэрбум төгрөгөөр	124
График 63. Үнэт цаас гаргагчийн импорт тээврийн борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр	124
График 64. Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр	125
График 65. Үнэт цаас гаргагчийн экспорт тээврийн орлогын төсөөлөл, тэрбум төгрөгөөр	126
График 66. Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн орлого, тэрбум төгрөгөөр	127
График 67. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр	129
График 68. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр	130
График 69. Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн бүтэц, тэрбум төгрөгөөр	130





Үнэт цаас гаргагч

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БҮРТГЭВ-03

Монложистикс Групп эсвэл
Групп

Охин компани

Зэргэлдээ компани

Компанийн нэгдэл

ТУЗ

ХЭХ

ХХК

ХК

ХХН

МХБ

СЗХ

ҮЦТХТ

МТТ

УБТЗ

МТЗ

ТТЗ

ЗТХЯ

ҮСХ

ДНБ

БНСУ

АНУ



Монложистикс Холдинг ХХК

Монложистикс Холдинг ХХК болон түүний охин
компаниудыг хамтад нь

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3
дахь заалтад заасан хуулийн этгээдүүд

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15
дахь заалтад заасан хуулийн этгээдүүд

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14
дэх заалтад заасан хуулийн этгээдүүд

Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хувьцаат компани

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Монголиан Транспорт Тийм ХХК

Улаанбаатар Төмөр Зам ХНН

Монголын Төмөр Зам ТӨХК

Тавантолгой Төмөр Зам ХХК

Зам, тээврийн хөгжлийн яам



Үндэсний статистикийн хороо

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Бүгд Найрамдах Солонгос Улс

Америкийн Нэгдсэн Улс





ХБНГУ

Бүгд Найрамдах Энэтхэг Улс

БНТУ

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНЧУ

Оросын Холбооны Улс

ОУВС

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

АХБ

Бүгд Найрамдах Турк Улс

ЕСБХБ

Бүгд Найрамдах Чех Улс

Олон улсын валютын сан

МБ

Азийн хөгжлийн банк

Европын сэргээн босголт хөгжлийн банк

ГВАН

Монголбанк

Гадаад валютын албан нөөц

ЗЗҮ

Зах зээлийн үнэлгээ

ЗГ

Засгийн газар

ЛГИ

Ложистикийн гүйцэтгэлийн индекс

B2B

Байгууллага суурьтай бизнес

B2C

Хэрэглэгч суурьтай бизнес

ERP

Бизнесийн нэгдсэн платформ

ТББ

Төрийн бус байгууллага

KPI

Гүйцэтгэлийн урамшууллын систем

TMS

Тээврийн менежментийн систем

ЖДНӨ

Жилийн дундаж нийлмэл өсөлт

ХОС

Хөрөнгө оруулалтын сан

Нийтэд анх удаа хувьцаа санал болгох





ROA

Өөрийн хөрөнгийн өгөөж

P/E

Нийт хөрөнгийн өгөөж

P/B

Үнэ-ашгийн харьцаа

FCFE

Үнэ-дансны үнийн харьцаа

Pre-Money valuation

Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал

Post-Money valuation

Хөрөнгө татан төвлөрүүлэхээс өмнөх үеийн үнэлгээ

Roadshow

Хөрөнгө татан төвлөрүүлсний дараах үнэлгээ

ААНОАТ

Нийтэд танилцуулах аян

ХХОАТ

Аж ахуй нэгжийн орлогын албан татвар

ДЦС

Хувь хүний орлогын албан татвар

ISO

Дулааны цахилгаан станц

UNCTAD

Олон улсын стандартчилалын байгууллага

CRIMT

Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа, хөгжлийн байгууллага

АБТЭМА

БНХАУ-ын Төрийн өмчит төмөр замын чингэлэг тээврийн корпорац

МЛЭ

Ачих, буулгах тээвэр экспедицийн механикжсан анги

МЛЭК

Монложистикс Экүпментс ХХК

МЛК

Монложистикс Экспресс ХХК

Монложистикс Карго ХХК

Монложистикс Тракинг ХХК





МЛВ

Каус Аустралис ХХК

Монложистикс Транзит ХХК

Монложистикс Ворлдвайд ХХК



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



НЭГ.

**ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН
ТУХАЙ**

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

2023-06-14

БҮРТГЭВ-03

СЗХ
2023.06.23 өдөр
БҮРТГЭВ-03
№ 01

1.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга

Үнэт цаас гаргагч Монложистикс Холдинг ХХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч Монложистикс Групп (цаашид "Групп" гэх)-ийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

Цаашид үнэт цаасны танилцуулгад Монложистикс Холдинг ХХК болон түүний 9 охин компаниудыг хамтад нь Монложистикс Групп гэх бөгөөд толгой компани Монложистикс Холдинг ХХК-ийг Үнэт цаас гаргагч гэж нэрлэнэ.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит зэрэг тээвэр ложистикийн бүх салбарт олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлдэг.

Зураг 1. Монложистикс Группийн баг хамт олны зураг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Тус Групп нь олон улсын 160 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1,500 гаруй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран, 180 ажилтан, мэргэшсэн баг хамт олонтойгоор тээвэр ложистикийн зах зээлд төрөлжсөн үйл ажиллагаа явуулж буй салбартаа тэргүүлэгч байгууллага юм.

» Эрхэм зорилго

Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд

» Алсын хараа 2030

Орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

» Үнэт зүйл



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон



Инновацлаг багийн сэтгэлгээ



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл



Хариуцлага, сахилга бат



Шударга, ил тод байдал



2023-06-14

БҮРТГЭВ-03

1.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн мэдээлэл

СЭХ
2023-06-14
БҮРТГЭВ
№ :

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

Үнэт цаас гаргагчийн нэр	Монложистикс Холдинг ХХК
Байгуулагдсан огноо	2018.12.24
Улсын бүртгэлийн дугаар	9011784027
Регистрийн дугаар	6381251
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа Бизнесийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Эцсийн өмчлөгчийн тоо	3
Хувьцаа эзэмшигчийн тоо	8
Хувьцаат капитал	100,944,000 төгрөг
Үйл ажиллагаа эрхлэх хугацаа	Хугацаагүй
Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх	Үгүй

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм

Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн холбоо барих мэдээлэл

Хаяг	Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нью Хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот
Цахим хуудас	www.mlholding.mn
Цахим шуудан	info@mlholding.mn
Утас	+976-7701 5454

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл




1.3 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээд

Компанийн тухайн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.3 дахь заалтад “компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэх бөгөөд 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд охин компани” гэж заасан байдаг.

Үнэт цаас гаргагч нь 9 охин компанийн нийт хувьцааны 50-иас дээш хувийг толгой компанийн хувиар эзэмшдэг. Үнэт цаас гаргагчид хараат компани байхгүй.

Зураг 2. Үнэт цаас гаргагчийн охин компаниудын хувьцаа эзэмшлийн бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл





100 хувийн эзэмшлийн охин компаниуд

Үнэт цаас гаргагч нь Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Карго ХХК, Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Экүйпментс ХХК, Монложистикс Экспресс ХХК гэсэн 5 компанийн 100 хувийг эзэмшдэг.

БҮРТГЭВ-03

50-99 хувийн эзэмшлийн охин компаниуд

Үнэт цаас гаргагч нь Монложистикс Транзит ХХК, Каус Аустралис ХХК, Монложистикс Россия Холдинг ХХК, Монложистикс Транс Сервис ХХК гэсэн 4 компанийн 50-иас дээш хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг.

Монложистикс Транзит ХХК

Тус компанийн 60 хувийг Үнэт цаас гаргагч, 40 хувийг Тянь Жин Хай Тие Лянь Жие Олон Улсын Тээвэр Ложистикс ХХК эзэмшдэг.

Тянь Жин Хай Тие Лянь Жие Олон Улсын Тээвэр Ложистикс ХХК нь 2007 оны 08-р сард БНХАУ-ын Тяньжинь хотод үүсгэн байгуулагдсан. Тус компани нь БНХАУ болон ОХУ-ын хооронд чингэлэг тээвэрлэлт зохион байгуулдаг тээвэр ложистикийн компани юм. Тус компани нь ОХУ-ын Москва хот, БНХАУ-ын Манжуур, Шанхай, Чиндао, Гуанжоу хотуудад салбартай ба төв оффис нь Тяньжинь хотод байрладаг.

Каус Аустралис ХХК

Тус компанийн 51 хувийг Үнэт цаас гаргагч, 24.5 хувийг иргэн Б.Тэлэнгэд, 24.5 хувийг иргэн Ё.Болортуяа эзэмшдэг.

Тус компанийн хувьцаа эзэмшигч Б.Тэлэнгэд нь Үнэт цаас гаргагчийн 32.85 хувийн хувьцаа эзэмшигч юм. Иймд Каус Аустралис ХХК-ийн 75.5 хувийг Үнэт цаас гаргагч болон түүний нэгдмэл сонирхолтой этгээд хамтран эзэмшиж байна.

Монложистикс Россия Холдинг ХХК

Тус компанийн 90 хувийг Үнэт цаас гаргагч, 10 хувийг ОХУ-ын иргэн Тугаринов Василий Андреевич эзэмшдэг. Тэрээр тус компанийн охин компани болох Монложистикс Транс Сервис ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг.

Монложистикс Транс Сервис ХХК

Тус компани нь Монложистикс Россия Холдинг ХХК-ийн 90 хувийн охин компани юм. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалтад "толгой компани нь гуравдагч компанийн охин компани бол түүний охин компани нь гуравдагч компанийн хувьд мөн адил охин компани болно" гэж заасан байна. Тус заалтын дагуу толгой компани болох Монложистикс Россия Холдинг ХХК нь Монложистикс Холдинг ХХК-ийн охин компани тул Монложистикс Транс Сервис ХХК нь мөн адил Үнэт цаас гаргагчийн охин компани болно.

Үнэт цаас гаргагч нь 8 компанийн хувьцааг шууд эзэмшдэг боловч Монложистикс Транс Сервис ХХК нь дээрх хуулийн дагуу охин компанийн хэлбэрт хамаарах тул нийт 9 охин компанитай болно.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн охин компаниудын мэдээлэл

№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар
1	Монложистикс Ворлдвайд ХХК	2685949	9011037101
2	Монложистикс Транзит ХХК	6449549	9019097149
3	Монложистикс Тракинг ХХК	6662951	9011824671
4	Монложистикс Карго ХХК	6663036	9011824676
5	Монложистикс Экүйпментс ХХК	6957447	9011846187
6	Монложистикс Экспресс ХХК	6957536	9011846193
7	Каус Аустралис ХХК	6455727	9011609023
8	Монложистикс Россия Холдинг ХХК	6688969	9011826561
9	Монложистикс Транс Сервис ХХК	3812536496	1213800014141

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн охин компаниудын дүрэм

Зэргэлдээ компаниуд

Компанийн тухайн хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь заалтад "нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани" гэж заасан байдаг. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 4. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниудын мэдээлэл

№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Хувь эзэмшил
1	Эрчим Тээг ХХК	6088724	9011622078	Л.Ганзоригт	60%
2	Эл Жи Эф Инвестмент ХХК	6828396	9011836694	Л.Ганзоригт	100%
3	Имажн Скүарэд ХХК	5875307	9011502071	Г.Хишигбат	60%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



СЗХ 1.4 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц
 ДН СЗХ 2023-06-14
 БҮРТГЭЭ № 1

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 0.30 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 336,480,000 ширхэг хувьцааг гаргасан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хувьцааг 7 хувь хүн, 1 хуулийн этгээд эзэмшиж байна. Мөн хувьцаа эзэмшигч Л.Ганзоригт болон түүний холбогдох этгээд болох Г.Хишигбат нар компанийн нийт 142,080,000 ширхэг буюу 42.23 хувийг хамтран эзэмшдэг болно.

Хүснэгт 5. Хувьцаа эзэмшлийн бүтэц, хувь болон үнийн дүн

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Нэрлэсэн үнэ	Үнийн дүн, төгрөгөөр
Л.Ганзоригт	110,520,000	32.85%	0.30	33,156,000
Б.Тэлэнгэд	110,520,000	32.85%	0.30	33,156,000
Г.Хишигбат	31,560,000	9.38%	0.30	9,468,000
А.Одгэрэл	31,560,000	9.38%	0.30	9,468,000
Л.Эрдэнэсоёл	15,000,000	4.46%	0.30	4,500,000
Н.Алтанзул	15,000,000	4.46%	0.30	4,500,000
Н.Эрдэнэбилэг	15,000,000	4.46%	0.30	4,500,000
Мандал Праявит Экүити Хувийн ХОС ХХК	7,320,000	2.18%	0.30	2,196,000
Нийт	336,480,000	100%	0.30	100,944,000

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдээс Л.Ганзоригт, Б.Тэлэнгэд, Г.Хишигбат нар нь Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-д харъяалагддаг. Мөн Г.Хишигбат, А.Одгэрэл, Н.Алтанзул, Н.Эрдэнэбилэг, Л.Эрдэнэсоёл нар нь Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын эрх бүхий албан тушаалыг эрхэлж байна. Дээрх хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын 1.6 болон 1.7 дахь хэсэгт тусгасан болно.





1.5 Монложистикс Группийн түүхэн замнал

Зураг 3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт

**Монложистикс
Ворлдвайд ХХК-г**
үүсгэн байгуулсан.

2005.11.27

Монложистикс Холдинг ХХК
буюу толгой компанийг үүсгэн
байгуулж нийт 4 хувьцаа
эзэмшигчтэй болсон.

2018.12.24

**Монложистикс
Тракинг ХХК-г**
үүсгэн
байгуулсан.

2021.02.05

БНХАУ-ын Тянь Жин Хай Тие
Лянь Жие Олон Улсын Тээвэр
Ложистикс ХХК-тай хамтран
Монложистикс Транзит ХХК-г
60 хувийн хөрөнгө оруулалттай
үүсгэн байгуулсан.

2019.07.04

**Монложистикс
Карго ХХК-г**
үүсгэн
байгуулсан.

2021.02.05

**Монложистикс
Россия Холдинг
ХХК-г** 90 хувийн
хөрөнгө
оруулалттайгаар
үүсгэн
байгуулсан.

2021.03.31

**Мандал Праявит Экүити
Хувийн ХОС ХХК нь**
Монложистикс Холдинг
ХХК-д стратегийн хөрөнгө
оруулагчаар хөрөнгө
оруулсан.

2022.03.21

**Монложистикс
Экспресс ХХК-г**
үүсгэн байгуулсан.

2022.11.28

**Монложистикс
Экүйпментс ХХК-г**
үүсгэн байгуулсан.

2022.11.28

**Каус Аустралис
ХХК-д** 51 хувиар
хөрөнгө оруулсан.

2022.06.10



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



1.6 Үнэт цаас гаргагчийн засаглал, бүтэц зохион байгуулалт

ОН 2023 САР
БҮРГЭЭ
№ 11

Үнэт цаас гаргагчийн засаглалын хэрэгжилтийг хариуцах гол субъект нь ТУЗ юм. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг томилж, хувьцаа эзэмшигчид нь ТУЗ болон хөндлөнгийн аудитаар дамжуулан компанид зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрэлдсэн эсэхэд хяналт тавин ажилладаг.

Зураг 4. Үнэт цаас гаргагчийн засаглал, бүтэц зохион байгуулалт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцсэн бодлого, стратегийг тодорхойлж гүйцэтгэх удирдлагыг компанийн үйл ажиллагааг удирдан явуулахад нь чиглүүлдэг. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь компанийн засаглалын кодексийн дагуу олон талт ур чадвар, мэдлэг туршлага, хараат бус байдлыг зохистойгоор хангасан нийт 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 6. ТУЗ-ийн бүрэлдэхүүн

№	ТУЗ-ийн гишүүний овог нэр	Албан тушаал
1	Лувсанжамба ГАНЗОРИГТ	ТУЗ-ийн дарга
2	Бааст ТЭЛЭНГЭД	ТУЗ-ийн ердийн гишүүн
3	Ганзоригт ХИШИГБАТ	ТУЗ-ийн ердийн гишүүн
4	Балдан ЭНХТҮВШИН	ТУЗ-ийн ердийн гишүүн
5	Санжаа САЙНБАТ	ТУЗ-ийн ердийн гишүүн
6	Эрэндоо ОЮУНБИЛЭГ	ТУЗ-ийн хараат бус гишүүн
7	Готов ЦЭРЭНПҮРЭВ	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

MANUAL CAPITAL
MARKETS SC
LCC
USTR 62 90210701 56134

МОНЛОЖИСТИК ХОЛДИНГ
ХХК
monlogistics
HOLDING
ATAS299 6381151
0021011093

Хүснэгт 7. ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга



Лувсанжамба
ГАНЗОРИГТ

»
Үүсгэн байгуулагч,
ТУЗ-ийн дарга

Боловсрол:

1981-1986 он: ОХУ, Ленинградын кино инженерийн дээд сургууль - Цахилгааны инженер, бакалавр

Ажлын туршлага:

1986-1990 он: Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Инженер

1990-1992 он: Чингис Хаан Зочид Буудал, Инженер

1992-2005 он: Бадачи Трейд ХХК, Гадаад харилцаа эрхэлсэн захирал

2005-2016 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Худалдаа санхүү эрхэлсэн захирал

2016-2020 он: Монложистикс Ворлдвайд ХХК, ТУЗ-ийн дарга

2020 оноос: Монложистикс Холдинг ХХК, ТУЗ-ийн дарга

БҮРТГЭВ-03



Бааст
ТЭЛЭНГЭД

»
Үүсгэн байгуулагч,
ТУЗ-ийн ердийн
гишүүн

Боловсрол:

1983-1988 он: Болгар Улс, Хөдөө аж ахуйн тракиа их сургууль - Зоо инженер, бакалавр

1996-1997 он: Монгол улсын их сургууль - Санхүүгийн менежмент, магистр

Ажлын туршлага:

1988-1992 он: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Судалгааны ажилтан

1992-1994 он: Англи улс, Кэмбрижийн Их Сургууль, Байгаль орчны судалгааны ажилтан

1994-1998 он: АНУ, Си Ланд ХХК- Монгол Улс дахь төлөөлөгч

1998-2005 он: Монголиан Транспорт Тийм ХХК, БНХАУ дахь суурин төлөөлөгч

2005-2016 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Ерөнхий захирал

2019 оноос: Монложистикс Транзит ХХК, Гүйцэтгэх захирал, Монложистикс Холдинг ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн






Санжаа
САЙНБАТ

ТУЗ-ийн ердийн
гишүүн

Боловсрол:

1993-1997 он: Шинжлэх ухаан технологийн их сургууль - Программ хангамжийн инженер бакалавр



Ажлын туршлага:

1996-2003 он: Номин Трейд ХХК, Импорт хариуцсан менежер
2003-2008 он: Номин Электроникс ХХК, Гүйцэтгэх захирал
2008-2010 он: Номин Холдинг ХХК, Мэдээллийн технологийн газрын захирал
2010-2014 он: Номин Холдинг ХХК, Байгууллагын хамтын ажиллагааны салбарын захирал
2015-2020 он: Номин Холдинг ХХК, Гүйцэтгэх захирал
2020-2022 он: Улсын Их Дэлгүүр ХК, ТУЗ-ийн дарга
2007 оноос: Оллоо ХХК, ТУЗ-ийн гишүүн
2017 оноос: Ариг банк ХХК, ТУЗ-ийн гишүүн
2022 оноос: Монложистик Холдинг ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн



Ганзоригт
ХИШИГБАТ

ТУЗ-ийн ердийн
гишүүн

Боловсрол:

2008-2012 он: АНУ, Флоридагийн их сургууль - Системийн инженер, бакалавр

Ажлын туршлага:

2012-2014 он: Ньюком Групп ХХК, Хөрөнгө оруулалтын шинжээч
2014-2015 он: Изинис Эйрвэйз ХХК, Төлөвлөлтийн менежер
2015-2016 он: Имажн Скүарэд ХХК, Гүйцэтгэх захирал
2016-2019 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Бизнес хөгжил, санхүү эрхэлсэн захирал
2019 оноос: Монложистикс Холдинг ХХК, Гүйцэтгэх захирал





**Балдангийн
ЭНХТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн



Боловсрол:

1998-2002 он: Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль - Нягтлан бодогч, бакалавр
2007-2010 он: Монгол улсын их сургууль - Бизнесийн удирдлага, магистр

Ажлын туршлага:

2003-2011 он: Тээвэр хөгжлийн банк, Эдийн засагч, Тооцооны төвийн эрхлэгч, Гадаад төлбөр тооцооны дарга, Дотоод төлбөр тооцооны албаны дарга, Хөрөнгө удирдлагын газрын захирал
2011-2013 он: Мандал даатгал ХК, Санхүү эрхэлсэн захирал
2013-2015 он: Си Пи Эм Си ХХК, Санхүү, төсөл хариуцсан захирал
2015-2017 он: Таван богд интернэйшнл ХХК, Санхүү албаны дарга
2017-2019 он: Нано Интернэйшнл ХХК, Санхүү эрхэлсэн захирал
2019 оноос: Мандал даатгал ХК, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
2023 оноос: Монложистикс Холдинг ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн



**Эрэндоо
ОЮУНБИЛЭГ**

ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Боловсрол:

1981-1986 он: ОХУ, Ленинградын их сургууль - Олон улсын эдийн засгийн харилцаа, бакалавр
2004-2006 он: БНСУ, Хандонг Глобал их сургууль - Бизнесийн удирдлага, магистр
2005-2007 он: АНУ, Стониер банкны сургууль-Мэргэжил дээшлүүлэх диплом

Ажлын туршлага:

2001-2013 он: Хаан банк ХК, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
2014-2020 он: Олон улсын санхүүгийн корпорац, Зөвлөх
2016-2021 он: Петровис ХХК, Засаглал эрхэлсэн захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
2022 оноос: Монложистик Холдинг ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн





**ГОТОВ
ЦЭРЭНПҮРЭВ**

**ТУЗ-ийн хараат
бус гишүүн**



Боловсрол:

1977-1981 он: ОХУ, Уран барилгын техникум - Дулаан салхивчийн техникч, бакалавр
1987-1991 он: Удирдлагын академи - Эдийн засагч, бакалавр
1999-2001 он: Нидерланд Улс, Маастрихтын менежментийн сургууль - Бизнесийн удирдлага, магистр
2015- 2018 он: ОХУ, Санхүүгийн их сургууль - Судлаач багш, бакалавр
2015- 2019 он: ОХУ, Санхүүгийн их сургууль - Эдийн засгийн ухаан, доктор

Ажлын туршлага:

1984-1987 он: Завхан аймгийн Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Хороо, Хянан шалгах штабын нарийн бичгийн дарга
1991-1999 он: Хөрөнгө оруулалт технологийн шинэчлэлийн банк, Нягтлан бодогч, Эдийн засагч, Ахлах эдийн засагч, Газрын захирал
1999-2000 он: Монголбанк, Сургалтын төвийн захирал
2000-2005 он: Хадгаламж банк, Гүйцэтгэх захирал
2005-2009 он: Монголын банкны холбоо, Гүйцэтгэх захирал
2009-2012 он: Монголбанк, Тамгын газрын захирал
2012 оноос: ОХУ, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк, Орлогч дарга, Захирлын зөвлөлийн гишүүн
2014 оноос: Азийн банкны холбоо, Захирлын зөвлөлийн гишүүн
2014 оноос: Олон улсын "People to People" байгууллага, Захирлын зөвлөлийн гишүүн
2023 оноос: Монложистикс Холдинг ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн



2023-06-17

БҮРТГЭЭ-03



Энхбаатар
НАРАНГАРВУУ

ТУЗ-ийн Нарийн
бичгийн дарга

Боловсрол:

2004-2008 он: ОХУ, Москвагийн Эрчим хүчний их сургууль - Эдийн засагч, бакалавр
2008-2010 он: ОХУ, Москвагийн эрчим хүчний их сургууль - Бизнесийн удирдлага, магистр
2017 оноос: ОХУ, Санхүү эдийн засгийн сургууль - Маркетинг, дэд доктор

Ажлын туршлага:

2010-2022 он: ОХУ, Эксперт шинжилгээний төв, Захиргаа үйл ажиллагааны албаны мэргэжилтэн
2022-2023 он: Монложистикс Холдинг ХХК, Захиргаа, захирлын туслах
2023 оноос: Монложистикс Холдинг ХХК, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо, Стратеги бизнес хөгжлийн хороо гэсэн 3 хороотой. ТУЗ-ийн хороодын гишүүд нь хорооны бодлого стратегийг тодорхойлон хяналт тавьж, тус тусын чиг үүргийн дагуу ажилладаг.

Хүснэгт 8. ТУЗ-ийн хороодын гишүүд, тэдгээрийн чиг үүрэг

ТУЗ-ийн хороодын нэр	Хороодын гишүүдийн нэр	Чиг үүрэг
Аудит, эрсдэлийн удирдлагын хороо	-Э.Оюунбилэг (Дарга) -Б.Тэлэнгэд -Б.Энхтүвшин	Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж, энэ тухай зөвлөмж, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, дэмжлэг үзүүлэх
Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо	-Л.Ганзоригт (Дарга) -С.Сайнбат -Э.Оюунбилэг	ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад зохих ур чадвар, мэдлэг, боловсрол, туршлагатай этгээдийг дэвшүүлэх, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих



Стратегийн төлөвлөлтийн бүтэц, үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийг оновчтой болгох талаар зөвлөмж, дүгнэлт гаргах, компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, стратегийн асуудлаар ТУЗ, гүйцэтгэх удирдлага үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Дотоод аудитор

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Дотоод аудиторыг томилдог. Дотоод аудитор нь Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны чиг үүргийн дагуу ТУЗ-ийн засаглал, компанийн үйл ажиллагааг бүхэлд нь хянан шалгаж, ТУЗ-д тайлагнах үүрэгтэй.

Дотоод аудитор нь компанийн бүхий л засаглал, үйл ажиллагааны түвшинд эрсдэлд суурилсан дотоод аудитын үйл ажиллагааг явуулдаг бөгөөд шударга, бодитой байх, нууцыг хадгалах, ур чадвартай байх зарчимд тулгуурлан дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Группийн засаглалын үйл явцыг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх
- Эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулах
- Группийн дотоод хяналтын систем болон компаниудын үйл ажиллагааны үр нөлөөтэй ба ашигтай байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх
- Санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл болон тогтолцооны зөв найдвартай ажиллагааг үнэлэх, сайжруулах, зөвлөмж боловсруулах ба санхүүгийн тайланд баталгаажуулалт хийх
- Группийн хүний нөөцийн бодлого, журам, түүний хэрэгжилт, нийцлийг үнэлэх, сайжруулах, зөвлөмж өгөх

Охин компаниудын ТУЗ

Монложистикс Экспресс ХХК, Монложистикс Экүйпментс ХХК, Монложистикс Транс Сервис ХХК-аас Үнэт цаас гаргагчийн бусад охин компаниуд тус бүр 3 гишүүдээс бүрдэх ТУЗ-тэй. Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Үнэт цаас гаргагч буюу толгой компанийн ТУЗ хэрэгжүүлдэг бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхийг итгэмжлэн хариуцдаг.

Охин компаниудын нь хувьцаа эзэмшигчдийн хурал буюу түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэгч толгой компаниас баталсан эрх мэдлийн хуваарилалт, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу ажилладаг. Энэ нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн явуулж буй үйл ажиллагаа, бодлого чиглэл нэг системээр хэрэгждэгийн илрэл юм. Харин 90 хувь ба түүнээс доош хувьтай охин компаниудын хувьд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын олонхи эрхийг хэрэгжүүлэх замаар удирдан чиглүүлдэг.

Гүйцэтгэх удирдлага, бүтэц зохион байгуулалт

Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг. Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад Санхүү, Мэдээлэл технологи, Стратеги бизнес хөгжил, Захиргаа хүний нөөц, Ложистик гэсэн 5 хэлтэс харьяалагддаг.



Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагуудын танилцуулга



Ганзоригт
ХИШИГБАТ

Гүйцэтгэх
захирал

Боловсрол:

2008-2012 он: АНУ, Флоридагийн их сургууль - Системийн инженер, бакалавр

Ажлын туршлага:

2012-2014 он: Ньюком Групп ХХК, Хөрөнгө оруулалтын шинжээч

2014-2015 он: Изинис Эйрвэйз ХХК, Төлөвлөлтийн менежер

2014 оноос: Имажн Скүарэд ХХК, Гүйцэтгэх захирал

2016-2019 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Бизнес хөгжил, санхүү эрхэлсэн захирал

2019 оноос: Монложистикс Холдинг ХХК, Гүйцэтгэх захирал



Амгалан
ОДГЭРЭЛ

Ложистик
эрхэлсэн захирал

Боловсрол:

2002-2006 он: Шинжлэх ухаан технологийн их сургууль - Олон улсын тээврийн менежмент, бакалавр

2020-2022 он: Санхүү эдийн засгийн их сургууль - Энтрепренершип ба инноваци, магистр

Ажлын туршлага:

2006-2022 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Тээврийн менежер, Ахлах менежер, Тээвэр эрхэлсэн дэд захирал, Гүйцэтгэх захирал

2022 оноос: Монложистикс Холдинг ХХК, Ложистик эрхэлсэн захирал





Заанхүүгийн
ШИНЭ-ОД

Санхүү
эрхэлсэн захирал

Боловсрол:

2007-2011 он: Мандах бүртгэл их сургууль-Нягтлан бодогч, бакалавр

Ажлын туршлага:

2011-2015 он: М-Си-Эс Групп, Санхүүгийн шинжээч
2015-2021 он: АНУН ХХК, Санхүүгийн менежер
2021-2023 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Санхүү эрхэлсэн захирал
2023 оноос: Монложистикс Холдинг ХХК, Санхүү эрхэлсэн захирал



Эрхэмбаатарын
ЭЛДЭВ-ОЧИР

Стратеги, бизнес
хөгжил эрхэлсэн
захирал

Боловсрол:

2009-2014 он: Канад Улс, Бритиш Колумбын их сургууль - Санхүүгийн удирдлага, бакалавр
2017-2021 он: Монгол улсын их сургууль - Эрх зүйч, бакалавр

Ажлын туршлага:

2015-2016 он: Монотт ХХК, Үйл ажиллагаа хариуцсан захирал
2016-2020 он: Худалдаа хөгжлийн банк, Менежер
2020-2021 он: Анами ХХК, Гүйцэтгэх захирал
2022 оноос: Монложистикс Холдинг ХХК, Стратеги, бизнес хөгжил эрхэлсэн захирал



2023-06-14

БҮРТГЭВ-03



Баатарын
АЗЖАРГАЛ

»
Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал

Боловсрол

2006-2010 он: БНХАУ, Бээжингийн нэгдсэн их сургууль - Олон улсын худалдаа, эдийн засаг, бакалавр

2021 оноос: Санхүү эдийн засгийн их сургууль-Энтерпренершип ба инноваци, магистр

Ажлын туршлага:

2010-2019 он: М-Си-Эс Групп, Хангамжийн ажилтан, Үйлдвэрийн менежер, Хүний нөөцийн менежер, Хангамжийн менежер

2020-2021 он: Монложистикс Холдинг ХХК, Сургалт хөгжлийн менежер

2021-2022 он: Монложистикс Холдинг ХХК, Хүний нөөцийн ахлах менежер

2023 оноос: Монложистикс Холдинг ХХК, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал



Муратайн
Майгүл

»
Ерөнхий
нягтлан бодогч

Боловсрол

2008-2013 он: ОХУ, Санхүүгийн их сургууль - Нягтлан бодох бүртгэл, анализ, аудит, бакалавр

Ажлын туршлага:

2013-2021 он: Шунхлай ХХК, Дотоод аудитор, Нягтлан бодогч

2021-2023 он: Монложистикс Холдинг ХХК, Төлөөлөгч

2023 оноос: Монложистикс Холдинг ХХК, Ерөнхий нягтлан бодогч

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



2023-06-14

БҮРТГЭВ-03

Охин компаниудын Гүйцэтгэх удирдлага

Хүснэгт 10. Охин компаниудын Гүйцэтгэх удирдлага

ОХ
2023.06.23
БҮРТГЭВ
№ 1

№	Компанийн нэр	Гүйцэтгэх захирал	Бусад албан тушаал
1	Монложистикс Ворлдвайд ХХК	И.Цогбаяр	Монложистикс Экспресс ХХК-ийн Гүйцэтгэх захирал
2	Монложистикс Тракинг ХХК	Н.Алтанзул	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч
3	Каус Аустралис ХХК	Н.Эрдэнэбилэг	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч
4	Монложистикс Россия Холдинг ХХК	Г.Хишигбат	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, Монложистикс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн
5	Монложистикс Транс Сервис ХХК	Тугаринов.В.А	Монложистикс Россия Холдинг ХХК болон Монложистикс Транс Сервис ХХК-ийн хувьцаа эзэмшигч
6	Монложистикс Карго ХХК	Г.Хишигбат	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, Монложистикс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн
7	Монложистикс Транзит ХХК	Б.Тэлэнгэд	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн ердийн гишүүн
8	Монложистикс Экспресс ХХК	И.Цогбаяр	Монложистикс Ворлдвайд ХХК-ийн Гүйцэтгэх захирал
9	Монложистикс Экүйпментс ХХК	Г.Хишигбат	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, Монложистикс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн


Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Дээрх компаниудаас 4 компанийн Гүйцэтгэх захирлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд ажиллаж байна. Тэдгээр албан тушаалтнуудын мэдээллийг Үнэт цаасны танилцуулгын 1.6 дахь хэсэгт тусгасан болно.

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS YUK ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК
monlogistics
HOLDING
ATA5299 6383751
9021031093

Хүснэгт 11. Охин компаниудын гүйцэтгэх удирдлагын танилцуулга



**Идэрцогт
ЦОГБАЯР**


Монложистикс
Ворлдвайд ХХК,
Монложистикс
Экпресс ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Боловсрол:

2012-2016 он: Япон Улс, Хитоцубаши их сургууль -
Санхүүгийн менежмент, бакалавр
2016-2017 он: Япон Улс, Хитоцубаши Их сургууль -
Бизнесийн удирдлага, магистр

Ажлын туршлага:

2017-2019 он: БУТИ ХХК, Бизнес хөгжлийн албаны
дарга
2019-2020 он: Ноно Пиано ХХК, Үүсгэн байгуулагч
2020-2022 он: Монложистикс Холдинг ХХК,
Портфолио, төслийн менежер
2022 оноос: Монложистикс Ворлдвайд ХХК,
Гүйцэтгэх захирал
2022 оноос: Монложистикс Экспресс ХХК,
Гүйцэтгэх захирал



**Тугаринов
Василий Андреевич**

Монложистикс
Транс Сервис ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Боловсрол:

2006-2011 он: ОХУ, Эрхүүгийн тээврийн их сургууль
- Төмөр замын тээвэр зохион байгуулалт,
Удирдлагын инженер, бакалавр

Ажлын туршлага:

2011-2015 он: Зүүн сибирийн төмөр замын
хөдөлгөөний удирдлагын төв, Инженер
2015-2016 он: Зүүн сибирийн төмөр замын
хөдөлгөөний удирдлагын төвийн харъяа төмөр
замын Наушки өртөө, Орлогч дарга
2016-2017 он: Зүүн сибирийн төмөр замын
хөдөлгөөний удирдлагын төвийн харъяа төмөр
замын Залари өртөө, Орлогч дарга
2017-2020 он: Зүүн сибирийн төмөр замын
хөдөлгөөний удирдлагын төвийн харъяа төмөр
замын Наушки өртөө, Дарга
2020-2022 он: Монложистикс Транзит ХХК,
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
2022 оноос: Монложистикс Транс Сервис ХХК,
Гүйцэтгэх захирал





Нэргүй
АЛТАНЗУЛ

Монложистикс
Тракинг ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Боловсрол:


2002-2006 он: Шинжлэх ухаан технологийн их сургууль- Олон улсын тээврийн менежмент, бакалавр

2019-2021 он: Удирдлагын академи - Бизнесийн удирдлага, магистр

Ажлын туршлага:

2006-2021 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Тээвэр ложистикийн мэргэжилтэн, Борлуулалтын ахлах менежер, Тээвэр эрхэлсэн дэд захирал, Олон улсын тээврийн албаны захирал

2021 оноос: Монложистикс Тракинг ХХК, Гүйцэтгэх захирал



Нанжид
ЭРДЭНЭБИЛЭГ

Каус Аустралис
ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Боловсрол:

1987-1991 он: Төмөр замын техникум - Төмөр замын ашиглалтын техникч, тусгай дунд
1991-1993 он: Улаанбаатар дээд сургууль - Зураг хөдөлмөрийн багш, дээд

2013-2014 он: Менежер, карьерийн институт - Удирдахуйн болон хүний нөөцийн менежер, бакалавр

Ажлын туршлага:

1991-1993 он: УБТЗ Багануур өртөө, Ачаа вагон хүлээлцэгч

1999-2004 он: Монголиан Транспорт Тийм ХХК, Экспедитр

2005-2020 он: Монложистикс Ворлдвайд ХХК, Тээврийн менежер, Дэд захирал

2020-2022 он: Монложистикс Транзит ХХК, Үйл ажиллагаа хариуцсан захирал

2022 оноос: Каус Аустралис ХХК, Гүйцэтгэх захирал

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



1.7 Эрх бүхий албан тушаалтан

2023 ОУХ
ОН САР
БҮРТГЭЛ
№ 11

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх заалтад заасан албан тушаалын тодорхой нэр заасан этгээдүүд болон компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцдог.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 11.1 дэх хэсэгт компанийн эрх бүхий албан тушаалтныг дээрх хуулийн дагуу тодорхойлсон. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 11-р сарын 07-ны өдрийн 20-005-2022BOD/20221107 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ложистик эрхэлсэн захирал, стратеги бизнес хөгжил эрхэлсэн захирал, санхүү эрхэлсэн захирал, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, ерөнхий нягтлан бодогч гэсэн албан тушаалтнуудыг эрх бүхий албан тушаалтнаар тогтоон шийдвэрлэсэн байна. Үнэт цаас гаргагч нь нийт 13 эрх бүхий албан тушаалтантай.

Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд

№	Овог нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг
1	Лувсанжамба ГАНЗОРИГТ	ТУЗ-ийн дарга	110,520,000
2	Бааст ТЭЛЭНГЭД	ТУЗ-ийн ердийн гишүүн	110,520,000
3	Санжаа САЙНБАТ	ТУЗ-ийн ердийн гишүүн	-
4	Ганзоригт ХИШИГБАТ	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	31,560,000
5	Балдан ЭНХТҮВШИН	ТУЗ-ийн ердийн гишүүн	-
6	Эрэндоо ОЮУНБИЛЭГ	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
7	Готов ЦЭРЭНПҮРЭВ	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
8	Энхбаатар НАРАНГАРВУУ	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	-
9	Амгалан ОДГЭРЭЛ	Ложистик эрхэлсэн захирал	31,560,000
10	Заанхүү ШИНЭ-ОД	Санхүү эрхэлсэн захирал	-
11	Эрхэмбаатар ЭЛДЭВ-ОЧИР	Стратеги, бизнес хөгжил эрхэлсэн захирал	-
12	Баатар АЗЖАРГАЛ	Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	-
13	Муратай МАЙГҮЛ	Ерөнхий нягтлан бодогч	-



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



1.8 Үнэт цаас гаргагчийн хэлцлүүд

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 89-р зүйлийн 89.1 дэх заалтад “энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий харилцаанд орсон бол компанитай, эхсүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно” гэж тусгагдсан.

Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн мэдээллээс үзвэл дээрх хуулийн заалтын дагуу сүүлийн гурван жил буюу 2020 оны 02-р сарын 01-ээс 2023 оны 02-р сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 14 сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулсан байна.

Тус хэлцлүүдийг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байх тул мөн зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилгүй бусад гишүүд батлах шаардлагатай байдаг.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй гишүүд нь 2023 оны 03-р сарын 02-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоолоор тус 14 хэлцлийг хүлээн зөвшөөрч шийдвэрлэсэн болно. Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасны дагуу эрх олгогдоогүй этгээдийн хийсэн үйлдлийг бүрэн эрх бүхий этгээд хожим дэмжин хүлээн зөвшөөрснөөр тухайн үйлдлийг хүчин төгөлдөр гэж үзэх тухай зохицуулалт байдаг тул дээрх сонирхлын зөрчил бүхий хэлцлийг зохих ёсоор хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан гэж дүгнэсэн.

Их хэмжээний хэлцэл

Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлээр зохицуулсан бөгөөд 87.1.1 дэх заалтад “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)”; мөн хуулийн 87.1.2 дахь хэсэгт “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг” гэж тус тус тодорхойлсон байдаг.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жил буюу 2020 оны 02-р сарын 01-ээс 2023 оны 02-р сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд 2 (хоёр) их хэмжээний хэлцэл байгуулсан байна. Үүнд:

- (i) Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 04-р сарын 28-ны өдрийн 8-002-2022BOD/20220428 тоот шийдвэрийн үндсэн дээр Монложистикс Ворлдвайд ХХК-ийн биржийн бус зах зээлд гаргасан 2.0 тэрбум төгрөгийн хаалттай бондын үндсэн болон хүүгийн төлбөр, андеррайтерийн гэрээгээр тогтоосон төлбөрийг батлан даахаар үүрэг гүйцэтгүүлэгч буюу Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-тай Б/22/09 тоот “Батлан даалтын гэрээ”-г байгуулсан. Мөн 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн Б/22/09-1 тоот “Батлан даалтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийг өөрийн охин компаниуд болох Монложистикс Карго ХХК, Монложистикс Транзит ХХК, Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Россия Холдинг ХХК





нартай хамтран батлан даах үүрэг хүлээсэн байна. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 06-р сарын 30-ны өдрийн 10-001-2022BOD/20220630 тоот тогтоолоор санал нэгтэй баталсан.

БҮРТГЭВ-03

2022 оны 11-р сарын 11-ний өдрийн 2-005-2022ХЭХ/20221111 тоот хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Мандал Праявит Экүйти Хувийн ХОС ХХК (Хувьцаа худалдагч) болон Үнэт цаас гаргагч (Хувьцаа худалдан авагч) нарын хооронд 2022 оны 11-р сарын 15-ны өдөр "Хувьцаа худалдах, худалдан авах болон эрх шилжүүлэх гэрээ"-г байгуулсан. Тус гэрээнд Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан энгийн хувьцааны 8 хувьтай тэнцүү хэмжээний хувьцааг гэрээнд заасан үнээр эргүүлэн худалдан авах, нөгөө талаас хувьцааг худалдагч нь тус хувьцааг шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Дээрх хэлцлүүдийг Компанийн тухай хуулийн 88-р зүйлийн 88.1 дэх заалт, 49-р зүйлийн 49.10 дэх заалтад тус тус үндэслэн дүгнэвэл Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэсэн өдрийн байдлаар 100,944,000 төгрөг байгаа бөгөөд түүний тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 5,047,200 төгрөг ба түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцлүүд байна.

2023 оны 02-р сарын 01-ний өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээнд үүрэг хүлээсэн нийт 24 гэрээ байгуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээ хэлцлүүдийн хувьд хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байна.


Хувьцаа эзэмшигчдийн гэрээ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалт, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Үнэт цаас гаргагчийн одоогийн зарим хувьцаа эзэмшигчид болох Л.Ганзоригт, Б.Тэлэнгэд, Г.Хишигбат, А.Одгэрэл, Л.Эрдэнэсоёл, Н.Алтанзул, Н.Эрдэнэбилэг нар 2023 оны 04-р сарын 10-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн гэрээг шинэчлэн байгуулсан болно.

Тус гэрээний гол нөхцлүүдийг дурдвал:

Компанийн тухай хуулийн 4.5 дахь заалтад "хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид тохиролцсоны үндсэн дээр хувьцаагаа захиран зарцуулах эрхээ харилцан хязгаарласан гэрээ байгуулж болно" гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувьцааны 5 хүртэлх хувийг нээлттэй болон хаалттай хэлбэрээр чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй байна. Компани нь нийтэд нээлттэй хувьцаат компани болох замаар хэлбэрээ өөрчилсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчид нь хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх хорооны зөвшөөрөл гарснаас хойш 6 сарын турш нийт хувьцаагаа захиран зарцуулах эрхгүй байхаар харилцан тохиролцсон.

Мөн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн хүрээнд хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувьцааг захиран зарцуулах буюу гуравдагч этгээдэд хувьцаагаа шилжүүлэх тохиолдолд энэ гэрээний тал болон оролцсон



2023-06-14

БҮРТГЭЭ-03

бусад хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн худалдан авах эрхтэй байхаар тохиролцсон.

Түүнчлэн, тус гэрээний нэг дэх хэсэгт заасны дагуу тус хувьцаа эзэмшигчдийн гэрээ нь зөвхөн гэрээ байгуулагч талуудад хамааралтай буюу анхдагч зах зээлийн арилжааны үеэр болон түүний дараагаар Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах ирээдүйн хөрөнгө оруулагч нар тус гэрээний дагуу аливаа үүрэг хүлээхээргүй байна.

Дээрх хэсэгт дурдсан их хэмжээний, сонирхлын зөрчилтэй, хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, ач холбогдол бүхий гэрээ хэлцлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралтад тусгагдсан хуулийн дүгнэлтээс үзнэ үү.



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



ХОЁР.

**ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТУХАЙ**

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ




2.1 Үнэт цаас гаргагч, охин компани тус бүрийн үйл ажиллагаа, тэдгээрийн онцлог

Ази тивийн эх газрын төвд оршдог, далайд гарцгүй Монгол Улсын хувьд тээвэр ложистикийн тогтвортой байдал нь гадаад худалдааны эргэлт, цаашлаад эдийн засгийн тогтвортой байдалд стратегийн чухал ач холбогдолтой.

Тодруулбал, тээвэр ложистикийн салбар нь Монгол Улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортын бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгахад чухал ач холбогдолтой.

Тээвэр ложистикийн үйл ажиллагааг тээврийн төрлөөс хамааруулан импорт, экспорт, транзит гэж ангилдаг. Монложистикс Групп нь тээврийн төрөл тус бүрт төрөлжсөн 9 охин компаниудаар дамжуулан тээвэр ложистикийн цогц үйлчилгээг үзүүлдэг.

Зураг 5. Үнэт цаас гаргагчийн охин компаниудын үйл ажиллагааны төрөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



СЭХ
04.03.2023 САР
БҮРТГЭВ
№ 11

Импортын тээвэр

Бусад улс орноос Монгол Улс руу импортоор орж ирж буй бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх үйл явцыг импортын тээвэр гэнэ. Энэ нь барааны гарал үүслийн цэгээс эцсийн хүрэх газар хүртэлх тээвэрлэлтийг удирдан зохион байгуулах үйл ажиллагаа юм.

2023-06-14
БҮРТГЭВ-03

Монложистикс Холдинг ХХК-ийн охин компаниуд болох Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Экспресс ХХК нь В2В зах зээлд, Монложистикс Карго ХХК нь В2С зах зээлд импортын тээврийн үйлчилгээ үзүүлдэг.

Монгол Улсын импортын голлох бүтээгдэхүүнд машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, нефтийн бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, химийн бодис ордог бөгөөд нефтээс бусад өргөн хэрэглээний бараанууд ихэвчлэн чингэлэгт ачигдан тээвэрлэгддэг.

Монгол Улсын импортын чингэлэг тээврийн 80 гаруй хувь нь БНХАУ-ын Тяньжинь боомтоор дамжиж ирдэг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монложистикс Групп нь дэлхийн 60 гаруй улсаас авто, агаар, далай, төмөр зам болон холимог тээврээр ачааг тээвэрлэж байна.

Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн 92 гаруй хувь нь Замын-Үүд хилийн боомтоор, 8 хувь нь Алтанбулаг хилийн боомтоор дамжин тээвэрлэгдэж байна.

Зураг 6. Монложистикс Группийн импортын тээврийн газрын зураг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Монложистикс Ворлдвайд ХХК /В2В зах зээл/

Монложистикс Ворлдвайд ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсанаас хойш 18 жилийн турш импортын тээвэр ложистикийн үйлчилгээг үзүүлж байна.

Тус компани нь Үнэт цаас гаргагчийн ууган компани бөгөөд Монгол Улсын импортын чингэлэг тээврийн ТОП-5 компанийн нэг юм. Монложистикс Ворлдвайд ХХК нь Монгол Улсын тээвэр ложистикийн салбарт анх удаа ISO9001:2008 олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн түүхтэй.

MA...
M...
ISO 9001:2008
[Signature]

MONLOGISTICS HOLDING
ATA5299 6381251
9021031093

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монложистикс Ворлдвайд ХХК нь 160 гаруй улс орны 800 гаруй харилцагч түнш, Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг зэрэг хилийн боомт, төлөөлөгчийн газруудаар дамжуулан 1,500 гаруй байгууллагад тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Зураг 7. Монложистикс Ворлдвайд ХХК-ийн хамтрагч байгууллага



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Тус компани нь Улаанбаатар хотын бүх гаалийн терминалаар ачаа авах гэрээтэй, Дархан, Эрдэнэт хотуудад гэрээт төлөөлөгч, өөрийн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүд, түгээлтийн авто машинтай юм.

Монложистикс Ворлдвайд ХХК нь гадаад улс орнуудаас тээвэрлэлт хийхээс гадна гаалийн бүрдүүлэлт, терминалын үйлчилгээ, агуулах, хүргэлт гэх мэт харилцагчдын барааг хүссэн газарт нь найдвартай хүргэж өгөхөд шаардлагатай тээвэр ложистикийн цогц үйлчилгээг үзүүлдэг.

Үйл ажиллагааны онцлог

Тус компани нь импортын тээврийн үйлчилгээ үзүүлдэг бусад компаниудтай харьцуулахад бүх ачааг ачаа, тээврийн даатгалд хамруулж, дараа төлбөрт, уян хатан төлбөрийн нөхцөлийг олгон, харилцагчдад тээврийн явцын мэдээллийг технологийн шийдлээр дамжуулан тогтмол хүргүүлж, шаардлагатай нөхцөлд захиалгат нислэг, хүргэлтийн үйлчилгээг санал болгодог ороо онцлогтой.

Монложистикс Ворлдвайд ХХК нь Скайхайпермаркет ХХК, Говь ХК, Юнител Групп, Сүү ХК, Мобиком Корпорац ХХК, Монос Фарм Трейд ХХК, Нэкст Групп, Макс Групп зэрэг дотоодын томоохон аж ахуй нэгжүүдийн итгэлтэй түнш болсны зэрэгцээ олон улсын тээвэр ложистикийн томоохон компаниудын Монгол Улс дахь албан ёсны агентаар ажилладаг.

Тодруулбал, тус компани нь БНХАУ-ын төрийн өмчит төмөр замын чингэлэг тээврийн корпорац (цаашид "China Railway International Multimodal Transportation буюу CRIMT" гэх)-ийг Монголын зах зээлд төлөөлж, чингэлгийн хяналт, ашиглалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Тус компани нь БНХАУ-ын хамгийн том чингэлэг тээврийн компаниудын нэг бөгөөд дотоод болон олон улсын 76 чиглэлд чингэлэг тээврийн өргөн сүлжээг удирдан ажиллуулдаг.



Зураг 8. Монложистикс Ворлдвайд ХХК болон CRIMT-ийн хамтарсан цуваа

2023-06-14

В-03



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Монложистикс Карго ХХК /B2C зах зээл/

Дэлхий дахинд болон Монгол Улсад цахим худалдаа (e-commerce)-ны хэрэглээ, ач холбогдол жилээс жилд нэмэгдэж байна. Цахим худалдаа нь 1) хэрэглэгч биетээр барааг эрж хайх цаг, зардлыг хэмнэдэг 2) хэрэглэгч тухайн оршин байгаа улс орны зах зээлээр хязгаарлагдахгүйгээр дэлхийн хаанаас ч хүссэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах боломжийг олгодог ороо онцлогтой.

Монложистикс Карго ХХК нь 2021 онд үүсгэн байгуулагдсанаас хойш B2C зах зээлд импортын тээврийн үйлчилгээг үзүүлж, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 4000 гаруй харилцагчдад карго үйлчилгээ үзүүлж байна.

Тус компани нь технологийн шийдлийг ашиглан дэлхийн худалдааны томоохон цахим платформ болох Tmall-ыг холбосон Cheepah.mn сайтыг хөгжүүлэн, харилцагчдад дэлхийн зах зээлээс хүссэн барааг дундын зуучлагчийн шимтгэлгүйгээр худалдан авах боломжийг бүрдүүлсэн.

Зураг 9. Cheepah.mn сайтын зураг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



MANUAL CAPITAL
MARKETS SG
LLC

[Handwritten signature]

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК

monlogistics
HOLDING

ATA5:00 € 0381251
900 1031000




Монложистикс Карго ХХК нь харилцагчдын Cheepah.mn сайтаар дамжуулан өгсөн захиалгыг цуглуулбар ачаа хэлбэрээр тээвэрлэж, хэрэглэгчдийн гарт 7-14 хоногийн дотор хүргэдэг. Захиалсан бүх барааг ачаа тээврийн даатгалд үнэ төлбөргүй хамруулж, найдвартай байдлыг бүрэн хангадагаараа онцлогтой.

Монложистикс Экспресс ХХК /B2B зах зээл/

Монложистикс Экспресс ХХК нь 2022 оны 11-р сард үүсгэн байгуулагдсанаас хойш олон улсын харилцагчдад тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг Монгол Улс руу илгээх тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Тус компани нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэгч тал буюу олон улсын харилцагчдад тээврийн үйлчилгээг санал болгодоогоороо Монложистикс Ворлдвайд ХХК-аас ялгаатай.

Зураг 10 . Монложистикс Экспресс ХХК болон Монложистикс Ворлдвайд ХХК-ийн үйл ажиллагааны ялгаатай байдал



Монложистикс Ворлдвайд ХХК
Ачаа барааг хүлээн авагч /худалдан авагч/ тал буюу импортлогч талаас тээврийн үйлчилгээний захиалгыг хүлээн авдаг.

Монложистикс Экспресс ХХК
Ачаа барааг илгээгч /нийлүүлэгч/ тал буюу экспортлогч талаас тээврийн үйлчилгээний захиалгыг хүлээн авдаг.

Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн зураглал

Олон улсын худалдааны нөхцөлд нийлүүлэгч тал нь бараа бүтээгдэхүүнийг худалдан авагч талд хүргэж өгөх нөхцөлтэй худалдаа түгээмэл байдаг боловч Монгол Улсын газар зүйн байршил, геополитикийн нөхцөл байдал, дэд бүтцийн сул хөгжил, далайд гарцгүй байдал зэргээс шалтгаалан бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэн хүргэхэд хүндрэлтэй байдаг.

Энэ нь тээвэр ложистикийн үйлчилгээ авч буй харилцагчдад ачаа бараа нь саатах, төсөвт өртөг нэмэгдэх, барааны чанар алдагдах гэх мэт асуудлыг үүсгэдэг сөрөг талтай.

Иймд Монложистикс Экспресс ХХК нь Монгол Улс руу бараа бүтээгдэхүүн нийлүүлж буй олон улсын харилцагчдад тулгардаг дээрх асуудлуудыг цогц байдлаар шийдэх тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Транзит тээвэр

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин БНХАУ, ОХУ зэрэг гуравдагч орон руу хийгдэж буй тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь транзит буюу дамжин өнгөрөх тээвэр юм.

Транзит тээвэр нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамаарч олон улсын ачааг өөрийн нутгаар дамжуулан тээвэрлэлтийг зохион байгуулсны үр дүнд нэмүү өртөг бүтээж байдгаараа бусад тээврээс онцлогтой.



Монгол Улсын хувьд БНХАУ, ОХУ гэх хөгжингүй улсуудын дунд оршдог газар зүйн таатай байршилтай, Ази, Европыг холбох хамгийн дөт замд тооцогддог.

Үнэт цаас гаргагчийн охин компани Монложистикс Транзит ХХК нь транзит тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.

Монложистикс Транзит ХХК

Монложистикс Транзит ХХК нь Зүүн Өмнөд Азийн зарим улс орнууд болон БНХАУ, ОХУ, Европын улс орнуудын хооронд Монгол Улсаар дамжин өнгөрөх төрөл бүрийн транзит тээвэр зохион байгуулалт, гаалийн бүрдүүлэлттэй холбогдох тээвэр ложистикийн цогц үйлчилгээг 24 цагийн турш үзүүлдэг.

Тус компани нь ОХУ-ын хамгийн том чингэлэг тээврийн компани болох Транс Контейнер ХК-ийн Монгол Улсаар дамжин өнгөрөх чингэлгийн ачаа тээврийг зохион байгуулан ажилладаг.

Зураг 11. Транс Контейнер ХК-ийн чингэлгийн цуваа



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Монложистикс Транзит ХХК нь Замын-Үүд, Сүхбаатар боомт дахь Улаанбаатар төмөр зам ХНН (цаашид "УБТЗ" гэх)-ын дэд бүтцээр дамжин транзит тээврийг гүйцэтгэхийн зэрэгцээ Монгол Улсын газар зүйн байршлын онцлог, БНХАУ талын төмөр замын тээвэрлэлтийн ачаалал зэргээс хамааран холимог транзит тээвэр ложистикийн үйлчилгээг гүйцэтгэдэг.

Тус компанийн үйл ажиллагаа зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүйгээр БНХАУ, ОХУ-ын төмөр замын корридор, алс дорнодын боомтуудаар дамжуулан тээвэр ложистикийн үйл ажиллагааг эрхэлдэг.

Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд төмөр замын шинэ корридорууд баригдсаны дараа зүүн корридорын Бичигт-Эрээнцав боомт, баруун корридорын Арцсуурь-Шивээхүрэн боомтуудаар дамжуулан транзит тээврийг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.



СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 31

Зураг 12. Транзит тээврийн маршрут



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Экспортын тээвэр

Монгол Улсаас бусад хоёрдогч улс орон руу бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх үйл явцыг экспортын тээвэр гэнэ. Монгол Улсын экспортын орлогын 90 орчим хувийг нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэр нь Монгол Улсын эдийн засагт өндөр ач холбогдол бүхий салбар юм.

Үнэт цаас гаргагчийн охин компани Каус Аустралис ХХК нь экспортын тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.

Каус Аустралис ХХК

Каус Аустралис ХХК нь 2022 оны 04-р сараас эхлэн УБТЗ болон Монголын Төмөр Зам ТӨХК (цаашид "МТЗ" гэх)-ын өртөөгөөр дамжуулан Цогтцэций-Зүүнбаян-Эрээн болон Чойр, Мааньт, Олон овоо, Сайншанд, Сүхбаатар зэрэг өртөөнөөс Эрээн боомтын чиглэлд нүүрс, цайрын баяжмал зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар экспортлох тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Тус компани нь бүх төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнийг уурхайн амнаас эцсийн хэрэглэгч хүртэл тээвэрлэх цогц үйлчилгээг санал болгодог ороо онцлогтой.

Каус Аустралис ХХК нь Энержи Ресурс ХК, Эрдэнэс Тавантолгой ТӨХК-тай нүүрс худалдан авах гэрээтэй БНХАУ-ын компаниудад тээврийн үйлчилгээ үзүүлж, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 5 цуваа буюу 250 ширхэг тавцант вагон, 500 гаруй задгай чингэлгээр экспорт тээвэрлэлт хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Ханги, Шивээ хүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтоор төмөр замаар дамжуулан экспорт тээврийг өргөжүүлэхээр төлөвлөж байна.



Зураг 13. Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн маршрут



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Бусад тээвэр

Үнэт цаас гаргагчийн бусад охин компаниуд болох Монложистикс Транс Сервис ХХК, Монложистикс Россия Холдинг ХХК, Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Экүйпментс ХХК нь тээвэр ложистикийн экосистемийг бүрдүүлэн ажилладаг.

Монложистикс Транс Сервис ХХК, Монложистикс Россия Холдинг ХХК

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн, 2021 онд олон улсын зах зээлд анхны охин компанийг байгуулсан нь Монложистикс Россия Холдинг ХХК юм.

Тус компани нь аливаа нэг тээврийн үйчилгээг үзүүлдэггүй, зөвхөн толгой компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Монложистикс Россия Холдинг ХХК-ийн 90 хувийн охин компани болох Монложистикс Транс Сервис ХХК нь ОХУ-д байршиж, Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын хооронд экспорт, импорт, транзит тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Монложистикс Транс Сервис ХХК нь Монгол Улсын эдийн засаг, тээврийн нөхцөл байдлаас үл хамааран ОХУ-д тээврийн үйл ажиллагааг явуулдагаараа онцлогтой.

Тус компани нь БНХАУ болон ОХУ-ын томоохон вагон, чингэлэг эзэмшигч нар болох РЖД Бизнес Актив /RJD Business Active LLC/, Транс Контейнер ХК /Trans Container JSC/, ФЕСКО /FESCO International JSC/, Тяньжинь Свифт /Tianjin Swift LLC/, Непчунь Шеньжень /Neptune Shenzhen LLC/ зэрэг компаниудын ачааг Эрээн-Наушки, Манжуур-Забайкальск зэрэг боомтуудаар ОХУ, БНХАУ-ын хооронд Транс-Сибирийн төмөр зам, авто замаар тээвэрлэж байна.

Монложистикс Тракинг ХХК

Монложистикс Тракинг ХХК нь 2021 онд үүсгэн байгуулагдсанаас хойш Монгол Улсын экспорт, импорт, транзитын чиглэлд олон улсын гаалийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл бүхий хөргүүртэй, задгай, бүхээгтэй крантай гэх мэт төрөл бүрийн авто тээврийн хэрэгслээр ачааг тээвэрлэж байна.



Тус компани нь Европын улс орнууд, ОХУ, Турк, Дундад Ази, БНХАУ гэх зэрэг орнуудаас Замын-Үүд, Алтанбулаг, Булган боомтоор дамжуулан авто тээврийг зохион байгуулдаг.

Зураг 14. Монложистикс Тракинг ХХК-ийн тээвэрлэлт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Мөн Монложистикс Ворлдвайд ХХК болон бусад охин компаниудын ачааг хилийн боомтоос Улаанбаатар болон бусад хот хүртэл импорт, экспорт, Монгол Улсаар дамжуулан гадаад улс руу транзит тээврийг авто замаар тээвэрлэх үйлчилгээ үзүүлдэг.

Тус компани нь бүх тээврийн төрлүүдийг холбож энгийн жижиг илгээмжээс хэтрүү овортой буюу хэт хүнд техник, тоног төхөөрөмж, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардах ачааг хаалганаас хаалганд хүргэх тээвэрлэлтийг хийдгээрээ онцлогтой.

Монложистикс Экүйпментс ХХК

Монложистикс Экүйпментс ХХК нь төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн буюу вагон түрээсийн үйл ажиллагаа явуулах зорилгоор 2022 онд үүсгэн байгуулагдсан.

Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын төмөр замын тээвэрлэлтэд ашиглаж буй УБТЗ-ын эзэмшлийн вагонуудын ихэнх нь ашиглалтын хугацаа дууссан (2021 оны УБТЗ-ын мэдээллээр нийт хөдлөх бүрэлдэхүүний 86 хувь нь 25 ба түүнээс дээш жилийн насжилттай), хүрэлцээгүй зэргээс үүдэн экспортын тээвэрлэлтэд ОХУ-аас вагон түрээслэн ашиглаж байна.

Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд төмөр замын бүтээн байгуулалтууд бий болох үед вагоны эрэлт хэрэгцээ улам нэмэгдэх хүлээлттэй байна.

Иймд Монложистикс Экүйпментс ХХК нь эрэлттэй байгаа тус зах зээлд өөрийн эзэмшлийн вагон худалдан авч, техник технологийн шаардлага хангасан вагон түрээсийн үйлчилгээг үзүүлэх, Үнэт цаас гаргагчийн бусад охин компаниудын вагон болон хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээг хангах зорилгоор үйл ажиллагаа явуулж байна.





2.2 Үнэт цаас гаргагчийн охин компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ

Тээвэр ложистикийн үйл ажиллагааг тээврийн төрлөөс хамааран экспорт, импорт, транзит тээвэр; тээврийн хэлбэрээс хамааран төмөр замын, авто замын, далайн, агаарын тээвэр гэж ангилдаг.

Зураг 15. Тээврийн ангилал



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн охин компаниуд нь тээврийн бүх хэрэгслээр дамжуулан харилцагчдын ачаа барааг тээвэрлэж байна.

Хүснэгт 13. Монложистикс Группийн тээврийн төрөл, тээврийн хэлбэрээр

Тээврийн хэлбэр \ Тээврийн төрөл	Төмөр зам	Авто зам	Далай	Агаар
Импорт	✓	✓	✓	✓
Транзит	✓	✓		
Экспорт	✓	✓		
Бусад	✓	✓		

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээвэр нь хуурай замын тээврийн төрлүүдээс их хэмжээний ачааг богино хугацаанд, бага зардлаар, цаг уурын нөхцөл байдлаас үл хамааран хийдгээрээ давуу талтай.

Тус тээвэр нь тусгайлан бэлдсэн зам дээр битүү вагон, хагас вагон, тавцант болон тусгай зориулалтын зэрэг олон төрлийн вагоноор ачааг тээвэрлэхээс гадна хялбар муудах ачааг хөргүүртэй болон тогтмол дулаантай вагоноор, үнэ цэнтэй ачааг харуул хамгаалалттай вагоноор тээвэрлэх зэрэг тээвэрлэлтийн олон хэлбэрүүдээс сонгох боломжийг олгодог.

Монгол Улс далайд гарцгүй боловч Европ, Ази тивийг холбосон төмөр замын өндөр хүчин чадалтай дэд бүтцийн дунд байрлалтай. Уг дэд бүтцийг ашиглан



экспорт, импорт, транзит тээврийг төмөр замаар богино хугацаанд зохион байгуулах өргөн боломж бүрдсэн байдаг.

Үнэт цаас гаргагчийн Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Экүйпментс ХХК-иас бусад охин компаниуд нь Монгол Улсын болон олон улсын төмөр замын сүлжээг ашиглан экспорт, импорт, транзит тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

Тус компаниуд нь Европын улс орнууд болон ОХУ-с Сүхбаатар боомт, БНХАУ болон гуравдагч орноос Замын-Үүд боомтоор дамжуулан төмөр замын тээвэрлэлтийг хийж гүйцэтгэдэг. Монгол Улсын хилийн боомтод ирсэн ачааг УБТЗ-аар Улаанбаатар болон төмөр замд холбогдсон Монгол Улсын бусад өртөөд рүү тээвэрлэдэг.

Агаарын тээвэр

Агаарын тээвэр нь ачаа барааг хамгийн хурдан шуурхай тээвэрлэдэг тээврийн төрөл бөгөөд шуудан, яаралтай, түргэн муудаж чанараа алдах, эмзэг ачааг шууд болон дамжих нислэгээр ихэвчлэн тээвэрлэдэг.

Шаардлагатай нөхцөлд агаарын тээвэрт зориулсан тусгай баглаа боодол, гаалийн бүрдүүлэлт хийх, ачаа барааг хаягаар очиж авах, хүргэх зэрэг нэмэлт үйлчилгээг харилцагчдад үзүүлдэг.

Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн охин компаниуд нь БНХАУ-ын Бээжин, ХБНГУ-ын Франкфурт хотуудаас шууд нислэгээр, БНСУ-ын Инчеон, БНТУ-ын Истанбул хотуудаар дамжин өнгөрөх нислэгээр гуравдагч улс орнуудын ачааг агаараар тээвэрлэж байна.

Далайн тээвэр

Тээврийн төрлүүдээс хамгийн өртөг багатай, ачаа эргэлт өндөр тээвэр нь далайн тээвэр юм. Монгол Улс далайд гарцгүй тул бусад улс орны далайн боомтуудаар дамжуулан өөрийн хилийн боомт руу авто болон төмөр замаар буюу холимог тээвэрлэлт хийж гүйцэтгэдэг.

Монгол Улсын хувьд хамгийн ойр байгаа далайн боомт нь Тяньжинь боомт бөгөөд БНХАУ-аас Монгол Улсыг чиглэсэн нийт тээврийн 80 хувь нь тус боомтоор дамжин ирдэг.

Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн охин компаниуд нь Монгол Улсад ирэх боломжит далайн тээврийн агентуудаар дамжуулан дэлхийн бусад бүх улс орнуудаас чингэлэг тээвэрлэлт зохион байгуулахын сацуу мөн овор ихтэй, задгай ачаа барааг тээвэрлэж байна.



Тус компаниуд нь БНХАУ-ын Тяньжинь, Чингхуангдао, Бэйхай, Чингдао, ОХУ-ын Владивосток, Новороссийск, Литва улсын Клайпеда, Латви улсын Рига боомтуудаар дамжуулан далайн тээвэрлэлтийг хийдэг.

Авто тээвэр

Хуурай газрын тээврээс төмөр замын тээвэр нь өртөг багатай, хурдан шуурхай боловч тусгайлан зассан замыг хэрэглэдэг, үйл ажиллагааны нарийн чанд технологийг шаарддаг, цаг хугацааны нарийвчилсан хуваарийн дагуу явагддаг зэрэг сул талтай.

Харин авто тээвэр нь төмөр замаас өртөг өндөртэй хэдий ч илгээгчийн агуулахаас хүлээн авагчийн агуулах хүртэл хаалганаас хаалганд ачааг шууд харилцагчдад хүргэж өгдөг, хүссэн цагт ачааг тээвэрлэх боломжтой үн хатан байдгаараа давуу талтай.





Монложистикс Тракинг ХХК нь авто тээврийн үйлчилгээг дагнан хүргэдэг бөгөөд Үнэт цаас гаргагчийн импорт, транзит тээврийн компаниуд нь мөн авто тээврийн үйлчилгээг зохион байгуулдаг.

Тус компаниуд нь Европын улс орнууд, ОХУ, БНТУ, Дундад азийн орнуудаас Алтанбулаг, Цагаан нуур боомтоор, БНХАУ-аас Замын-Үүд, Булган боомтуудаар дамжуулан импорт, экспорт, транзит ачааг эцсийн цэг хүртэл авто тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн авто тээврийн үйлчилгээ үзүүлэгч охин компаниуд нь олон улсын гаалийн дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл /TIR/ бүхий бүхээгтэй, хөргүүртэй, задгай гэх мэт төрөл бүрийн тээврийн хэрэгслээр энгийн жижиг илгээмжээс бүтэн машин, хэтрүү овортой, хүнд жинтэй, гаалийн баталгаат гэх мэт бүх төрлийн ачаа тээврийн үйлчилгээг үзүүлдэг.

Бусад үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь авто зам, төмөр зам, далайн, агаарын тээврийн үйлчилгээг хүргэхээс гадна гаалийн бүрдүүлэлт, терминалын үйлчилгээ, тээврийн даатгал, агуулах, хүргэлтийн үйлчилгээг нэмэлтээр үзүүлэн цогц тээвэр ложистикийн үйлчилгээг харилцагчдад санал болгодог.

Гаалийн бүрдүүлэлт

Бараа бүтээгдэхүүнийг гаальд мэдүүлэх нь холбогдох хууль журмын дагуу олон үе шаттай явагддаг нарийн үйл ажиллагаа юм. Харилцагч барааг гаальд мэдүүлэх талаар хангалттай мэдлэггүйн улмаас санаандгүй хууль дүрэм зөрчих, торгуулах, бараа устгуулах, нэмэлт зардал төлөх гэх мэт асуудал үүсдэг.

Үнэт цаас гаргагчийн охин компани Монложистикс Ворлдвайд ХХК нь гаалийн зуучлагчийн тусгай зөвшөөрлийн хүрээнд импорт, экспорт, транзит тээврийн гаалийн бүрдүүлэлтийн дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:


- Гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримтыг шалгах, бүрдүүлэх
- Барааны үнэ, үнэлгээг хянуулах
- Гаалийн болон бусад татвар хураамжийг төлөхөд бэлдэх
- Барааг гаальд шалгуулах
- Баталгаажсан гаалийн мэдүүлгийг хэвлэж өгөх
- Бусад гаальтай холбоотой үйлчилгээ, зөвлөгөө

Монложистикс Ворлдвайд ХХК нь Замын-Үүд, Алтанбулаг, Улаанбаатар хотын гааль, Ти Ай Ложистикс, Амгалан ложистик, Чингис хаан нисэх буудал, УБТЗ-ын Ачих Буулгах Тээвэр Экспедицийн Механикжсан Анги (цаашид "АБТЭМА" гэх)-д байрлах 7 салбар оффист нийт 20 гаруй мэргэшсэн мэргэжилтнээр дамжуулан гаалийн зуучлалын үйлчилгээ үзүүлж байна.

Үүнээс гадна Монложистикс Транс Сервис ХХК нь ОХУ-ын импорт, экспорт, транзит тээврийн барааны гаалийн бичиг баримт шалгах үйлчилгээг үзүүлдэг. Энэхүү үйлчилгээ нь тухайн улсын гаалийн байгууллагын шаардлагын дагуу бичиг баримт бүрдүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлдэг.



Зураг 16. Үнэт цаас гаргагчийн охин компаниудын гааль болон терминалын ажилчид



Чингис хаан нисэх буудлын агуулах терминал



Амгалан терминал дахь оффис



Замын-Үүд боомт, Дорноговь аймаг



АБТЭМА терминал, Улаанбаатар хот



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Цуглуулбар ачаа тээвэр

Харилцагчдад бага хэмжээний ачааг олон улсаас импортлох эсвэл экспортлох хэрэгцээ шаардлага тулгардаг. Тус нөхцөлд агаарын тээвэр, бүтэн машин, эсвэл бүтэн чингэлэгээр ачаа тээвэрлэх нь өртөг өндөр байдаг. Иймд харилцагчийн энэхүү эрэлт хэрэгцээнд нийцүүлэн овор багатай ачаануудыг нэгтгэн тээвэрлэхийг цуглуулбар ачааны тээвэр гэнэ. Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн охин компаниуд тус үйлчилгээг үзүүлдэг.

БНХАУ-иас импортлох ачааг Эрээн боомт, БНЧУ, ХБНГУ, ОХУ-аас импортлох ачааг Эрхүү, Улаан-Үүд хотууд, АНУ, Зүүн өмнөд азийн орнууд болон бусад улсаас импортлох ачааг БНСУ-ын Инчеон боомтуудаар дамжуулан тээвэрлэдэг.

Агуулах

Үнэт цаас гаргагчийн охин компаниуд болох Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Транс Сервис ХХК нь харилцагчийн ачааг гаалийн багалгаат, энгийн, дулаан болон хүйтэн агуулахад хадгалах үйлчилгээг туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд үзүүлдэг.



Зураг 17. Агуулахын зураг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.3 Хүний нөөцийн бодлого

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын тээврийн салбарын гол хөдөлгөх хүч болсон хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллан, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 180 орчим ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 18. Үнэт цаас гаргагчийн ажилчид



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын буюу Монложистикс Группийн нийт ажилтнуудын 59 хувь эмэгтэй, 41 хувь эрэгтэй ажилтнуудаас бүрддэг. Нийт ажилтнуудын 63 хувийг 20-35 насны залуу боловсон хүчин бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй охин компаниудаас гадна ОХУ-д үйл ажиллагаа явуулж буй Монложистикс Транс Сервис ХХК-д төмөр замаар мэргэшсэн баг хамт олон тээврийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Үнэт цаас гаргагч нь Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн олон талт харилцаа, тэрхүү харилцаанд оролцогч бүх талуудын өрх



зүйн тэнцвэртэй байдлыг хангасан зохицуулалт, хүний нөөцийн менежментийн нэгдсэн бодлого, стратегийг байгууллагын соёлд нийцүүлэн хэрэгжүүлдэг.

Монложистикс Групп нь хүний нөөцийн дараах үндсэн 4 стратегийг баримтлан ажилладаг.

Мэргэжлийн сонгон шалгаруулалт, ирээдүйн карьер хөгжил

Үнэт цаас гаргагчид жилд 1,500 гаруй ажил горилогч ханддаг бөгөөд 5 үе шатаас бүрдсэн сонгон шалгаруулалтын үр дүнд чадварлаг мэргэжлийн боловсон хүчнийг сонгон шалгаруулж авдаг.

2021 оноос эхлэн Үнэт цаас гаргагч нь жилд 30-с дээш ажлын байрыг бий болгож, ажилтнуудын 20-25 хувь ажил мэргэжлийн өсөлт гаргасан байна.

Өрсөлдөхүйц цалин хөлс, нийгмийн баталгаа

Үнэт цаас гаргагч нь зах зээлийн цалингийн судалгаанд үндэслэн Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц цалингийн сүлжээг баримтлан ажилладаг. Мөн ажилласан жил, ур чадвар, илүү цаг, шөнийн цагийн нэмэгдлийг хуулийн хүрээнд бусад хөнгөлөлт хангамжийн хамт тогтмол олгож, ажилтнуудыг тогтвортой ажиллах нөхцлөөр бүрэн хангахын төлөө зорьдог.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Үнэт цаас гаргагчийн урт хугацааны сургалт хөгжлийн бодлогын дагуу удирдлагын шатны залгамж халааг бэлдэх зорилгоор жил бүр Сингапур улсын Үндэсний их сургууль, Менежментийн их сургуулиудтай хамтран манлайллын хөтөлбөрт залуу менежер, захирлуудыг хамруулдаг.

Зураг 19. Манлайллын хөтөлбөр ба ажилчдад зориулсан сургалт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Сургалт хөгжил бодлогын хүрээнд Группийн хэмжээнд ажилтны хувь хүний хөгжлийн төлөвлөгөөнд зориулан 1 ажилтанд дунджаар улирал бүр 1.5 сая төгрөгийн төсөв бүхий гадаад дотоод, мэргэжлийн болон ерөнхий ур чадварын сургалт хөгжлийн үйл ажиллагааг зарцуулдаг.

Аз жаргалтай багийг хадгалах соёл

Үнэт цаас гаргагч нь бие эрүүл, ухаан саруул, ажил амьдралын зохицлыг бүрэн хангасан баг хамт олныг бүрдүүлэгч байхаар зорьдог ба ажлын 2 цагийн уян системд, бие, сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжсэн мэргэжлийн сэтгэл зүйчийг ажиллуулж, "Speak UP" ажилчдын дуу хоолойг хаалттай хүлээн авах талбарыг бий болгосон.



Зураг 20. Үнэт цаас гаргагчийн оффисийн ажилчид



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.4 Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

Олон улсын стандартад нийцсэн компанийн сайн засаглалыг төлөвшүүлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь оновчтой удирдлага, зөв зохион байгуулалт, хариуцлагатай байдлын цогц нэгдэл бүхий бодлого хэрэгжүүлэхийг зорин ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь компанийн бүтээмжийг сайжруулах зорилгоор 2018 оноос бизнесийн нэгдсэн платформ ERP системийг нэвтрүүлсэн. Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй удирдан, тогтвортой хөгжил рүү чиглүүлэн, үнэт зүйлс, соёл, стратеги төлөвлөлт зэргийг нийгэм, эдийн засаг болон байгаль орчны асуудлуудтай уялдуулан, нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн.

Future CEO төсөл хөтөлбөр

“Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл” үнэт зүйлийг баримтлан, оюутан залуусын хөгжилд оюунлаг хөрөнгө оруулалт хийхээр ирээдүйн манлайллын хөтөлбөр болох Future CEO төслийг санаачилсан.

2021 оноос эхлэн тус төслийн хүрээнд математикийн элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан төгсөгч нараас шилдэг 3 оюутныг шалгаруулж, нийт 120 сая төгрөг бүхий багц тэтгэлэгт хөтөлбөрийн эрхээр шагнасан.

Тэтгэлэгт шалгарсан оюутнууд нийгэмд дараагийн түвшний залуу манлайлагч болон хөдөлмөрийн зах зээл дээр шууд бэлтгэгдэн гарч ирэхээр суралцаж байна.

Зураг 21. Future CEO тэтгэлгийн эздэд шагнал гардуулж буй зураг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Volunteer Hub төсөл хөтөлбөр

Үнэт цаас гаргагч нь Лантуун дохио төрийн бус байгууллага (цаашид "ТББ" гэх), Ид шидийн орон төвүүдийн санаачлагч, үүсгэн байгуулагч Ч.Ганжавхлантай хамтран 2023 онд Монгол Улсад анх удаа төвлөрсөн сайн дурын төв болох Volunteer Hub ТББ-ыг байгуулахаар санаачилж, хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Зураг 22. Сайн дурын төв байгуулах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ёслол



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Жил бүр 1000 мод төсөл хөтөлбөр

Нийгмийн хариуцлагын хүрээнд 1000 ширхэг хайлаас модыг 2022 оны 10-р сарын 15-ны өдөр суулгаж нийслэлийн байгаль орчны газар болон хариуцах байгууллагад хүлээлгэж өгсөн. Уг арга хэмжээнд Үнэт цаас гаргагчийн 70 гаруй ажилтан оролцон мод тарих хэмжээг 2024, 2025 онд тогтмол өсгөж ирээдүй хойч үед ногоон ирээдүйг бэлэглэхээр зорилт тавин ажиллаж байна.

Зураг 23. 1000 мод тарих арга хэмжээ



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Ложистикс форум

Монгол Улсын тээвэр ложистик, гадаад худалдааны салбарт тулгамдсан олон сорилт, бэрхшээлийг шийдвэрлэх, гадаад дотоод нөхцөл байдал, суурь шалтгааны талаарх үнэн бодит мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд өгөх, тээвэр ложистикийн нөхцөл байдлын талаарх зөв хүлээлт бий болгох, цаашдын гарц шийдэл гарган салбарын боловсрол олгох зорилгоор Үнэт цаас гаргагч нь Ложистикс форум арга хэмжээг 2022 оноос эхлэн жил бүр зохион байгуулж байна.

2022 онд зохион байгуулагдсан Ложистикс Форумд 200 гаруй зочид оролцож, тээвэр ложистикийн салбарын нөхцөл байдлыг ярилцан, сайжруулах гарц шийдлийг боловсруулсан.



2023-06-14

Зураг 24. "Ложистикс Форум 2022"-ын зураг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Ложистикийн боловсрол олгох хөтөлбөр

2022 оноос эхлэн Үнэт цаас гаргагч нь гадаад худалдаа, ханган нийлүүлэгч нарын тээвэр ложистикийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор боловсролын цуврал контентыг боловсруулан Bloomberg телевиз болон Монложистикс Группийн цахим хуудсаар дамжуулан долоо хоног тутам олон нийтэд танилцуулж байна. Мөн өөрсдийн байнгын харилцагч түншүүд рүү долоо хоног тутам мэдээлэл хүргэдэг бөгөөд Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 74400 хүн/нэгжид тус мэдээллийг хүргэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь 2022 онд ханган нийлүүлэгчдийг чадавхжуулах, харилцагч түнш, тээврийн мэргэжлийн оюутан залууст зориулж олон улсын тээвэр ложистик, гаалийн бүрдүүлэлт, гадаад худалдааны чиглэлээр нийт 3,600 цагийн сургалтыг орсон.

Зураг 25. Ложистикийн боловсрол олгох цахим контент



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.5 Эрсдэлийн удирдлагын бодлого

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Үнэт цаас гаргагч нь тулгарч болох эрсдэлүүд, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бодлого чиглэлийг боловсруулан хэрэгжүүлж, охин компаниудын үйл ажиллагааг эрсдэлийн бодлоготой уялдуулан ажилладаг.

Монложистикс Холдинг ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого болон хэрэгжилтэд хяналт



тавьж ажилладаг. Гүйцэтгэх удирдлагын баг нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог компанийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг.

Эрсдэл, түүнийг бууруулах арга зам

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, дэд бүтэц доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, ханшийн хэлбэлзэл үүсэх, үнэнч харилцагчийг алдах, хөдлөх бүрэлдэхүүн, ажиллах хүчин хомстох, хууль эрх зүйн орчинд өөрчлөлт гарах зэрэг эрсдэлүүд учирч болзошгүй.

Үнэт цаас гаргагчид учирч болзошгүй эрсдлүүдийг тохиолдох магадлал болон үзүүлэх нөлөөгөөр доорх эрсдэлийн матрицад харуулсан болно.

Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн матриц

		Магадлал		
		Бага	Дунд	Их
Нөлөө	Их	Мэдээллийн аюулгүй байдал алдагдах	Ханшийн хэлбэлзэл үүсэх	Үнийн өрсөлдөөн бий болж үнэнч харилцагчийг алдах
	Дунд	Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах	Хөрвөх чадвар алдагдах	Хөдлөх бүрэлдэхүүн хомстох
	Бага	Хууль эрх зүйн орчинд өөрчлөлт гарах	Ажиллах хүчин хомстох	Дэд бүтэц доголдох

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, дайн, улс төр эдийн засгийн хямрал, геополитикийн таарамжгүй нөхцөл байдал зэрэг нь хил гаалийн хориг саадыг бий болгож, боомтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Тус эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн тээврийн эргэлтийг удаашруулах, өртгийг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн хугацааг уртасгах, улмаар ашигт ажиллагааг бууруулах сөрөг үр дагаврыг бий болгох боломжтой.

Тус эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь хамтран ажиллагч түншүүдийн холбоог өргөжүүлэн, нэг боомт, нэг улсаас хамаарах хамаарлыг бууруулах замаар удирддаг.

Үнэт цаас гаргагч нь 2020-2022 онд ОХУ болон БНХАУ-ын хамтран ажиллагч түнш байгууллагыг 2 дахин нэмэгдүүлэн, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 160 орны 800 түнш байгууллагатай хамтран ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улсад нийт 39 боомт үйл ажиллагаа явуулдагас 2020 оноос хойш Үнэт цаас гаргагч нь боомтын сувгийг 3 дахин нэмэгдүүлэн, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 9 боомтоор дамжуулан тээврийн үйл ажиллагаа явуулж, нэг боомтоос хараат байдлыг бууруулж байна.

Дэд бүтэц доголдох

Үнэт цаас гаргагч нь агаарын, далайн, авто, төмөр замын тээврийн үйлчилгээг үзүүлдэг. Тус үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай дэд бүтэц доголдох буюу дэд



бүтцэд техникийн эвдрэл гэмтэл гарах, терминалын хүчин чадлын ашиглалт дүүрэх, хэвийн үйл ажиллагаа алдагдсаны улмаас тээвэрлэлт удаашрах, бизнесийн тасралтгүй хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй.

Тус эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь хамтран ажиллаж буй терминалын тоог нэмэгдүүлж, нэг терминалаас хамаарах хамаарлыг бууруулах замаар удирддаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 14 гаалийн терминал үйл ажиллагаа явуулж байгаагаас Үнэт цаас гаргагч нь бүх терминалтай хамтран ажиллаж, терминалын сувгийг өргөжүүлэн ажиллаж байна.

Терминал болон дэд бүтэц нь гуравдагч байгууллагын эзэмшилд байдаг тул хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдах боломж хомс байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийн, өөрийн эзэмшлийн терминалыг байгуулж, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангахаар төлөвлөсөн.

Хүний нөөц хомстох

2022 оны байдлаар олон улсын тээвэр ложистикийн салбарт тулгарч буй хамгийн том эрсдэл нь хүний нөөцийн хомстол байна.

Тээвэр ложистикийн салбарт мэргэшсэн чадварлаг ажилтнуудын хомстолд орох, туршлагатай, мэргэшсэн ажилтнууд ажлаас гарах, хүний нөөцийн тогтворгүй байдал үүсэх зэрэг нь бизнесийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй.

Тус эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгын 2.3 дахь хэсэгт тусгагдсан хүний нөөцийн 4 бодлого, стратегийг хэрэгжүүлэх замаар бууруулан ажилладаг. Тодруулбал, Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, түлхүүр ажилтнуудыг хадгалах хүрээнд ажлын 2 цагийн уян систем нэвтрүүлэн, мэргэжлийн сэтгэл зүйчийг ажиллуулж, ажилтнуудын хүүгүй зээлийг олгон ажилтнуудын хэрэгцээ шаардлагыг хангахын төлөө зорин ажиллаж байна.

Ханшийн хэлбэлзэл үүсэх

Макро эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдал нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Үүнд валютын ханшийн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн нөхцөл байдалд чухал нөлөөтэй.



Үнэт цаас гаргагчийн төлбөр тооцоо гадаад валютаар хийгддэг тул валютын ханшийн огцом савалгаанд алдагдал хүлээх эрсдэлтэй. Тодруулбал, Үнэт цаас гаргагч нь олон улсын агентуудад төлөх төлбөрийг дараа төлбөрт нөхцөлөөр, гадаад валютаар хийдэг бөгөөд тус хугацаанд валютын ханш чангарвал Үнэт цаас гаргагчид ханшийн эрсдэл үүсч, ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй.

Үнэт цаас гаргагч нь ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор авлага, өглөгийн эргэцийг тогтмол удирдан, гадаад валютаарх авлагыг өглөгөөс өндөр түвшинд хадгалан ажилладаг.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 82 хувь нь гадаад валютаар орж ирдэг нь ханшийн эрсдэлийг бууруулж байна.

Үнийн өрсөлдөөн бий болж үнэнч харилцагчийг алдах

2022 оны байдлаар Монгол Улсын тээврийн салбарт 2,500 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй импорт, экспорт, транзит тээвэр ложистикийн зах зээлд 223 байгууллага Сам, тээврийн хөгжлийн яамнаас олгогдсон гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.



СЭХ
ОН 2021 СЭР
БҮРГЭ
№ 31

Монгол Улсын тээвэр ложистикийн салбар нь өрсөлдөөн их, олон тоглогчдоос бүрддэг тул харилцагчийн шилжих зардал бага, үнийн өрсөлдөөн өндөр хэмжээнд явагддаг. Иймд тус өрсөлдөөнт зах зээлд Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, брэндинг буурах, харилцагчийн үйлчилгээний стандарт алдагдахад үнэнч харилцагчийг алдах, нөгөө талаас өрсөлдөгч байгууллагууд зах зээлийн үнийг бууруулснаар тээврийн дундаж үнэ буурч, борлуулалтын орлого буурах эрсдэлтэй.

Харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулах хүрээнд Үнэт цаас гаргагч нь харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээг ажилтнуудын KPI гүйцэтгэлийн системтэй уялдуулж, хянан ажилладаг.

Тээвэр ложистикийн өрсөлдөөнт зах зээлд Үнэт цаас гаргагч нь үнээр бус үйлчилгээгээр ялгарах стратегийг барин ажилладаг. Тодруулбал, Үнэт цаас гаргагч нь тээвэр ложистикийн бусад компаниудтай харьцуулахад бүх ачааг ачаа, тээврийн даатгалд хамруулж, дараа төлбөрт, уян хатан төлбөрийн нөхцөлийг олгон, харилцагчид тээврийн явцын мэдээллийг технологийн шийдлээр дамжуулан тогтмол хүргүүлж, шаардлагатай нөхцөлд захиалгат нислэг, хүргэлтийн үйлчилгээг санал болгодогдоороо онцлогтой.

Хууль эрх зүйн орчинд өөрчлөлт гарах

Үнэт цаас гаргагч нь тээвэр ложистикийн салбарын хууль эрх зүйн хүрээнд холбогдох олон улсын дүрэм журам, дотоодын хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох эрсдэлтэй.

Монгол Улсын тээвэр ложистикийн салбар нь Иргэний хууль болон тээврийн төрөл бүрт хамаарах хууль, дүрэм журмаар зохицуулагддаг. Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаанд Зам, тээврийн хөгжлийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газраас тусгай зөвшөөрлүүдийг авч, дүрэм журмыг мөрдөн ажиллаж тус эрсдэлийг бууруулдаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаанд холбогдох бүх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, аливаа нэг хууль, эрх зүйн зөрчил үүсгээгүй байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй уул, уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн зохицуулалт болон улс төрийн эрсдэл өндөртэй салбар юм. Тодруулбал, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрэн тодорхойлогдоогүй, шинэчилсэн зохицуулалтууд тухай бүр бий болж буй нь Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, ашигт ажиллагааг бууруулах эрсдэлтэй байна.

Үнэт цаас гаргагч нь Энержи Ресурс ХК, Эрдэнэс Тавантолгой ТӨХК-тай нүүрс худалдан авах гэрээтэй БНХАУ-ын компаниудад тээврийн үйлчилгээ үзүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар тус эрсдэлийг бууруулахаар төлөвлөж байна.

Мэдээллийн аюулгүй байдал алдагдах

Үнэт цаас гаргагч нь бизнесийн дотоод үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс TMS тээврийн менежментийн систем (Transport Management System), Veritex (Veritech) компанийн ERP (Enterprise Resource Planning), Google компанийн G-suite зэрэг програм хангамжийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг. Тус програм хангамжийн хэвийн үйл ажиллагаа доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах нөхцөлд бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Тус эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь үндсэн 2 ажлыг дотоод бүтэц зохион байгуулалтаар дамжуулан гүйцэтгэж бууруулдаг. Системийн хэвийн үйл

MANDAL CAPITAL
MARKETS LLC
117014 902107014 5213421

monlogistics
ATA5299 6303251
9021071059

СЭХ
2023.06.23 өдөр
БҮРТГЭВ
№ 17

БҮРТГЭВ-03

ажиллагааг хангах үүднээс серверийг олон улсын AWS (Amazon Web Services), GCP (Google Cloud Platform) болон дотоодын Мобиком серверт тус тус тархаан байршуулдаг.

Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах ажлын хүрээнд системийн хандах эрхийн тохиргоо, firewall, backup, recovery plan зэргийг хэрэгжүүлж, Үнэт цаас гаргагчийн Мэдээлэл технологийн хэлтсийн баг хамт олон хяналт тавьдаг. Түүнчлэн ажилтнуудад мэдээллийн аюулгүй байдлын талаарх сургалт тогтмол зохион байгуулан эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

Хөрвөх чадвар алдагдах

Бизнесийн тогтвортой өсөлт, ашигт байдлыг нэмэгдүүлэх явцад төлбөр түргэн гүйцэтгэх зохистой түвшин алдагдах, хөрвөх чадвар алдагдах, улмаар бизнесийн үйл ажиллагаанд саатал үүсэж, ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй.

Төлбөр түргэн гүйцэтгэх зохистой түвшинг хадгалах хүрээнд Үнэт цаас гаргагч нь компанийн богино хугацаат авлага, өглөгийг зорилтот түвшинд төлөвлөдөг. Түүнчлэн харилцагчдад дараа төлбөр нөхцөлийг санал болгох болон өөрчлөлт оруулахад компанийн санхүүгийн нэгжээс ирүүлсэн дотоод үнэлгээг үндэслэн тухай бүр хариу арга хэмжээг авч ажилладаг.

Хөрвөх чадварыг хадгалах хүрээнд Үнэт цаас гаргагч нь шаардлагатай нөхцөлд дотоодын банк санхүүгийн байгууллагаас зээлийн санхүүжилт авах, биржийн бус зах зээлд бондын санхүүжилт татах замаар эрсдэлийг бууруулдаг.

2020-2022 онд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа 2.0-3.1 түвшинд байсан нь Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар өндөр болохыг илтгэж байна.

Хөдлөх бүрэлдэхүүн хомстох

Тээвэр ложистикийн үйл ажиллагааг үзүүлэхэд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүн буюу вагон, автомашин болон нисэх онгоцны хүрэлцээ дутмаг байдлаас үүдэн хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн өртөг нэмэгдэх, тээврийн эргэлт удаашрах, бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.

Үнэт цаас гаргагчийн охин компаниуд нь тээвэр ложистикийн үйлчилгээг үзүүлэхэд авто машин, төмөр замын вагон, чингэлэгийг БНХАУ, ОХУ болон дотоодоос түрээслэдэг тул зах зээл дэх хөдлөх бүрэлдэхүүний хүрэлцээ нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлдэг.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь ОХУ-аас 50 ширхэг вагоныг экспортын тээврийн үйл ажиллагаанд түрээслэн ашиглаж байна. Цаашид экспортын тээвэр ложистикийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд Үнэт цаас гаргагчид вагоны хэрэгцээ шаардлага өндөр байгаа бөгөөд тус вагоны олдоц буурах, түрээсийн үнэ өсөх нөхцөлд Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй.



Тус эрсдэлийг бууруулах зорилгоор Үнэт цаас гаргагч нь 2023 онд 2 цуваа буюу 100 вагоныг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Мөн авто тээврийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс Монложистикс Тракинг ХХК-ийг үүсгэн байгуулж хөдлөх бүрэлдэхүүн түрээслэгч гуравдагч байгууллагаас хамаарсан авто тээврийн хэрэгслийн хангамжийн эрсдэлийг бууруулан ажиллаж байна.

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS BC
LLC
ШТК0162 9021070414 521348

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК
monlogistics
HOLDING
АТАС228 611251
9021070103

2.6 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



Хуулийн этгээдийн хувьд Монложистикс Холдинг ХХК буюу Монложистикс Группийн толгой компани нь Үнэт цаас гаргагч боловч санхүүгийн тайлагналын хувьд Монложистикс Группийн толгой болон 9 охин компаниудыг нэгтгэсэн байдлаар Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд тодорхойлогдоно.

Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 2020 онд Бэйкер Тилли Далайван Аудит ХХК, 2021 болон 2022 онд Грант Торнтон Аудит ХХК хараат бус аудит хийж гүйцэтгэн дүгнэлт гаргасан.

Тус дүгнэлтэд "Бидний дүгнэлтээр Монложистикс Холдинг ХХК-ийн 2022 оны 12-р сарын 31-рх нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна." гэж тусгагдсан байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахад жил бүрийн 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон охин компаниудын санхүүгийн тайланг нэгтгэсэн. Нэгтгэлийг хийхэд охин компани хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, дотоодын ажил гүйлгээнээс гарсан аливаа хэрэгжээгүй олзыг хасаж цэвэр дүнгээр тайлагнасан. Охин компаниудын ашиг, алдагдлыг нэгтгэсэн тайлан руу бүртгэхэд эзэмшлийн хувьд уялдуулан эзэмшигчид болон хяналтын оролцоогүй хувьд хуваарилсан болно.



Орлогын тайлангийн шинжилгээ (нэгтгэсэн байдлаар)

2023-06-14

БҮРТГЭВ-03

Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн орлогын нэгтгэсэн тайлан, сая төгрөгөөр

	2020	2021	2022
Борлуулалтын орлого	61,394	82,340	140,122
Борлуулалтын өртөг	(54,712)*	(74,066)	(123,260)
Нийт ашиг	6,682	8,274	16,862
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,254)*	(3,504)	(5,440)
Борлуулалт, маркетингийн зардал	-	(93)	(804)
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	203	(34)	(281)
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)	3,631	4,643	10,337
Ханшийн зөрүүний олз (гарз)	395	(41)	1,401
Үйл ажиллагааны бус бусад орлого (зарлага)	2	(24)	(3)
Хүү, татварын өмнөх ашиг	4,028	4,578	11,735
Хүүгийн зардал	-	-	(385)
Татвар төлөхийн өмнөх ашиг	4,028	4,578	11,350
Орлогын татварын зардал	(430)	(686)	(1,659)
Татварын дараах ашиг	3,598	3,892	9,691
Толгой компанийн хувь эзэмшигчид ногдох	2,995	3,496	8,375
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	603	396	1,316

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитын тайлан

Борлуулалтын орлого

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2022 онд өмнөх онтой харьцуулахад 70.2 хувиар өсөж, 140.1 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь 2020-2022 онд жилийн дундаж нийлмэл өсөлтөөр (цаашид "ЖДНӨ" болон "жилийн дундаж өсөлт" гэх) 31.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь 1) нийт тээврийн тоо ширхэг 2) нэгж тээврийн үнэ 3) валютын ханшаас бүрддэг.

Үүнээс 1 болон 2-р хүчин зүйлсийн үржвэр нь Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогыг ам.доллороор илэрхийлэх бол түүнийг 3-р хүчин зүйл буюу валютын ханшаар үржүүлснээр төгрөгөөр илэрхийлэгдсэн борлуулалтын орлого гарна.

* 2021 оноос эхлэн тээврийн үйл ажиллагаанд шууд оролцдог ажилтнуудын цалинг ерөнхий ба удирдлагын зардалаас борлуулалтын өртөг рүү ангилж бүртгэдэг болсон. 2020 онд тус ангиллын дагуу залруулаагүй болно.




Тээврийн тоо ширхэг

Үнэт цаас гаргагчийн тээврийн тоо ширхэг нь тухайн жилд эцсийн харилцагчдад хүргэгдсэн тээврийн тоо ширхэгийн нийлбэрээр тодорхойлогддог.

График 1. Үнэт цаас гаргагчийн нийт тээврийн тоо ширхэг

ЖДНӨ(2013-2022): 27.8 хувь

ЖДНӨ(2020-2022): 7.0 хувь



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2017 он хүртэл Үнэт цаас гаргагч нь зөвхөн импортын тээврийн үйл ажиллагааг явуулж байсан. 2017 оноос эхлэн Монложистикс групп нь транзит тээврийн үйл ажиллагааг нэвтрүүлснээр тээврийн тоо ширхэг тус хугацаанд өмнөх онтой харьцуулахад 155.4 хувиар өссөн.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр 2021 онд хил гаалийн хориг саадын улмаас тээврийн эргэлт удааширч, чингэлэгийн хомстол үүссэнээр Үнэт цаас гаргагчийн тээврийн тоо ширхэг өмнөх онтой харьцуулахад 6 хувиар буурсан.




2022 онд 1) хил, гааль хэвийн үйл ажиллагаанд шилжсэн 2) БНХАУ-ын CRIMT компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, тус компанийн Монгол Улс дах тээвэрлэлтийг хариуцан ажиллах агентын борлуулалтын орлого нэмэгдсэн 3) экспортын тээвэр ложистикийн үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлснээр Үнэт цаас гаргагчийн тээврийн тоо ширхэг өмнөх онтой харьцуулахад 21.8 хувиар өсөж, 25,707-д хүрсэн. Энэ нь 2020-2022 онд жилд дунджаар 7.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тээврийн үнэ

Тээврийн шинж чанар, чиглэл, тээвэрлэх зай, тээврийн хэрэгслийн нөхцөл зэрэг хүчин зүйлээс хамааран тээврийн үнэ ялгаатай тогтдог. Үнэт цаас гаргагчийн ам.доллаар орх борлуулалтын орлогыг тээврийн тоо ширхэгт хувааснаар нэгж тээврийн дундаж үнийг тооцов.



График 2. Үнэт цаас гаргагчийн нэгж тээврийн дундаж үнэ, ам.доллаароор



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн нэгж тээврийн дундаж үнэ 2013-2016 онд 2,964 ам.доллаароор хэмжигдэж байсан. 2017 оноос эхлэн Үнэт цаас гаргагч нь транзит тээвэр ложистикийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь тээврийн тоо ширхэгийг нэмэгдүүлсэн ч транзит тээвэр нь импортын тээвэртэй харьцуулахад тээврийн зай богино, нэгж тээврийн үнэ бага байдагтай холбогдуулан тайлант хугацаанд тээврийн дундаж үнэ өмнөх онтой харьцуулахад 51 хувиар буурсан.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр үүссэн хил гаалийн хориг саадын улмаас тээврийн эргэлт удааширснаар 2021 онд нэгж тээврийн дундаж үнэ өмнөх онтой харьцуулахад 40.9 хувиар өсөж, 1,369 ам.долларт хүрсэн. Улмаар 2022 онд Үнэт цаас гаргагчийн тээврийн дундаж үнэ 1,736 ам.долларт хүрсэн.

Валютын ханш

Тээвэр ложистикийн үйлчилгээний үнэ гадаад валютаар тогтож, борлуулалтын орлого гадаад валютаар орж ирдэг. 2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 82 хувь нь гадаад валютаар орж ирсэн байна.

Иймд голлох валют болох ам.долларын ханшийн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогод шууд нөлөө үзүүлдэг.



График 3. Монголбанкнаас зарласан ам.долларын жилийн дундаж ханш

ЖДӨ(2013-2022): 7.5 хувь

ЖДӨ(2013-2022): 5.7 хувь



Эх сурвалж: YCX

2022 онд Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш дунджаар 3,145 байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 10.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Монгол Улсын хувьд ам.долларын гарах урсгал орох урсгалаас өндөр байдаг тул 2013 оноос хойш төгрөгийн ам.доллартай харьцах ханш тасралтгүй жилд дунджаар 7.5 хувиар суларсан байна.

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын өсөлтийг дээр дурдсан 3 хүчин зүйлсээр задлан харуулбал дараах байдалтай байна. Тодруулбал 2022 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 70 хувиар өссөний 12 хувийг валютын ханшийн өсөлт, 26 хувийг тээврийн тоо ширхэгийн өсөлт, 32 хувийг тээврийн дундаж үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

График 4. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр

ЖДӨ(2013-2022): 27.2 хувь

ЖДӨ(2020-2022): 51.1 хувь



Эх сурвалж: 2013-2020 оны аудитлагдаагүй тайлан, 2021-2022 оны нэгтгэсэн аудитын тайлан



График 5. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, түүний өсөлтийн хувийн задаргаа



Эх сурвалж: 2013-2020 оны аудитлагдаагүй тайлан, 2021-2022 оны нэгтгэсэн аудитын тайлан, Үндсэн андеррайтерийн тооцоолол

Борлуулалтын өртөг болон үйл ажиллагааны зардал

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөгт вагон болон тээврийн хэрэгслийн түрээсийн зардал, гадаад агентын төлбөр, төмөр замын төлбөр, тээврийн үйл ажиллагаанд шууд оролцож буй ажилчдын цалин хөлс, түүнтэй холбоотой зардлууд багтдаг.

2021 оноос эхлэн тээврийн үйл ажиллагаанд шууд оролцож буй ажилчдын цалин хөлс, түүнтэй холбоотой зардлуудыг ерөнхий ба удирдлагын зардлаас борлуулалтын өртөг рүү шилжүүлэн бүртгэж эхэлсэн. Улмаар тус залруулгатай холбоотойгоор 2021 онд 1.8 тэрбум төгрөг, 2022 онд 2.9 тэрбум төгрөг борлуулалтын өртөгт бүртгэгдсэн байна. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртгийг харуулбал дараах байдалтай байна.

График 6. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөг, борлуулалтад эзлэх хувь, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: 2013-2020 оны аудитлагдаагүй тайлан, 2021-2022 оны нэгтгэсэн аудитын тайлан

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн хэмжээ өмнөх онытой харьцуулахад 103.8 хувиар өсөж, 16.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ үйл ажиллагааны хувийн нийт ашгийн маржинтай тэнцэж байна.

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ATA5299 / 6381231
9021031093

График 7. Ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалтад эзлэх хувь, сая төгрөгөөр



Эх сурвалж: 2013-2020 оны аудитлагдаагүй тайлан, 2021-2022 оны нэгтгэсэн аудитын тайлан

2022 оны байдлаар ерөнхий ба удирдлагын зардлын 64.7 хувийг ажилтнуудын цалин, НДШ-ийн зардал, 7.3 хувийг элэгдэл, хорогдлын зардал, 28.0 хувийг бусад зардал эзэлж байна. Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардал борлуулалтын орлогын 3.9 хувийг бүрдүүлж байна.

Үйл ажиллагааны бусад зардал


2022 онд Үнэт цаас гаргагч нь компанийн брэндиг маркетингийг сайжруулах хүрээнд анхаарч ажилласнаар Үнэт цаас гаргагчийн борлуулалт маркетингийн зардал 804 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь борлуулалтын орлогын 0.6 хувьтай тэнцэж байна. Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь 281 сая төгрөгийн үйл ажиллагааны бусад зардалтай ажилласан байна.

Үйл ажиллагааны ашиг

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ашиг 2022 онд өмнөх онтой харьцуулахад 122.6 хувиар өсөж, 10.3 тэрбум төгрөгт хүрсэн. Харин үйл ажиллагааны ашгийн маржин 2022 онд 7.4 хувьд хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 1.8 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант хугацаанд борлуулалтын өртгийн бууралт нь үйл ажиллагааны ашгийн маржин нэмэгдүүлэхэд голлон нөлөөлсөн байна.



График 8. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ашиг, борлуулалтад эзлэх хувь, сая төгрөгөөр



Эх сурвалж: 2013-2020 оны аудитлагдаагүй тайлан, 2021-2022 оны нэгтгэсэн аудитын тайлан

Ханшийн зөрүүний олз/гарз

Үнэт цаас гаргагч нь харилцагчдад дараа төлбөрт нөхцөлөөр гадаад валютаар үйлчилгээ үзүүлж, авлага үүсгэдэг. Тус хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшид өөрчлөлт орсноор Үнэт цаас гаргагчид ханшийн зөрүүний олз гарз бүртгэгддэг. Үүнтэй холбоотойгоор 2022 онд Үнэт цаас гаргагчид 6.2 тэрбум төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний олз бүртгэгдсэн.

Үнэт цаас гаргагчийн үндсэн өртөг болох агентийн төлбөр нь дараа төлбөрт нөхцөлөөр гадаад валютаар хийгдэж, өглөг үүсдэг. Үүнтэй холбоотойгоор 2022 онд 4.8 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүний гарз бүртгэгдсэн.

Ийнхүү тайлант хугацаанд цэвэр дүнгээр 1.4 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүний олз орлогын тайланд бүртгэгдсэн байна.

Хүүгийн зардал

Үнэт цаас гаргагч нь 2022 оноос өмнө өрийн санхүүжилтын эх үүсвэр ашигладаггүй байсан тул хүүгийн зардал үүсээгүй болно. 2022 онд Үнэт цаас гаргагчийн охин компани 1) 2.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийг биржийн бус зах зээлд гаргасан 2) Арилжааны банкнаас зээлийн эх үүсвэр авсантай холбогдуулан 325 сая төгрөгийн хүүгийн зардал гарсан байна.

Татварын дараах цэвэр ашиг

Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг охин компани тус бүрийн эзэмшлийн хувьд үндэслэгдэн толгой компанийн хувьцаа эзэмшил болон хяналтын эрхгүй хувь оролцоонд хуваарилагддаг.



График 9. Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашиг, түүний бүтэц, сая төгрөгөөр

ЖДНӨ(2013-2022): 23.6 хувь

ЖДНӨ(2020-2022): 65.8 хувь



Эх сурвалж: 2013-2020 оны аудитлагдаагүй тайлан, 2021-2022 оны нэгтгэсэн аудитын тайлан

2022 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 148.9 хувиар өсөж, 9.7 тэрбум төгрөгт хүрсэн. Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн 86 хувь нь толгой компани буюу Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд, 14 хувь нь хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдож байна.

Үнэт цаас гаргагч нь 2020 оноос эхлэн охин компаниудтай болсноор хяналтын эрхгүй хувь оролцоонд цэвэр ашиг хуваарилагдаж эхэлсэн. Тэдгээр охин компаниудын цэвэр ашиг нэмэгдсэнтэй холбоотой 2021-2022 онд хяналтын эрхгүй хувь оролцооны эзлэх хувь өссөн.



СЗХ
он сар
БҮРГЭЭ
№ 1

2023-06-14
03

Орлогын тайлангийн шинжилгээ (бизнесийн чиглэл бүрээр)

Үнэт цаас гаргагчийн бизнесийн чиглэл тус бүрээр дэлгэрүүлсэн орлогын тайлангийн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитлагдсан тайлан болон охин компани тус бүрийн аудитлагдсан тайланд үндэслэн хийж гүйцэтгэв.

Хүснэгт 16. Монложистикс Группийн нэгтгэсэн орлогын тайлангийн задаргаа, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Импорт	Экспорт	Транзит	Бусад	Тохируулга	Нийт дүн
Борлуулалтын орлого	106,515	7,122	21,612	10,233	(5,359)	140,123
Борлуулалтын өртөг	(94,640)	(5,738)	(18,967)	(7,408)	3,492	(123,260)
Нийт ашиг	11,875	1,384	2,645	2,825	(1,868)	16,862
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,600)	(151)	(1,166)	(2,377)	1,854	(5,440)
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	(336)	(2)	(5)	(661)	(81)	(1,085)
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)	7,939	1,231	1,475	(212)	(95)	10,337
Үйл ажиллагааны бус бусад орлого (зардал)	591	69	494	1,581	(1,317)	1,398
Хүү, татварын өмнөх ашиг	8,530	1,299	1,949	1,369	(1,412)	11,735
Хүүгийн зардал	(487)	-	(4)	(46)	152	(385)
Татвар төлөхийн өмнөх ашиг	8,040	1,299	1,945	1,323	(2,215)	11,350
Орлогын татварын зардал	(1,110)	(130)	(190)	(217)	(12)	(1,659)
Татварын дараах ашиг	6,933	1,169	1,755	1,106	(2,227)	9,691
Толгой компанийн хувь эзэмшигчид ногдох	7,888	596	1,053	1,056	(2,219)	8,375
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	-	573	702	49	(8)	1,317

Эх сурвалж: Толгой болон охин компани тус бүрийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2022 оны нэгтгэсэн аудитын тайлан, Үндсэн андеррайтерийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлийг Үнэт цаасны танилцуулгын 2.2 дахь хэсэгт тусгасны дагуу импорт, экспорт, транзит болон бусад хэлбэрээр ангилан тодорхойлсон. Тус бизнесийн чиглэл бүрээр Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогыг задлан харуулбал дараах байдалтай байна.

MANDAL CAPITAL
MARKETS LLC
ШТНД1102 9021070414 521342

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
XX
monlogistics
HOLDING
ATA5290 6381251
9021031093





График 10. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого ба цэвэр ашгийн задаргаа, сая төгрөгөөр



Эх сурвалж: Толгой болон охин компани тус бүрийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2022 оны нэгтгэсэн аудитын тайлан, Үндсэн андеррайтерийн тооцоолол

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын орлогын 75.1 хувийг импортын тээвэр, 15.2 хувийг транзит тээвэр, 5.0 хувийг экспортын тээвэр, 4.6 хувийг бусад тээврийн орлого бүрдүүлж байна. Үүнд толгой компани Монложистикс Холдинг ХХК-ийн борлуулалтын орлого нь охин компаниудаас авдаг менежментийн төлбөр тул хасч тооцсон болно.

Импортын тээвэр

Түүхэн хугацаанд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын дийлэнх хувийг импортын тээврийн охин компани болох Монложистикс Ворлдвайд ХХК бүрдүүлж ирсэн.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 94.3 хувиар өсөж, 106.5 тэрбум төгрөгт хүрсэн.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн нийт ашиг өмнөх онтой харьцуулахад 66.2 хувиар өсөж, 11.9 тэрбум төгрөгт, цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 2.0 дахин өсөж 7.0 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашгийн 63.2 хувийг бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн нийт ашгийн маржин 11.1 хувь, цэвэр ашгийн маржин 6.5 хувь байна.


Транзит тээвэр

Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн борлуулалтын орлого 2021 онд өмнөх онтой харьцуулахад 23.7 хувиар өсөж 27.4 тэрбум төгрөгт хүрсэн бол 2022 онд 21.1 хувиар буурч, 21.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Энэ нь 2022 оны эхний улиралд БНХАУ-ын Тяньжинь боомтод ачаалал үүссэнээс Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит ачаанд ногдох вагоны тоог буурч, Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн орлого буурсантай холбоотой.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн нийт ашиг өмнөх онтой харьцуулахад 7.1 хувиар өсөж 2.6 тэрбум төгрөгт, цэвэр ашиг өмнөх онтой харьцуулахад 55.2 хувиар өсөж 1.7 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашгийн 16.4 хувийг бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн нийт ашгийн маржин 12.2 хувь, цэвэр ашгийн маржин 8.1 хувь байна.



Экспортын тээвэр



Үнэт цаас гаргагч нь 2022 оноос эхлэн экспортын тээврийн үйлчилгээг нэвтрүүлж, 2022 оны байдлаар 7.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь 67.0 мянган тонн нүүрс тээврийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

2022 онд Үнэт цаас гаргагч нь экспортын тээврийн үйл ажиллагаанаас 1.4 тэрбум төгрөгийн нийт ашиг, 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашгийн 10.9 хувийг бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн нийт ашгийн маржин 19.4 хувь, цэвэр ашгийн маржин 16.4 хувь байна.

Бусад тээвэр

Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн орлогыг авто тээврийн үйл ажиллагаа болон ОХУ дахь тээврийн үйл ажиллагаа явуулдаг охин компаниуд бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд ОХУ-Монгол Улс хоорондын тээврийн үйл ажиллагааг зохион байгуулдаг байсан бол 2022 онд ОХУ дотор болон ОХУ-с бусад улс орон руу тээврийн үйл ажиллагааг зохион байгуулдаг болсноор бусад тээврийн борлуулалтын орлого өсөж, 2022 оны байдлаар 10.2 тэрбум төгрөгт хүрсэн.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь бусад тээврийн үйл ажиллагаанаас 2.8 тэрбум төгрөгийн нийт ашиг, 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашгийн 10.3 хувийг бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн нийт ашгийн маржин 27.6 хувь, цэвэр ашгийн маржин 10.8 хувь байна.

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн үзүүлэлтийг дүгнэн үзэхэд 1) импортын тээвэр нь нийт борлуулалтын орлогын 75.1 хувь, цэвэр ашгийн 63.2 хувийг бүрдүүлж Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаанд голлох байр суурь эзэлдэг 2) транзит тээвэр нь импортын тээврийн дараа орохуйц томоохон тээвэр боловч УБТЗ-ийн хүчин чадал, дэд бүтцээс шалтгаалан өсөлт нь удааширсан 3) экспортын тээвэр нь үйл ажиллагаа эхлүүлээд удаагүй боловч Үнэт цаас гаргагчийн бизнесийн чиглэлүүдээс хамгийн өндөр ашгийн маржинтай байна.





Санхүү байдлын тайлангийн шинжилгээ (нэгтгэсэн байдлаар)

Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүү байдлын тайлан, сая төгрөгөөр

	2020	2021	2022
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,277	5,816	14,198
Дансны ба бусад авлага	13,689	13,630	19,504
Бараа материал	-	18	103
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,103	4,471	5,662
Эргэлтийн хөрөнгийн дүн	25,070	23,934	39,467
Үндсэн хөрөнгө	330	1,153	1,286
Биет бус хөрөнгө	46	63	163
Урт хугацаат хөрөнгө оруулалт	14	14	14
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	296	909
Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн	390	1,527	2,372
Нийт хөрөнгийн дүн	25,460	25,461	41,839
Дансны болон бусад өглөг	12,367	6,038	11,399
Урьдчилж орсон орлого	-	337	1,558
Богино хугацаат зээл	-	750	2,800
Санхүүгийн түрээсийн богино хугацаат өр төлбөр	-	216	83
Бусад богино хугацаат өр төлбөр	50	334	922
Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,417	7,676	16,762
Урт хугацаат зээл	-	750	17
Хойшлогдсон татварын өр	-	1	88
Санхүүгийн түрээсийн урт хугацаат өр төлбөр	-	98	105
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	849	210
Хувьцаат капитал	100	100	106
Халаасны хувьцаа	-60	-60	(3,001)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	2,234
Гадаад валютийн хөрвүүлэлтийн нөөц	-	-	(139)
Хуримтлагдсан ашиг	11,852	15,348	23,723
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох өмч	11,892	15,388	22,993
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох өмч	1,151	1,548	1,944
Эздийн өмчийн дүн	13,043	16,936	24,867
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	25,460	25,461	41,839

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитын тайлан

Хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2022 онд өмнөх онтой харьцуулахад 64.3 хувиар өсөж 41.8 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт хөрөнгийн 94.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 5.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй тээвэр ложистикийн салбар нь авлага, өглөгийн эргэц буюу эргэлтийн хөрөнгө өндөр байдгаараа онцлогтой.



График 11. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, сая төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитын тайлан


2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн 49.4 хувийг дансны авлага болон бусад авлага, 36.0 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 14.3 хувийг урьдчилж төлсөн зардал, 0.3 хувийг бараа материал бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө 2.4 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Үүнд 908 сая төгрөгийн ашиглах эрхтэй (түрээсийн) хөрөнгө, 822 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 248 сая төгрөгийн тавилга эд хогшил, 199 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, 163 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 31 сая төгрөгийн бусад эргэлтийн бус хөрөнгө багтаж байна.

Эх үүсвэр

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт хөрөнгийн 40.6 хувийг нь өр төлбөр, 59.4 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

График 12. Өр төлбөр ба эзний өмчийн дүн, сая төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр 17.0 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Үүнд 11.4 тэрбум төгрөгийг гадаадын агентуудад өгөх дансны



өглөг, 2.0 тэрбум төгрөгийг биржийн бус зах зээлд гаргасан өрийн бичиг, 0.8 тэрбум төгрөгийг Худалдаа хөгжлийн банкаас авсан эргэлтийн хөрөнгийн зээл, 1.6 тэрбум төгрөгийг урьдчилж орсон орлого, 1.2 тэрбум төгрөгийг бусад богино болон урт хугацаат өр төлбөр бүрдүүлж байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн дүн 24.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Үүнд 95.4 хувь буюу 23.7 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг, үлдсэн 4.6 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг эздийн өмчийн бусад хэсэг бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь 2022 онд Мандал Прайвят Экүйти хувийн ХОС ХХК-тай Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулж, Мандал Прайвят Экүйти хувийн ХОС ХХК нь Үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотойгоор тайлант хугацаанд 2.2 тэрбум төгрөгийн нэмж төлөгдсөн капитал үүссэн.

2022 оны 11-р сард Үнэт цаас гаргагч нь Мандал Праявит Экүйти Хувийн ХОС ХХК-тай байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах болон эрх шилжүүлэх гэрээний дагуу 3.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хувьцааг буцаан худалдан авч, халаасалсан.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу 50-иас дээш хувийг эзэмшдэг охин компаниудыг бүрэн нэгтгэх (full consolidation) аргыг ашиглан нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг.

Тус аргын хүрээнд Монложистикс Холдинг ХХК-иас бусад хувьцаа эзэмшигчдэд хамаарах эздийн өмчийн дүнг хяналтын эрхгүй өмчийн дүнгээр бүртгэдэг. Энэ нь Монложистикс Холдинг ХХК-д хамааралгүй буюу бусад хувьцаа эзэмшигчдэд хамааралтай дүн болно.

Хүснэгт 18. Хувь эрхгүй оролцоонд ногдох эздийн өмч, цэвэр ашиг, сая төгрөгөөр

Хугацаа	Эздийн өмч		Цэвэр ашиг	
	Толгой компанид ногдох	Хувь эрхгүй оролцоонд ногдох	Толгой компанид ногдох	Хувь эрхгүй оролцоонд ногдох
2020	11,892	1,151	2,995	603
2021	15,387	1,548	3,496	396
2022	22,922	1,944	8,374	1,316

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитын тайлан

Тодруулбал, 2022 оны байдлаар хяналтын эрхгүй эздийн өмч 1.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Энэ нь Каус Аустралис ХХК-ийн 24.5 хувийн хувьцаа эзэмшигч иргэн Ё.Болортуяа, 24.5 хувийн эзэмшигч Б.Тэлэнгэд, Монложистикс Транзит ХХК-ийн 40 хувийн эзэмшигч Тянь Жин Хай Тие Лянь Жие Олон Улсын Тээвэр Ложистикс ХХК, Монложистикс Транс Сервис ХХК-ийн 10 хувийн эзэмшигч Тугаринов Василий Андреевич нарт хамаарах эздийн өмч болно.



Санхүү байдлын тайлангийн шинжилгээ (бизнесийн чиглэл бүрээр)

Үнэт цаас гаргагчийн бизнесийн чиглэл тус бүрээр дэлгэрүүлсэн санхүү байдлын тайлангийн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитлагдсан тайлан болон охин компани тус бүрийн аудитлагдсан тайланд үндэслэн хийж гүйцэтгэв.

Хүснэгт 19. Монложистикс Группийн санхүү байдлын тайлангийн задаргаа, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Импорт	Экспорт	Транзит	Бусад	Тохируулга	Нийт дүн
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,724	1,909	2,088	1,476	1	14,198
Дансны авлага болон бусад	17,133	802	1,497	5,042	(4,971)	19,504
Бусад	1,235	3,254	1,053	535	(313)	5,765
Эргэлтийн хөрөнгийн дүн	27,092	5,965	4,639	7,054	(5,283)	39,467
Урт хугацаат хөрөнгө оруулалт	14	-	-	5,054	(5,054)	14
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,251	28	49	1,334	(304)	2,358
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,265	28	49	6,388	(5,358)	2,372
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	28,358	5,993	4,688	13,442	(10,641)	41,839
Дансны өглөг	8,273	4,272	296	4,288	(5,730)	11,399
Бусад богино хугацаат өр төлбөр	2,650	1,458	-	824	(430)	5,363
Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,923	5,730	296	5,113	(5,300)	16,762
Урт хугацаат зээл	250	-	-	17	(250)	17
Бусад өр төлбөр	190	-	31	22	(49)	193
Урт хугацаат өр төлбөрийн дүн	440	-	31	38	(299)	210
Хуримтлагдсан ашиг, алдагдал	13,561	262	2,990	8,293	560	25,667
Бусад	3,434	0.2	1,371	(3)	(5,602)	(799)
Эздийн өмчийн дүн	16,995	263	4,361	8,290	(5,043)	24,867
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	28,358	5,993	4,688	13,442	(10,641)	41,839

Эх сурвалж: Толгой болон охин компани тус бүрийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2022 оны нэгтгэсэн аудитын тайлан, Үндсэн андеррайтерийн тооцоолол


2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 67.8 хувийг импортын тээвэр, 14.3 хувийг экспортын тээвэр, 11.2 хувийг транзит тээвэр, 6.7 хувийг бусад тээврийн хөрөнгө бүрдүүлж байна.



Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн нийт хөрөнгө 28.3 тэрбум төгрөг, транзит тээврийн нийт хөрөнгө 4.7 тэрбум төгрөг, экспортын тээврийн нийт хөрөнгө 6.0 тэрбум төгрөг, бусад тээврийн нийт хөрөнгө 13.4 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

Тайлант хугацаанд компани хооронд 10.6 тэрбум төгрөгийн санхүүгийн гүйлгээ хийгдсэнийг хасч үзвэл Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 41.8 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Үнэт цаас гаргагчийн биржийн бус зах зээлд гаргасан өрийн бичиг Монложистикс Ворлдвайд ХХК, Худалдаа хөгжлийн банкнаас авсан эргэлтийн хөрөнгийн зээл Монложистикс Ворлдвайд ХХК болон Монложистикс Тракинг ХХК-иудад бүртгэлтэй болно.

График 13. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, бизнесийн чиглэлээр, сая төгрөгөөр



Эх сурвалж: Толгой болон охин компани тус бүрийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2022 оны нэгтгэсэн аудитын тайлан, Үндсэн андеррайтерийн тооцоолол

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эздийн өмч 24.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж буйгаас 56.8 хувийг импортын тээвэр, 0.9 хувийг экспортын тээвэр, 14.6 хувийг транзит тээвэр, 27.7 хувийг бусад тээвэр бүрдүүлж байна.

Санхүүгийн харьцаа үзүүлэлтийн шинжилгээ


Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

	2020	2021	2022
Үйл ажиллагааны эргэц			
Авлага цуглуулах дундаж хоног	81	60	50
Өглөг төлөгдөх дундаж хоног	81	29	33
Хөрвөх чадварын харьцаа			
Эргэлтийн харьцаа	2.0	3.1	2.4
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	1.8	2.5	2.0
Өрийн харьцаа			
Өр төлбөр ба нийт хөрөнгийн харьцаа	0.5	0.3	0.4
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн харьцаа	1.0	0.5	0.7
Ашигт ажиллагааны харьцаа			
Нийт ашгийн маржин	10.9%	10.0%	12.0%
Үйл ажиллагааны ашгийн маржин	5.9%	5.6%	7.4%
Цэвэр ашгийн маржин	5.9%	4.7%	6.9%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	27.6%	23.0%	38.4%
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	15.8%	18.1%	28.4%

Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол

Үйл ажиллагааны харьцаа

График 14. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны харьцаа, үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол


Үнэт цаас гаргагч нь харилцагчдад дараа төлбөрт нөхцөлөөр борлуулалт хийн авлага үүсгэж, нөгөө талаас гадаадын агентуудад дараа төлбөрт нөхцөлөөр төлбөр тооцоо хийн, өглөг үүсгэдэг.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн авлагын эргэц 50 хоног, өглөгийн эргэц 33 хоногоор хэмжигдэж байна. 2020 онд Үнэт цаас гаргагчийн авлага цуглуулах дундаж хугацаа 80 хоног байсан бол 2022 онд 50 хоног болж буурч, авлагын эргэц сайжирсан байна.

Тээврийн гадаад агентын төлбөр, вагон чингэлэг түрээсийн төлбөр төлөхтэй холбоотойгоор өглөг үүсдэг. 2020 онд Үнэт цаас гаргагчийн дундаж өглөг төлөх хугацаа 81 хоног байсан бол 2022 онд 33 болж буурч, өглөгийн эргэц сайжирсан байна.

Хөрвөх чадварын харьцаа



График 15. Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа, үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа 2.4 байна. Энэ нь Үнэт цаас гаргагч эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулах чадвартай буюу хөрвөх чадвар өндөр болохыг илтгэж байна.

2020-2022 онд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа 2.0-3.1 хооронд хэлбэлзэж буй бөгөөд 2022 онд Үнэт цаас гаргагч нь өрийн санхүүжилтын эх






үүсвэрийг ашиглан богино хугацаат өр төлбөрийг нэмэгдүүлснээр эргэлтийн харьцаа буурсан байна.

Өрийн харьцаа

График 16. Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн харьцаа үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол


2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ 40.6 хувь буюу өрийн хөшүүрэг бага байна. Энэ нь Үнэт цаас гаргагчид өрийн дарамт учрах эрсдэл бага болохыг илтгэж байна.

Мөн Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөрийн 1.2 хувийг урт хугацаат өр төлбөр бүрдүүлж буй нь Үнэт цаас гаргагчид урт хугацаанд төлөх өрийн дарамт бага болохыг илтгэж байна.

Ашигт ажиллагааны харьцаа

Үнэт цаас гаргагчийн ашгийн маржинг орлогын тайлангийн шинжилгээнд тайлбарласан тул доорх графикт нийт ашгийн маржин, үйл ажиллагааны ашгийн маржин, цэвэр ашгийн маржинг харьцуулан харуулав.

График 17. Үнэт цаас гаргагчийн ашгийн маржин




Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол

Харин доорх графикт Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн болов нийт хөрөнгийн өгөөжийг харуулав.



График 18. Үнэт цаас гаргагчийн өгөөжийн харьцаа, үзүүлэлт



■ Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) ■ Нийт хөрөнгийн өгөөж (ROA)

Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж 23.2 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 39.0 хувь байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа өндөр болохыг илтгэж байна. 2020-2022 онд Үнэт цаас гаргагч нь ашигт ажиллагааг тогтмол сайжруулсан байна.


Санхүүгийн харьцааны задаргаа

Хүснэгт 21. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд, охин компани тус бүрээр

Харьцаа үзүүлэлтүүд	Импорт	Экспорт	Транзит	Бусад	Нэгтгэсэн
Үйл ажиллагааны эргэц					
Авлага цуглуулах дундаж хоног	58	41	25	177	50
Өглөг төлөгдөх дундаж хоног	31	268	6	208	33
Хөрвөх чадварын харьцаа					
Эргэлтийн харьцаа	2.5	1.0	15.7	1.4	2.4
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	2.4	0.5	12.1	1.3	2.0
Өрийн харьцаа					
Өр төлбөр ба нийт хөрөнгийн харьцаа	0.4	1.0	0.1	0.4	0.4
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн харьцаа	0.7	21.8	0.1	0.6	0.7
Ашигт ажиллагааны харьцаа					
Нийт ашгийн маржин	11%	19%	12%	28%	12%
Үйл ажиллагааны ашгийн маржин	7%	17%	7%	-2%	7%
Цэвэр ашгийн маржин	7%	16%	8%	11%	7%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	41%	445%	40%	13%	38%
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	24%	20%	37%	8%	23%

Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн тооцоолол





Үнэт цаас гаргагчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтийг бизнесийн чиглэл тус бүрээр дэлгэрүүлбэл 1) импортын тээврийн охин компаниудын үйл ажиллагааны эргэц, хөрвөх чадвар сайн, ашигт ажиллагаа бусад бизнесийн чиглэлүүдтэй харьцуулахад бага, өрийн хөшүүрэг бага 2) экспортын тээврийн охин компанийн өрийн хөшүүрэг өндөр, ашигт ажиллагаа өндөр 3) транзит тээврийн охин компанийн хөрвөх чадвар өндөр, өрийн хөшүүрэг бага байна.

Мөнгөн урсгалын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 22 . Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын хураангуй тайлан, сая төгрөгөөр

	2020	2021	2022
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	4,625	(6,244)	9,382
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	761	(748)	(1,232)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,774)	3,528	(492)
Валютын ханшийн зөрүү	(1)	2	725
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,611	(3,462)	8,383
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,667	9,277	5,816
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,277	5,816	14,198

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн аудитын тайлан

Үнэт цаас гаргагчийн цэвэр мөнгөн урсгал 2020 болон 2022 онд эерэг дүнтэй байна. Харин 2021 онд 3.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь дансны өглөг өмнөх оноос 6.3 тэрбум төгрөгөөр буурч үйл ажиллагааны мөнгөн урсгал хасах гарсантай холбоотой байна. Тус гарах мөнгөн урсгалыг 3.5 тэрбум төгрөгийн өрийн болон өмчийн хэлбэрээр санхүүжүүлсэн байна.



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



ГУРАВ.

**ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ТУХАЙ**

3.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

СГХ
2023.05.23
БҮРТГЭВ-03
№ 11

3.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал Бодит сектор

2023-05-11
БҮРТГЭВ-03

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (цаашид “ДНБ” гэх) 2020 онд өмнөх онтой харьцуулахад 385 тэрбум төгрөгөөр буюу 1.02 хувиар буурсан нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр үйлчилгээ, үйлдвэрлэл, агаарын тээвэр, аялал жуулчлал зэрэг салбаруудын үйл ажиллагаа зогсонги байдалд шилжсэнтэй холбоотой юм. Харин 2021 онд 16.3 хувиар, 2022 онд 21.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны ДНБ-ийн өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 22.1 хувиар, уул уурхайн олборлолтын салбар 19.7 хувиар, аж үйлдвэр, барилгын салбар 24.1 хувиар, үйлчилгээний салбар 19.0 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татвар 30.6 хувиар тус тус өмнөх оноос өссөн.

График 19. Монгол Улсын ДНБ, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: УСХ

2022 онд үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-д эзлэх салбарын хувь хэмжээг авч үзвэл хөдөө аж ахуй 13.3 хувь, уул уурхай 24.3 хувь, аж үйлдвэр болон барилга 12.7 хувь, үйлчилгээ 38.8 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 10.9 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 22. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2023Т
Дэлхийн банк	5.3%
Олон улсын валютын сан	4.5%
Азийн хөгжлийн банк	5.4%
Европын сэргээн босголт хөгжлийн банк	7.0%
Монголбанк	4.7%
Дундаж	5.4%

Эх сурвалж: Олон улс болон дотоодын эдийн засгийн институт

Олон улсын болон дотоодын шинжээчдийн таамаглалын дагуу Монгол Улсын эдийн засаг экспорт, уул уурхайн салбарын сэргэлт, түүний тээвэр болон бусад

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS UIC XXX
LLC
90210314 521348

MONLOGISTICS HOLDING
ATA5299 6381261
9021031093

салбаруудад үзүүлж буй эерэг нөлөөгөөр 2023 онд өмнөх оноос дунджаар 5.4 хувиар өсөх төлөвтэй байна.


Гадаад сектор

2022 оны байдлаар Монгол Улсын гадаад худалдаа 3.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнд экспортын хэмжээ 12.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны үеэс 36 хувиар өссөн нь нөлөөлсөн. Хэдийгээр БНХАУ-тай хиллэдэг боомтуудын хязгаарлалт үргэлжилж байгаагаас экспортын гарц муу байсан боловч дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс экспортын үнэ өссөн.

Гэвч ОХУ-Украины мөргөлдөөн бий болсноос хойш Монгол Улсын ОХУ-аас авдаг гол импортын бүтээгдэхүүн болох түлш, шатахууны өртөг нэмэгдсэн, нийлүүлэлтийн гацаа үүссэн нь тээврийн өртгийг нэмэгдүүлж импортыг 8.7 тэрбум ам.долларт хүргэсэн. Улмаар 2022 онд гадаад худалдааны ашиг өмнөх оны үеэс 60 хувиар өссөн юм.

2022 онд газрын тосны үнэ нэг баррель нь дунджаар 96.6 ам.долларт хүрч өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүний импорт өмнөх жилээс 29 хувиар, машин, тоног төхөөрөмж 1 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 59 хувиар, тээврийн хэрэгсэл 38 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

График 20. Экспортын голлох бүтээгдэхүүн, сая доллароор




Эх сурвалж: YCX

Төсвийн сектор

2022 оны байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.0 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Нэгдсэн төсвийн орлого 2021 оны 12-р сард 2020 оны үеэс 35 хувиар өсөж, 12.7 их наяд төгрөгт хүрээд байсан бол 2022 онд энэ үр дүн 36 хувиар өсөж, 17.2 их наяд төгрөгт хүрээд байна. Үүнээс ААНОАТ 19 хувиар, ХХОАТ 19 хувиар, нийгмийн даатгалын орлого 34 хувиар, НӨАТ-ын орлого 38, гадаад үйл ажиллагааны орлого буюу гаалийн тариф 37 хувиар өссөн байна. Хэдийгээр дотоодод цар тахлын хөл хориог сулруулсан ч олон улсын эдийн засгийн орчин тааламжгүй байгаагаас бизнесүүд орлогоо алдсан тул төсвийн орлогоо хангалттай бүрдэж чадаагүй байна.



График 21. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: УСХ

Монгол Улсын Засгийн газраас татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, урсгал шилжүүлэг, цалин хөлсний зардлыг нэмэгдүүлэх замаар дотоодын эдийн засаг дахь эрэлтийг дэмжих зорилгоор мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Цар тахлын нөлөөгөөр 2020 онд Монгол Улсын нийт төсвийн алдагдал ДНБ-ний 9.6 хувьтай тэнцэж байсан бол 2021 онд 3.4 хувьтай, 2022 онд 1.9 хувьтай тэнцэж байна.

Мөнгөний сектор

Инфляц

2021 оны эхний 3 сард цар тахлын өвчлөлийн тохиолдол нэмэгдсэн нь улс орнуудад дотооддоо хөл хорио тогтоохоос өөр аргагүй байдалд хүргэснээр хилийн хязгаарлалт тогтоож, үйлдвэрлэлийн гарц огцом буурсан. Энэ нь улс орнуудад 2-3 сарын хоцрогдолтой нийлүүлэлтийн гаралтай нөлөөлсөн бөгөөд Монгол Улсад 2021 оны 6-р сараас эхлэн инфляцын түвшин огцом нэмэгдсэн.

График 22. Инфляцын түвшин, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Улмаар 2022 оны 12-р сард Монгол улсын инфляцын түвшин 13.2 хувьд хүрсэн. Тус өсөлтөд эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 17 хувиар өссөн нь голдох нөлөө үзүүлсэн ба хүнсний бүтээгдэхүүн 15 хувиар, зочид буудал, нийтийн хоолны



СЭХ
2023.06.23
БҮРТГЭГ
N 1

2023-06-14
57-105-03

үйлчилгээ 15 хувиар, гэр ахуйн бараа 15 хувиар тус тус өссөн нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлжээ. Дэлхий дахинд үүссэн цар тахлын хөл хорионоос шалтгаалан үүсээд байсан нийлүүлэлтийн гацаа бага багаар арилж, инфляц дахь тээврийн зардлын дарамт сүүлийн 4 улирлын турш дарааллан буураад байна.

Монгол Улсын хэрэглээний сагсны 40 орчим хувийг импортын бараа бүтээгдэхүүн эзэлдэг. Импортын барааны үнийн өсөлт нэмэгдэхэд шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт, бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хүндрэл, хил гаалийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын хэрэглээний үнэ нийлүүлэлтийн гаралтай өссөн.

Хүснэгт 23. Инфляцын төсөөлөл

	2023Т
Олон улсын валютын сан	11.2 %
Азийн хөгжлийн банк	10.9%
Монголбанк	11.4%
Дундаж	11.2%

Эх сурвалж: Олон улс болон дотоодын эдийн засгийн институт

ОХУ-Украины мөргөлдөөн нь нийт импортын 30 орчим хувийг ОХУ-аас импортолдог Монгол Улсын хувьд импортын гол бүтээгдэхүүн болох газрын тос, цахилгаан, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасрах, үнэ нэмэгдэх нөхцөлийг бий болгосон. Үүнээс хамаарч олон улсын болон дотоодын шинжээчдийн зүгээс Монгол Улсын инфляцын түвшинг 2023 оны эцэст дунджаар 11.2 хувьд хүрнэ гэж төсөөлж байна.

Мөнгөний нийлүүлэлт, мөнгөний бодлого

2022 оны 12-р сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны үеэс 6.5 хувиар өсөж, 29.7 их наяд төгрөгт хүрсэн. М2 мөнгөний жилийн өсөлтөд төгрөгийн харилцах 13 нэгж хувиар, валютын харилцах 111 нэгж хувиар өссөн нь нөлөөлсөн. Харин хадгаламжийн хүү буурсантай холбоотойгоор төгрөгийн хадгаламж 16 нэгж хувиар буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Харин валютын ханш өсөж байгаатай холбоотойгоор валютын хадгаламж 18 нэгж хувиар өссөн.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо мөнгөний бодлогын хүүг 2020 онд 6 хувьд барьж байсан бол 2023 оны 01-р сарын байдлаар инфляцыг нам түвшинд байлгах, хязгаарлах зорилгоор бодлогын хүүг 7 нэгж хувиар нэмэгдүүлэн 13 хувьд хүргэснээр мөнгөний нийлүүлэлт буурч эхэлсэн. Энэ нь хадгаламжийн хүү нэмэгдэх суурь болсон. Арилжааны банкууд хадгаламжийн дундаж хүүг 12 хувьд хүргэсэн ч хадгаламжид өсөлт ажиглагдсангүй.

Валютын нийлүүлэлтийн гаралтай ханшийн өсөлт бий болоод байгаагаас харилцах дансны долларжилт 44 хувьд, хадгаламж дахь долларжилт 27 хувьд хүрээд байгаа нь 2020 оны 12 сараас хойших хугацааны хувьд өндөр түвшин юм.

MANDAL CAPITAL
MARKETS SC
LC
ШТК0162 9021070414 521342

monlogistics
HOLDING
ATAS209 6381751
9021071093

График 23. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, хувиар



Эх сурвалж: Монголбанк

2021 оны дунд үеэс иргэд, аж ахуй нэгжийг дэмжих, цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор (1) Монгол Улсын Засгийн Газар эдийн засгийн дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн (2) банкууд репо санхүүжилт авч иргэд, аж ахуй нэгжид бага хүүтэй зээл тогтмол олгож буй нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц болсон.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2022 онд урьдчилсан байдлаар 727 сая ам.долларын алдагдалтай, урсгал данс 2,876 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 2,168 сая ам.долларын ашигтай байна.

Ковид-19 цар тахлыг хязгаарлах дэлхийн улсуудын бодлогоос шалтгаалан дэлхий даяар үйлчилгээний салбарын үйл ажиллагааны идэвх саарсан, гадаад үйлчилгээний эрэлт буурсан нь Монгол Улсын төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний алдагдал өсөхөд нөлөө үзүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний данс 2,337 сая ам.долларын алдагдалд хүрсэн. Дэлхийн ихэнх улсууд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аялалын хязгаарлалт тогтоосон, мөн тээврийн сүлжээний тасалдал үүссэн зэрэг нь үйлчилгээний дансны алдагдал өндөр байхад нөлөөлсөн.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулагч компаниудын үйл ажиллагаа сэргэснээр ногдол ашгийн шилжүүлэг, гадаад ажилтнуудын цалингийн шилжүүлэг нэмэгдэж, анхдагч орлогын алдагдал 2,093 сая ам.долларт хүрсэн байна. Харин хоёрдогч орлого буюу урсгал шилжүүлгийн орох урсгал 448 сая ам.долларт хүрсэн нь цар тахлыг даван туулахад чиглэсэн гадаадын буцалтгүй тусламж татарснаас үүдэлтэй байна.



График 24. Төлбөрийн тэнцэл, сая доллароор




Эх сурвалж: Монголбанк

Валютын ханш

2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын гадаад валютын албан нөөц 3,400 сая ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 22 хувиар буурсан нь импортын 4.3 сарын хэрэгцээтэй тэнцэж байна. Монголбанк валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 онд 22.9 тонн алт худалдаж авсан нь өмнөх оноос 10 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тээвэрлэлтийн зардал нэмэгдсэн, дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өссөн зэргээс хамаарч түлш, шатахууны импорт, тээврийн зардалтай холбоотойгоор валютын гарах урсгал нэмэгдсэн байна. 2023 онд төлөгдөх байсан Гэрэгэ бондын 500.0 сая ам.долларын бондын өрийг 2028 онд төлөгдөх Хүннү бондоор дахин санхүүжүүлсэн бөгөөд 2023 онд Хөгжлийн банкны 500.0 сая ам.доллар, Самурай бондын 30.0 тэрбум иены эргэн төлөлт хийгдэхээр хүлээгдэж байна.

График 25. Гадаад валютын албан нөөц, сая доллароор



Эх сурвалж: Монголбанк




3.2 Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРГЭ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 6.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 хувиар өссөн байна. Энэ нь ДНБ-ний 14.4 хувьтай тэнцэж байна.

График 26. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөгөөр болон ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Үнэт цаасны зах зээлийн 2022 оны тайлан, СЗХ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж буй нийт 184 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 93.9 хувийг бүрдүүлж байна.

Зах зээлийн индексүүд

2022 онд ТОП-20 индекс 15.4 хувиар, MSE-A индекс 8.7 хувиар тус тус буурсан бол MSE-B индекс 3.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 24. Индексүүд

Индекс	2021	2022	Өөрчлөлт
ТОП 20	44,411.6	37,565.6	-15.4%
MSE A	15,482.8	14,137.9	-8.7%
MSE B	12,202.6	12,667.4	3.8%



Эх сурвалж: МХБ

Үнэт цаасны арилжаа

2022 онд 594.9 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн. Үүнээс 57.7 хувийг хувьцаа, 22.5 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 17.5 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 2.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.


Хувьцааны зах зээлийн хувьд 2022 онд анхдагч зах зээлийн арилжаа өмнөх оноос 2.4 дахин өссөн бол хоёрдогч зах зээлийн арилжаа 1.4 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Банкны реформын хүрээнд Богд банк, Төрийн банк, Голомт банкууд хөрөнгийн зах зээлд анх удаа хувьцаа гаргасан нь анхдагч зах зээлийн арилжааг өмнөх оноос өсөхөд нөлөө үзүүлсэн бол Монголбанкнаас инфляцыг бууруулах зорилгоор явуулж буй мөнгөний хатуу бодлогын хүрээнд бодлогын хуулийн 5



удаа нэмэгдүүлж 6 хувиас 13 хувьд хүргэсэн нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа буурахад нөлөө үзүүлээд байна.

График 27. Хувьцааны арилжаа, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: МХБ

3.3 Олон улсын тээвэр ложистикийн зах зээлийн нөхцөл байдал

Олон улсын тээвэр ложистикийн салбарын үүсэл хөгжил

Тээвэр ложистик нь ачаа барааг нэг цэгээс нөгөө цэгт боломжит бага зардлаар түргэн шуурхай хүргэхээс гадна түүнийг агуулах, хадгалах, хянах цогц үйлчилгээг илэрхийлдэг.

Өнөөгийн тээвэр ложистикийн системийн суурь нь эртний Грек, Ромын үед бий болсон гэж тэмдэглэгдсэн байдаг. Тухайн үед дайнд ялахын тулд цэргүүдийн хоол хүнс, зэр зэвсэгийг түргэн шуурхай хүргэх шаардлага үүсч, улмаар ачаа барааг нарийвчлан зохион байгуулах үүрэг бүхий ложистака нэртэй тусгай ажилтнууд бий болсон байна.

Тус ажилтнууд нь цэргүүдэд шаардлагатай зэвсэг болон хоол хүнсийг тээвэрлэх ажлыг хариуцан ажиллаж эхэлсэнээр тээвэр ложистикийн үйлчилгээний эхлэл тавигдсан. Ложистикийн үйлчилгээг цэргийнхэн олон жилийн турш, ялангуяа Дэлхийн 1 ба Дэлхийн 2-р дайны үед ашиглаж байсан бол олон улсын бизнесийн практикт XVIII-р зууны сүүл үеэс нэвтэрсэн байна.

Дэлхийн анхны тээвэр ложистикийн компани болох Thomas Meadows and Company Limited нь худалдаачид болон үйлдвэрлэгчдэд тээвэр ложистикийн үйлчилгээ үзүүлэхээр 1836 онд үүсгэн байгуулагдсан байна.

Тус компани нь захиалга өгөх, үйлдвэрлэлийн төлөвлөлт, бүтээгдэхүүн түгээх, агуулах, хадгалах цогц үйлчилгээг харилцагчдад үзүүлж, Англи болон БНЭУ-ын хооронд ачаа бараа тээвэрлэх чиглэлд мэргэшсэн байна.

XX-р зууны дунд үеэс даяаршил бий болж, олон улсын худалдаа эрчимжсэнээр тээвэр ложистикийн үйлчилгээний цар хүрээ улам өргөжсөн байна. Тухайн үед бизнесийн байгууллагууд тээвэрлэлтийн үйл явцыг илүү хялбар, өртөг бага, түргэн шуурхай, олон улс даяар тээвэрлэх арга замыг эрэлхийлж, улмаар далайн, төмөр зам, агаарын тээврийн дэд бүтцийг ашиглаж эхэлсэн байна.

Нөгөө талаас гадаад худалдааны хэмжээ нэмэгдэж, тээврийн сүлжээ өргөжихийн хэрээр бизнес эрхлэгчдэд өөрсдийн ачаа тээвэрлэлтийг удирдахад улам бүр хүндрэлтэй болсон байна. Иймд тээвэр зохион байгуулагч гэж нэрлэгддэг гуравдагч байгууллагууд бий болжээ. Эдгээр тээвэр ложистикийн байгууллагууд нь тээвэрлэгчидтэй хамтран ажиллахаас эхлээд тээврийн бүрдүүлэлт, хүргэлтийг зохион байгуулах хүртэлх тээвэрлэлтийн бүхий л үйл

СЗХ
ОМ 2019.06.25
БҮРТГЭВ
№ 1

2023-08-15
БҮРТГЭВ-03

MANDAL CAPITAL MARKETS SC
LLC
5213AR1

monlogistics HOLDING
ATAS299 4 381251
902103103

явцыг удирдан зохион байгуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, учирч болох эрсдэлээс сэргийлж эхэлсэн байна.

СЭХ
ОН САР
БҮРЭГ
№

Өдгөө тээвэр ложистикийн салбар нь олон улсын худалдаа, нийлүүлэлтийн гинжин хэлхээний салшгүй нэг хэсэг болж, эдийн засагт чухал байр суурь эзэлж байна.


2023-03-14
БҮЛЭГ 03

Олон улсын тээвэр ложистикийн салбарын нөхцөл байдал

Expert Market Research байгууллагын судалгаагаар 2022 оны байдлаар олон улсын тээвэр ложистикийн зах зээл 10 их наяд ам.доллороор хэмжигдэж, өмнөх онтой харьцуулахад 6 хувиар өссөн байна.

Олон улсын тээвэр ложистикийн зах зээлд авто болон далайн тээвэр голлох байр суурийг эзэлдэг. Тодруулбал, 2022 оны байдлаар тээвэр ложистикийн салбарын орлогын 34 хувийг авто тээвэр, 33 хувийг далайн тээвэр, 25 хувийг төмөр замын тээвэр, 8 хувийг агаарын тээвэр бүрдүүлж байна.

График 28. Тээвэр ложистикийн зах зээлийн бүтэц



Эх сурвалж: www.expertmarketresearch.com

Тээвэр ложистикийн нөхцөл байдал нь тухайн улсын газар зүйн байршлаас ихээхэн хамаардаг. Иймд тээвэр ложистикийн зах зээлд далайд гарцтай орнууд гол тоглогчид байдаг. Тодруулбал, олон улсын тээвэр ложистикийн салбарт БНХАУ, Япон Улс, ХБНГУ, АНУ томоохон байр суурь эзэлдэг.

2021 оны байдлаар БНХАУ-ын тээвэр ложистикийн орлого 1.9 их наяд ам долларт хүрч, ложистикийн гүйцэтгэлийн индекс /цаашид "ЛГИ" гэх/ үнэлгээгээр дэлхийд 26-д, Япон Улсын тээвэр ложистикийн орлого 160 тэрбум ам.долларт хүрч, ЛГИ үнэлгээгээр 5-д, ХБНГУ-ын тээвэр ложистикийн орлого 301 тэрбум ам.долларт хүрч, ЛГИ үнэлгээгээр 1-т, АНУ-ын тээвэр ложистикийн орлого 347.9 тэрбум ам долларт хүрч, ЛГИ үнэлгээгээр 14-т тус тус бичигдэж байна.



3.4 Олон улсын тээвэр ложистикийн салбарын цаашдын төлөв


Expert Market Research байгууллагын судалгаагаар тээвэр ложистикийн зах зээл 2023-2028 онд жилд дунджаар 6.3 хувиар өсөж, 2028 онд 14.4 их наяд ам.долларт хүрэх төлөвтэй байна. Тус өсөлтөд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

Цахим худалдааны өргөжилт

Цахим худалдааны зах зээл өргөжихийн хирээр тухайн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд түргэн шуурхай, найдвартай хүргэх тээвэр ложистикийн үйлчилгээний эрэлт нэмэгдэж байна.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн байгууллагын (UNCTAD) 2020 оны 04-р сард гаргасан судалгаагаар олон улсын цахим худалдааны зах зээл 2018 онд 25.6 их наяд ам.долларт хүрсэн нь олон улсын ДНБ-ийн 30 хувьтай тэнцэж байна. Харин онлайн худалдааны ложистикийн зах зээл 2022 оны байдлаар 532.3 тэрбум ам.доллаароор хэмжигджээ.

График 29. Цахим худалдааны зах зээл, тэрбум ам.доллаароор



Эх сурвалж: www.statista.com


Statista байгууллагын судалгаагаар 2026 онд цахим худалдааны зах зээл 831 тэрбум ам.долларт хүрч, жилд дунджаар 12.0 хувиар өсөх төлөвтэй байна. Энэ нь тус зах зээлтэй шууд хамааралтай тээвэр ложистикийн зах зээлийг өргөжүүлэхэд түлхэц болохоор байна.

Олон улсын худалдааны өргөжилт



Улс хоорондын даяарчлал бий болохын хэрээр үйлдвэрлэгчид болон худалдааны байгууллагууд өөрсдөө тээвэрлэлт хийж гүйцэтгэх нь улам хүндрэлтэй болж байна. Иймд тээвэр ложистикийн байгууллагаар дамжуулан нийлүүлэлтийн гинжин хэлхээний тогтвортой байдлыг хангах, бүтээгдэхүүнийг харилцагчдад цаг тухайд нь хүргэх шаардлага үүсч байна. Цаашид ч олон улсын даяарчлал нэмэгдэх төлөвтэй байгаа нь тээвэр ложистикийн салбарын орлогыг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Технологийн дэвшил

Блокчэйн, хиймэл оюун ухаан зэрэг технологийн дэвшил нь тээвэр ложистикийн салбарыг өөрчилж, илүү үр ашигтай, ил тод, зардал багатай болгож байна. Энэ нь худалдааны салбарын байгууллагуудад тээвэр ложистикийн үйлчилгээ ашиглах эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх төлөвтэй байна.



Дүгнэж хэлэхэд, олон улсын худалдаа, цахим худалдааны өсөлт, хөгжиж буй зах зээлийн өсөлт, технологийн дэвшил зэргээс шалтгаалан дунд хугацаанд тээвэр ложистикийн зах зээл өсөх төлөвтэй байна.



3.5 Дотоодын тээвэр ложистикийн зах зээлийн нөхцөл байдал

Дотоодын тээвэр ложистикийн салбарын үүсэл хөгжил

Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын үүсэл хөгжил нь эдийн засгийн хөгжил, бүс нутгийн худалдаатай нягт холбоотой. 1990-ээд оны эхээр буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн үед буюу тээвэр ложистикийн салбарт хувийн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Улмаар 2000 оноос эхлэн БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт өргөжиж гадаад худалдааны эргэлт нэмэгдсэнээр тээвэр ложистикийн салбарын цар хүрээ өргөжсөн байна.

Дотоодын тээвэр ложистикийн салбарын нөхцөл байдал


Олон улстай харьцуулахад

Далайд гарцгүй, 3.3 сая хүн амтай, уул уурхайн салбараас өндөр хамааралтай Монгол Улсын хувьд тээвэр ложистикийн салбар эдийн засагт чухал байр суурийг эзэлсээр ирсэн.

Олон улсын худалдаа нь тээвэр ложистикийн салбартай салшгүй холбоотой. 2022 оны байдлаар Монгол Улсын гадаад худалдаа нь ДНБ-ийн 126 хувийг эзэлж буй нь олон улсын дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт юм. Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар 2021 онд Монгол Улс нь тус үзүүлэлтээр 240 улсаас 29-д эрэмбэлэгдсэн байна. Үүнээс харахад Монгол Улс нь дэлхийн бусад улсуудтай харьцуулахад тээвэр ложистикийн салбараас ихэд хамааралтай болох нь харагдаж байна.

Гэвч 2018 оны Дэлхийн банкнаас гаргасан ЛГИ үнэлгээгээр Монгол Улс 160 орноос 130-д эрэмбэлэгдсэн. Энэ нь Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын хөгжил нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад сул байгааг харуулж байна. Тус үнэлгээгээр Монгол Улсын дэд бүтцийн үзүүлэлт хамгийн бага үзүүлэлт авсан байна.

График 30. Ложистикийн Гүйцэтгэлийн Индекс 2018 -Монгол Улс




Дэлхийн Эдийн Засгийн Форум-с гаргасан өрсөлдөх чадварын тайланд дурдсанаар Монгол Улс дэд бүтцийн хөгжлөөр 137 орноос 105-д эрэмбэлэгдсэн байна.

Дээрх олон улсын байгууллагуудын судалгаанаас үзэхэд хэдийгээр Монгол Улс гадаад худалдаа болон тээвэр ложистикийн салбараас өндөр хамааралтай боловч тээвэр ложистикийн салбарын хөгжил сул байгаа нь харагдаж байна.

Ерөнхий байдлаар

2022 оны байдлаар Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын орлого 2.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. 2013 оноос хойш Монгол Улсын эдийн засаг, өрхийн хэрэглээний өсөлт болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлтөөс улбаалж тээвэр ложистикийн салбарын орлого 2 дахин томорч, жил дунджаар 7.7 хувиар өсжээ.

График 31. Тээврийн нийт орлого, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: УСХ

2010-2019 онд Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын орлого тасралтгүй өссөн боловч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хил гаалийн хориг саад, нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдал үүсч, улмаар салбарын орлого буурсан. 2022 онд хил, гаалийн нөхцөл байдал сэргэж, тээврийн эргэлт сайжирснаар Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын орлого өмнөх онтой харьцуулахад 47.6 хувиар өссөн байна.

2022 оны байдлаар тээвэр ложистикийн салбарын орлого ДНБ-ийн 4.0 хувьтай тэнцэж байна. 2013 оноос хойш тээвэр ложистикийн салбар нь дунджаар ДНБ-ийн 4.5 хувийг бүрдүүлж ирсэн. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр тус хувь хэмжээ 2021 онд хамгийн бага түвшинд буюу 3.7 хувьд хүрсэн. 2022 онд хил гаалийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэнтэй холбоотой тус хувь хэмжээ өмнөх онтой харьцуулахад 0.3 хувиар өссөн байна.



График 32. Тээврийн салбарын ДНБ-д эзлэх хувь, ДНБ үйлдвэрлэлийн аргаар, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: ҮСХ

Азийн хөгжлийн банкны 2018 оны судалгаагаар Монгол Улсын хэмжээнд худалдаалагдаж буй бараа бүтээгдэхүүний үнийн 30 орчим хувийг тээвэр ложистикийн зардал бүрдүүлж байна. Энэ нь тээвэр ложистикийн салбар нь Монгол Улсын эдийн засагт чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Үндэсний статистикийн хороо (цаашид "ҮСХ" гэх)-с гаргасан 2021 оны судалгаагаар Монгол Улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж байгууллагуудын 3.1 хувь буюу 2,500 гаруй нь тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Тус байгууллагуудын 69.1 хувь нь Улаанбаатар хотод, 10.4 хувь нь Өмнөговь аймагт, 3.0 хувь Дорноговь аймагт, 17.5 хувь нь бусад аймагт байрлаж байна.


Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын нөхцөл байдлыг дэлгэрүүлэх үүднээс доорх хэсэгт 1) тээврийн хэрэгслээр 2) тээврийн төрлөөр ангилан тодорхойлов.

Тээврийн хэрэгслээр

Тээврийн салбарын орлого нь тээврийн хэрэгслээр төмөр замын, авто, агаарын болон далайн тээвэр гэж ангилагдана. Олон улсын тээврийн салбарт далайн тээвэр нь нийт салбарын орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг. Гэвч Монгол Улс нь газар зүйн байршлын хувьд далайд гарцгүй тул хуурай замын тээвэр буюу авто зам, төмөр замын тээврүүд нь нийт тээврийн орлогын 74 хувийг, тээсэн ачааны 99.9 хувийг бүрдүүлж байна.



График 33. Тээврийн нийт орлого тээврийн хэлбэрээр, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: YCX

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 60.8 сая тонн ачаа тээвэрлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 11.6 сая тонн буюу 23.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант хугацаанд Ковид-19 цар тахалтай холбоотой БНХАУ-тай хиллэх худалдааны гол боомтууд хаалттай хэвээр байсан хэдий ч салбарын нийт тээсэн ачаа тээвэр 2020 оны түвшинд хүрсэн. Энэхүү өсөлтөд авто тээврийн ачаа 84.1 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

График 34. Нийт тээсэн ачаа тээврийн хэлбэрээр, сая тонноор



Эх сурвалж: YCX

Авто замын тээвэр

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд авто тээврийн салбарын орлого 784.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 370.7 тэрбум төгрөг буюу 89.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 25. Авто замын тээврийн үзүүлэлт

	2018	2019	2020	2021	2022
Тээврийн орлого, тэрбум төгрөг	695.9	796.1	564.4	413.9	784.6
Өсөлтийн хувь (Y-Y)	37.4%	14.4%	-29%	-26.7%	89.6%
Тээсэн ачаа, сая тонн	42.0	40.8	30.5	18.0	33.1
Өсөлтийн хувь (Y-Y)	34.7%	-2.8%	-25.4%	-41.0%	84.1%

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
УТХ0162 90210704-4 5017401

Эх сурвалж: YCX

МОНЛОГИСТИКС ХОЛДИНГ
monlogistics
HOLDING
ATA5299 0381251
902101093

Тайлант хугацаанд авто тээврээр 33.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 84.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд авто замын экспортын тээвэр 88.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Авто замын тээврийн 97 гаруй хувийг экспортын тээвэр бүрдүүлж буй бол 3 гаруй хувийг импортын тээвэр бүрдүүлж байна. Үүнд нүүрсний экспортын тээвэр нь 28.9 сая тонноор хэмжигдэж, авто замын тээврийн 87.2 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 26. Авто тээвэр ачааны төрлөөр, мянган тонноор

Ачааны төрөл	2021	2022	Өөрчлөлтийн хувь
Нүүрс	14,036	28,857	105.6%
Газрын тос	547	346	-36.7%
Зэсийн баяжмал	594	501	-15.6%
Төмрийн хүдэр	178	912	413.7%
Бусад	2,617	2,459	-6.0%
Нийт	17,970	33,076	84.1%

Эх сурвалж: ЗТХЯ

2022 оны байдлаар экспортын тээврийн 61.0 хувь нь Гашуунсухайт боомтоор, 18 хувь нь Шивээхүрэн боомтоор, 10 хувь нь Ханги боомтоор, үлдсэн 11 хувь нь бусад боомтуудаар тээвэрлэгдэж байна.

Төмөр замын тээвэр

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд төмөр замын тээврийн салбарын орлого 747.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 19.1 тэрбум төгрөг буюу 2.5 хувиар буурсан байна.

2020 он хүртэл төмөр замын тээврийн салбарын орлого тасралтгүй өссөн ч 2021 онд Ковид-19 цар тахлын нөлөө, 2022 онд дэд бүтцийн хүчин чадал хүрэлцээгүйн улмаас буурсан.

Хүснэгт 27. Төмөр замын тээврийн үзүүлэлтүүд

	2018	2019	2020	2021	2022
Тээврийн орлого, тэрбум төгрөг	616.0	708.6	770.1	766.3	747.2
Өсөлтийн хувь (Ү-Ү)	16.2%	15.0%	8.7%	-0.5%	-2.5%
Тээсэн ачаа, сая тонн	25.8	28.1	29.8	31.3	27.7
Өсөлтийн хувь (Ү-Ү)	13.2%	9.2%	6.0%	4.8%	-11.5%

Эх сурвалж: ҮСХ

2022 оны байдлаар төмөр замаар тээвэрлэгдэж буй нийт ачааны 43.2 хувь нь дотоодод, 31.2 хувь нь экспорт, 14.1 хувь нь импорт, 11.5 хувь нь транзит тээвэр байна.

Төмөр замаар тээвэрлэгдэж буй ачаанд нүүрс, төмрийн хүдэр, барилгын материал голлох байр суурийг эзэлдэг. Тодруулбал, 2022 оны байдлаар 11.2 сая тонн нүүрс төмөр замын тээврээр тээвэрлэгдсэн нь төмөр замын тээврийн 40.5 хувийг бүрдүүлж, өмнөх онтой харьцуулахад 14.0 хувиар өссөн байна.



Хүснэгт 28. Төмөр замын тээвэр ачааны төрлөөр, мянган тонноор



Ачааны төрлөөр	2021	2022	Өөрчлөлтийн хувь
Нүүрс	9,855	11,205	13.7%
Төмрийн хүдэр	7,349	3,919	-46.7%
Барилгын материал	2,994	2,656	-11.3%
Бусад	11,063	9,901	-10.5%
Нийт тээсэн ачаа	31,261	27,681	-11.5%

Эх сурвалж: YCX

Монгол Улс нүүрсний экспортыг тавцант болон задгай вагоноор төмөр замаар тээвэрлэдэг. Монгол Улсын хэмжээнд нийт 3,181 ширхэг тавцант вагон бүртгэлтэй байгаагийн өмчлөлийн хэлбэрийг авч үзвэл 1,624 ширхэг буюу 51 хувь нь УБТЗ, МТЗ зэрэг байгууллагуудын эзэмшлийн вагон, 1,557 ширхэг буюу 49 хувь нь түрээсийн вагон байна.

Агаарын тээвэр

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд агаарын тээврийн салбарын орлого 505.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 305.1 тэрбум төгрөг буюу 152.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 29. Агаарын тээврийн үзүүлэлт

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Тээврийн орлого, тэрбум төгрөг (Үндэсний тээвэрлэгч)	442.3	498.6	164.1	200.0	505.2
Өсөлтийн хувь	14.7%	12.7%	-67.1%	21.9%	152.5%
Тээсэн ачаа, тонн	5,752	5,761	2,741	6,429	12,893
Өсөлтийн хувь	7.1%	0.2%	-52.4%	134.7%	100.6%

Эх сурвалж: YCX

Тайлант хугацаанд агаарын тээврээр тээсэн ачаа 12.9 мянган тоннд хүрсэн. Тус өсөлтөд гадаадын тээвэрлэгч компанийн ачаа өмнөх онтой харьцуулахад 370.8 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 30. Агаарын тээвэр, тээвэрлэгчийн төрлөөр, сая тонноор

Тээврийн төрөл	2021	2022	Өөрчлөлтийн хувь
Олон улсад	6,414	12,869	100.6%
Үндэсний тээвэрлэгч	4,906	5,769	17.6%
Гадаадын тээвэрлэгч	1,508	7,100	370.8%
Дотоодод	18	24	59.6%
Нийт тээсэн ачаа	6,429	12,893	100.5%

Эх сурвалж: YCX

Далайн тээвэр


Монгол Улс нь далайд гарцгүй орон тул далайн тээвэр маш бага хувийг эзэлдэг. Дотоодын далайн тээврээр ачааг бараа тээвэрлэсэн статистик байхгүй бөгөөд тус тээврээр зөвхөн зорчигч тээврийн үйлчилгээ явагдаж байна.

Тээврийн төрлөөр

Тээвэр ложистикийн үйл ажиллагааг төрлөөс нь хамааруулан импорт, экспорт, транзит, дотоод гэж ангилдаг. 2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт тээсэн ачааны 66 хувийг экспорт, 20 хувийг дотоод, 9 хувийг импорт, 5 хувийг транзит тээвэр бүрдүүлж байна.



График 35. Нийт тээсэн ачаа тээврийн төрлөөр, сая тонноор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Импортын тээвэр

2022 онд Монгол Улсын импортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 14.0 хувиар өсөж 4.9 сая тоннд хүрсэн байна. Тайлант хугацаанд импортын ачаа тээврийн 78.3 хувь нь төмөр замаар, 21.5 хувь нь авто замаар, 0.2 хувь нь агаарын замаар тээвэрлэгдсэн байна.

График 36. Импортын тээврийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Тайлант хугацаанд нийт импортыг бүтээгдэхүүнээр нь ангилан авч үзвэл 34 хувийг эрдэс бүтээгдэхүүн буюу нефтийн бүтээгдэхүүн, 11 хувийг төмөр, гангийн бүтээгдэхүүн, 7 хувийг автомашин, 7 хувийг чулуу, гипс, цементэн бүтээгдэхүүн, 41 хувийг бусад бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Транзит тээвэр

2022 онд Монгол Улсын транзит тээврийн ачаа өмнөх онтой харьцуулахад 25.1 хувиар буурч, 3.2 сая тоннд хүрсэн байна. Монгол Улсын транзит тээвэр нь 100 хувь төмөр замаар тээвэрлэгддэг.

2022 он хүртэл Монгол Улсын транзит тээврийн ачаа тогтмол өссөн боловч 2021 оноос эхлэн Ковид 19 цар тахлын нөлөө, ОХУ-Украины мөргөлдөөнтэй холбоотойгоор буурсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-06-14
БҮРТГЭВ-03

ӨСӨЛТИЙН
ЛУВААНД
ХАМДАА
monlogistics
HOLDING

График 37. Транзит тээврийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: УСХ

2022 оны байдлаар БНХАУ-аас ОХУ руу 1.0 сая тонн ачаа, ОХУ-аас БНХАУ руу 2.1 сая тонн ачаа тээвэрлэгдсэн байна.

Экспортын тээвэр

2022 онд Монгол Улсын экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 45.0 хувиар өсөж 40.8 сая тоннд хүрсэн байна. Үүнд нүүрсний экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

График 38. Экспортын тээвэр бүтээгдэхүүнээр, сая тонноор



Эх сурвалж: УСХ

Тайлант хугацаанд нийт экспортын 78.3 хувийг нүүрс, 11.6 хувийг төмрийн хүдэр 3.6 хувийг зэсийн баяжмал, 1 хувийг жонш, үлдсэн 5.5 хувийг бусад бараа бүтээгдэхүүн эзэлж байна. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрс нь экспортын тээврийн голлох бүтээгдэхүүн болохыг илэрхийлж байна.

2022 оны байдлаар Монгол Улсын экспортын тээврийн 78.7 хувь нь авто тээврээр, 21.3 хувь нь төмөр замаар тээвэрлэгдсэн байна. Тайлант хугацаанд 28.9 сая тонн нүүрс авто замаар, 2.9 сая тонн нүүрс төмөр замаар тээвэрлэгдсэн байна.



График 39. Экспортын тээврийн хэмжээ тээврийн хэлбэрээр, сая тонноор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Дотоод тээвэр

2022 онд Монгол Улсын дотоод тээврийн ачаа өмнөх онтой харьцуулахад 5.6 хувиар буурч, 11.9 сая тоннд хүрсэн байна. Дотоодын ачаа тээврийн 73 хувийг Дулааны Цахилгаан Станц (цаашид "ДЦС" гэх)-д нийлүүлэх нүүрс тээвэр эзэлдэг бөгөөд Багануур, Шивээ овоо, Шарын голын уурхайн эрчим хүчний нүүрсийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын ДЦС руу тээвэрлэдэг. Дотоодод тээвэрлэгдэж буй ачааны 99.9 хувь нь төмөр замаар тээвэрлэгдэж байна.

График 40. Дотоод тээврийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: ҮСХ



3.6 Дотоодын тээвэр ложистикийн салбарын цаашдын төлөв байдал

Тээврийн салбарын цаашдын бодлого

2013-2022 онд Монгол Улсын тээврийн салбарын нийт тээсэн ачаа жилд дунджаар 4 хувиар, тээврийн салбарын орлого 8 хувиар өссөн байна.

График 41. Тээврийн тоо хэмжээ ба тээврийн орлогын өсөлт



Эх сурвалж: УСХ

Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын цаашдын төлөв байдлыг дараах байдлаар төсөөлсөн. Үүнд:

- Тээврийн төрөл тус бүрээр ачаа тээврийн хэмжээг тодорхойлсон.
- Түүхэн хугацааны мэдээлэлд регрессийн шинжилгээ хийж, ачаа тээврийн хэмжээ болон орлогын өсөлтийн хамаарлыг тодорхойлсон.
- Тус өсөлтийн нийцтэй байдлыг Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй харьцуулан шалгасан.

Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын цаашдын төлөв байдал нь Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлоготой шууд холбоотой. Боомтын сэргэлтийн бодлогын баримт бичиг нь дараах үндсэн гурван зорилгыг агуулж байна. Үүнд:


1. Экспортын гарцыг нэмэгдүүлэх: Монгол Улсын уул уурхайн баялаг нөөцийг богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулж Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хөшүүрэг болох
2. Импортын бүтээмж болон эргэлтийг нэмэгдүүлэх: Импортын тээврийг Монгол Улсын хэмжээнд илүү үр ашигтай бүтээмжтэй болгож зардал болон цаг хугацаа хэмнэх
3. Транзит тээврийг нэмэгдүүлэх: Газар зүйн давуу талыг ашиглаж Монгол Улсаар дамжин өнгөрөх тээврийн урсгалыг нэмэгдүүлэх

Экспортын тээвэр

Олон улсын валютын сангийн шинжээчдийн төсөөллийн дагуу 2023-2027 онд Монгол Улсын нийт экспортын тоо хэмжээ дараах байдлаар өсөх төлөвтэй байна. Тус судалгааны дагуу Монгол Улсын нийт экспортын хэмжээ 2023 онд 46.0 сая тоннд хүрч, 2022 онтой харьцуулахад 5.4 сая тонноор өсөх төлөвтэй байна. Улмаар 2027 онд Монгол Улсын нийт экспортын хэмжээ 62.8 сая тоннд хүрэх төлөвтэй байна.



График 42. Нийт экспортын хэмжээний төсөөлөл, сая тонноор



Эх сурвалж: ОУВС

2018-2022 оны дунджаар Монгол Улсын нийт экспортын 71.1 хувийг нүүрсний экспорт эзэлж байна. Иймд Монгол Улсын нийт экспортын хэмжээ нүүрсний экспорттой шууд хамааралтай байгаа тул цаашдын төлөв байдлыг тодорхойлоход БНХАУ-ын нүүрсний импортын төлөв байдлыг авч үзэх шаардлагатай.

Sxcoal.com судалгааны дагуу БНХАУ-ын нүүрсний импорт 2023-2027 онд жилд дунджаар 5.0 хувиар өсөх төлөвтэй байна. 2018-2022 оны дунджаар Монгол Улс нь тус импортын 10.8 хувийг бүрдүүлсэн байна. Цаашид тус хувь хэмжээгээр БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлийг Монгол Улс бүрдүүлэхээр төсөөлбөл дараах байдалтай байна. Үүнд Монгол Улс 2023 онд 33 сая тонн нүүрс, 2027 онд 40 сая тонн нүүрс БНХАУ руу экспортлох төлөвтэй байна.

График 43. БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: www.statista.com, Үндсэн андеррайтерийн төсөөлөл

Дүгнэн үзэхэд 2023 онд Монгол Улсын нийт экспортын 72.0 хувийг БНХАУ руу экспортлох нүүрс, 28.0 хувийг бусад экспорт эзлэхээр хүлээгдэж байна. Тус үзүүлэлт нь Монгол Улсын нийт экспортод эзлэх нүүрсний экспортын 2018-2022 оны дундаж үзүүлэлттэй ойролцоо түвшинд байна.

Дараах хэсэгт Монгол Улсын нүүрсний экспортын өсөлтийг тээвэрлэх дэд бүтэц, тээвэр ложистикийн хүчин чадлыг авч үзэв.



Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд төмөр замын бүтээн байгуулалтууд хийгдэж, экспортын төмөр замын шинэ гарцыг бий болгохоор 2022 онд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замууд ашиглалтад орсон.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар тус төмөр замуудын хилийн холболт хийгдээгүй байгаа ч 2023-2025 онд үе шаттайгаар холболт хийгдэж, ашиглалтад орохоор хүлээгдэж байна. Мөн 2025 онд Бичигт болон Шивээхүрэн төмөр замын боомтууд шинээр ашиглалтад орохоор хүлээгдэж байна.

Хүснэгт 31. Экспортын голлох боомтуудын хүчин чадлын төсөөлөл, сая тонноор

Боомтууд	2023T	2024T	2025T	2026T	2027T
Гашуунсухайт	40	40	40	40	40
Ханги	20	20	20	20	20
Шивээхүрэн	10	10	10	10	10
Бичигт	-	-	20	20	20
Замын-Үүд	30	30	30	30	30
Нийт	100	100	120	120	120


Эх сурвалж: УБТЗ, МТЗ

2023 онд Монгол Улс нийт 46 сая тонн экспортыг БНХАУ руу тээвэрлэхээр төсөөлсөн ба голлох экспортын боомтуудын хүчин чадлыг авч үзэхэд 100 сая тонн экспортын тээвэр хийх хүчин чадалтай байна. Иймд дээрх төсөөлсөн экспортыг тээврийг гүйцэтгэхэд Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд шинээр байгуулагдах тээвэр, ложистикийн дэд бүтцийн хүчин чадал хангалттай хүрэлцэхүйц гэж үзлээ.

Импортын тээвэр

Олон улсын валютын сангийн шинжээчдийн төсөөллийн дагуу 2023-2027 онд Монгол Улсын импортын тоо хэмжээ дараах байдлаар өсөх төлөвтэй байна. Тус судалгааны дагуу Монгол Улсын нийт импортын хэмжээ 2023 онд 5.9 сая тоннд хүрч, 2022 онтой харьцуулахад 1.0 сая тонноор өсөх төлөвтэй байна. Улмаар 2027 онд Монгол Улсын нийт импортын хэмжээ 6.7 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

График 44. Импортын тээврийн хэмжээний төсөөлөл, сая тонноор




Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжиж буй "Замын-Үүд боомтын барилга байгууламж, дэд бүтцийн барилга угсралтын ажил" төслийн хүрээнд ачаа тээврийн хэсэгт 28 барилга байгууламжийн бүтээн байгуулалтыг хийхээр төлөвлөсөн. Монгол Улсын Засгийн газрын мэдээллэснээр 2023 оны 3 дугаар улиралд ачаа тээврийн шинэ бүтээн байгуулалт ашиглалтад орж нийт импортын тээврийн хүчин чадал нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Транзит тээвэр

2013-2022 онд Монгол Улсын транзит тээврийн хэмжээ жилд дунджаар 6.8 хувиар өссөн байна. 2023-2027 онд УБТЗ-ын дэд бүтцэд суурилан тус замаар тээвэрлэх транзит ачааны өсөлтийг түүхэн дундаж өсөлтөөр өсөхөөр төсөөлсөн.

Мөн 2025 оноос зүүн корридорын төмөр зам ашиглалтад орсноор транзит тээврийн ачаа 40 хувиар нэмэгдэж 5.1 сая тоннд хүрэх төлөвтэй байна. Цаашид жилд 21-27 хувиар өссөнөөр 2027 онд транзит тээврийн хэмжээ 7.8 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

График 45. Транзит тээврийн хэмжээний төсөөлөл, сая тонноор



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төсөөлөл

Монгол Улсын транзит тээвэр нь БНХАУ-ОХУ болон БНХАУ-Европын улс хоорондын гадаад худалдаанаас шууд хамааралтай тул эдгээр улс хоорондын ачаа тээврийн тоо хэмжээг 2020-2027 он хүртэл харуулав.

График 46. БНХАУ- ОХУ, БНХАУ- Европын улсууд хоорондын нийт ачаа эргэлт, сая тонноор



■ Монгол улсаар дамжин өнгөрөх тээврийн хэмжээ
■ Бусад улсаар дамжин өнгөрөх транзит тээвэр



Эх сурвалж: YCX, www.globaltimes.cn

2023-06-14

БНХАУ-ын хувьд ОХУ болон Европын орнуудтай хийсэн нийт тээврийн хэмжээ 2020-2022 онд жилд дунджаар 13.5 хувиар өссөн бөгөөд цаашид тус өсөлтийн хувиар өсөхөөр төсөөлөв.


2022 онд БНХАУ-ын ОХУ болон Европын орнууд руу тээвэрлэсэн нийт ачааны 17 хувь нь Монгол Улсаар дамжин өнгөрсөн байна. 2023-2024 онд тус ачааны Монгол Улсаар дамжин өнгөрөх хувь нь 2022 оны түвшинд, 2027 он гэхэд 22 хувьд хүрэх төлөвтэй байна.

Төмөр замын зүүн корридорын хүчин чадал нь 20 сая тонн бөгөөд Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит тээврийн тоо хэмжээг 2027 онд 7.8 сая тоннд хүрэхээр төсөөлсөн нь тээвэр ложистикийн дэд бүтцийн хүчин чадал хүрэлцэхүйц болохыг илтгэж байна.

Дотоодын тээвэр

2013-2022 онд Монгол Улсын дотоод тээврийн хэмжээ жилд дунджаар 1.2 хувиар өссөн байна.

График 47. Дотоод тээврийн тоо хэмжээний төсөөлөл, сая тонноор



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төсөөлөл

2023 онд Монгол Улсын дотоод тээврийн хэмжээ 12.1 сая тоннд хүрч 2022 онтой харьцуулахад 0.1 сая тонноор өсөх төлөвтэй байна. Цаашид жилд дунджаар 1.2 хувиар өсөж, 2027 онд 12.7 сая тоннд хүрэхээр төсөөлөв.

Тээврийн салбарын тоо хэмжээний төсөөлөл

Дээрх хэсэгт тооцоолсон тээврийн төрөл тус бүрээр таамагласан тоо хэмжээг нэгтгэж Монгол Улсын тээврийн салбарын ачааны тоо хэмжээг харуулбал дараах байдалтай байна.






2023-06-14

БҮРТГЭВ-03

График 48. Нийт тээврийн тоо хэмжээний төсөөлөл, сая тонноор




Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төсөөлөл

Монгол Улсын ачаа тээврийн тоо хэмжээ 2023 онд 2022 онтой харьцуулахад 11 хувиар өсөж 67 сая тоннд хүрэх төлөвтэй байна. Дунд хугацаанд жилд 6-10 хувиар өссөнөөр 2027 онд ачаа тээврийн тоо хэмжээ 90 сая тоннд хүрэх төлөвтэй байна. 2023-2027 онд нийт ачааны 68-70 хувийг экспортын тээвэр бүрдүүлэхээр байна.

Тээврийн салбарын орлогын төсөөлөл

Тээврийн салбарын тоо хэмжээ болон орлогын хамаарлыг 1993-2022 оны түүхэн дундаж тоо статистикт суурилж регрессийн тэгшитгэлээр тооцов.

График 49. Тээврийн тоо хэмжээ болон тээврийн орлогын өсөлтийн регресс




Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төсөөлөл

Регрессийн тэгшитгэлийн үр дүнд тээврийн тоо хэмжээ 1.0 хувиар өсөхөд тээврийн орлого 8.7 хувиар өсдөг болох нь харагдсан. Тус тооцооллын дагуу тээврийн салбарын орлогыг тээврийн тоо хэмжээнээс хамааруулан тооцоход дараах байдалтай байна.



График 50. Тээврийн салбарын орлогын төсөөлөл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төсөөлөл

Тээврийн салбарын орлого 2023 онд өмнөх онтой харьцуулахад 16 хувиар өсөж 2.4 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Улмаар 2023-2027 онд жилд дунджаар 13-15 хувиар өсөж, 2027 оны эцэст тээврийн салбарын орлого 4.0 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлттэй харьцуулахад

Тээврийн салбарын орлогын өсөлт нь Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй түүхэн хугацаанд өндөр хамааралтай байсан тул тээврийн салбарын орлогын төсөөллийн нийцтэй байдлыг дараах тооцооллоор шалгав.


Тээврийн салбарын орлогын өсөлт нь үнийн түвшин болон тээврийн тоо хэмжээнээс хамаарна. Иймд тээврийн салбарын 1) үнийн түвшинг Олон улсын валютын сангийн шинжээчдийн таамагласан Монгол Улсын инфляцын түвшний төсөөллөөр 2) тээврийн тоо хэмжээг Олон улсын валютын сангийн шинжээчдийн таамагласан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллөөр тооцож тээврийн салбарын орлогын төсөөллийг шалгав.

Хүснэгт 32. Эдийн засгийн өсөлтөд үндэслэсэн борлуулалтын орлогын төсөөлөл

Үзүүлэлт	2023T	2024T	2025T	2026T	2027T
Бодит ДНБ өсөлт	4.5%	5.5%	6.0%	5.5%	5.0%
Инфляц	11.2%	8.8%	7.9%	7.4%	6.5%
Нэрлэсэн ДНБ өсөлт	16.2%	14.7%	14.3%	13.3%	11.8%
Тээврийн салбарын орлого	2,512	2,908	3,406	3,878	4,350

Эх сурвалж: ОУВС, Үндсэн андеррайтерийн тооцоолол

Дээрх төсөөллийн дагуу тээврийн салбарын орлого 2027 онд 4.3 их наяд төгрөгт хүрэхээр байна. Харин тээврийн тоо хэмжээний өсөлттэй уялдуулан төсөөлсөн тээврийн салбарын орлого 2027 онд 4.0 их наяд төгрөг байсан нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад консерватив (бууруулсан тооцоогоор) тооцсоныг илэрхийлж, биелэгдэх боломжтой гэж Үндсэн андеррайтерийн зүгээс үзэж байна.



3.7 Үнэт цаас гаргагчийн богино болон дунд хугацааны стратеги

Бизнесийн стратеги

Үнэт цаас гаргагч нь урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд бизнесийн чиглэл тус бүрт тохирсон стратегийг баримталдаг. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааг мөчлөгөөс хамааруулан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

График 51. Бизнесийн амьдралын мөчлөг



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Импортын тээврийн зах зээлд баримтлах стратеги

B2B зах зээл

Үнэт цаас гаргагчийн охин компаниудаас Монложистикс Ворлдвайд ХХК болон Монложистикс Экспресс ХХК нь импортын B2B тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Монложистикс Ворлдвайд ХХК нь импортын тээвэр ложистикийн зах зээлд 18 жилийн турш тогтвортой үйл ажиллагаа явуулж, үнэнч харилцагчдыг бий болгон, зах зээлд тэргүүлэх байр суурийг эзэлсэн.


Цаашид B2B импортын тээвэр ложистикийн зах зээл нь Монгол Улсын дэд бүтцийн хүчин чадлаас шалтгаалж богино хугацаанд өндөр өсөлт үзүүлэх боломжгүй тул тус зах зээлд эзлэх байр суурийг хадгалах стратегийг Үнэт цаас гаргагч нь баримтална.

Үүнд үнэнч харилцагчдыг тогтоон барих, шинэ харилцагчдыг татахад үнээр бус үйлчилгээгээр өрсөлдөж, ялгарах стратегийг баримтална. Тодруулбал, Монложистикс Ворлдвайд ХХК нь богино болон дунд хугацаанд дараа төлбөрт тээвэр ложистикийн үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний олон улсын ISO 9001:2015 стандартыг шинээр нэвтрүүлнэ.

B2C зах зээл

Үнэт цаас гаргагчийн охин компани Монложистикс Карго ХХК нь импортын B2C тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Тус зах зээл нь цахим худалдааны салбарын хурдацтай өсөлттэй холбоотойгоор богино хугацаанд өндөр өсөлт үзүүлэх боломжтой.





Монложистикс Карго ХХК нь 2021 онд үүсгэн байгуулагдсанаас хойш бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн, Sheerah.mn платформ нэвтрүүлэн бизнес мөчлөгийн нэвтрэлтийн үе шатад явж байна. Тус зах зээлд Үнэт цаас гаргагч нь тодорхой байр суурийг эзэлж тогтворжоогүй байгаа тул өсөлтийн стратеги баримтлан, оновчтой хөрөнгө оруулалт хийх замаар тээврийн зардлыг бууруулан, үнэ болон үйлчилгээгээр ялгарах стратегийг баримтлан 2025 онд зах зээлд тэргүүлэгч болгох зорилттой байна.

Экспортын тээврийн зах зээлд баримтлах стратеги

Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд экспортын тээврийн зах зээл богино хугацаанд өндөр өсөлт үзүүлэх төлөвтэй байна. Зах зээлийн нөхцөл байдал, экспортын тээвэр ложистикийн эрэлттэй уялдуулан Үнэт цаас гаргагч нь экспортын тээврийн зах зээлд өсөлтийн стратеги баримтална.

Богино болон дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь экспортын тээврийн зах зээлд голлох хөрөнгө оруулалт хийн, өөрийн эзэмшлийн дэд бүтцийг бий болгоно. Үнэт цаас гаргагч нь 18 жилийн хугацаанд бий болгосон БНХАУ-ын компаниудын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийн стратегийн хэрэгжилтийг хангана.

Транзит тээврийн зах зээлд баримтлах стратеги

Транзит тээврийн зах зээлийн тэлэх боломж нь Монгол Улсын дэд бүтцийн хүчин чадлаас шууд хамааралтай. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар транзит тээврийн дэд бүтцийн хүчин чадлын ашиглалт тулсан, 2025 он хүртэл огцом өсөлт үзүүлэх боломж хязгаарлагдмал байна.


Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн охин компани Монложистикс Транзит ХХК-ийн үйл ажиллагаа болон зах зээлд эзлэх байр суурь тогтворжсон. Богино болон дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь транзит тээврийн зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх стратегийг баримтална. Тус компани нь ОХУ-ын Транс Сервис ХХК-тай хамтарсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх, үйлчилгээний чанар стандартыг олон улсын түвшинд хүргэхээр төлөвлөж байна.

Бусад тээврийн зах зээлд баримтлах стратеги

Бусад тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй Монложистикс Транс Сервис ХХК болон Монложистикс Тракинг ХХК нь үүсгэн байгуулагдаад удаагүй бөгөөд нэвтрэх үе шатад явж байна.

Тус компаниудын үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн өсөлт тогтворжсон тул богино болон дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь өөрийн онцлог, давуу талд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, зах зээлд тодорхой байр суурь эзлэхээр зорин ажиллаж байна. Тодруулбал, Монложистикс Тракинг ХХК нь илүү холын зайны, олон улсын авто тээврийн зах зээлд төвлөрч ажиллах бол Монложистикс Транс Сервис ХХК нь ОХУ болон БНХАУ-ын тээврийн сувгийг хөгжүүлнэ.

Тээвэр ложистикийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ, Монгол Улсын урт хугацааны бодлоготой уялдуулан Үнэт цаас гаргагчийн охин компаниудын уялдаа холбоог сайжруулах, ложистикийн эко системийг зорилгоор Монложистикс Экүйпментс, Монложистикс Экспресс компаниудыг үүсгэн байгуулсан бөгөөд одоогоор үйл ажиллагаа нь эхлэх үе шатанд явж байна.



Үйл ажиллагааны стратеги

Үнэт цаас гаргагч нь урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах хүрээнд дараах үйл ажиллагааны стратегийг баримтална. Үүнд:

Технологид суурилах

Тээвэр ложистикийн салбар нь бусад салбарын адил орчин үеийн технологийн шийдэлтэй уялдан, өрсөлдөөний давуу талыг бий болгож байна. Иймд Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд технологид суурилсан тээвэр ложистикийн компани болох стратегитай ажиллаж байна.

Дотоод үйл ажиллагаанд технологийн шийдлийг нэвтрүүлж, бүтээмжийг сайжруулна

Үнэт цаас гаргагч нь 2016 оноос эхлэн өдөр тутмын үйл ажиллагаанд өөрийн дотоодод хөгжүүлсэн TMS тээврийн менежментийн системийг нэвтрүүлсэн. Энэхүү систем нь компанийн бусад дотоод системтэй холбогдон ажилладаг. Тус систем нь ажилтнуудад тээврийн үйл ажиллагааг бүхэлд нь удирдах, хянах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг хэмжих боломжийг олгохоос гадна ажилтнуудын KPI гүйцэтгэл, бүтээмжийг хэмжигдгээрээ онцлогтой.

Үнэт цаас гаргагч нь технологид суурилан бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 2021 оноос TMS-ийг улам боловсронгуй болгон шинэчилсэн дотоод систем болох LMS-ийг хөгжүүлж буй бөгөөд 2023 оны 3 дугаар улиралд тус системийг нэвтрүүлэхээр хүлээгдэж байна.

Тус систем нэвтэрч, CRM системтэй холбогдсоноор харилцагч төвтэй үйлчилгээ үзүүлэх, цаашлаад охин компаниудын уялдаа холбоо сайжрах нөхцөл бүрдэнэ.

Байгууллагын харилцагчдад зориулсан технологийн системийг хөгжүүлнэ

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар TMS тээврийн менежментийн систем нь ажилтан төвтэй буюу ажилтнуудын бүтээмж, процессийг сайжруулахад чиглэн нэг төвтэй ажиллаж байна. Дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь тус системийг харилцагч төвтэй болгон сайжруулж, харилцагчдад тээвэр ложистикийн цогц мэдээлэл, үйлчилгээг бодит горимд, онлайнгаар хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.

Тээвэр ложистикийн үйл ажиллагааг автоматжуулна

Хиймэл оюун ухаанд суурилан тээвэр ложистикийн процессийг хэсэгчлэн автоматжуулах бүрэн боломжтой болсон. Үнэт цаас гаргагч нь бизнес процесс автоматжуулалтын судалгааг хийж эхэлсэн ба 2024 оноос хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийг хийхээр төлөвлөж байна. Эхний үе шатад Үнэт цаас гаргагч нь үнэ тооцооллын процессийг бүрэн автоматжуулна.


Дэд бүтцэд хөрөнгө оруулах

Тээвэр ложистикийн бизнесийн тасралтгүй байдал нь дэд бүтцийн хүчин чадал, ашиглалтаас шууд хамааралтай оршдог. Иймд Үнэт цаас гаргагч нь бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний давуу талыг бий болгох зорилгоор богино болон дунд хугацаанд дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийж, олон улсын зах зээлд нэвтэрнэ.

Олон улсын зах зээлд нэвтэрнэ

Үнэт цаас гаргагч нь Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд **monlogistics** зорилгын хүрээнд дотоодын зах зээлд манлайлахаас гадна олон улсын зах зээлд тэлж өргөжин, Ази Европыг холбосон тээвэр ложистикийн





компани болохоор зорьж байна. Тус зорилгын хүрээнд Үнэт цаас гаргагч нь 2021 онд Монложистикс Россия Холдинг ХХК-ийг үүсгэн байгуулж, ОХУ-д болон ОХУ-с бусад улс хоорондын тээвэр ложистикийн үйлчилгээг үзүүлж байна.

Богино болон дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь БНХАУ дахь өөрийн тээвэр ложистикийн компанийг үүсгэн байгуулж, БНХАУ-с бусад улс хоорондын тээвэр ложистикийн үйлчилгээг үзүүлж, бизнесийн цар хүрээг тэлэхээр төлөвлөж байна.

Хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийнэ

Үнэт цаас гаргагч нь хөдлөх бүрэлдэхүүн буюу вагон, чингэлэг, авто машин, онгоц зэргийг гадаад болон дотоодын түнш байгууллагуудаас түрээслэн тээврийн үйлчилгээг үзүүлж байна.

Экспортын тээврийн бизнесийн өсөлтийн стратегийн хүрээнд Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүн худалдан авч, гуравдагч талд төлөх түрээсийн төлбөр болон үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахаар төлөвлөж байна.

Терминалын дэд бүтэц байгуулна

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 14 гаалийн терминал үйл ажиллагаа явуулж байгаагаас Үнэт цаас гаргагч нь бүх терминалтай хамтран ажиллах гэрээ байгуулан түрээсэлдэг. Энэ нь тус терминалын дэд бүтцүүд дотоод болон гадаад хүчин зүйлийн улмаас доголдох тохиолдолд Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд шууд эрсдэл үүсгэж байна.

Үнэт цаас гаргагч нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээг үзүүлэн, тус зах зээлд төвлөрсөн тэргүүлэгч байгууллага болохын хувьд өөрийн эзэмшлийн дэд бүтцийг буюу терминалыг бий болгон, бизнесийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахаар төлөвлөж байна.

Байгаль орчин, нийгэм, загсаглалын хөгжил


Үнэт цаас гаргагч нь урт хугацааны тогтвортой хөгжлийг компанийн сайн засаглал, мэргэшсэн баг хамт олон бүрдүүлнэ гэж үздэг. Иймд Үнэт цаас гаргагч нь богино болон дунд хугацаанд компанийн сайн засаглалыг төгөлдөршүүлэх, тээвэр ложистикийн салбар бүрт мэргэшсэн баг хамт олныг бүрдүүлнэ.

Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангана

2021 оноос эхлэн Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн тогтвортой байдлын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь тогтвортой хөгжлийг хангах хүрээнд Түлхүүр ажилтны опцион хөтөлбөр (Key Employee Stock Option), Бүх ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг (Employee Stock Ownership Program) хэрэгжүүлнэ.

Компанийн сайн засаглалыг нэвтрүүлнэ


Нээлттэй ил, тод засаглалтай байх нь компанийг урт хугацаанд оршин тогтноход чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор засаглалын хөгжлийн ажлууд болон сонгодог практикуудыг үйл ажиллагаанд нэвтрүүлээд зогсохгүй, энэхүү бодлогыг байгаль орчин нийгэмтэй уялдуулан ажиллахаар төлөвлөж байна.



3.8 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь

Үнэт цаасны танилцуулгын 3.5 дахь хэсэгт тусгагдсан зах зээлийн нөхцөл байдалд суурилахад Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй тээврийн салбарын орлого 2022 онд 2.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж буйгаас Үнэт цаас гаргагч нь зах зээлийн 6.9 хувийг эзэлж байна.

График 52. Монложистикс Группийн зах зээлд эзлэх хувь, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: УСХ, Үндсэн андеррайтерийн тооцоолол

Үнэт цаасны танилцуулгын 3.6 дахь хэсэгт тусгагдсан зах зээлийн төсөөллийн дагуу 2027 онд тээврийн салбарын орлого 3.9 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Үүнд Үнэт цаас гаргагч нь 3.7 дахь хэсэгт тусгагдсан богино болон дунд хугацааны бодлого, стратегийг хэрэгжүүлснээр 2027 онд 428.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллан, зах зээлийн 10.8 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.

Тээвэр ложистикийн зах зээлийг импорт, экспорт, транзит тээврийн төрөл бүрээр нарийвчлан Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурийг ачаа тээврийн тоо хэмжээнд суурилан тодорхойлбол дараах байдалтай байна. Үүнд :

Хүснэгт 33. Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь, тээврийн төрлөөр

Тээврийн төрөл	Нийт тээврийн хэмжээ, сая тонн		Үнэт цаас гаргагчийн эзлэх хувь	
	2022	2027	2022	2027
Импортын тээвэр	5.0	6.7	2.1%	2.9%
Импортын чингэлэг тээвэр	1.0	1.4	10.1%	13.8%
Экспортын тээвэр	40.6	62.8	0.2%	0.6%
Нүүрсний экспортын тээвэр	31.8	40.3	0.2%	1.0%
Транзит тээвэр	3.2	7.8	6.4%	6.8%

Эх сурвалж: Үндсэн андеррайтер, Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Импортын тээвэр

2022 онд Монгол Улсын хэмжээнд 4.9 сая тонн импортын ачаа тээвэрлэгдсэнээс Үнэт цаас гаргагч нь 11,148 ширхэг тээвэр бүхий нийт 104 мянган тонн импортын ачааг тээвэрлэсэн байна. Энэ нь нийт импортын тээврийн зах зээлийн 2.1 хувийг эзэлж байна. 2027 онд Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн зах зээлд эзлэх байр суурь 2.9 хувьд хүрэх төлөвтэй байна.

Үнэт цаас гаргагч нь импортыг чингэлэг тээврээр зохион байгуулдаг тул тус зах зээлд эзлэх хувь хэмжээг дараах байдлаар тодорхойлов.

Чингэлэг тээвэр нь 2022 онд нийт импортын тээврийн 20.7 хувийг бүрдүүлж байна. Цаашид тус хувь хэмжээгээр нийт импортын зах зээлд эзлэх чингэлэг тээврийн зах зээлийг дараах байдлаар төсөөлөв.

График 53. Чингэлэг тээврийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь 2022 онд импортын чингэлэг тээврийн зах зээлийн 10.1 хувийг эзэлж буй бол 2027 онд 13.8 хувийг бүрдүүлэхээр байна.

Экспортын тээвэр


2022 онд Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн охин компани нь 2,201 ширхэг тээвэр бүхий 67.0 мянган тонн нүүрсний экспортыг тээвэрлэсэн бөгөөд энэ нь нийт экспортын тээврийн 0.2 хувийг эзэлж байна. Үнэт цаас гаргагч нь 2027 онд нийт 402 мянган тонн нүүрс тээвэрлэхээр төлөвлөсөн. Энэ нь нийт экспортын тээврийн 0.6 хувийг бүрдүүлэхээр байна.

Үнэт цаас гаргагч нь зөвхөн нүүрсний экспортын тээврийг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байгаа тул тус зах зээлд эзлэх хувийг дараах байдлаар тодорхойлов.

Үнэт цаас гаргагч нь 2022 оны байдлаар нүүрсний экспортын тээврийн зах зээлд 0.2 хувийг эзэлж байгаа бол 2027 онд 1.0 хувийг эзлэх төлөвтэй байна.



График 54. Нүүрсний экспортын тээврийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Транзит тээвэр

2022 онд Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн охин компани нь нийт 11,354 ширхэг тээвэр бүхий 202.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн. Энэ нь нийт транзит тээврийн зах зээлийн 6.4 хувийг эзэлж байна. 2027 онд Үнэт цаас гаргагч нь 437.7 мянган тонн транзит ачааг тээвэрлэж нийт транзит тээврийн зах зээлийн 6.8 хувийг эзлэхээр байна.

График 55. Транзит тээврийн хэмжээ, сая тонноор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл



3.9 Санхүүгийн төлөвлөгөө

Орлогын тайлангийн төсөөлөл (нэгтгэсэн байдлаар)

Хуулийн этгээдийн хувьд Монложистикс Холдинг ХХК буюу Монложистикс Группийн толгой компани нь Үнэт цаас гаргагч боловч санхүүгийн тайлагналын хувьд Монложистикс Группийн толгой болон 9 охин компаниудыг нэгтгэсэн байдлаар Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд тодорхойлогддог.

Иймд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөллийг толгой болон охин компани тус бүрийн орлогын тайланг төсөөлж нэгтгэсэн дүнгээс компани хоорондын ажил гүйлгээг хасч цэвэрлэсэн дүнгээр боловсруулсан.


Хүснэгт 34. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	2022	2023T	2024T	2025T	2026T	2027T
Борлуулалтын орлого	140,122	215,507	273,462	350,349	393,189	428,617
Борлуулалтын өртөг	(123,260)	(187,603)	(231,160)	(299,182)	(334,870)	(365,646)
Нийт ашиг	16,862	27,904	42,302	51,167	58,318	62,971
Ерөнхий ба удирдлагын зардал	(5,440)	(8,743)	(10,043)	(11,834)	(13,653)	(15,791)
Борлуулалт маркетингийн зардал	(804)	(1,007)	(1,033)	(1,117)	(1,199)	(1,288)
Үйл ажиллагааны бусад орлого (зардал)	(281)	(1,472)	(1,563)	(1,732)	(1,947)	(2,198)
Үйл ажиллагааны ашиг	10,337	16,682	29,663	36,484	41,520	43,694
Үйл ажиллагааны бус орлого (зарлага)	1,398	582	(86)	(88)	-	-
Хүү, татвар, элэгдлийн өмнөх ашиг	11,735	17,264	29,577	36,397	41,520	43,694
Элэгдлийн зардал	-	(876)	(1,866)	(1,871)	(1,927)	(1,973)
Хүү, татварын өмнөх зардал	11,735	16,388	27,710	34,525	39,593	41,721
Хүүгийн зардал	(385)	(1,757)	(2,850)	(2,294)	(1,738)	(1,182)
Татвар төлөхийн өмнөх ашиг	11,350	14,631	24,860	32,231	37,855	40,540
Орлогын татварын зардал	(1,659)	(2,179)	(3,876)	(5,410)	(6,617)	(7,025)
Татварын дараах ашиг	9,691	12,452	20,984	26,821	31,238	33,515
Толгой компанид ногдох	8,375	9,417	16,813	20,953	24,776	26,939
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	1,317	3,035	2,693	3,086	2,942	2,787


Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл



Борлуулалтын орлого



Санхүүгийн тайлангийн шинжилгээнд дурдсанчлан Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 1) нийт тээврийн тоо ширхэг 2) нэгж тээврийн үнэ 3) валютын ханшаас хамааралтай.



Тээврийн тоо, ширхэг

2022 онд Үнэт цаас гаргагч нь 25,707 ширхэг тээвэр хийж гүйцэтгэсэн. 2023 онд 1) төмөр замын шинэ бүтээн байгуулалтууд ашиглалтад орж, тээврийн дэд бүтцийн хүчин чадал нэмэгдэх 2) Үнэт цаас гаргагч нь хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулах зэрэгтэй уялдан нийт тээврийн тоо, ширхэг өмнөх онтой харьцуулахад 44.6 хувиар өсөж, 2027 он хүртэл жилд дунджаар 18.1 хувиар өсөхөөр төлөвлөсөн. Энэ нь 2013-2022 оны тээврийн дундаж тоо ширхэгийн жилийн дундаж өсөлт болох 27.8 хувьтай харьцуулахад бага юм.

Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд 2025 онд төмөр замын зүүн корридор ашиглалтад орсноор Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн тоо ширхэг нэмэгдэх хүлээлттэй байна. Улмаар 2027 онд Үнэт цаас гаргагч нь 59,116 тээвэр зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

График 56. Тээврийн тоо төсөөлөл, ширхэгээр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Тээврийн дундаж үнэ

Үнэт цаас гаргагч нь тээврийн төрөл тус бүрт ялгаатай үнийн бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд доорх графикт ам.доллароор илэрхийлэгдсэн нэгж тээврийн дундаж үнийг харуулав.



График 57. Тээврийн дундаж үнийн төсөөлөл, ам. доллароор



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр үүссэн хил гаалийн хориг саад, ачааллын улмаас тээврийн эргэлт удааширч, улмаар нэгж тээврийн дундаж үнэ дэлхийн дахинд өсөж, 2022 онд Үнэт цаас гаргагчийн нэгж тээврийн дундаж үнэ 1,731 ам.долларт хүрсэн.

2023 онд хил гаалийн үйл ажиллагаа хэвийн төлөвт шилжин, тээврийн эргэлт сайжирснаар Үнэт цаас гаргагчийн нэгж тээврийн дундаж үнийг өмнөх онтой харьцуулахад 7 хувиар буурч, 1,610 ам.долларт хүрнэ гэж төсөөлсөн.

2024 онд нэгж тээврийн дундаж үнэ транзит тээврийн үнэтэй шууд хамааралтайгаар өөрчлөгдөж буй бол тус хугацаанаас хойш жилд дунджаар 1 хувиар өсөхөөр тооцсон.

Валютын ханшийн төсөөлөл

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3,484 байна. Энэ нь өмнөх оны ам.долларын дундаж ханштай харьцуулахад 10.7 хувиар өссөн үзүүлэлт юм.

2023 оны төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг Олон улсын валютын сангийн шинжээчдийн төсөөллийн дагуу 3,602-д хүрэхээр тооцсон. 2024-2027 оны төсөөллийг Дэлхийн банкны шинжээчдийн судалгааны дагуу тооцсон.


График 58. Төгрөгийн ам доллартой харьцах ханшийн төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын өсөлтийг дээр дурдсан 3 хүчин зүйлсээр задлан харуулбал дараах байдалтай байна. Тодруулбал, 2023 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 51.9 хувиар өсөж, 215.5 тэрбум төгрөгт хүрэхээр хүлээгдэж байна. Үүнд тээврийн тоо ширхэг 45 хувиар, тээврийн дундаж үнэ -9 хувиар, ам.долларын ханш 15 хувиар өссөн нь тус тус нөлөөлж байна.

График 59. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөлөл ба түүний өсөлтийн хувь, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл


Улмаар 2023-2027 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого жилд дунджаар 25.1 хувиар өсөж, 2027 онд 428.6 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2020-2022 оны жилийн дундаж өсөлт болох 51.1 хувьтай харьцуулахад бага юм.

Борлуулалтын өртөг болон үйл ажиллагааны зардал

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөг борлуулалтын орлогын 88 хувьтай тэнцэж байна. Үнэт цаас гаргагч нь 2023 оноос ашгийн маржин өндөртэй экспортын тээврийн борлуулалтыг нэмэгдүүлж, хөдлөх бүрэлдэхүүн худалдан авснаар гуравдагч байгууллагад төлж буй вагоны түрээсийн зардал буурч, улмаар 2024-2027 онд борлуулалтын өртгийн борлуулалтын орлогод эзлэх хувь 3 нэгж хувиар буурахаар хүлээгдэж байна. Улмаар Үнэт цаас гаргагч нь 2023 онд 13 хувь, 2024-2027 онд 16 хувийн нийт ашгийн маржинтай ажиллах төлөвтэй байна.



График 60. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөгийн төсөөлөл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл


2022 оны байдлаар үйл ажиллагааны зардал борлуулалтын орлогын 3.9 хувьтай тэнцэж байна. 2023-2027 онд тус хувь хэмжээг дунджаар 4.1 хувийн түвшинд төсөөлсөн. 2024 онд борлуулалтын өртөгийн борлуулалтад эзлэх хувь 3 нэгж хувиар буурахаар төсөөлсөн нь хөдлөх бүрэлдэхүүн буюу вагон түрээсийн зардал буурахтай холбоотой.

Үнэт цаас гаргагч нь 2023 онд 2 цуваа буюу 100 ширхэг вагон худалдан авахаар төлөвлөж буй бөгөөд тус хөрөнгө оруулалтын 31 хувийг нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр, үлдсэн 69 хувийг санхүүгийн түрээсээр санхүүжүүлэхээр төсөөлсөн. Үйл ажиллагааны бусад орлого, зардлыг түүхэн дундаж түвшинд төсөөлсөн.

Татварын дараах ашиг

2022 онд Үнэт цаас гаргагч нь 9.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Төсөөллийн хугацаанд буюу 2023-2027 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг жилд дунджаар 28.1 хувиар өсөж, 2027 онд 33.5 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөж байна.

График 61. Татварын дараах цэвэр ашиг, сая төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл



2023-06-14

БҮРТГЭВ-03


Орлогын тайлангийн төсөөлөл (бизнесийн чиглэл бүрээр)

Үнэт цаас гаргагчийн бизнесийн чиглэл тус бүрээр дэлгэрүүлсэн орлогын тайлангийн шинжилгээг доорх хэсэгт харуулав.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт борлуулалтын орлогын 75.1 хувийг импортын тээвэр, 15.2 хувийг транзит тээвэр, 5.0 хувийг экспортын тээвэр, 4.6 хувийг бусад тээврийн орлого бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд экспортын тээврийн бизнес өргөжсөнөөр 2027 онд борлуулалтын орлогын 68 хувийг импортын тээвэр, 8 хувийг транзит тээвэр, 19 хувийг экспортын тээвэр, 5 хувийг бусад тээвэр бүрдүүлэх төлөвтэй байна.

График 62. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын төсөөлөл, тээврийн төрлөөр, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Импортын тээвэр

Үнэт цаас гаргагч нт үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш борлуулалтын орлогын дийлэнх хувийг импортын тээврийн Монложистикс Ворлдвайд ХХК бүрдүүлж ирсэн. Дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь Sheeran брэндийг хөгжүүлэн Монложистикс Карго ХХК-ийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлж, улмаар импортын тээвэр ложистикийн B2B болон B2C зах зээлд тэргүүлэгч болох төлөвлөгөөтэй байна.

График 63. Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

СЭХ
БҮРТГЭВ
№ 03

2022 онд Үнэт цаас гаргагч нь импортын тээврийн хүрээнд 106.5 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан. 2023-2027 онд импортын тээврийн борлуулалтын орлого жилд дунджаар 23.6 хувиар өсөж, 2027 онд 307.2 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Үүнд Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн тоо, ширхэгийг жилд дунджаар 15.0 хувиар (2020-2022 оны дундаж өсөлт 46.2 хувь), нэгж тээврийн дундаж үнийг жилд дунджаар 2 хувиар (2020-2022 оны дундаж өсөлт 5.3 хувь), ам.долларын ханшийг жилд дунджаар 6 хувиар (2020-2022 оны дундаж өсөлт 5.8 хувь) өсөхөөр тооцсон.

Улмаар 2027 онд Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн борлуулалтын орлого нийт борлуулалтын орлогын 68 хувийг, нийт цэвэр ашгийн 59 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.

Транзит тээвэр

Нэг талаас Монгол Улсын газар зүйн байршил ОХУ, БНХАУ-ын дунд орших Ази-Европыг холбосон байршилтай учраас транзит тээврийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа, нөгөө талаас Монгол Улсын Засгийн Газраас баталсан Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд дунд хугацаанд транзит тээврийн дэд бүтэц тэлж, хүчин чадал нэмэгдэж буйтай холбогдуулан Үнэт цаас гаргагчийн транзит тээвэр ложистикийн үйл ажиллагаа тэлэх төлөвтэй байна.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 01-р сард ОХУ-ын хамгийн том чингэлэг тээврийн компани болох Транс Контейнер ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит тээврийг хариуцан ажиллаж эхэлсэн.

График 64. Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

2022 онд Үнэт цаас гаргагч нь транзит тээврийн хүрээнд 21.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан. Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн борлуулалтын орлогыг 2025 онд төмөр замын зүүн корридор ашиглалтад орохтой холбогдуулан 30 хувиар өсгөхөөр төлөвлөсөн. 2026-2027 транзит тээврийн орлогыг Дэлхийн банкнаас гаргасан Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны өсөлт болох 5 хувиар өсөхөөр төсөөлсөн.

2023-2027 онд транзит тээврийн борлуулалтын орлого жилд дунджаар 12 хувиар өсөж, 2027 онд 38 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Үүнд Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн тоо, ширхэгийг жилд дунджаар 13.6 хувиар өсөхөөр (2020-2022 оны дундаж өсөлт -18.9), нэгж тээврийн дундаж

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MANDAL CAPITAL
ШТХД-ийн 2023-10-14 521342

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХК
monlogistics
HOLDING
ATA5299 6311251
902103100


үнийг жилд дунджаар 7 хувиар буурахаар (2020-2022 оны дундаж өсөлт 15.1 хувь), ам.долларын ханшийг жилд дунджаар 6 хувиар (2020-2022 оны дундаж өсөлт 5.8 хувь) өсөхөөр тооцсон.

Улмаар 2027 онд Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн борлуулалтын орлого нийт борлуулалтын орлогын 9 хувийг, нийт цэвэр ашгийн 6 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.

Экспортын тээвэр

Үнэт цаас гаргагчид богино болон дунд хугацааны өсөлтийг бий болгох гол бизнесийн чиглэл нь экспортын тээврийн бизнес юм. Үнэт цаас гаргагч нь 2023 онд экспортын тээвэр ложистикийн үйл ажиллагаанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр тээврийн тоо ширхэгийг нэмэгдүүлж, зах зээлд эзлэх байр суурийг тэлэх төлөвлөгөөтэй байна.

График 65. Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн орлогын төсөөлөл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

2022 онд Үнэт цаас гаргагч нь 20 цуваа вагон буюу 67.0 мянган тонн нүүрс тээврийг зохион байгуулсан. 2023 онд Үнэт цаас гаргагч нь 191 мянган тонн нүүрс тээвэрлэхээр төлөвлөж байна. Энэ нь дараах хүчин зүйлст үндэслэсэн:

- 2022 онд үүсгэн байгуулагдсанаас хойш 6 сарын хугацаанд нүүрс тээврийн үйл ажиллагааг зохион байгуулахад 7.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. 2023 онд өмнөх жилийн түвшинд тээвэрлэлт хийхэд тээврийн тоо ширхэг хамгийн багадаа 2 дахин өсөх боломжтой.
- Гашуунсухайт болон Ханги Мандал боомтуудаар 2023 оноос эхлэн төмөр замын экспортын тээвэр хийгдэж эхэлснээр борлуулалтын орлого нэмэгдэнэ. Нүүрсний экспортын тээврийн эрэлтийг Үнэт цаасны танилцуулгын 3.6 дахь хэсэгт тусгасан.
- Нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө болон санхүүгийн түрээсээр 2 цуваа буюу 100 ширхэг вагон худалдан авснаар хөдлөх бүрэлдэхүүний хүчин чадал нэмэгдэж, тээврийн эргэлт сайжирна.

2023-2027 онд экспортын тээврийн борлуулалтын орлого жилд дунджаар 157 хувиар өсөж, 2027 онд 68 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.



Үүнд Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн тоо, ширхэгийг жилд дунджаар 43.1 хувиар, нэгж тээврийн дундаж үнийг жилд дунджаар 3.5 хувиар, ам.долларын ханшийг жилд дунджаар 6 хувиар өсөхөөр тооцсон.

Улмаар 2027 онд Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн орлого нийт борлуулалтын орлогын 16 хувийг, нийт цэвэр ашгийн 30 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.

Бусад тээвэр

Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн орлогыг авто тээврийн үйл ажиллагаа болон ОХУ дахь тээврийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд бүрдүүлдэг.

График 66. Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

2022 онд Үнэт цаас гаргагч нь бусад тээврийн хүрээнд 4.9 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан. 2023-2027 онд бусад тээврийн борлуулалтын орлого жилд дунджаар 26 хувиар өсөж, 2027 онд 15.4 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Үүнд Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн тоо, ширхэгийг жилд дунджаар 32.4 хувиар өсөхөөр, нэгж тээврийн дундаж үнийг жилд дунджаар 10.1 хувиар буурахаар, ам.долларын ханшийг жилд дунджаар 6 хувиар өсөхөөр тооцсон.

Улмаар 2027 онд Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн борлуулалтын орлого нийт борлуулалтын орлогын 4 хувийг, нийт цэвэр ашгийн 5 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.



Санхүү байдлын тайлангийн төсөөлөл (нэгтгэсэн байдлаар)

2023 -00- 11

Хүснэгт 35. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	2022	2023T	2024T	2025T	2026T	2027T
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,198	26,289	45,422	70,678	98,650	128,129
Дансны авлага болон бусад	19,607	19,123	20,220	21,906	24,499	26,655
Урьдчилж төлсөн зардал	5,662	7,945	11,194	16,169	17,516	18,616
Эргэлтийн хөрөнгийн дүн	39,467	53,358	76,835	108,752	140,665	173,401
Үндсэн хөрөнгө	1,153	28,418	27,374	26,264	25,272	24,410
Биет бус хөрөнгө	133	153	388	488	488	488
Бусад хөрөнгө	1,086	-	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,372	28,571	27,762	26,752	25,760	24,898
Нийт хөрөнгийн дүн	41,839	81,929	104,598	135,504	166,425	198,299
Дансны өглөг	11,399	13,358	14,648	17,176	18,062	19,147
Богино хугацаат зээл	2,800					
Урьдчилж орсон орлого	1,558	4,531	7,652	11,936	13,455	13,455
Бусад өглөг	1,005					
Богино хугацаат өр төлбөрийн дүн	16,762	17,889	22,300	29,112	31,517	32,602
Урт хугацаат зээл	17	15,778	13,052	10,325	7,599	4,873
Бусад өр төлбөр	193					
Урт хугацаат өр төлбөрийн дүн	210	15,778	13,052	10,325	7,599	4,873
Энгийн хувьцаа	106	124	124	124	124	124
Халаасны хувьцаа	(3,001)	-	-	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	2,234	13,185	13,185	13,185	13,185	13,185
Бусад	(139)	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	23,723	30,116	47,174	68,703	94,407	122,107
Хяналтын эрхгүй өмчийн дүн	1,944	4,837	8,763	14,054	19,593	25,408
Эздийн өмчийн дүн	24,867	48,262	69,246	96,067	127,309	160,824
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	41,839	81,929	104,598	135,504	166,425	198,299


Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2023 онд өмнөх онтой харьцуулахад 39.5 тэрбум төгрөгөөр өсөж, 81.9 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Үүнд нийт хөрөнгийг 35 хувийг эргэлтийн бус хөрөнгө, 33 хувийг эргэлтийн хөрөнгө, 23 хувийг мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө, үлдсэн хувийг бусад хөрөнгүүд эзэлж байна.



График 67. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 2.4 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй, хөдлөх бүрэлдэхүүнийг дотоодын болон гадаадын гуравдагч байгууллагаас түрээслэж байна. Үнэт цаас гаргагч нь нийтэд анх удаа хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлэх хөрөнгө болон санхүүгийн түрээсээр 2 цуваа буюу 100 ширхэг вагон худалдан авснаар 2023 онд Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгө 28.6 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Тээвэр ложистикийн салбар нь авлага, эргэцийн өндөр буюу эргэлтийн хөрөнгийн эргэц өндөр байдгаараа онцлогтой. Тус зах зээлд Үнэт цаас гаргагч нь өрсөлдөөний давуу талыг бий болгох зорилгоор харилцагчдад дараа төлбөрт нөхцөлөөр тээврийн үйл ажиллагаа үзүүлдэг нь авлагыг үүсгэдэг. 2027 онд Үнэт цаас гаргагчийн авлагын хэмжээ 26.6 тэрбум төгрөгт, урьдчилж төлсөн зардал 18.6 тэрбум төгрөгт, улмаар нийт хөрөнгө 198.2 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

2020-2022 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө жилд дунджаар 28 хувиар өссөн бол хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр төсөөллийн хугацаанд буюу 2023-2027 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө жилд дунджаар 36 хувиар өсөхөөр хүлээгдэж байна.

Эх үүсвэр

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт хөрөнгийн 40.5 хувийг өр төлбөр, 59.4 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. 2023 онд Үнэт цаас гаргагч нь 23.2 тэрбум төгрөгөөр хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулах буюу 100 ширхэг вагон худалдан авна. Үүнээс 65 хувь буюу 15.7 тэрбум төгрөгийг арилжааны банкны санхүүгийн түрээсээр, 35 хувь буюу 8.5 тэрбум төгрөгийг нийтэд анх удаа хувьцаа санал болгох замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэхээр төсөөлсөн.


Санхүүгийн түрээсийн өр төлбөрөөс жилд 2 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт төлж барагдуулна. Улмаар 2023 онд Үнэт цаас гаргагч нь нийт хөрөнгийн 42 хувийг өр төлбөр, 58 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр байна. Дунд хугацаанд Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирснаар 2027 онд нийт хөрөнгийн 19 хувийг өр төлбөр, 81 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төлөвтэй байна.



График 68. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр



2023-06-14
БҮРТГЭВ-03



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

2022 онд Үнэт цаас гаргагчийн эздийн өмч 24.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж буйгаас 1.9 тэрбум төгрөг нь хяналтын эрхгүй оролцоонд, 23.0 тэрбум төгрөг нь толгой компанид буюу Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдож байна.

График 69. Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн бүтэц, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь 2023 онд нийтэд анх удаа хувьцаа санал болгосноор хувьцаат капиталыг 10 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ. Улмаар тайлант хугацаанд эздийн өмчийн хэмжээ 48.0 тэрбум төгрөгт хүрэхээс хяналтын эрхгүй оролцоонд 4.8 тэрбум төгрөг, толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд 43.2 тэрбум төгрөгийн эздийн өмч ногдож байна.

2027 онд эздийн өмч 160.8 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдөж буйгаас 25.4 тэрбум төгрөг буюу 15.8 хувь нь хяналтын эрхгүй оролцоонд, 145.4 тэрбум төгрөг буюу 84.2 хувь нь толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдож байна.



Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл

Хүснэгт 36. Мөнгөн урсгалын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

2023-06-14

-03

Үзүүлэлт	2022	2023T	2024T	2025T	2026T	2027T
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	9,382	15,112	22,917	28,843	31,628	33,316
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,232)	(26,972)	(1,058)	(861)	(935)	(1,111)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	232	23,950	-2,726	-2,726	-2,721	-2,726
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,382	12,091	19,133	25,256	27,972	29,479
Мөнгөний эхний үлдэгдэл	5,815	14,198	26,289	45,422	70,678	98,650
Мөнгөний эцсийн үлдэгдэл	14,198	26,289	45,422	70,678	98,650	128,129

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн төсөөлөл

2023 онд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ эерэг дүнтэй байгаа бол хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ хасах дүнтэй байна.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийснээр 27 тэрбум төгрөгийн сөрөг мөнгөн гүйлгээ гарсан. Харин 15.2 тэрбум төгрөгийн санхүүгийн лизинг авах, 10 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлэх, 2.8 тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг барагдуулахтай холбоотой нийт 24 тэрбум төгрөгийн санхүүжилтийн цэвэр мөнгөн гүйлгээ гарахаар төлөвлөгдсөн байна. Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр болон өр төлбөрөө төлөх бүрэн чадамжтай байна.



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



ДӨРӨВ.

**ҮНЭТ ЦААСНЫ
ТУХАЙ**

2023-06-14

БҮРТГЭВ-03

4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ



4.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч Монложистикс Холдинг ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04-р сарын 10-ны өдрийн 23/ХЭХ/13 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03-р сарын 17-ны өдрийн 23/ТУЗ/10/01 тогтоолыг үндэслэн олон нийтэд санал болгосны дараах нийт хувьцааны 15 хувь буюу 59,378,822 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анх удаа нийтэд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 37. Нийтэд санал болгох үнэт цаасны тухай


Үнэт цаас гаргагч	Монложистикс Холдинг ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо ширхэг	336,480,000
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	59,378,822
Нийтэд санал болгох хувь	15%
Үүнээс:	
Стратегийн хөрөнгө оруулагчдад	70% буюу 41,565,175 ширхэг
Олон нийтэд	30% буюу 17,813,647 ширхэг
Нийтэд санал болгох үнэ	185 төгрөг
Татан төвлөрүүлэх дүн	10,985,082,070 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга
Үнэт цаасны бүртгэл	Монголын хөрөнгийн биржийн I ангилал

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

4.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 0.3 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 336,480,000 ширхэг зарласан бөгөөд гаргасан хувьцаатай байна. Үнэт цаас гаргагч нь нэмж 59,378,822 ширхэг энгийн хувьцаа буюу нийтэд санал болгосны дараах хувь эзэмшлийн 15.0 хувьтай тэнцэх энгийн хувьцааг нийтэд нээлттэй санал болгон арилжаална.

Үнэт цаас гаргагч нь хувьцаа нэмж гарган, нийтэд санал болгон арилжаалсны дараа доорх хувьцаа эзэмшлийн бүтэцтэй болно. Үүнд:



Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь
Л.Ганзоригт	110,520,000	32.85%	110,520,000	27.92%
Б.Тэлэнгэд	110,520,000	32.85%	110,520,000	27.92%
Г.Хишигбат	31,560,000	9.38%	31,560,000	7.97%
А.Одгэрэл	31,560,000	9.38%	31,560,000	7.97%
Л.Эрдэнэсоёл	15,000,000	4.46%	15,000,000	3.79%
Н.Алтанзул	15,000,000	4.46%	15,000,000	3.79%
Н.Эрдэнэбилэг	15,000,000	4.46%	15,000,000	3.79%
Мандал Праявит Экүити Хувийн ХОС ХХК	7,320,000	2.18%	7,320,000	1.85%
Олон нийт			59,378,822	15.00%
Нийт	336,480,000	100%	395,858,822	100%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

4.3 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Гэрэгэ Эстимэйт ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэж, үр дүнг 2022 оны 04 сарын 03-ны өдрийн Хараат бус бизнесийн үнэлгээний тайлангаар хүргүүлсэн.

Гэрэгэ Эстимэйт ХХК нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар тооцоолсон.



Үнэлгээний байгууллага нь Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу зах зээлийн харьцуулалтын хандлага, хөрөнгөд суурилсан хандлага, орлогын хандлагын аргуудаар үнэлсэн.


Зах зээлийн харьцуулалтын хандлага

Хараат бус бизнесийн үнэлгээний тайлангийн үр дүн нь дараах байдалтай байна. Тодруулбал:

Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг Зах зээлийн хандлагын аргаар үнэлэхэд Монгол Улсын зах зээл болон олон улсын зах зээл гэсэн 2 бүлэгт хуваан харьцуулалтын шинжилгээг хийсэн болно.

Монголын хөрөнгийн бирж дээр эзэмшигчийн өмчийн хэмжээ ойролцоо, хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг компаниудыг сонгон авсан. Гэвч тус





компаниуд нь эздийн өмчийн хэмжээгээр Үнэт цаас гаргагчтай ойролцоо боловч өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтээр Үнэт цаас гаргагч нь харьцангуй өндөр байгаа тул шууд ашиглах нь тохиромжгүй гэж үзсэн. Иймд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголын хөрөнгийн биржийн I болон II ангиллын 36 компанийг сонгож, өөрийн хөрөнгийн өгөөжтэй нь харьцуулсан регрессийн шинжилгээ хийх зэргээр үнэ-ашигын (P/E) харьцаа болон үнэ-дансны үнийн (P/B) харьцаагаар бизнес өмчлөлийн үнэ цэнийг тодорхойлсон байна.

Олон улсын тээвэр ложистикийн салбарын хувьд АНУ, БНХАУ, Малайз, Тайланд, Индонез улсуудыг сонгож, тухайн улсын тээвэр ложистикийн зах зээлийн дундаж P/E болон P/B харьцаа үзүүлэлтүүдээр үнэлгээг хийсэн. Эдгээр улсуудыг сонгоход Дэлхийн банкнаас гаргасан орлогын түвшний ангилал бүрээс тээвэр ложистикийн зах зээлийн мэдээллийн олдоцтой байдлыг харгалзан үзэж төлөөллүүдийг сонгосон байна.

Зах зээлийн харьцуулалтын аргын үндсэн зорилго нь тухайн компани Монголын хөрөнгийн биржид нийтэд нээлттэй болсны дараах үеийн хөрөнгө оруулагчдын хүлээлт, хандлагыг баримжаалан тооцоолоход оршино. Гэвч Үнэт цаас гаргагчтай харьцуулж буй компаниудын үйл ажиллагаа, санхүүгийн байдал өөр тул зах зээлийн харьцуулалтын аргыг ашиглан гаргасан үнэлгээгээр бизнесийн өмчлөлийн үнэ цэнийг тогтооход учир дутагдалтай гэж хөндлөнгийн үнэлгээний байгууллага үзсэн.

Хөрөнгөд суурилсан хандлага

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Үнэт цаас гаргагчийн биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагч нь нийт 9 охин компанитайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрээс 6 компанийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээнд 1) Монложистикс Россия Холдинг ХХК нь 100% толгой компанийн зохион байгуулалттайгаар ажилладаг 2) Монложистикс Экүпментс ХХК болон Монложистикс Экспресс ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар үйл ажиллагаа эхлүүлээгүй байсан тул тус 3 охин компанийн цэвэр хөрөнгийн дүнг материаллаг биш гэж үзэн үнэлгээнд тусгаагүй. Мөн толгой компанийн онцлогоос шалгаалан Монложистикс Холдинг ХХК-ийн бие даасан хөрөнгийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтыг хассан байдлаар цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулсан.

Хөрөнгийн хандлагад суурилсан үнэлгээний үр дүнд Үнэт цаас гаргагчийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 23,759,974,051 төгрөгөөр хэмжигдэж байна. Гэвч тус хандлага нь компанийн ирээдүйн орлого олох чадварт чухал нөлөө үзүүлэх гүүдвилл, барааны тэмдэгт, менежментийн ур чадвар зэрэг биет бус хөрөнгүүдийг оруулаагүй тул бизнесийн өмчлөлийн үнэ цэнийг тооцоход тохиромжгүй гэж дүгнэсэн байна.

Орлогын хандлага

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог, санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсний дараах үнэлгээ (Post-Money Valuation) нь үнэлгээний ажлын зорилготой нийцнэ гэж дүгнэсэн байна.



Орлогын хандлагаарх үнэлгээнд хорогдуулсан мөнгөн урсгалын арга, тодруулбал эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгалын (Free Cash Flow to Equity) аргыг ашигласан.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлийг охин компани тус бүрээр бизнес төлөвлөгөөнд үндэслэн хийж гүйцэтгэсэн байна. Үнэт цаас гаргагчийн охин компаниудын ирээдүйн мөнгөн урсгалтай холбоотой эрсдэл нь тухайн компанийн ажиллаж байгаа салбар, бизнес хөгжлийн үе шатаас хамаарч өөр өөр байгаа тул хорогдуулалтын хувийг охин компани тус бүрээр тооцоолсон ба компаниудын ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын дүнгээр жинлэсэн дундаж хорогдуулалтын хувь нь 24.5 хувь байна. Түүнчлэн урт хугацааны өсөлтийг 5 хувиар тооцсон байна.

Орлогын хандлагаарх үнэлгээнд Үнэт цаас гаргагчийн 7 охин компанийн 100 хувийн бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 110,176,782,717 төгрөг байхаар тооцоолсон. Үүнд толгой компанийг цэвэр хөрөнгийн үнэ цэнийн аргаар 2,613,333,400 төгрөгөөр үнэлснийг нэмж нийт 112,790,116,117 төгрөгөөр Монложистикс Группийн 100 хувийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг тооцоолсон байна.

Үүнээс Үнэт цаас гаргагч буюу толгой компани Монложистикс Холдинг ХХК-д ногдох бизнес өмчлөлийн үнэ цэнийг дараах 2 үе шаттайгаар тооцоолсон байна.

1. Монложистикс Холдинг ХХК-ийн хувь эзэмшилд хамаарах үнэ цэн

Үнэт цаас гаргагч Монложистикс Холдинг ХХК-ийн хувь эзэмшилд хамаарах нийт үнэ цэнийг 90,234,101,958 төгрөгөөр тодорхойлсон.

Хүснэгт 39. Монложистикс Группийн нийт үнэлгээ ба Монложистикс Холдинг ХХК-ийн эзэмшлийн үнэ цэн

№	Компаниуд	Үнэлгээний үр дүн	Монложистикс Холдинг ХХК-ийн эзэмшил	Монложистикс Холдинг ХХК-ийн эзэмшлийн үнэ цэн
1	Импортын тээвэр	52,787,135,845	100%	52,787,135,845
2	Экспортын тээвэр	39,943,541,205	51%	20,371,206,015
3	Транзит тээвэр	7,187,215,453	60%	4,312,329,272
4	Бусад тээвэр	10,258,890,125	99%	10,150,097,427
	Нийт үнэ цэн	110,176,782,717		87,620,768,558
5	Монложистикс Холдинг ХХК	2,613,333,400	100%	2,613,333,400
	Нийт	112,790,116,117		90,234,101,158

Эх сурвалж: Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан



2. Толгой компанийн хөнгөлөлт

Охин компаниудаас толгой компанид шилжих аливаа орлого, хөрөнгөд татвар ногдуулдаг. Иймд Үнэт цаас гаргагч буюу толгой компани Монложистикс Холдинг ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийн тооцоололд татан буулгалтын хөнгөлөлтийг 10 хувь байхаар тооцож, хөнгөлөлтийг охин компаниудын хувь эзэмшилд ногдуулж хорогдуулан бизнес өмчлөлийн үнэ цэнийг 81,472,025,102 төгрөгөөр тооцсон.

Үнэлгээний үр дүн

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Гэрэгэ Эстимэйт ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн онцлог, үнэлгээний зорилго, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан орлогын хандлагын аргаар олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсний дараах Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг (Post-Money Valuation) 81,472,025,102 төгрөгөөр тодорхойлсон. Энэ нь нэгж хувьцааны үнээр илэрхийлбэл 206 төгрөгтэй тэнцэж байна.

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтеруудийн зүгээс зах зээлийн нөхцөл байдлыг харгалзаж үзэн Үнэт цаас гаргагчийн ХЭХ-ийн 2023 оны 04-р сарын 10-ны өдрийн 23/ХЭХ/13 тоот тогтоолоор нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 185 төгрөгөөр буюу 10 хувиар хямдруулан санал болгохоор шийдвэрлэсэн. Энэ нь бизнес өмчлөлийн үнэ цэнээр илэрхийлбэл 73,233,882,070 төгрөгтэй тэнцэж байна.

4.4 Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь нийт 59,378,822 ширхэг энгийн хувьцааг нэг бүр нь 185 төгрөгөөр нийтэд санал болгон арилжаалж, нийт 10,985,082,070 төгрөгийг татан төвлөрүүлнэ. Богино болон дунд хугацааны стратеги, бодлогын хүрээнд Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн санхүүжилтын 73 хувь буюу 8.1 тэрбум төгрөгийг экспортын тээврийн үйл ажиллагаанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалтад, 27 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд зарцуулна.

Хүснэгт 40. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, сая төгрөгөөр


№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Дүн	Эзлэх хувь
1	Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	73%
2	Эргэлтийн хөрөнгө	2,923	27%
	Нийт	10,985	100%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт

2022 онд Үнэт цаас гаргагч нь 5 цуваа буюу 250 ширхэг тавцант вагон, 500 гаруй задгай чингэлгээр 67.0 мянган тонн нүүрс, цайрын баяжмалын экспортын тээврийг дотоодын болон ОХУ-аас вагон түрээслэж зохион байгуулсан.


Үнэт цаасны танилцуулгын 3.6 дахь хэсэгт дурдсанчлан экспортын тээврийн зах зээлийн тэлэх боломж өндөр, үүнд Үнэт цаас гаргагч нь өсөлтийн стратеги баримтлан ажиллаж буй тул экспортын тээврийн үйл ажиллагааг өргөжин тэлэхэд зориулж 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцант вагоныг



ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Тус вагоныг Үнэт цаас гаргагчийн 100 хувийн эзэмшлийн охин компани Монложистикс Экүйпментс ХХК эзэмшинэ.

Зураг 26. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэдэг 13-6953 загварын тавцант вагоны зураг

СЗХ
ОН 2023 сар 7 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Тус тавцант вагон худалдан авахад нийт 23.2 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай. Үүнд санхүүжилтын 35 хувь буюу 8.1 тэрбум төгрөгийг нийтэд хувьцаа санал болгох замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр, 65 хувь буюу 15.2 тэрбум төгрөгийг арилжааны банкны санхүүгийн түрээсээр санхүүжүүлнэ. Тавцант вагон худалдан авалтын өртөгт вагоныг ОХУ-аас худалдан авч ашиглах хүртэлх хугацаанд гарах вагон худалдан авалтын төлбөр, гаалийн татвар, тээврийн зардал зэрэг бүх зардал багтсан.

Хүснэгт 41. Вагон худалдан авах өртөгийн задаргаа

Үзүүлэлт	Үнийн дүн
Нэгжийн зардал	
Нэгж вагоны үнэ, ам.доллараар	53,400
Вагоны тоо	100 ширхэг
Татвар хэмжээ	15.5%
Нэгж вагоны тээврийн зардал, ам.доллараар	2500
Төгрөгийн ам.доллартой харьцах ханш	3600
Нийт зардал	
Вагоны нийт өртөг, ам.доллараар	5,340,000
Татварын зардал, ам.доллараар	858,700
Тээврийн зардал, ам.доллараар	250,000
Нийт өртөг, ам.доллараар	6,448,700
Нийт өртөг, төгрөгөөр	23,215,320,000

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулах буюу тавцант вагон худалдан авснаар Үнэт цаас гаргагчийн гуравдагч байгууллагад төлж буй түрээсийн зардал буурч, ашигт ажиллагаа сайжрахаас гадна экспортын тээврийн эргэлт нэмэгдэх, экспортын тээврийн зах зээлд өрсөлдөөний давуу тал үүсэх стратегийн ач холбогдолтой.

Түүнчлэн тавцант вагон нь хөдлөх бүрэлдэхүүн тул экспортын тээвэрлэлт хийж гүйцэтгэхээс гадна Үнэт цаас гаргагчийн импортын тээвэр ложистикийн экосистемд ашиглагдах боломжтой.

Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт

Тээвэр ложистикийн бизнес нь эргэлтийн хөрөнгийн эргэц өндөртэй байдгаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд дараа

MANDAL CAPITAL
MARKETS LLC
MONGOLIAN STOCK EXCHANGE
0023110414 5213487

monlogistics
HOLDING
ATA5200 6301054



төлбөрт нөхцөлтэй авлага, өглөг тогтмол үүсч, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтын хэрэгцээ шаардлага өндөр байдаг.

Үнэт цаас гаргагч нь импортын тээврийн зах зээлд өрсөлдөөний давуу байдлыг бий болгох зорилгоор харилцагчдад дараа төлбөрт нөхцөлөөр тээврийн ложистикийн үйлчилгээг санал болгодог. Энэ нь харилцагчдын нэрийн өмнөөс тээврийн зардлыг олон улсын агентуудад төлж, улмаар харилцагчаас ачаа бараа хүлээн авснаас хойш 30 хоног хүртэлх хугацаанд төлбөрийг хүлээн авдаг үйлчилгээ юм.

Иймд Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагаа явуулж буй тээвэр ложистикийн салбар, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үүсдэг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд татан төвлөрүүлэх хөрөнгийн 27 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг зарцуулна.

4.5 Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрмийн төсөлд зааснаар дараах эрхүүдийг эдэлнэ. Үүнд:



- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- Холбогдох хууль тогтоомжид заасан бөгөөд нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад Компанийн талаарх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах;
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

Үнэт цаас эзэмшигчийн үүрэг

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээллэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэдэгдэх
- Нийт гаргасан хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу нийтэд мэдээллэх замаар худалдан авах санал гаргах

- Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр харилцагчид хүлээх





- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг

4.6 Ногдол ашгийн бодлогын төсөл

Үнэт цаас гаргагч нь нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТУЗ-өөс нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, нөхцөлийг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн тогтооно.

Ногдол ашгийн бодлого нь компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байх ба хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд хуваарилах зарчмыг баримтална.

Ногдол ашгийн бодлогын зорилго

Ногдол ашгийн бодлогын зорилго нь Үнэт цаас гаргагч Монложистикс Холдинг ХХК-ийн ногдол ашиг хуваарилах, түүний хэмжээ, хуваарилах нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээллэх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Ногдол ашиг хуваарилах хувь хэмжээ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашгийн хэмжээ нь тайлант үеийн татварын дараах цэвэр ашгийн 20-50 хувьтай тэнцүү байна.

Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.

Үнэт цаас гаргагч нь ногдол ашгийг хуваарилахад дор дурдсан нөхцлийг харгалзан үзнэ. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадвартай байх
- Ногдол ашиг төлсний дараа Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэргийн нийлбэрээс их байх
- Үнэт цаас гаргагч нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх


Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилах ба Үнэт цаас гаргагч эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

Ногдол ашгийг эд хөрөнгийн болон үнэт цаасны хэлбэрээр олгох тохиолдолд түүний үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмыг баримтлан тодорхойлно.

Ногдол ашиг хуваарилах шийдвэр


Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.



Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:



- Хувьцааны төрөл, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт болон ногдол ашиг гаргах бүртгэлийн өдөр
- Ногдол ашиг төлөх өдөр буюу олгож эхлэх, дуусах хугацаа
- Ногдол ашгийг олгох хэлбэр



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ногдол ашиг хуваарилах талаар ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдэгдэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа үндэслэл шалтгаан, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

4.7 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-ийн ТУЗ-ийн 2018 оны 01-р сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны 2021 оны 06-р сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 10-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 185 төгрөгөөр тогтоосон бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнийн аргаар хийж гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь нэмж гаргах хувьцааны 70 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгоно.

Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжаа дараах төлөвлөгөөний дагуу явагдана.

Хүснэгт 42. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төлөвлөгөө

1. Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагааг эхлүүлнэ.

2. Roadshow (Нийтэд танилцуулах)

Эрх бүхий зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэснээр Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг эхлүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө СЗХ-нд мэдэгдэн, дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэт цаасны мэдээллийг хүргэх
- Нийтэд зориулсан танилцуулга уулзалт зохион байгуулах
- Үнэт цаасны танилцуулга, хураангуй танилцуулгыг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах
- Маркетингийн төлөвлөгөөний дагуу бусад арга хэлбэрээр танилцуулна.

3. Анхдагч зах зээлийн арилжаа

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь анхдагч зах зээлийг эхлүүлэх хугацаа, хуваарь зэрэг мэдээллийг тусгасан анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөг уг ажиллагаа эхлэхээс ажлын 3-с доошгүй өдрийн өмнө СЗХ-нд мэдэгдэнэ. Улмаар анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөний дагуу арилжааг эхлүүлнэ.

Хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.


Хүснэгт 43. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцоход авах алхмууд



Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн төлөвлөгөө

Үнэт цаасны данс нээлгэх

Хөрөнгө оруулагч нь үнэт цаасны данстай нөхцөлд өөрийн харилцааг үнэт цаасны компаниар дамжуулан хувьцааг худалдан авна. Хэрэв үнэт цаасны дансгүй нөхцөлд МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компаниар



2023-06-14

БҮРТГЭВ-03



дамжуулан цахимаар болон биечлэн үнэт цаасны данс нээлгэж, захиалга өгнө.

Мөнгөн хөрөнгө байршуулах

Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкаар дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (цаашид "ҮЦТХТ" гэх)-д бүртгэлтэй өөрийн нэрийн дансанд мөнгөө байршуулна. Байршуулах мөнгөн хөрөнгийн дүн нь үнэт цаасыг худалдан авах нийт үнийн дүнд үйлчлүүлж буй үнэт цаасны компанийн арилжааны шимтгэлийг нэмсэн дүн байна.

Захиалга өгөх

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хувьцааг худалдан авах захиалга өгнө. Анхдагч зах зээлийн захиалгыг СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 7.3-т заасны дагуу ажлын 5 хоног байна.

4. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлд 59,378,822 ширхэг энгийн хувьцааг санал болгохоос 70 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилна.

Хүснэгт 44. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт

Хөрөнгө оруулагчийн төрөл	Санал болгох хувь	Санал болгох хувьцааны тоо, ширхэг	Санал болгох үнэ	Нийт татан төвлөрүүлэх дүн, төгрөг
Стратегийн хөрөнгө оруулагчдад	70%	41,565,175	185	7,689,557,375
Олон нийтэд	30%	17,813,647	185	3,295,524,695
Нийт	100%	59,378,822	185	10,985,082,070

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хувь тэнцүүлэх зарчмын хүрээнд 500 ширхэг хувьцааны захиалгыг бүрэн биелүүлж, үлдсэн дүнг хувь тэнцүүлэн хуваарилна. Тус хуваарилалтыг хийхэд үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

Стратегийн хөрөнгө оруулагч

Стратегийн хөрөнгө оруулагч нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасыг 6 сарын хугацаанд тусгаарлах, 50,000,000 төгрөг болон түүнээс дээш үнийн дүнгээр хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэй байна. Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга нь 100 хувь биелэх нөхцөлтэй байна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа

Үндсэн андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцвол Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (цаашид "ҮЦТХТ" гэх)-д өмчлөх эрхийн бүртгэл хийх болон МХБ-д үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ

ҮЦТХТ нь СЗХ-ны дээрх зөвшөөрлийн дагуу ажлын 5 өдрийн дотор Үнэт цаас гаргагчийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийж, СЗХ болон МХБ-д мэдэгдэнэ. ҮЦТХТ-ийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэл хийгдсэнээр МХБ нь



ажлын 2 өдрийн дотор хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгоно.

2023-06-14

БҮРТГЭВ-03

СЗХ
04
СЗД
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцааг бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

4.8 Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн гаргасан энгийн хувьцааны хоёрдогч зах зээлийн ханшийн тогтвортой байдлыг хангах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг СЗХ-ноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу дараах нөхцөлд хэрэгжүүлнэ.

Хүснэгт 45. Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэх худалдан авах нөхцөл

Нөхцөл	Хувьцааны үнэ анх гаргасан үнээс 15 хувь болон түүнээс дээш хэмжээнд унах
Хугацаа	Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 сар
Үнийн дүн	500 сая төгрөг
Нэмэлт нөхцөл	Багц арилжааны хэлцэл хамаарахгүй.

Эх сурвалж: Үнэ тогтворжуулах гэрээ

Хувьцааны үнэ тогтворжуулах үйл ажиллагаанаас гарах зардал нь Үнэт цаас гаргагчийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс суутгагдахгүй. Хувьцааны үнэ тогтворжуулах нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй бөгөөд ийнхүү урвуулан ашигласан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.



СЭХ
он сар өдөр
2023 06 23
БҮРТГЭВ
№ 01

2023-06-14

БҮРТГЭВ-03

МАНДАЛ КАПИТАЛ
МАРКЕТИНГ ХХК
MANDAL CAPITAL
MARKETING LLC
MT
USTR001003011270416 9215437

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК
monlogistics
HOLDING
[Signature]
ATA5299 of 6381251
9021031093

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



ТАВ.

**ҮНЭТ ЦААС ГАРГАХ
АЖИЛЛАГААНД
ОРОЛЦСОН
БАЙГУУЛЛАГУУД**



5. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

БҮРТГЭВ-03

5.1 Хөндлөнгийн үнэлгээний байгууллага танилцуулга, гэрээ

Хүснэгт 46. Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын товч танилцуулга

Байгууллагын нэр	Гэрэгэ Эстимэйт ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011215085
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгийн үнэлгээ Даатгалын хохирлын үнэлгээ Бизнесийн зөвлөх үйлчилгээ
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Эрдмийн ордон, 1004 тоот
Утас	+976-7000 5000
Цахим шуудан	info@geregepartners.mn


Эх сурвалж: Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын мэдээлэл

Гэрэгэ Эстимэйт ХХК нь хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр ажилладаг үнэлгээний мэргэжлийн компани юм. Үнэлгээний баг нь үнэлгээчин, актуарч, нягтлан бодогч, эдийн засагч, санхүүч зэрэг олон чиглэлийн нарийн мэргэжлийг гадаад дотоодын их дээд сургуулиудад эзэмшиж, мэргэжлээрээ ажилласан туршлагатай чадварлаг мэргэжилтнүүдээс бүрддэг. Бизнесийн үнэлгээний болон хөрөнгийн үнэлгээний томоохон ажлууд дээр Гэрэгэ Эстимэйт ХХК болон Гэрэгэ Партнерс ХХК-ийн мэргэжилтнүүдийн хамтарсан баг ажилладаг. Гэрэгэ Партнерс ХХК нь эдийн засаг, санхүү, бизнес, актуарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани юм.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь МХБ дээр үнэт цаас арилжаалах компаниудын бизнесийн үнэлгээ хийх эрхтэй СЗХ-д бүртгэлтэй компани бөгөөд үнэлгээний багт Монгол Улсын Сангийн яамнаас олгодог мэргэшсэн үнэлгээчин сертификаттай 3 үнэлгээчин ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг МХБ дээр анхлан гаргах зориулалтаар хийсэн үнэлгээний багийн ахлагчаар Доноровын Гантулга ажиллав. Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институт (RICS)-ийн гишүүн, бизнесийн болон биет бус хөрөнгийн үнэлгээний мэргэшсэн үнэлгээчин ба RICS нь газар, хөрөнгө, дэд бүтэц, байгууламжийн үнэлгээний мэргэшил болон стандарт тогтоодог дэлхийн тэргүүлэх байгууллага юм.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээчид нийт 20 орчим бизнесийн үнэлгээний ажил хийж гүйцэтгэсэн. Тэрээр 2017 онд Монгол Улсын анхны финтек компани болох ЛендМН ББСБ ХК, 2018 онд Инвескор ББСБ ХК, 2019 онд Бодь Даатгал ХК, 2021 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК, 2022 онд Сэндли ББСБ ХК, Монголын Хөрөнгийн Бирж ХК зэрэг компаниудын бизнесийн үнэлгээг тус компаниудын хувьцааг хөрөнгийн биржид анхлан гаргах зориулалтаар хийж гүйцэтгэсэн туршлагатай бөгөөд эдгээр компаниудын хувьцаа нь МХБ дээр амжилттай арилжаалагдаж байна.





Хөндлөнгийн үнэлгээний байгууллагатай байгуулсан гэрээний тухай

СЗХ
043.000.23
БҮРТГЭЛ
№ 11

Үнэт цаас гаргагч нь үнэлгээний Гэрэгэ Эстимэйт ХХК-тай 2023 оны 01 сарын 25-ны өдөр байгуулсан 23/ЧАГ/03 дугаартай "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу Гэрэгэ Эстимэйт ХХК нь Монложистикс Холдинг ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийж, Үнэт цаас гаргагчийн хувьцааг МХБ дээр анх удаа олон нийтэд санал болгох зориулалтаар Монгол Улсын хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж шаардлагын хүрээнд үнэлгээний олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэхээр тохиролцсон байна.

Бизнесийн үнэлгээний гэрээнд Үнэт цаас гаргагч нь үнэлгээний ажилд шаардагдах мэдээ, мэдээллийг зөвхөн шаардлагатай хэмжээгээр гарган өгөх гэрээгээр тохиролцсон ажлын хөлсийг төлөх, Гэрэгэ Эстимэйт ХХК нь гэрээнд заасан хугацаанд үнэлгээний тайланг аливаа эрхийн зөрчилгүй, хууль тогтоомж, стандарт аргачлалд нийцсэн байдлаар хүлээлгэн өгөх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн Үнэт цаас гаргагчийн болон эд хөрөнгийн өмчлөгчийн талаарх бүхий л мэдээлэл, баримт бичиг, зураг, төсөл, программ хангамж, дижитал мэдээллийг (үүгээр хязгаарлагдахгүй) түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүрэг хүлээхээр тохиролцсон байна.

5.2 Хөндлөнгийн аудитын компанийн танилцуулга, гэрээ

Хүснэгт 47. Хөндлөнгийн аудитын компанийн товч танилцуулга

Байгууллагын нэр	Грант Торнтон Аудит ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9018001038
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйлчилгээ
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж-31, Далай тауэр, 9-р давхар
Утас	+ 976-7011 0799
Цахим шуудан	info@mn.gt.com

Эх сурвалж: Хөндлөнгийн аудитын компанийн мэдээлэл

Грант Торнтон Аудит ХХК нь анх Улаанбаатар Аудит Корпораци ХХК нэрээр 1999 онд аудитын үйлчилгээ эрхлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Аудитын салбарт 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй хараат бус, найдвартай мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг Монгол Улсын аудитын салбарт тэргүүлэх томоохон аудитын компанийн нэг юм.

2017 оны 11-р сарын 24-ний өдрөөс эхлэн Грант Торнтон Интернэшнл нь дэлхийн сүлжээ байгууллагын гишүүн болсон ба тус сүлжээг Монгол Улсад төлөөлөн ажиллах бүрэн эрхтэй гишүүн компаниар хүлээн зөвшөөрөгдөнүйл ажиллагаа явуулж байна. Одоогоор дэлхийн 140 гаруй улс оронд, 750 дээш оффис, 62,000 гаруй мэргэжилтнүүдээс бүрдсэн аудит баталгаажуулалт, татвар, зөвлөх үйлчилгээний бие даасан фирмүүдээс бүрддэг.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 01-р сарын 29-ний өдрийн 23 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар бүртгэгдсэн ба СЗХ-ны 2014 оны 02-р сарын 12-ны өдрийн 40 тоот тогтоолыг үндэслэн даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээг авсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
LIAN STOCK EXCHANGE
ATA5299 / 6381351
9021001093

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
LIAN STOCK EXCHANGE
ATA5299 / 6381351
9021001093

СЭХ
ОН сар 23
БҮРТГЭЛ
№ 01

Компанийн аудиторууд нь СЭХ, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт хамтран зохион байгуулдаг үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх аудиторуудад зориулсан цогц сургалтанд 3 жил тутам хамрагдаж, зохих шалгалтуудыг өгч, гэрчилгээ авсан.

БҮРТГЭВ-03

Хөндлөнгийн аудитын компанитай байгуулсан гэрээний тухай

Грант Торнтон Аудит ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2022 оны 09-р сарын 09-ны өдөр 2022/38 тоот "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан бөгөөд Монгол Улсын иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудитын стандартын дагуу үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргаж өгөхөөр гэрээгээр тохиролцсон.

Гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хууль, тогтоол, тушаал, дүрэм, журам, заавраар батлагдсан маягтын дагуу гаргасан санхүүгийн тайлан (баланс)-г өгөх, санхүүгийн тайлан гаргахтай холбогдсон ерөнхий журнал, данс, тусгай журнал, дэлгэрэнгүй бүртгэл зэргийг аудитын компанийн хүсэлт, шаардлагын дагуу үзүүлж тайлбарлан танилцуулах үүрэгтэй. Аудитын үйлчилгээ үзүүлж буй компани нь Үнэт цаас гаргагчийн гаргасан санхүүгийн тайланг аудитороор шалгуулж баталгаажуулах, Монгол Улсын Аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, аудитын олон улсын стандарт үндэслэн санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүдийг нотлох баримтуудаар шалгаж, зөрчил дутагдлуудын тайлан бичиж бүхэлд нь дүгнэлт өгөхөөр гэрээгээр тохиролцсон байна.

5.3 Хуулийн фирмийн танилцуулга, гэрээ

Хуулийн фирмийн танилцуулга


Хүснэгт 48. Хуулийн фирмийн товч танилцуулга


Байгууллагын нэр	Хаанлекс Партнерс ХХН
Улсын бүртгэлийн дугаар	9022003026
Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн зөвлөх үйлчилгээ
Хаяг	Улаанбаатар 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-5, Аюуд тауэр, 14 давхар 1404 тоот
Утас	+976-77471122
Цахим шуудан	info@khanlex.mn

Эх сурвалж: Хуулийн фирмийн мэдээлэл

Өмгөөллийн Хаанлекс Партнерс ХХН нь банк санхүү, үнэт цаас, дэд бүтэц, эрчим хүч, шүүхийн маргаан, бизнесийн болон компанийн эрх зүйн салбарт голчлон хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монголын тэргүүлэх хуулийн фирмүүдийн нэг юм. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд өөрсдийн үйлчилгээ, мэдлэг, туршлагаа олон улсын зах зээлийн томоохон оролцогч нарт хүргэж ирсэн ба эдгээрт олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагууд, гадаадын төрийн өмчит болон хувийн салбарын тэргүүлэгч компаниуд багтдаг.

Хуулийн фирм нь Монгол Улсад хийгдсэн олон улсын шинжтэй томоохон гэрээ, хэлцлүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч, амжилттай ажилласан ба тэдгээрийн зарим





нь олон улсын хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүнчлэн, хууль зүйн зөвлөгөө өгч ажилладаг үндсэн эрх зүйн салбарууд (банк санхүү, дэд бүтэц, бизнесийн эрх зүй, шүүхийн маргаан зэрэг)-аас гадна хурдтай хөгжиж буй "ногоон санхүүжилт"-ийн эрх зүйн чиглэлээр ажилласан байдал, туршлагаараа Монгол Улсын хуулийн фирмүүдийн дунд тэргүүлэх байр суурь эзэлж байна.

Хуулийн зөвлөхийн үйл ажиллагаа явуулж буй үндсэн чиглэлийн нэг нь үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн үйлчилгээ үзүүлсэн туршлагатай. Тухайлбал, тус хуулийн фирмийн хуульчид нь Хай Би Ойл ХК, ЛэндМН ББСБ ХК, Даваанбулаг ХК, Түмэншувуут ХК, Мон-Бийф ХХК, ХаанБанк ХК зэрэг компаниудын хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO болон FPO) ажилд хууль зүйн үйлчилгээг амжилттай үзүүлсэн ба Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас Эрдэнэ Рэсурс Девелопмент Корпораци ХК-ийн хувьцаанд хөрвөх санхүүжилтийн ажилд оролцсон туршлагатай. Түүнчлэн хувьцаанаас бусад үнэт цаасны хувьд Омни Актив ТЗК болон Нөмөр Кредит Ассет ТЗК нарын МХБ-ээр дамжуулан арилжаалсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Мөнхийн үсэг ХХК болон Степпе Бэвэриж ХХК-аас хаалттай бонд тус тус гаргах төсөлд хуулийн дүгнэлт гарган, хууль зүйн үйлчилгээ үзүүлэн оролцжээ.


Хуулийн фирмтэй байгуулсан гэрээний тухай

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчтай 2023 оны 01-р сарын 25-ны өдөр байгуулсан 23/ҮАГ/02 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгох, хувьцаат компани болоход шаардагдах хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон.

Тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь үйлчилгээтэй холбоотой үнэн бодитой мэдээллээр түргэн шуурхай хангах, хуулийн фирмээс ирүүлсэн асуулт, хүсэлтэд түргэн шуурхай хариу өгөх, гэрээний дагуу холбогдох төлбөр тооцоог цаг тухайд нь барагдуулах үүрэг хүлээсэн. Харин хуулийн фирм нь гэрээгээр тохиролцсон үйлчилгээг үзүүлэхдээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн оновчтой менежементээр гүйцэтгэж, гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар ажиллах бөгөөд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлоыг хамгаалах, үйлчилгээг үзүүлэхдээ үнэн зөв бодит мэдээллээр хангах, мэдээллийг чандлан хадгалах үүрэг хүлээсэн байна.



5.4 Үндсэн андеррайтерийн танилцуулга, гэрээ



Хүснэгт 49. Үндсэн андеррайтерийн товч танилцуулга

Байгууллагын нэр	Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011145061
Үйл ажиллагааны чиглэл	Андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, Меру Таур, 602 тоот, Улаанбаатар хот
Утас	+976-7575 3399
Цахим шуудан	info@mandal.capital

Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн мэдээлэл

Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани юм. 2008 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Өдгөө Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасны үйл ажиллагаа эрхлэх брокер, дилер, андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн байгууллага юм.

2021 оны байдлаар Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь нийт 47.6 тэрбум төгрөгийг дотоодын анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн туршлагатай хамт олон юм.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь 15 компанийн биржийн бус зах зээлийн бонд, 2 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг зах зээлд гаргаж, нийт 107 тэрбум төгрөгийн санхүүжилтыг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үндсэн андеррайтер нь 2023 оны 01-р сарын 31-ний өдрийн А/23/01 тоот "Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу Үнэт цаас гаргагчийг олон нийтэд анх удаа нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд Үндсэн андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байна. Тус гэрээний хүрээнд Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчид өөрийн энгийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татахад Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах үүднээс шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг удирдан гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад бүх хүчин чармайлт /Best effort/ гаргаж үзүүлэхээр тохиролцсон.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад СЗХ болон МХБ-ээс гаргасан үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг бэлтгэн, тухайн хамтарсан төлөвлөгөөний дагуу оролцогч талуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад зөвлөгөө өгөх, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэхэд шаардлагатай удирдлагаар хангах, санал зөвлөмжийг өгөх,



стратегийн хөрөнгө оруулагч нарт хувьцааны танилцуулгыг компанийг төлөөлөн танилцуулах үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтерт гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь эсвэл баталгаажсан хуулбарыг Үндсэн андеррайтераас шаардсан цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээсэн.

5.5 Туслах андеррайтерийн танилцуулга

Хүснэгт 50. Туслах андеррайтерийн товч танилцуулга

Байгууллагын нэр	Инвескор Капитал ҮЦК ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011741137
Үйл ажиллагааны чиглэл	Андеррайтер, брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Жамьян Гүний гудамж 18/1, Даун Таун барилга, 6 давхар, 601 тоот
Утас	+976-7755 0077
Цахим шуудан	info@icapital.mn

Эх сурвалж: Туслах андеррайтерийн мэдээлэл

“Инвескор Капитал ҮЦК” ХХК нь үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд юм. “Инвескор Капитал ҮЦК” ХХК нь тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцагч, үйлчлүүлэгчдэд хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөгөө өгөх, биржийн болон биржийн бус зах зээлд үнэт цаас гаргах үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргах ажиллагааг зохион байгуулж мэргэшсэн зөвлөгөөгөөр харилцагч үйлчлүүлэгчийг хангах, үнэт цаасны арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцох, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулж буй хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөх компани юм.

“Инвескор Капитал ҮЦК” ХХК нь 2019 онд Инвескор ББСБ ХК, 2022 онд Голомт Банк ХК, Монголын Хөрөнгийн Бирж ХК-г анх удаа нийтэд хувьцаагаа санал болгох үйл ажиллагаанд андеррайтераар ажиллаж нийт 149.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн туршлагатай бөгөөд эдгээр хувьцаанууд өдгөө МХБ дээр амжилттай арилжаалагдаж байна. 2021 онд Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох “Инвескор Актив ХБҮЦ”-ыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 4 тэрбум төгрөгийг, 2022 онд “Инвескор ББСБ” ХК-ийн нэмж олон нийтэд хувьцаа гаргах үйл ажиллагаанд андеррайтераар ажиллаж 16.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус амжилттай татан төвлөрүүлсэн.

Мөн “Инвескор Капитал ҮЦК” ХХК нь биржийн зах зээлд 54.0 тэрбум төгрөгийн нээлттэй бонд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны андеррайтераар ажиллаж, тус санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Өдгөө “Инвескор Капитал ҮЦК” ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, дотоодын болон олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах, үнэт цаасны зах зээлд шинэлэг

бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож хөрөнгө оруулагчдад үр шим, өгөөж хүртэх
боломжийг өргөн хүрээнд олгох зорилготойгоор баг хамт олноо өргөжүүлэн
тэлж, үйл ажиллагаа явуулж байна.



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



ЗУРГАА.

ХАВСРАЛТ

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО”-нд

АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

“Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК (цаашид “Андеррайтер” гэх) нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 11-р сарын 10-ны өдөр олгосон Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд “Монложистикс Холдинг” ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх)-тай 2023 оны 01-р сарын 31-ны өдөр 23/02 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан.

Тус хүрээнд бид Үнэт цаас гаргагчийн нэмж гаргасны дараах нийт хувьцааны 15 хувьтай тэнцэх буюу 59,378,822 ширхэг энгийн хувьцааг нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд Үндсэн андеррайтераар ажиллаж байна. Андеррайтер нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06-р сарын 11-ний өдөр баталсан “Үнэт цаас бүртгэлийн журам”-ын 3.1.6-д заасан Андеррайтерийн тодорхойлох захидлыг дараах агуулгын хүрээнд гаргаж байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдахад ашиглах арга, хэлбэр
- Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн тухай
- Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтыг татан төвлөрүүлэх баталгааны тухай

Андеррайтер нь энэхүү тодорхойлох захидал болон Үнэт цаас гаргагчийн танилцуулгыг хөндлөнгийн шинжээчдийн тайлан дүгнэлт болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичигт тулгуурлан боловсруулсан. Энэхүү тодорхойлох захидал болон Үнэт цаас гаргагчийн танилцуулгыг бэлтгэх явцад холбогдох талуудаас баримт бичиг, мэдээллийг нуун орхигдуулсан, буруу танилцуулсан нөхцөлд Андеррайтер хариуцлага хүлээхгүй болно.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай холбоо хамааралгүй бөгөөд бие даасан, хараат бус дүгнэлтийг гаргасан.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгох хувьцааг анхдагч зах зээлд байршуулах тухай

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04-р сарын 10-ны өдрийн 23/ХЭХ/13 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03-р сарын 17-ны өдрийн 23/ТУЗ/10/01 тогтоолыг үндэслэн нийтэд санал болгосны дараах нийт хувьцааны 15 хувьтай тэнцэх буюу 59,378,822 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, нэгж хувьцааны үнийг 185 төгрөгөөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
117K0162 9021070414 6213487

MONJISTIX HOLDING
ХХК
monjistic
HOLDING
ATA5289 4 030 01
9021031000

2023-06-14

БҮРТГЭВ-03

СЗХ

он 2023 сар 14
БҮРТГЭВ
№ 31

дамжуулан анх удаа нийтэд санал болгон арилжаалж, 10,985,082,070 төгрөгийг татан төвлөрүүлнэ.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06-р сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдөр баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас бүртгэх шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор, анхдагч зах зээлийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-иар дамжуулан ажлын 5 өдөрт багтаан зохион байгуулна.

Нэмж гаргах хувьцааны 70 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн хэсэг буюу 30 ба түүнээс дээш хувийг олон нийтэд хуваарилна. Стратегийн хөрөнгө оруулагч нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасыг 6 сарын хугацаанд тусгаарлах, 50,000,000 төгрөг болон түүнээс дээш үнийн дүнгээр хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэй байна. Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга нь 100 хувь биелэх нөхцөлтэй байна.

Үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдөр баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 10 дугаар зүйлд заасан тогтоосон үнийн аргаар санал болгож нийт худалдан авах захиалгын тоо ширхэг нийт санал болгосон үнэт цаасны тоо ширхэгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан хуваарилалтыг хийнэ.

Хувь тэнцүүлэх зарчмын хүрээнд 500 хүртэлх ширхэг хувьцааны захиалгыг бүрэн биелүүлж, үлдсэн дүнг хувь тэнцүүлэн хуваарилна. Тус хуваарилалтыг хийхэд үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн тухай

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, тээвэр ложистикийн салбарын төлөв байдал, зах зээлд эзлэж буй байр суурь, санхүүгийн нөхцөл байдал болон бизнес төлөвлөгөө, эрсдэлийн бодлогыг хянасны үндсэн дээр Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06-р сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаас бүртгэлийн журам", Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 01-р сарын 25-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан.

Үнэт цаас гаргагч болон хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Хаанлекс Партнерс" ХХН-ийн хооронд 2023 оны 01-р сарын 25-ны өдөр байгуулсан 23/ЧАГ/02 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд "Хаанлекс Партнерс" ХХН нь хууль зүйн дүгнэлт гаргасан. Үүнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг "Хаанлекс Партнерс" ХХН нь хянаж дүгнэлт гаргасан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06-р сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаас бүртгэлийн журам"-ын 3.1.4 дэхь заалт, Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 01-р сарын 25-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын





2.8.3 дах заалтад хүрээнд аудитын үйлчилгээ үзүүлэгч "Грант Торнтон Аудит" ХХК-иар Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр болох тодорхойлолтыг гаргасан. "Грант Торнтон Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчийн 2021 оны 12-р сарын 31-ны өдөр болон 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Үнэт цаас гаргагч болон бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч "Гэрэгэ Эстимэйт" ХХК-ийн хооронд 2023 оны 01-р сарын 25-ны өдөр байгуулсан 23/ЧАГ/03 тоот Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үүнд Олон улсын үнэлгээний стандарт, Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх бизнес өмчлөлийн үнэ цэнийг "Гэрэгэ Эстимэйт" ХХК тодорхойлсон.

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, Санхүүгийн зохицуулах хорооны баталсан "Үнэт цаас бүртгэлийн журам"-ын 3.5 дахь заалт, Монголын хөрөнгийн биржийн баталсан "Үнэт цаас бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлд заасан Үнэт цаасны танилцуулгад зайлшгүй тусгах шаардлагатай мэдээллийг бүрэн оруулсан. Танилцуулгад хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээллүүдийг тусгахаар зорьсон.

Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтыг татан төвлөрүүлэх баталгааны тухай

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай 2023 оны 01-р сарын 31-ны өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-т заасан "хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах" нөхцөлөөр 23/02 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан.

Андеррайтер нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах хүрээнд нэмж гаргаж буй хувьцааны 5 хувь хүртэлх буюу 2,968,941 ширхэг хүртэлх хувьцааг худалдан авна. Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн хооронд 2023 оны 04-р сарын 25-ны өдөр байгуулсан Үнэ тогтворжуулах гэрээний дагуу Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн гаргасан энгийн хувьцааны хоёрдогч зах зээлийн ханшийн тогтвортой байдлыг хангах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг 6 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг анх удаа нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтыг татан төвлөрүүлэхийн тулд Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, тээвэр ложистикийн салбарын төлөв байдал, зах зээлд эзлэж буй байр суурь, санхүүгийн нөхцөл байдал болон бизнес төлөвлөгөө, эрсдэлийн бодлогыг шинжилсэн. Үүнд:

Бизнесийн үйл ажиллагаа


Үнэт цаас гаргагч нь тээвэр ложистикийн салбарт төрөлжсөн үйл ажиллагаатай, зах зээлд тэргүүлэгч Монложистикс Группийн толгой компани юм. Монложистикс Групп нь импорт, экспорт, транзит, бусад тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг нийт 9 охин компаниудаас бүрддэг.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монложистикс Групп нь 160 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1,500 гаруй аж ахуйн нэгж



2023-06-14

БҮРТГЭВ-03



байгууллагуудтай хамтран, 180 ажилтан, мэргэшсэн баг хамт олонтойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Импортын тээвэр

Импортын тээврийн зах зээлд Үнэт цаас гаргагчийн “Монложистикс Ворлдвайд” ХХК, “Монложистикс Экспресс” ХХК, “Монложистикс Карго” ХХК гэсэн охин компаниуд нь тээврийн үйлчилгээг үзүүлдэг. Үүнээс “Монложистикс Ворлдвайд” ХХК нь 2005 оноос хойш 18 жилийн турш импортын тээврийн үйлчилгээг ачаа тээврийн бүрэн даатгал, дараа төлбөрт уян хатан нөхцөлтэйгээр үзүүлж байна.

“Монложистикс Карго” ХХК нь Sheeran брэндийг хөгжүүлж харилцагчдад онлайнаар худалдан авалт хийх, түүнийг түргэн шуурхай харилцагчдын гарт хүргэх тээврийн үйлчилгээг зохион байгуулдаг. “Монложистикс Экспресс” ХХК нь бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч олон улсын харилцагчдад бараа бүтээгдэхүүнийг Монгол Улс руу илгээх тээврийн үйлчилгээг үзүүлдэг.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн импортын тээврийн охин компаниуд нь борлуулалтын орлогын 75.1 хувийг, цэвэр ашгийн 63.2 хувийг, нийт хөрөнгийн 67.8 хувийг бүрдүүлж байна.

Экспортын тээвэр

Үнэт цаас гаргагчийн охин компани “Каус Аустралис” ХХК нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн үйлчилгээг үзүүлдэг. Тус компани нь 2022 онд 5 цуваа буюу 250 ширхэг тавцант вагон, 500 гаруй задгай чингэлгээр 67.0 мянган тонн нүүрс, цайрын баяжмалын экспортын тээврийг хийж гүйцэтгэсэн.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн охин компани нь борлуулалтын орлогын 5.0 хувийг, цэвэр ашгийн 10.7 хувийг, нийт хөрөнгийн 14.3 хувийг бүрдүүлж байна.

Транзит тээвэр

Үнэт цаас гаргагчийн охин компани “Монложистикс Транзит” ХХК нь транзит тээврийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Тус компани нь ОХУ-ын хамгийн том чингэлэг тээврийн компани болох “Транс Контейнер” ХК-ийн Монгол Улсаар дамжин өнгөрөх ачаа тээврийг зохион байгуулдаг.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн транзит тээврийн охин компани нь борлуулалтын орлогын 15.2 хувийг, цэвэр ашгийн 16.0 хувийг, нийт хөрөнгийн 11.2 хувийг бүрдүүлж байна.


Бусад тээвэр

Үнэт цаас гаргагчийн “Монложистикс Транс Сервис” ХХК, “Монложистикс Россия Холдинг” ХХК, “Монложистикс Тракинг” ХХК, “Монложистикс Экүйпментс” ХХК гэсэн охин компаниуд нь ОХУ дахь тээврийн үйл ажиллагаа, авто тээврийн төрөлжсөн үйлчилгээ, хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн үйл ажиллагаа зэргээр Үнэт цаас гаргагчийн бий болгосон тээвэр ложистикийн экосистемийг бүрдүүлэн ажилладаг.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн бусад тээврийн охин компаниуд нь борлуулалтын орлогын 4.6 хувийг, цэвэр ашгийн 10.1 хувийг, нийт хөрөнгийн 6.7 хувийг бүрдүүлж байна.


Санхүүгийн төлөв байдал

Хуулийн этгээдийн хувьд “Монложистикс Холдинг” ХХК буюу Монложистикс Группийн толгой компани нь Үнэт цаас гаргагч боловч санхүүгийн тайлагналын хувьд Монложистикс Группийн толгой болон 9 охин компаниудыг нэгтгэсэн байдлаар Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд тодорхойлогддог.



2023-06-14

БҮРТЭГ-03



Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 2020 онд "Бэйкер Тилли Далайван Аудит" ХХК, 2021 болон 2022 онд "Грант Торнтон Аудит" ХХК хараат бус аудит хийж гүйцэтгэн дүгнэлт гаргасан.

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2022 онд өмнөх онтой харьцуулахад 70 хувиар өсөж, 140 тэрбум төгрөгт хүрсэн. 2013-2022 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого жилийн дундаж нийлмэл өсөлтөөр (цаашид "жилд дунджаар" гэх) 27 хувь, 2020-2022 онд жилд дунджаар 51 хувиар өссөн.

2022 онд Үнэт цаас гаргагчийн орлого 70 хувиар өсөхөд 1) тээврийн тоо ширхэг 26 хувиар өссөн 2) тээврийн үнэ 32 хувиар өссөн 3) ам.долларын ханш 12 хувиар өссөн нь нөлөөлсөн. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого гадаад валютаар илэрхийлэгддэгээр онцлогтой. Тодруулбал, 2022 оны байдлаар борлуулалтын орлогын 82 хувь нь гадаад валютаар орж ирсэн нь төгрөгийн орлоготой бизнесүүдтэй харьцуулахад Үнэт цаас гаргагчид ханшийн эрсдэл бага болохыг илтгэж байна.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөг 123 тэрбум төгрөг, нийт ашиг 16.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж, нийт ашгийн маржин 12.0 хувь байна. 2022 онд Үнэт цаас гаргагч нь 9.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь (цэвэр ашгийн маржин 6.9 хувь) өмнөх онтой харьцуулахад 149 хувиар өссөн үзүүлэлт юм. 2013-2022 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг жилийн дундаж нийлмэл өсөлтөөр (цаашид "жилд дунджаар" гэх) 23.6 хувь, 2020-2022 онд жилд дунджаар 65.8 хувиар өссөн.

Тус цэвэр ашгийн 86 хувь буюу 8.4 тэрбум төгрөг нь толгой компани буюу "Монложистикс Холдинг" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд, 14 хувь буюу 1.3 тэрбум төгрөг нь хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдож байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь 41.8 тэрбум төгрөгийн (өмнөх онтой харьцуулахад 64.3 хувиар өссөн) нийт хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 94.3 хувийг эргэлтийн хөрөнгө, 5.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Нийт хөрөнгийн 40.6 хувийг өр төлбөр, 59.4 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн нийт эздийн өмч 24.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж буйгаас 22.9 тэрбум төгрөг нь толгой компани буюу "Монложистикс Холдинг" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд, 1.9 тэрбум төгрөг нь хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдож байна.

2022 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны эргэц сайжирсан (авлага цуглуулах дундаж хугацаа 50 хоног, өглөг төлөх дундаж хугацаа 33 хоног), хөрвөх чадвар өндөр (эргэлтийн харьцаа 2.4), өрийн дарамт бага (өр төлбөрийн нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ 40.6 хувь), ашигт ажиллагаа өндөр (нийт хөрөнгийн өгөөж 23.2 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 38.4 хувь) байна.

Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтээр Үнэт цаас гаргагч нь Монголын хөрөнгийн зах зээлд 2015 оноос хойш нийтэд анх удаа хувьцаа санал болгосон компаниудаас нэгдүгээрт, Монголын хөрөнгийн биржийн I ангиллын хувьцаат компаниудтай харьцуулахад хоёрдугаарт бичигдэж байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нэгж эздийн өмчид ногдох ашиг өндөр болохыг илэрхийлж байна.

Үнэт цаас гаргагч нь нийтэд анх удаа хувьцаа санал болгох хүрээнд 10,985,082,070 төгрөгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлнэ. Тус санхүүжилтын 73 хувь буюу 8.1 тэрбум төгрөгийг экспортын тээврийн үйл ажиллагаанд шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалтад, 27 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд зарцуулна.

Дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг хийснээр 2023-2027 онд Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого жилд дунджаар 25.1%



2023-06-14

В-03

СЗХ
ОН
БҮР
№

хувиар өсөж, 2027 онд 428.6 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Тус хугацаанд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг жилд дунджаар 28.1 хувиар өсөж, 2027 онд 33.5 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө жилд дунджаар 36 хувиар өсөж, 198.2 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Тээвэр ложистикийн салбарын төлөв байдал

Тээвэр ложистикийн салбар нь далайд гарцгүй Монгол Улсын хувьд гадаад худалдаа, эдийн засгийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн нөхцөл байдал

2022 оны байдлаар Монгол Улсын гадаад худалдаа нь дотоодын нийт бүтээгдэхүүн (цаашид "ДНБ" гэх)-ийн 126 хувийг эзэлж буй нь дэлхийн дундажтай харьцуулахад 2 дахин өндөр үзүүлэлт боловч Дэлхийн банкнаас гаргасан Ложистикс гүйцэтгэлийн индексийн үнэлгээгээр 160 орноос 130-д эрэмбэлэгдсэн нь Монгол Улс гадаад худалдаа болон тээвэр ложистикийн салбараас өндөр хамааралтай боловч тээвэр ложистикийн салбарын хөгжил сул байгааг илэрхийлж байна.

2022 оны байдлаар Монгол Улсын тээврийн салбарын орлого 2.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж буй нь ДНБ-ийн 4.0 хувьтай тэнцэж байна. Тайлант хугацаанд Монгол Улсын хэмжээнд 60.8 сая тонн ачаа тээвэрлэгдсэнээс 66 хувийг экспорт, 20 хувийг дотоод, 9 хувийг импорт, 5 хувийг транзит тээвэр бүрдүүлж байна. Үүнд экспортын тээврийн 78 хувийг нүүрсний тээвэр эзэлж байна.

Цаашдын төлөв байдал болон Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь

Тээвэр ложистикийн зах зээлийн 2023-2027 оны төлөв байдлыг тээврийн тоо хэмжээг төсөөлж, түүнтэй уялдуулан тээврийн салбарын орлогыг тодорхойлсон.

Тодруулбал, экспорт болон импортын тээврийн тоо хэмжээний өсөлтийг Олон улсын валютын сангийн төсөөлөлд үндэслэж, үр дүнг тус тээврүүдийн дэд бүтцийн хүчин чадал болон олон улсын гадаад худалдааны эргэлттэй харьцуулан шалгасан. Транзит тээврийн тоо хэмжээг 2013-2022 оны түүхэн дундаж өсөлт болон төмөр замын зүүн корридор ашиглалтад орохтой уялдуулан төсөөлж, үр дүнг БНХАУ-ОХУ, БНХАУ-Европын улс хоорондын ачаа тээврийн Монгол Улсаар дамжин өнгөрөх түүхэн хэмжээтэй харьцуулан шалгасан. Дотоод тээврийн тоо хэмжээг 2013-2022 оны түүхэн дундаж өсөлтөөр төсөөлсөн.

Дээрх төсөөлөлд суурилахад 2027 онд Монгол Улсын нийт тээврийн тоо хэмжээ 90.0 сая тоннд хүрэх төлөвтэй байна. Үүнд 70 хувийг экспорт, 14 хувийг дотоод, 9 хувийг транзит, 7 хувийг импортын тээвэр бүрдүүлж байна. Улмаар тээврийн салбарын орлогыг тээврийн тоо хэмжээнээс хамааруулан тооцоход 2027 онд Монгол Улсын тээврийн салбарын орлого 4.0 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Тус төсөөллийг макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулан шалгахад бага гарсан буюу консерватив хандлагаар боловсруулсан.

Тээврийн салбарын орлого 2022 онд 2.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж буйгаас Үнэт цаас гаргагч нь зах зээлийн 6.9 хувийг бүрдүүлж байна. Богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Үнэт цаас гаргагч нь 2027 онд зах зээлийн 11.1 хувийг эзлэх төлөвтэй байна.

Богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө

Богино болон дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь импортын тээврийн байгууллага суурьтай буюу B2B зах зээлд үнэнч харилцагчдыг тогтоон барих, шинэ харилцагчдыг татах замаар үйлчилгээгээр ялгарах стратегийг хэрэгжүүлж, харилцагч суурьтай буюу B2C зах зээлд оновчтой хөрөнгө оруулалт хийх замаар



2023-06-14

БҮРТГЭВ-03

СЭХ
ОН
БҮРТГЭВ
№ 0

өртгийг бууруулан, үнэ болон үйлчилгээгээр ялгарах стратегийг хэрэгжүүлж зах зээлд эзлэх байр суурийг тэлнэ.

Экспортын тээврийн зах зээл богино хугацаанд өндөр өсөлт үзүүлэх төлөвтэй байгаа тул Үнэт цаас гаргагч нь тус зах зээлд өсөлтийн стратеги баримтлан, өөрийн эзэмшлийн дэд бүтцийг бий болгоно. Транзит тээврийн зах зээлд эзлэх байр суурийг "Монложистикс Транс Сервис" ХХК-тай хамтарсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх, үйлчилгээний чанар стандартыг олон улсын түвшинд хүргэхээр замаар тэлэхээр төлөвлөсөн.

Үнэт цаас гаргагч нь урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангах хүрээнд технологид суурилах, дэд бүтцэд хөрөнгө оруулах, байгаль орчин, нийгэм, засаглалын хөгжлийг төгөлдөршүүлэх гэсэн үндсэн 3 бодлогыг баримталж байна.

Бизнесийн үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг "Гэрэгэ Эстимэйт" ХХК орлогын хандлагын аргаар хийж гүйцэтгэсэн. Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь охин компани тус бүрийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг тодорхойлж нэгтгэн 2022 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаарх Монложистикс Группийн 100 хувийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг 112,790,116,117 төгрөгөөр үнэлсэн.

Үүнээс Үнэт цаас гаргагч "Монложистикс Холдинг" ХХК-д хамаарах үнэ цэн болон толгой компанийн хөнгөлтийг хассанаар Үнэт цаас гаргагчийн олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсний дараах бизнес өмчлөлийн үнэ цэнийг (Post-Money Valuation) 81,472,025,102 төгрөгөөр тодорхойлсон. Энэ нь нэгж хувьцааны үнээр илэрхийлбэл 206 төгрөгтэй тэнцэж байна.

Нийтэд санал болгох үнэлгээ

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлттэй уялдуулан нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 185 төгрөгөөр буюу бизнесийн үнэлгээнээс 10 хувийн хямдруулалттай үнээр санал болгохоор шийдвэрлэсэн.

Ногдол ашгийн бодлого

Үнэт цаас гаргагч нь нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болж өөрчлөн байгуулагдсаны дараа Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, нөхцөлийг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн тогтооно.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашгийн хэмжээ нь тайлант үеийн татварын дараах цэвэр ашгийн 20-50 хувьтай тэнцүү байна.

Эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, дэд бүтэц доголдох, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, ханшийн хэлбэлзэл үүсэх, үнэнч харилцагчийг алдах, хөдлөх бүрэлдэхүүн, ажиллах хүчин хомстох, хууль эрх зүйн орчинд өөрчлөлт гарах зэрэг эрсдэлүүд учирч болзошгүй байна.

Андеррайтер нь хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, дэд бүтэц доголдох, хууль эрх зүйн орчинд өөрчлөлт бий болох эрсдэлийг учрах магадлал болон хохирлын хэмжээгээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн эрсдэлүүдээр тодорхойллоо.

Хууль эрх зүйн орчинд өөрчлөлт гарах





Тээвэр ложистикийн салбарын хууль эрх зүйн хүрээнд холбогдох олон улсын дүрэм журам, дотоодын хууль эрх зүйн зохицуулалт өөрчлөгдөх, түүнийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үйл ажиллагааны хязгаарлалтад орох эрсдэлтэй. Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаанд Зам, тээврийн хөгжлийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газраас тусгай зөвшөөрлүүдийг авч, дүрэм журмыг мөрдөн ажиллаж тус эрсдэлийг бууруулдаг.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй уул, уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн зохицуулалт болон улс төрийн эрсдэл өндөртэй салбар юм. Тодруулбал, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрэн тодорхойлогдоогүй, шинэчилсэн зохицуулалтууд тухай бүр бий болж буй нь Үнэт цаас гаргагчийн экспортын тээврийн бизнесийн үйл ажиллагааг тасалдуулах, ашигт ажиллагааг бууруулах эрсдэлтэй. Үнэт цаас гаргагч нь 18 жилийн турш бий болгосон БНХАУ-ын компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, нүүрс худалдан авах компаниудтай хамтран ажиллах замаар тус эрсдэлийг бууруулахаар төлөвлөсөн байна.

Хил гаалийн хэвийн үйл ажиллагаа алдагдах

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, улс төр, эдийн засгийн хямрал, геополитикийн таарамжгүй нөхцөл байдал зэрэг нь хил гаалийн хориг саадыг бий болгож, боомтын хэвийн үйл ажиллагаа алдагдсанаар тээврийн эргэлт удаашрах, өртөг нэмэгдэх, улмаар Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй.

Тус эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь хамтран ажиллагч түншүүдийн холбоо өргөжүүлэн, нэг боомт, нэг улсаас хамаарах хамаарлыг бууруулах замаар удирдаж байна. Үнэт цаас гаргагч нь 2020-2022 онд ОХУ болон БНХАУ-ын хамтран ажиллагч түнш байгууллагыг 2 дахин нэмэгдүүлэн, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар 160 орны 800 түнш байгууллагатай, боомтын сувгийг 3 дахин нэмэгдүүлэн, 9 боомтоор дамжуулан тээврийн үйл ажиллагаа явуулж, нэг боомт, нэг улсаас хараат байдлыг бууруулж байна.

Дэд бүтэц доголдох

Тээврийн дэд бүтцэд техникийн эвдрэл гэмтэл гарах, терминалын хүчин чадлын ашиглалт дүүрэх, хэвийн үйл ажиллагаа алдагдсаны улмаас тээврийн эргэлт удаашрах, бизнесийн тасралтгүй хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй. Тус эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь гэрээт терминалын тоог нэмэгдүүлж, нэг терминалаас хамаарах хамаарлыг бууруулах замаар удирддаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 14 гаалийн терминал үйл ажиллагаа явуулж буйгс Үнэт цаас гаргагч нь бүх терминалтай хамтран ажиллаж байна. Мөн дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь өөрийн эзэмшлийн дэд бүтэц, терминалыг бий болгох замаар гуравдагч байгууллагын үйл ажиллагаанаас хамаарах тус эрсдэлийг бууруулна гэж дүгнэж байна.

Дүгнэлт


Андеррайтер "Мандал Капитал Маркетс ҮЦК" ХХК нь өөрийн судалгаа шинжилгээ, хөндлөнгийн аудит, хууль, үнэлгээний байгууллагын тайлан дүгнэлт болон холбогдох бусад баримт бичигт үндэслэн "Монложистикс Холдинг" ХХК-ийн 59,378,822 ширхэг энгийн хувьцааг нэгж хувьцааны үнийг 185 төгрөгөөр нийтэд анх удаа санал болгож, анхдагч зах зээлээс 10,985,082,070 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн ирээдүйн төсөөлөл, таамаглал, биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хувьцааны ханшийн талаар Андеррайтер нь ямар нэгэн баталгаа гаргаагүй болно. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа



2023-06-14

БҮРЭГ-03



болон бусад гадаад хүчин зүйлсийн эрсдэлүүд нь хувьцааны ханшид нөлөөлж болох тул хөрөнгө оруулагчид компанийн үйл ажиллагаа, гадаад болон дотоод хүчин зүйлсийн эрсдэл, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахыг Андеррайтерийн зүгээс зөвлөж байна.

Дүгнэлтийг гаргасан:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЖЭЭЧ

Б.ПҮРЭВ

Дүгнэлтийг баталгаажуулсан:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХТУЯА





Grant Thornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

Үнэт цаасны танилцуулга дахь санхүүгийн мэдээллүүдийг аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгасан тухай Аудиторын тодорхойлох захидал

Далай тауэр 9 дөвхөр, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Улаанбаатар 14230,
Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Gate Tower, 9/F, UNESCO street,
Sukhbaatar District-1, Ulaanbaatar
14230, Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

"Монложистикс Холдинг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд

Бид "Монложистикс Холдинг" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2021, 2022 онуудын 12-р сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Компанийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс гаргадаг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн ба бид материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлэгдсэн гэж үзэж өөрчлөлтгүй дүгнэлтийг өгсөн.

Тодорхойлох захидлын хамрах хүрээ, зорилго

"Монложистикс Холдинг" ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 сарын 10-ны өдрийн 23/ХЭХ/13 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 17-ны өдрийн 23/ТУЗ/10/01 тогтоолыг тус тус үндэслэн нээлттэй хувьцаат компани болохоор хувьцаагаа олон нийтэд санал болгож байна.

Энэхүү хувьцаагаа нийтэд санал болгох үйл ажиллагааны хүрээнд "Грант Торнтон аудит" ХХК нь "Монложистикс Холдинг" ХХК-ийн 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийсэн бөгөөд тус компанийн зүгээс хувьцаагаа нийтэд санал болгохтой холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр хүргүүлж буй үнэт цаасны танилцуулга, уг танилцуулгад багтсан нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 6





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

дугаар сарын 11-ний 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу хяналт хийлээ.

Компанийн үүрэг хариуцлага

Үнэт цаасны танилцуулгад толилуулсан санхүүгийн түүхэн мэдээллүүдийн үнэн зөв байдал болон үнэт цаасны танилцуулгад дурьдах шаардлагатай иж бүрэн байдлыг компани хариуцна.

Аудиторын үүрэг хариуцлага

Бид Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400 Тохиролцсон горимоор гүйцэтгэх гэрээт ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ний 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан шаардлагуудын дагуу зохих аудитын горимуудыг гүйцэтгэсэн.

Энэхүү гэрээт ажил нь Аудитын олон улсын стандарт, Баталгаажуулах гэрээт ажлын олон улсын стандарт болон Нягтлах гэрээт ажлын олон улсын стандарт шиг баталгаажуулах дүгнэлт өгдөггүй, харин ажлын даалгаар болон дүрэм журмаар шаардсан зүйлсийн хүрээнд аудитын горимуудыг гүйцэтгэж, үр дүнг тайлагнадаг юм.

Хараат бус байдал

Энэхүү Тодорхойлох захидалтай холбогдуулж дараах зүйлсийг мэдэгдэж байна. Үүнд:

- Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Монгол Улсын Аудитын тухай хуулиар аудитын үйлчилгээнд тавигддаг ёс зүйн шаардлагууд болон манай компанийн Чанарын удирдлагын гарын авлагад заасан ёс зүйн шаардлагын дагуу тус компаниас хараат бус, сонирхлын зөрчилгүй гэдгээ баталгаажуулж, хараат бус байх үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.
- Бид үнэт цаас гаргагч "Монложистикс Холдинг" ХХК болон бусад мэргэжлийн оролцогч нартай аливаа сонирхлын зөрчилгүй бөгөөд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэсэн горимуудын тайлбар

Үнэт цаасны танилцуулгын 2.6-д Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээгээр үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ, харьцааны үзүүлэлтүүдийг харуулсан байна. Тухайлбал:

- Үнэт цаасны танилцуулгын 2.6-д Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээллүүд, санхүүгийн хураангуй тайлан нь дараах мэдээллүүдээс бүрдэж байна.





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

- Орлогын тайлангийн шинжилгээ (Хуудас 65)
- Борлуулалтын орлого (Хуудас 65)
- Борлуулалтын өртөг болон үйл ажиллагааны зардал (Хуудас 69)
- Үйл ажиллагааны бусад зардал (Хуудас 70)
- Үйл ажиллагааны ашиг (Хуудас 70)
- Ханшийн зөрүүний олз/гарз (Хуудас 71)
- Хүүгийн зардал (Хуудас 71)
- Татварын дараах цэвэр ашиг (Хуудас 71)
- Орлогын тайлангийн шинжилгээ - Хүснэгт 16 (Хуудас 73)
- Санхүү байдлын тайлангийн шинжилгээ - Хүснэгт 17 (Хуудас 76)
- Хөрөнгө (Хуудас 76-77)
- Эх үүсвэр (Хуудас 77-78)
- Санхүүгийн харьцааны задаргаа (Хуудас 83)
- Мөнгөн урсгалын тайлангийн шинжилгээ (Хуудас 84)

Санхүүгийн түүхэн мэдээллүүд дээрээ үндэслэн дараах графикуудыг оруулсан байна.

Үүнд:

- График 1. Үнэт цаас гаргагчийн 2021, 2022 оны нийт тээврийн тоо ширхэг (Хуудас 66)
- График 4. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2021, 2022 он (Хуудас 68)
- График 5. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого, түүний өсөлтийн хувь 2021, 2022 он (Хуудас 69)
- График 6. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын өртөг, борлуулалтад эзлэх хувь 2021, 2022 он (Хуудас 69)
- График 7. Ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалтад эзлэх хувь 2021, 2022 он (Хуудас 70)
- График 8. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ашиг, борлуулалтад эзлэх хувь (Хуудас 71)
- График 9. Үнэт цаас гаргагчийн нийт цэвэр ашиг, түүний бүтэц 2021, 2022 он (Хуудас 72)
- График 10. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого ба цэвэр ашгийн задаргаа (Хуудас 74)
- График 11. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө (Хуудас 77)
- График 12. Өр төлбөр ба эзний өмчийн дүн (Хуудас 77)
- График 14. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны харьцаа, үзүүлэлтүүд (Хуудас 81)
- График 15. Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварын харьцаа, үзүүлэлтүүд (Хуудас 81)
- График 16. Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн харьцаа үзүүлэлтүүд (Хуудас 82)
- График 17. Үнэт цаас гаргагчийн ашгийн маржин (Хуудас 82)
- График 18. Үнэт цаас гаргагчийн өгөөжийн харьцаа, үзүүлэлт (Хуудас 83)





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

- Хүснэгт 20-д харуулсан санхүүгийн хураангуй тайлан дээр үндэслэж дараах санхүүгийн шинжилгээнүүдийг тооцож, гаргасан байна. (Хуудас 80)

Үүнд:

- Үйл ажиллагааны эргэц
- Хөрвөх чадварын харьцаа
- Өрийн харьцаа
- Ашигт ажиллагааны харьцаа

Бид Үнэт цаасны танилцуулгад багтсан дээрх санхүүгийн түүхэн мэдээллүүд, эдгээр мэдээллүүд дээр үндэслэж хийсэн график дүрслэл болон харьцааны шинжилгээнүүд нь үнэн зөв тооцогдсон эсэхийг хянасан. Харьцааны болон санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцсон байна. Хураангуй санхүүгийн тайлан нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнтэй тохирч байна.

Үүнтэй холбоотой бид дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэт цаасны танилцуулгад дурьдсан санхүүгийн түүхэн мэдээллийг аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тоо мэдээтэй тулгасан.
- Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн тооцоолсон компанийн нийт хөрөнгө, өр төлбөр, эх үүсвэр, борлуулалтын орлого, түүний өсөлтийн хувь, өртөг болон үйл ажиллагааны зардал, цэвэр ашгийн талаарх тоон болон график мэдээллүүдийг давтан шалгасан.
- Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн гаргасан ашигт ажиллагааны харьцааны үзүүлэлтүүдийг давтан тооцоолсон.

Үнэт цаасны бүртгэлийн журмаар шаардсан бусад асуудал

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцэж буй эсэх, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үр ашигтай байдлыг хангаж чадаж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг гүйцэтгэсэн.

Бидний дүгнэлтээр, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг компанийн удирдлага тогтоосон ба 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү дотоод хяналтын дүрэм, журмаар тогтоосон процедурын дагуу санхүүгийн тайлангийн үр дүнтэй дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна гэж дүгнэсэн.

Дотоод хяналтыг шалгах аудитын горимын үр дүнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүний үр ашигтай байдлыг хангаж байна гэж дүгнэсэн. Үүнтэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналт, үүнд хяналтын орчин, эрсдэлийн үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл болон харилцаа, мониторинг зэргийн талаар ойлголт олж авсан ба эдгээр хяналтуудын талаар даган мөшгих сорил гүйцэтгэсэн.
- Эдгээр горимын үр дүнд компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналтад томоохон сул тал илрээгүй ба сайжруулах шаардлагатай зарим нэг асуудлын талаар компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлсэн.

Гүйцэтгэсэн аудитын горимуудтай холбоотой хязгаарлалтууд

- Үнэт цаасны танилцуулгыг хянаж дүгнэлт гаргах эдгээр аудитын горимууд нь зөвхөн санхүүгийн түүхэн мэдээллийг хамарсан ба дунд хугацааны бодлого, стратеги төлөвлөгөө болон санхүүгийн хэтийн төсөөллийг хамраагүй болно.
- Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хойших дараа үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийгээгүй учир уг өдрөөс хойш энэхүү захидал гарах хүртэлх санхүүгийн мэдээллийг аудитлаагүй болно.
- Дээр дурдсан горимууд нь хууль тогтоомж болон СЭХ-ны дүрэм журмын шаардлагын хүрээнд хийгдсэн ба эдгээр горимуудаар бид үнэт цаасны танилцуулгатай холбоотой бүх асуудлуудыг илрүүлэх шаардлагагүй бөгөөд танилцуулгад орсон бүх мэдээллүүд нь үнэн зөв эсэхэд ямар нэгэн баталгаа өгөхгүй.
- Эдгээр горимын үр дүнд бидний анхааралд өртсөн зөрүүтэй илэрхийлэл илрээгүй боловч үнэт цаасны танилцуулгад дурьдсан хяналт хийгдээгүй бусад мэдээллүүд нь бидний хяналт хийсэн санхүүгийн мэдээлэл болон холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа гэдэгт итгэж байна.
- Энэхүү тайланг зөвхөн үнэт цаас гаргахтай холбоотой андеррайтерийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд өөр бусад зорилгоор бэлтгээгүй болно.



Б.О.СОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

Улаанбаатар, Монгол улс
Огноо: 2023 оны 04 дүгээр сарын 27





monlogistics
HOLDING



МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

INITIAL PUBLIC OFFERING (IPO)

ХАРААТ БУС БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар Дүүрэг, 8-р Хороо
Сүхбаатарын талбай 20-6
Эрдэм товер, 1004 тоот
Утас: +976 7000 5000
Имэйл: gantulga@geregepartners.mn

Үнэлгээний өдөр
2022.12.31

Тайлангийн өдөр
2023.04.03





Монложистикс Холдинг ХХК-ийн Удирдлагад

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж
Нью Хоризонс оффис, 1101 тоот
Улаанбаатар, Монгол улс



2023 оны 4-р сарын 03-ны өдөр

Бизнесийн үнэлгээний үр дүнг хүргүүлэх тухай

Танай компанитай 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх" 23/УАГ/03, ГЭ-02/23 дугаар гэрээний дагуу бид Монложистикс Холдинг ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 81,472,025,102 (Наян нэгэн тэрбум дөрвөн зуун далан хоёр сая хорин таван мянга нэг зуун хоёр) төгрөг байхаар тооцоолж үнэлгээний үр дүнг хүргүүлж байна.

Энэхүү үнэлгээний ажлыг Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход тус компанийн хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Үнэлгээний тооцоололд Монложистикс Холдинг ХХК -иас ирүүлсэн мэдээлэл болон Үнэлгээчдийн өөрсдийн хийсэн шинжилгээ, төсөөллийг ашиглав.

Үнэлгээний ажилтай холбоотой асуулт, тодруулга байвал бидэнтэй холбоо барихыг хүсье.

Хүндэтгэсэн,


Гэрэгэ Эстимэйт ХХК-г төлөөлж:



Д.Ганбаатар, ММУ
Мэргэшсэн үнэлгээчин
Гүйцэтгэх захирал

Д.Гантулга, MRICS, MMY
Мэргэшсэн үнэлгээчин
Үнэлгээ хариуцсан захирал






1. ЕРӨНХИЙ ТОЙМ.....	5
2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД.....	8
3. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ.....	10
Макро эдийн засгийн төлөв байдал	10
Гадаад худалдаа	12
Тээвэр, ложистикийн салбар.....	13
Нүүрсний тээвэр	17
4. МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ТУХАЙ.....	19
Ерөнхий мэдээлэл	19
Санхүүгийн мэдээлэл	21
5. ҮНЭЛГЭЭ.....	23
Зах зээлийн харьцуулалтын шинжилгээ.....	23
Олон улсын компаниудын PE, PB харьцаа	23
Дотоодын компаниудын PE, PB харьцаа	28
Хөрөнгөд сүүрилсэн үнэлгээ	31
Охин компаниудын цэвэр хөрөнгийн үнэ цэнэ	31
Монложистикс Холдинг ХХК-ийн тусдаа компанийн хөрөнгө	33
Цэвэр хөрөнгө	33
Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ.....	34
Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл.....	34
Монложистикс Группийн ирээдүйн орлогын төсөөлөл	35
Монложистикс Группийн ирээдүйн зардлын төсөөлөл	39
Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувь	41
Ирээдүйн цэвэр мөнгөн үрсгалын төсөөлөл	43
Үнэлгээний үр дүн	47
Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ	48
Мэдрэмжийн шинжилгээ.....	49
6. ХАВСРАЛТ	51



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК





Зураг 1. ДНБ-ний өсөлт бууралт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр.....	10
Зураг 2. Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт	11
Зураг 3. Монгол Улсын гадаад худалдааны эргэлт.....	12
Зураг 4. Тээврийн салбарын орлогын өсөлт.....	13
Зураг 5. Тээврийн салбар ДНБ-д эзлэх хувиар	14
Зураг 6. Тээврийн орлого, тээврийн төрлөөр.....	14
Зураг 7. Экспортын ачаа гаргалт (мян.тн)	15
Зураг 8. Импортын ачаа оруулалт (мян.тн).....	15
Зураг 9. Дамжин өнгөрөх ачаа, төмөр зам (мян.тн)	16
Зураг 10. Монгол болон бусад 5 улсын LPI үзүүлэлтийн харьцуулалт, 2018 он	17
Зураг 11. Нүүрсний олборлолт, борлуулалт болон экспорт	17
Зураг 12. Төмөр замаар тээвэрлэсэн нүүрсний тоо хэмжээ	18
Зураг 13. “Боомтын сэргэлт” бодлогын үндсэн зорилт.....	25
Зураг 14. ROE болон РВ харьцааны регрессийн үр дүн.....	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол улсын эдийн засгийн төсөөлөл	10
Хүснэгт 2. Монгол төгрөгийн ханшийн мэдээлэл	11
Хүснэгт 3. Экспортын бараа эргэлт тээврийн төрлөөр.....	12
Хүснэгт 4. Импортын бараа эргэлтийн тээврийн төрлөөр.....	13
Хүснэгт 5. Монгол улсын ложистикийн гүйцэтгэлийн индекс.....	16
Хүснэгт 6. Монложистикс Группийн бүтэц, зохион байгуулалт.....	19
Хүснэгт 7. Монложистикс Группийн балансын үзүүлэлтүүд, 2019-2022 он.....	21
Хүснэгт 8. Монложистикс Группийн орлого үр дүнгийн үзүүлэлтүүд 2019-2022 он.....	21
Хүснэгт 9. Монложистикс Группийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 2019-2022 он	22
Хүснэгт 10. Үнэлгээний харьцаанууд, АНУ	26
Хүснэгт 11. Үнэлгээний харьцаанууд, БНХАУ	26
Хүснэгт 12. Үнэлгээний харьцаанууд, Малайз улс	27
Хүснэгт 13. Үнэлгээний харьцаанууд, Тайланд улс.....	27
Хүснэгт 14. Үнэлгээний харьцаанууд, Индонези улс	28
Хүснэгт 15. Үнэлгээний харьцаанууд, Улсуудын дундаж дүн	28
Хүснэгт 16. Эздийн өмч ойролцоо компаниудын PE, РВ харьцаа	29
Хүснэгт 17. Үндсэн ба биет бус хөрөнгийн үнэлгээ.....	32
Хүснэгт 18. Бусад эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ	32
Хүснэгт 19. Эргэлтийн хөрөнгийн үнэлгээ	32
Хүснэгт 20. Өр төлбөр	32
Хүснэгт 21. Монложистикс Холдинг ХХК (тусдаа), цэвэр хөрөнгийн үнэ цэнэ	33
Хүснэгт 22. Монложистикс Холдинг ХХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ.....	33
Хүснэгт 23. Эдийн засгийн үзүүлэлтүүд, 2022 – 2027 он.....	34
Хүснэгт 24. Орлогын төсөөлөл, Импортын ангилал, 2022 – 2027 он	36
Хүснэгт 25. Орлогын төсөөлөл, Экспортын ангилал, 2022 – 2027 он	37



Хүснэгт 26. Орлогын төсөөлөл, Транзит ангилал, 2022 – 2027 он	38
Хүснэгт 27. Орлогын төсөөлөл, Бусад тээврийн ангилал, 2022 – 2027 он	39
Хүснэгт 28. Нийт ашгийн маржин, борлуулалтын өртөг, 2022 – 2027 он	40
Хүснэгт 29. Үйл ажиллагааны болон бусад зардал, 2023 – 2027 он	41
Хүснэгт 30. Монложистик Группийн орлогын төсөөлөл, 2023 – 2027 он	43
Хүснэгт 31. Монложистик Группийн капитал зардлын тооцоолол, 2023 – 2027 он	44
Хүснэгт 32. Монложистик Группийн ажлын капиталын өөрчлөлт, 2023 – 2027 он	45
Хүснэгт 33. Монложистик Группийн цэвэр зээл, 2023 – 2027 он	45
Хүснэгт 34. Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээний үр дүн	48
Хүснэгт 35. Зах зээлийн харьцуулсан үнэлгээ	49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ -	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ -	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ -	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ -	Засгийн газар
ЗЗҮ -	Зах зээлийн үнэлгээ
КА -	Каус Аустралис
МЛВ -	Монложистикс Ворлдвайд
МЛК -	Монложистикс Карго
МЛХ -	Монложистикс Холдинг
МЛТ -	Монложистикс Транзит
МЛТр -	Монложистикс Тракинг
МЛТС -	Монложистикс Транс Сервис
МЛЭ -	Монложистикс Экүйпментс
МХБ -	Монголын Хөрөнгийн Бирж
ОХУ -	Оросын Холбооны Улс
ОУВС -	Олон Улсын Валютын Сан
СЗХ -	Санхүүгийн Зохицуулах Хороо
ҮОУС -	Үнэлгээний Олон Улсын Стандарт
ХХК -	Хариуцлагатай хувьцаат компани
ХК -	Хувьцаат Компани



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



1. ЕРӨНХИЙ ТОЙМ

Тайлангийн өдөр

Үйлчлүүлэгч

Үнэлгээнд хамрагдсан хөрөнгө

Үнэлгээний өдөр

Үнэлгээний стандартын нийцэл

Тайлангийн зорилго /
Үнэлгээний ажлын заавар

Ашигласан үнэ цэнийн суурь

Бизнес өмчлөлийн тооцоолсон нийт үнэ цэн

2023 оны 4-р сарын 03-ны өдөр

Монложистикс Холдинг ХХК
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж
Нью Хоризонс оффис, 1101 тоот, Улаанбаатар, Монгол улс

Монложистикс Холдинг ХХК -ийн 100%-ийн бизнес өмчлөл.
Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбаруудыг Хавсралт 1-д үзүүлэв.

2022 оны 12-р сарын 31-ний өдөр

Үнэлгээний Олон Улсын Стандарт 2022 (ҮОУС 2022)

Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгох ажлын хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д заасан үнэт цаасны танилцуулга бэлтгэх зорилгоор Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС) болон Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэх.

Зах зээлийн үнэ цэнэ

Монложистикс Холдинг ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 81,472,025,102 (Наян нэгэн тэрбум дөрвөн зуун далан хоёр сая хорин таван мянга нэг зуун хоёр) төгрөг байхаар тооцоолов.

Бидний үнэлгээ дараах мэдээлэлд тулгуурласан болно:

- Санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, санхүүгийн загвар гэх зэрэг Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл;
- Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл;
- Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана.

Бид Үйлчлүүлэгчээс өгсөн мэдээлэл болон бичиг баримтын буруу зөвд хариуцлага хүлээхгүй болно.

Таамаглал



Тооцооны нэгж: Үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний өдрийн байдлаарх Монложистикс Группийн компанийн засаглал, дотоод зохион байгуулалт, бизнесийн үйл ажиллагааны бодит нөхцөл байдалтай уялдуулан Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээг тус компанийн охин компаниудын үйл ажиллагааг нэгтгэсэн үзүүлэлтэд





үндэслэн хийж гүйцэтгэв.

Хэдийгээр үнэлгээний ирэх жилүүдийн төсөөллийн тооцооллыг охин компани бүрийн хувьд хийсэн боловч энэ нь Монложистикс Группийн аль нэг компанийг бие даасан байдлаар хийсэн үнэлгээ биш болохыг анхаарна уу.

Нэмэлт санхүүжилт: Монложистикс Холдинг ХХК нь МХБ дээр өөрийн энгийн хувьцааг олон нийтэд санал болгож 11.0 тэрбум төгрөгийн санхүүжилт татах ба үүнээс 8.0 тэрбум төгрөгийг хөдлөх бүрэлдэхүүнд, 3.0 тэрбум төгрөгийг охин компаниудын эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөж байна. Энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт татаж дээрх зориулалтаар ашиглагдах тохиолдолд хамаарах буюу Post-Money Valuation болно.

Тасралтгүй байдал: Монложистикс Группийн толгой компани болон охин компаниуд нь цаашид бизнесийн үйл ажиллагааг бизнес төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

Газар дээрх үзлэг, шалгалт, баримтын хадгалалт

Бид Үйлчлүүлэгчийн бизнестэй танилцах, мэдээлэл авах үүлзалтуудыг 2023 оны 1-р сарын 30-ны өдрөөс үнэлгээний тайлангийн өдөр хүртэл тогтмол хийж ажиллав. Бизнесийн болон бусад холбогдох мэдээллийг үнэлгээний ажлын явцад цахим шуудангаар авч үнэлгээнд ашиглав.

Стандартаас гажсан эсэх

Гажсаагүй

Үнэлгээчид

Үнэлгээчид нь Үйлчлүүлэгчээс өгсөн даалгаврын дагуу энэ төрлийн бизнесийн үнэлгээг хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна.

- Үнэлгээчин Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институтын (RICS) гишүүн, бизнес болон биет бус хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн үнэлгээчин бөгөөд бизнесийн үнэлгээний ажлыг удирдаж, үнэлгээний тайланг бэлтгэсэн болно.
- Үнэлгээчин Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал бөгөөд Хөрөнгийн суурилсан үнэлгээний хандлагын аргын багийн ахлагчаар ажиллав.
- Үнэлгээчин Л.Халиун нь АССА буюу олон улсын Мэргэшсэн нягтлан бодогч үнэлгээний ажлын Зах зээлийн хандлагын аргын багийн ахлагчаар ажиллав.




Ашиг сонирхлын зөрчил

Үнэлгээчдийн сертификатын хуулбарыг Хавсралт 3-д үзүүлэв.

Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно.



Бизнесийн үнэлгээ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Тайлангийн хэрэглээ

Мэргэжлийн хариуцлагын даатгал

Бусад

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



БҮРТГЭВ-03

Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно.

Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.

Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн болон Үнэлгээчдийн нэрсийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 26-р зүйлд заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан болно.

Тайланг Монгол хэл дээр бэлтгэсэн бөгөөд нэмэлт материалыг үндсэн эхийн хуулбар байдлаар хавсралтад үзүүлэв.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД

Он сар өдөр

БҮРТГЭВ

Үнэлгээний үр дүнг ашиглахаас өмнө үнэлгээнд ашигласан дараах үндсэн таамаглал болон өгөгдлүүдтэй танилцахыг зөвлөж байна.

Компаниудын нэршил: Үнэлгээний тайланд “Монложистикс Групп”, “Монложистикс Холдинг ХХК” гэх нэршлүүдийг ашигласан нь төөрөгдүүлэх эрсдэлтэй тул нэршлийн тайлбарыг оруулав. Тайланд “Монложистикс Групп” гэж охин компаниудыг хамтад нь авч үзэн санхүүгийн тайлангийн болон үйл ажиллагааны нэгтгэсэн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийхэд хэрэглэсэн бол “Монложистикс Холдинг ХХК” гэж охин компаниудын хувь эзэмшлийг тооцсон толгой компанийн үзүүлэлтүүдийн шинжилгээнд тус тус хэрэглэв.

Түүнчлэн үнэлгээний тайланд орсон “Үйлчлүүлэгч”, “Үнэт цаас гаргагч”, “Монложистикс Холдинг ХХК” зэрэг нэршлүүд нь нэг субъектыг илэрхийлэх бөгөөд тайлангийн өөр өөр хэсгүүдэд тухайн агуулгад тохиромжтой нэршлийг сонгон хэрэглэв.

Тооцооны нэгж: Охин болон хараат компаниудад хувь эзэмшдэг толгой компани буюу холдинг компанийн үнэ цэнэ нь үндсэндээ охин болон хараат компаниудын үнэ цэнийн нийлбэр дүнд үндэслэн тогтдог. Монложистикс Холдинг ХХК-ийн хувьд 1) хөрөнгө оруулалт хийсэн бүх компанид энгийн хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшдэг буюу зөвхөн охин компаниудтай, 2) Толгой компани болон охин компаниуд нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалттай ажилладаг, 3) Охин компаниудын бизнесийн үйл ажиллагаа нь хоорондоо нягт уялдаа холбоотой явагддаг зэрэг бодит нөхцөл байдалд үндэслэн орлогын хандлагын аргаар хийсэн бизнесийн үнэлгээг группийн нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтэд үндэслэн хийсэн болно.

Хэдийгээр ирэх жилүүдийн төсөөллийн тооцооллыг охин компани бүрийн хувьд хийсэн боловч энэ нь Монложистикс Группийн аль нэг компанийг бие даасан байдлаар хийсэн үнэлгээ биш болохыг анхаарна уу.

Дүгнэхэд, үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний өдрийн байдлаарх Монложистикс Группийн компанийн засаглал, дотоод зохион байгуулалт, бизнесийн үйл ажиллагааны бодит нөхцөл байдалтай уялдуулан Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээг тус компанийн охин компаниудын үйл ажиллагааг нэгтгэсэн үзүүлэлтэд үндэслэн хийж гүйцэтгэв.

Нэмэлт санхүүжилт: Монложистикс Холдинг ХХК нь МХБ дээр өөрийн энгийн хувьцааг олон нийтэд санал болгож 11.0 тэрбум төгрөгийн санхүүжилт татах ба үүнээс 8.0 тэрбум төгрөгийг хөдлөх бүрэлдэхүүнд, 3.0 тэрбум төгрөгийг охин компаниудын эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөж байна. Энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт татаж дээрх зориулалтаар ашиглагдах тохиолдолд хамаарах буюу Post-Money Valuation болно.

Тасралтгүй байдал: Монложистикс Группийн толгой компани болон охин компаниуд нь цаашид бизнесийн үйл ажиллагааг бизнес төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

Мэдээллийн найдвартай байдал: Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Монложистикс Холдинг ХХК болон охин компаниудаас гарган өгсөн бизнес төлөвлөлт, бусад тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Үнэт цаас гаргагч нь ирэх жилүүдийн санхүүгийн төсөөллийн тооцооллыг үнэлгээний ажлын явцад тасралтгүй шинэчилж, сайжруулалт хийж ирсэн болно. Үнэлгээний үр дүнгийн нарийвчлал нь мэдээллийн чанар бүрэн бүтэн

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

ШТХ0162 9021070414 5213487

АТЭС209 К 0010251
0021031000

байдалтай шууд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.

Үнэлгээний үр дүнгийн найдвартай байдал: Аливаа бизнесийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллын найдвартай байдал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь тус компанийн ирээдүйн ашигт ажиллагааны талаарх худалдагч болон худалдан авагчийн төсөөлөл зөрөх, хүлээж байгаа эрсдэлийн түвшин ялгаатай байх зэргээс хамаарч бизнес өмчлөлийн үнэ цэн нь талуудад өөр өөр байх боломжтой юм.

Цаашилбал, бизнес өмчлөлийн үнэ цэн нь ирээдүйд болох үйл явдлуудаас, тухайлбал зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагын шийдвэр, инфляцын өөрчлөлт, макро эдийн засгийн үзүүлэлтүүд зэргээс хамаарч өөрчлөгддөг онцлогтой.

Үнэлгээний өдрийн байдлаар Орос Украины дайнаас үүдэлтэй дэлхийн улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, дэлхий даяар тархсан КОВИД-19 цар тахлын эдийн засаг, бизнест үзүүлэх нөлөө зэрэг нь Үйлчлүүлэгчийн мөнгөн үрсгалын ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдлыг улам бүр ихэсгэж байна.

Үнэлгээний аргачлал, орц, таамаглал: Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, орц, таамаглалууд нь үнэлгээний өдрийн байдлаар үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Монложистикс Группийн ирээдүйн орлогын төсөөллийн тухай: Группийн хэмжээнд авч үзвэл ирэх жилүүдийн бизнесийн өсөлт авчрах үндсэн үйл ажиллагаа нь төмөр замын нүүрс тээвэрлэлт гэж төсөөлж байна. Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас нүүрсний экспортыг нэмэгдүүлэхийг зорьж олон арга хэмжээ авч ажиллаж байгаагийн дотор нүүрсний төмөр замын тээвэрлэлтийг хөгжүүлэх зорилт нь ач холбогдол өндөртэй, төрийн бодлогын цөмд орших зорилт болж байна.


Монложистикс Групп нь 2022 оноос эхлэн нүүрсний тээврийн үйл ажиллагаанд Каус Аустралис ХХК охин компанийн үйл ажиллагаагаар амжилттай оролцож эхэлсэн ба цаашид тус группийн бизнес төлөвлөгөөнд орсон төмөр замын нүүрс тээвэрлэлтийг зохион байгуулах ажил амжилттай хэрэгжих боломжтой гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

Тайлангийн хэрэглээ: Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглал, хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараах, Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь үнэлгээний ажлын зориулалтаас өөр зориулалтаар олон нийтэд гаргах аливаа баримт мэдээлэл, мэдэгдэлд Гэрэгэ Эстимэйт ХХК болон Үнэлгээчдийн нэрсийг дурдахыг хориглоно.






Макро эдийн засгийн төлөв байдал

Дотоодын эдийн засаг

Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2015 оны зэрэгцүүлэх үнээр сүүлийн 6 жилийн хугацаанд өөрчлөлт багатай буюу ойролцоогоор 23-28 их наяд төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. ДНБ-ний бодит өсөлт 2018 онд 7.6%-д хүрч байсан боловч Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд -4.4%-д хүртэл буурч, 2021 оноос эргэн сэргэж 1.4%, 2022 онд 4.8% өссөн байна.

ДНБ-ний 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон дүн болон өсөлт, бууралтыг доор үзүүлэв.¹

Зураг 1. ДНБ-ний өсөлт бууралт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр



Олон Улсын Валютын Сан (ОУВС)-аас Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг үнэлгээний өдрийн байдлаар дараах байдлаар төсөөлж байна.²

Хүснэгт 1. Монгол улсын эдийн засгийн төсөөлөл


Үзүүлэлт	2023	2024	2025	2026	2027
ДНБ оны үнээр, тэрбум төг	58,275.7	68,124.0	77,677.6	87,640.5	97,975.6
ДНБ бодит өсөлт, %	5.0%	7.0%	6.0%	5.5%	5.0%
Инфляци, %	6.561%	5.905%	5.314%	5.000%	5.000%
Ажилгүйдлийн түвшин, %	5.7	5.1	5.0	5.0	5.0
Засгийн газрын өр, тэрбум төг	45,754.1	51,300.5с	58,241.6	66,326.3	74,852.6



Мөнгөний нийлүүлэлт

M2 мөнгөний жилийн өсөлт өмнөх жилийн үзүүлэлтээс 6.5%-аар өсөж 29.7 их наядад хүрч, M1 мөнгө 9,6%-аар өсөж 7,2 их наядад хүрсэн байна.

Зураг 2. Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт



Төгрөгийн ханш

Монголбанкны статистик мэдээгээр төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2021 оны жилийн эцсийн байдлаар 2,849.34 төгрөг, 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 3,444.60 төгрөгт хүрч, өмнөх оны дүнгээс 20.9%-иар өссөн үзүүлэлттэй байна.³

Хүснэгт 2. Монгол төгрөгийн ханшийн мэдээлэл

Ханш	2019		2020		2021		2022	
	Нэгж үнэ	Өсөлт	Нэгж үнэ	Өсөлт	Нэгж үнэ	Өсөлт	Нэгж үнэ	Өсөлт
АНУ доллар	2 734.3	3.4%	2 849.9	4.2%	2 849.34	0.0%	3 444.6	21%
Евро	3 063.5	1.3%	3 504.5	14.4%	3 221.2	-8.1%	3 669.0	14%
БНХАУ-ын юань	392.4	2.1%	436.23	11.2%	447	2.5%	495.4	11%
ОХУ-ын рубль	44.06	16.0%	38.11	-13.5%	38.1	-0.1%	48.85	28%

Инфляци

Монгол банкны бодлогын хүү 2016 онд хамгийн дээд түвшин буюу 15% хүрч байсан ба аажмаар буурсан. Харин Ковид-19 цар тахлаас хойш инфляцийг бууруулах зорилгоор бодлогын хүүг дахин өсгөсөн ба 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 13.0% байсан бөгөөд тайлангийн өдрийн байдлаар өөрчлөгдөөгүй байна. Инфляцийн түвшин 2022 оны 12-р сарын байдлаар улсын хэмжээнд 13.2%, Улаанбаатар хотын хэмжээнд 12.9% байгаа нь инфляцийн зорилтот 6% (+/-2%)-аас харьцангуй өндөр байсаар байна.⁴



<https://www.mongolbank.mn/mn/currency-rate>
<https://www.mongolbank.mn/mn/inflation>

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Гадаад худалдаа

Монгол улсын нийт бараа эргэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 21.2 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнээс экспорт 12.5 тэрбум ам.доллар, импорт 8.7 тэрбум ам.доллар болсон байна.

Гадаад худалдааны тэнцэл 2022 жилийн эцсээр 3.9 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оноос 60%-аар нэмэгдсэн байна. Харин нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 32%, экспорт 36%, импорт 27%-аар тус тус өссөн байна.

Зураг 3. Монгол Улсын гадаад худалдааны эргэлт



Экспортын барааны нийт эргэлт Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2019, 2020 онуудад 2018 оны хэмжээнээс буурсан үзүүлэлттэй гарсан бөгөөд харин 2021 оноос нийт барааны эргэлт өсөж байна. 2022 онд экспортын барааны төмөр замын тээвэр өмнөх үеийнхээс 3.7%-аар буурч, авто зам 39.4%, агаарын зам 12%-иар тус тус өссөн байна.⁵

Хүснэгт 3. Экспортын бараа эргэлт тээврийн төрлөөр

Тээврийн төрөл	мян ам.доллараар				
	2018	2019	2020	2021	2022
Төмөр зам	1 930 952	1 962 277	2 118 809	3 282 076	3 164 669
Авто зам	5 035 919	5 251 018	3 689 516	4 923 345	8 118 991
Агаар зам	1 841 591	1 004 123	1 164 223	1 361 286	1 546 646
Шуудан	142	103	123	187	357
Буухиа шуудан	155	274	173	164	197

2022 онд голлох импортын барааны тээвэр болох төмөр замын тээвэр 4.2 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оноос 23.7%-иар буурсан, авто зам 2.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 12.1%-иар буурсан, агаар шуудан 546,2 сая ам.долларт хүрч өмнөх оноос 57.4%-иар буурсан үзүүлэлттэй байна.⁵



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Хүснэгт 4. Импортын бараа эргэлтийн тээврийн төрлөөр

мян ам.доллараар

Тээврийн төрөл	2018	2019	2020	2021	2022
Төмөр зам	3 561 730	3 546 880	2 920 198	5 470 104	4 173 325
Авто зам	2 305 608	2 541 823	2 436 179	2 799 640	2 461 900
Агаар зам	1 660 047	962 579	510 124	1 282 387	546 241
Шуудан	590	670	94	172	203
Бүүхиа шуудан	1 729	1 623	263	896	499


Тээвэр, ложистикийн салбар

Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээ” олгодог бөгөөд энэхүү гэрчилгээний хүрээнд “төмөр замын тээвэр зуучлал” гэрчилгээтэй 222 иргэн, хуулийн этгээд байна.⁶ 2022 онд Монгол Улс нийт 713.9 мянган тонн импортын бараа бүтээгдэхүүн тээвэрлэсэн ба үүний 68 орчим хувь нь тээвэр ложистикийнн компаниудаар дамжсан байна.

Монложистикс Ворлдвайд ХХК нь 2022 онд Монгол Улсад тээвэрлэсэн импорт, экспортын бараа бүтээгдэхүүний тоо хэмжээний үзүүлэлтээр салбартаа тэргүүлж байна. Тээвэр ложистикийн салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниудад Ландбридж ХХК, Росмон ложистик ХХК, Монгол Экспресс ХХК, Ворлдбридж ложистик ХХК, Монгол транс ХХК, Их нарлаг Монгол ХХК, Мастер Айфф ХХК, Шоонгарц ХХК, Туушин ХХК, Түмэн төмөрт ХХК, Азийн зам ХХК зэрэг компаниуд орно.

Тээврийн салбарын нийт орлого 2017 оноос 2019 он хүртэл өсөж харин Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020, 2021 онуудад харгалзан 25.2%, 7.9%-иар тус тус буурсан. Тээврийн нийт орлого 2022 онд өмнөх онтой харьцуулахад 47.6%-иар өссөн нь тус салбар буцаад сэргэж байгааг илтгэж байна. Энэ өсөлтөд авто замын тээврийн орлого 89.6%, агаарын тээврийн орлого 2.5 дахин өссөн нь нөлөөлсөн байна.

Зураг 4. Тээврийн салбарын орлогын өсөлт




⁶ Зам, тээврийн хөгжлийн яам, <https://mrttd.gov.mn>



СЭВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО 2018 ОНД ДНБ-НИЙ 4.7%-Г ЭЗЭЛЖ БАЙСАН БОЛ 2020, 2021 ОНУУДАД ХАМГИЙН БАГА БУЮУ 3.7%-Д ХҮРЧЭЭ. 2022 ОНД ДНБ-Д ЭЗЭЛХ ТЭЭВРИЙН НИЙТ ОРЛОГО 4.1% БОЛЖ СЭРГЭХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.⁷

Зураг 5. Тээврийн салбар ДНБ-д эзлэх хувиар



Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2022 онд нийт 60.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 23.59%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлтөд авто тээврээр тээсэн ачаа 84.06%-иар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 6. Тээврийн орлого, тээврийн төрлөөр



Өнгөрсөн жилүүдэд экспортын ачаа гаргалт авто тээврийн хувьд харьцангуй тогтвортой байсан бол экспортын барааны төмөр замын тээвэр хэлбэлзэл өндөр байна. Экспортын барааны төмөр замын тээвэр 2022 он гарсаар тасралтгүй нэмэгдэж 4-р улиралд 2.8 сая тонн ачаа тээвэрлэсэн байна.


MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

⁷ www.1212.mn Зам, тээврийн хөгжлийн яам

MON LOGISTICS HOLDING




Зураг 7. Экспортын ачаа гаргалт (мян.тн)



Импортын бараа бүтээгдэхүүний тээврийн хувьд төмөр замын тээвэр харьцангуй тогтвортой байсан байна. 2022 оны 4-р улиралд 1.0 сая тонн импортын ачааг төмөр замаар, 0.4 сая тонн ачааг авто тээврээр хийж гүйцэтгээд байна.

Зураг 8. Импортын ачаа оруулалт (мян.тн)




Төмөр замын дамжин өнгөрөх ачаа тээврийн хувьд БНХАУ-с ОХУ-д чиглэсэн буюу Баруун чиглэлийн (Westbound) тээвэр сүүлийн жилүүдэд хэмжээний хувьд бага бөгөөд харьцангуй тогтвортой байна. Харин Зүүн чиглэлийн (Eastbound) ачаа тээвэр 2022 онд өмнөх онуудаас багассан байна.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Зураг 9. Дамжин өнгөрөх ачаа, төмөр зам (мян.тн)



2022 онд БНХАУ-аас ОХУ-руу дамжин өнгөрөх ачаа 1,070,759 тн болж, өмнөх оны мөн энэ үеэс 100,997 тн буюу -8.6%-аар буурсан байна. Харин ОХУ-аас БНХАУ-руу 2,103,746 тн болж, өмнөх оны мөн энэ үеэс 965,492 буюу -31.5%-аар буурсан байна.

Монгол Улсын ложистикийн индекс

Дэлхийн банкны 2018 оны Ложистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)⁸-ээр Монгол улс 167 орноос 129 дэх байранд эрэмбэлэгдсэн. Монгол улсын ложистикийн гүйцэтгэл 2010-2018 онуудад LPI тайланд хэрхэн өөрчлөгдсөнийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Монгол улсын ложистикийн гүйцэтгэлийн индекс

Үзүүлэлтүүд		2010	2012	2014	2016	2018
LPI-ийн ерөнхий үзүүлэлт	Оноо	2.25	2.25	2.36	2.51	2.37
	Байр	141	140	135	108	129
Гааль	Оноо	1.81	1.98	2.2	2.39	2.22
	Байр	149	144	132	100	127
Дэд бүтэц	Оноо	1.94	2.22	2.29	2.05	2.1
	Байр	133	125	120	140	135
Олон улсын ачаа тээвэр	Оноо	2.46	2.13	2.62	2.37	2.49
	Байр	119	142	110	129	117
Ложистикийн өрсөлдөх чадвар	Оноо	2.24	1.88	2.33	2.31	2.21
	Байр	128	152	126	129	140
Ачаа тээвэрлэлтийн мэдээлэл	Оноо	2.42	2.29	2.13	2.47	2.1
	Байр	122	134	149	108	152
Цаг хугацаа	Оноо	2.55	2.99	2.51	3.4	3.06
	Байр	147	97	147	65	93

2016 онд гааль, ачаа тээвэрлэлтийн мэдээлэл, цаг хугацаа гэсэн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд сайжирсан бол 2018 онд бүх үзүүлэлт муудаж 108-аас 129-р байр хүртэл ухарсан байна

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

⁸ <https://lpi.worldbank.org>

ШТК0162-9021070414 5213487

БИЗНЕСИЙН ҮНЭЛЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Энэ үнэлгээнд зах зээлийн харьцуулалтын шинжилгээнд зориулж сонгосон 5 улсын LPI үзүүлэлтийг Монгол улсын LPI үзүүлэлттэй харьцуулж харахад дараах байдалтай байна.

Бусад улсууд 6 шалгуур үзүүлэлтүүдийн хувьд нэгэн жигд байна. Монгол улстай орлогын түвшнээр ойролцоо Индонез улс нь 2018 онд LPI үзүүлэлтээрээ 46-р байранд жагсжээ.

Зураг 10. Монгол болон бусад 5 улсын LPI үзүүлэлтийн харьцуулалт, 2018 он




Нүүрсний тээвэр

Дэлхийн нүүрсний нийт хэрэглээ 2022 онд өмнөх үеийнхээс 1.2%-аар өсөж, анх удаагаа 8.0 тэрбум тонн-д хүрчээ. Үүнээс хамгийн их хэрэглэгддэг цахилгаан эрчим хүчний салбарт нүүрсний хэмжээ 2%-аар өсөх төлөвтэй бол харин аж ахуйн нэгжийн хэрэглээ 1%-аар буурахаар байна. Хятад улс дангаар дэлхийн нүүрсний хэрэглээний 50-иас илүү хувийг хэрэглэж байна.⁹

2022 онд Монгол Улсын нүүрсний олборлолт нь 39.4 сая тонн буюу 21.7%-иар, нүүрсний борлуулалт 39.1 сая тонн буюу 46.3%-иар, нүүрсний экспорт 27.5 сая тонн буюу 72.9%-аар тус тус өссөн байна.¹⁰

Зураг 11. Нүүрсний олборлолт, борлуулалт болон экспорт



МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS SC
MANUAL CAPITAL
MARKETS SC
LLC
⁹ <https://www.iea.org>
¹⁰ Ашигт малтмал газрын тосны газар, <https://mrapm.gov.mn>
БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ
HOLDING
ХХК
ATA5789 6581231
902101093
17

СМОНГОЛ
ОН 2023
БҮРЭГ
№5


Монгол Улс нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг төмөр замаар тээвэрлэхийг зорьж байна. Гаалийн ерөнхий газрын мэдээгээр экспортын уул уурхайн бүтээгдэхүүний 10 хүрэхгүй хувь нь чингэлгээр тээвэрлэгдэж байна. Харин Монгол Улсын импортын 70 орчим хувь нь чингэлгээр тээвэрлэгддэг. Автомашин, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, гэр ахуйн цахилгаан бараа, холбооны төхөөрөмж болон хүнсний бүтээгдэхүүнийг ихэвчлэн чингэлгээр импортолж байна.

Монгол Улс 2022 он хүртэл зөвхөн УБТЗ ХХК-ийн эзэмшлийн ОХУ болон БНХАУ-г холбосон нийт 1,923 км урттай төмөр замыг идэвхитэй ашиглаж ирсэн ба 2022 - 2023 онд Тавантолгой - Гашуун сүхайт чиглэлийн 234 км төмөр зам, Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн 415.9 км төмөр зам, Зүүнбаян – Ханги чиглэлийн 116.9 км төмөр замыг ашиглалтад оруулж нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрт ашиглаж эхлээд байна.

Цаашид Монгол Улсын Засгийн газар Арцсуурь, Нарийн сүхайт, Шивээ хүрэн чиглэлийн 1,255 км урттай ОХУ – БНХАУ-г холбосон баруун коридор төмөр зам, Бичигт Чойбалсан чиглэлийн 426.1 км урттай төмөр замыг шинээр барьж зүүн коридор төмөр замтай болохыг зорин ажиллаж байна.

Дотоодын хэрэгцээнд болон экспортын чиглэлийн төмөр замаар тээвэрлэсэн нүүрсний тоо хэмжээ жилээс жилд өсөж байгаа бөгөөд 2022 онд 13.7%-иар өсөж 11.2 сая тонн болоод байна.⁷

Зураг 12. Төмөр замаар тээвэрлэсэн нүүрсний тоо хэмжээ




МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS УЦК ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
ШТК0162 9021070414 6213487

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК
Logistics
HOLDING
ATA/701 4 6380251
907 18 23



4. МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ТУХАЙ



Монложистикс Ворлдвайд ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсан, Монгол улсын ууган ложистикийн компаниудын нэг юм. 2019 онд Монложистикс Холдинг ХХК байгуулагдаж групп компанийн бүтцээр үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Үнэлгээний өдрийн байдлаар групп компанийн бүтэц, охин компаниудын үйл ажиллагааны чиглэл, байгуулагдсан огноог дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Монложистикс Группийн бүтэц, зохион байгуулалт

Охин компаниуд	Хувь эзэмшил	Бүртгэгдсэн улс	Байгуулагдсан эсвэл нэгдсэн огноо	Үйл ажиллагааны чиглэл
1 Монложистикс Ворлдвайд ХХК	100%	Монгол	11/27/05	Олон улсын тээвэр ложистик
2 Монложистикс Транзит ХХК	60%	Монгол	7/4/19	Дамжин өнгөрөх тээвэр
3 Монложистикс Тракинг ХХК	100%	Монгол	2/5/21	Олон улсын авто тээвэр
4 Монложистикс Карго ХХК	100%	Монгол	2/5/21	Олон улсын карго тээвэр
5 Монложистикс Экүйпментс ХХК	100%	Монгол	11/28/22	Вагон түрээс
6 Монложистикс Транс Сервис	90%	ОХУ	6/24/21	ОХУ-д тээвэр зохион байгуулагч
7 Каус Аустралис ХХК	51%	Монгол	6/10/22	Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр зохион байгуулагч
8 Монложистикс Россия Холдинг ХХК	90%	Монгол	3/31/21	Цэвэр холдинг компани
9 Монложистикс Экспресс ХХК	100%	Монгол	11/28/22	Олон улсын тээвэр

Монложистикс Холдинг ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь охин компаниудыг стратеги бодлого, хүний нөөц, менежментийн удирдлагаар ханган ажилладаг. Тайлангийн өдрийн байдлаар Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцаа эзэмшил: Монгол Улсын иргэн Л.Ганзоригт энгийн 110,520 хувьцаа - 32.85%, Б.Тэлэнгэд энгийн 110,520 хувьцаа - 32.85%, Г.Хишигбат энгийн 31,560 хувьцаа - 9.38%, А.Одгэрэл энгийн 31,560 хувьцаа - 9.38%, Н.Алтанзул, Л.Эрдэнэсоёл, Н.Эрдэнэбилэг тус бүр энгийн 15,000 хувьцаа - 4.46%, Мандал Праяват Экүйти хувийн ХОС ХХК энгийн 7,320 хувьцаа - 2.18%, нийт 336,480 хувьцаа - 100% эзэмшиж байна.

Монложистикс Ворлдвайд ХХК нь гадаад, дотоодын тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг ба 160 гаруй улс орны 800 гаруй харилцагч, түнш болон Замын Үүд, Сүхбаатар, Алтанбулаг, Гашуунсүхайд зэрэг хилийн боомтын төлөөлөгчийн газруудаар дамжуулан 1500 гаруй байгууллагын харилцагчдад тээврийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Монложистикс Транзит ХХК-ийн 40%-ийг БНХАУ-ын Тянь Жин Хай Тие Лянь Жие Олон Улсын Тээврийн Ложистикс ХХК эзэмшдэг. Компани нь Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх БНХАУ болон ОХУ, Европын орнуудын төмөр замын чингэлэгийн галт тэрэгний транзит тээвэр, гаалийн бүрдүүлэлтийн цогц үйлчилгээг үзүүлдэг.



Монложистикс Тракинг ХХК нь авто тээвэрлэлтийн үйл ажиллагааг дагнан хариуцаж байгаа ба үйлчлүүлэгчдийн хүсэл шаардлагад нийцүүлэн авто тээвэрлэлтийг эдийн засгийн хамгийн өртөгтэй байдлаар, тохиромжтой тээврийн хэрэгслээр хүссэн цагт нь үзүүлэхээр зорин ажиллаж байна.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

2023-06-14
БҮРТГЭВ-03

СЗХ
ОН
САР
БҮРТГЭВ
№ 01

Монложистикс Карго ХХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь олон улсын худалдааны томоохон платформуудаас шат дамжлага, нэмэлт өртөггүйгээр бараа захиалж, хүргэх өгөх юм.

Каус Аустралис ХХК-ийн 24.5%-ийг Монгол улсын иргэн Б.Тэлэнгид, 24.5%-ийг Монгол улсын иргэн Ё.Болортуяа тус тус эзэмшдэг. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний төмөр замын тээвэрлэлтийн ложистикийн үйлчилгээ, вагон болон чингэлэгийн түрээс, хамтарсан тээвэр зохион байгуулах гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд ажиллаж байна.

Монложистикс Транс Сервис ХХК-ийн 10%-ийг ОХУ-ын иргэн Тугаринов Василий Андреевич эзэмшдэг ба ОХУ-ын Эрхүү хотод үйл ажиллагаа явуулдаг. ОХУ-д тээвэр, ложистикийн бүхий л үйл ажиллагааг нэвтрүүлэх, ОХУ-тай хамтран ажиллах, цаашид олон улсын тээвэр ложистикийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилготой.

Монложистикс Экүйпментс ХХК-г ОХУ болон бусад улсаас вагон худалдан авч түрээслэх үйлчилгээг хөгжүүлэх үндсэн чиглэлээр 2022 оны 11-р сард үүсгэн байгуулсан.

Монложистикс Экспресс ХХК-г импортын гадаад тээврийн борлуулалтыг хөгжүүлэх зорилгоор 2022 оны 11-р сард үүсгэн байгуулсан.

Хүний нөөц

Тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг үйлчилгээний байгууллагын хувьд хүний нөөц онцгой үүрэг гүйцэтгэдэг. Бизнес оршин тогтнох, цаашид өргөжин тэлэх гол түлхүүр нь хүний нөөц гэж үздэг. Монложистикс Групп нь нийт 165 ажилтантай, үүний 16 ажилтан нь гүйцэтгэх захирал болон албаны захирлын албан тушаалд, 24 ажилтан нь менежерийн түвшний албан тушаалд, 125 ажилтан нь мэргэжилтний түвшний албан тушаалд ажиллаж байна.

Охин компаниудын голлох үүрэгтэй ажилтанууд нь олон улсад боловсрол эзэмшсэн, Монложистикс Ворлдвайд болон Монгол улсын бусад томоохон компаниудад ажиллаж байсан туршлагатай, англи, орос, хятад хэлтэй мэргэжилтнүүд байна.

Монложистикс Ворлдвайд компанийн үүсгэн байгуулагчдын нэг Л.Ганзоригт нь Ленинград хотын кино инженерийн дээд сургуулийг цахилгааны инженер мэргэжлээр төгссөн, 2005 оноос 2016 он хүртэл тус компанийн Санхүү эрхэлсэн захирлаар ажилласан, одоо Монложистикс Холдинг ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажилладаг.

Мөн үүсгэн байгуулагчдын нэг Б.Тэлэнгэд нь Болгарын ХАА Тракиа их сургуулийг зоо инженерийн мэргэжлээр төгссөн, 2005 оноос 2016 он хүртэл тус компанийн ерөнхий захирлаар ажиллаж байсан, одоо Монложистикс Транзит ХХК-ийн гүйцэтгэх захирал, Монложистикс Холдинг ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

Монложистикс Холдинг ХХК-ийн гүйцэтгэх захирлаар 2016 оноос хойш ажиллаж байгаа Г.Хишигбат нь АНУ-ын Флоридагийн их сургуулийг системийн инженер мэргэжлээр төгссөн, Ньюком Групп, Изинис Эйрвэйз, Imagine компаниудад хөрөнгө оруулалтын шинжээч, төлөвлөлтийн менежер, гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан туршлагатай.

Компанийн ажилтануудад ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан урамшуулалт цагин олгодог гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

Logistics
HOLDING

СЗХ

Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ

БҮРТГЭВ

№ 03

Монложистикс Ворлвайд ХХК нь Гаалийн ерөнхий газраас олгодог “Гаалийн зүүчлагчийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй. “Гаалийн зүүчлагчийн үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь 2-оос доошгүй гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй байх шаардлагатай. Монложистикс Ворлвайд ХХК нь тайлангийн өдрийн байдлаар 11 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээ” олгодог бөгөөд Монложистикс Ворлвайд ХХК болон Монложистикс Транзит ХХК-иуд нь энэхүү гэрчилгээний хүрээнд “төмөр замын тээвэр зуучлал” гэсэн ангиллын үйл ажиллагаа эрхэлдэг.

Програм хангамж

Группийн хэмжээнд Интерактив ХХК-ийн хөгжүүлсэн “Нягтлан бодох бүртгэл, цалин, цаг бүртгэлийн Veritech ERP SME”, “Хүний нөөц болон сонгон шалгаруулалтын Veritech ERP” цогц системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Монложистикс Групп нь дотооддоо хөгжүүлсэн TMS 3.0 (Transport management system) ашиглаж байгаа бөгөөд LMS (Logistic management system) хөгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн мэдээлэл

Монложистикс Холдинг ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн баланс болон орлого үр дүнгийн гол үзүүлэлтүүдийг 2019-2022 оны жилийн эцсийн байдлаар дор хураангуйлан үзүүлэв.


Хүснэгт 7. Монложистикс Группийн балансын үзүүлэлтүүд, 2019-2022 он

Балансын үзүүлэлтүүд /сая төгрөг/	2019	2020	2021	2022
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,395.8	9,277.3	5,815.5	14,198.3
Авлага	9,131.3	13,689.4	13,629.9	19,504.0
Эргэлтийн хөрөнгө	15,124.0	25,069.8	23,934.1	39,467.3
Нийт хөрөнгө	17,629.8	25,459.8	25,460.8	41,839.0
Богино хугацаат өр төлбөр	3,067.8	12,487.1	7,675.6	16,761.9
Өр төлбөрийн дүн	3,067.8	12,487.1	8,524.5	16,971.8
Эздийн өмч	14,562.0	12,972.7	16,936.3	24,867.2

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2019, 2020 онд идэвхижил мүүдсан эдийн засгийн эргэлт сэргэж 2021, 2022 онд борлуулалтын орлого эрс нэмэгдсэн. 2021 оны борлуулалтын орлого нэмэгдэхэд Монложистикс Ворлдвайд ХХК-ийн тээврийн борлуулалтын орлого өссөн нь ихээр нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Монложистикс Группийн орлого үр дүнгийн үзүүлэлтүүд 2019-2022 он

Орлогын үзүүлэлтүүд /сая төгрөг/	2019	2020	2021	2022
Борлуулалтын орлого	56,351.0	61,393.6	82,340.7	140,122.7
Борлуулалтын өртөг	48,365.5	54,711.7	74,066.3	123,260.3
Нийт ашиг	7,985.5	6,681.9	8,274.4	16,862.4
Тайлант үеийн ашиг/алдагдал/	5,131.8	3,527.2	3,892.6	9,519.9



2022 оны борлуулалтын орлого 70% өссөн нь Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Тракинг ХХК, Каус Аустралис ХХК-иудын борлуулалтын орлогын өсөлтүүд нөлөөлжээ.

Санхүүгийн үндсэн харьцаануудыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9. Монложистикс Группийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 2019-2022 он

Санхүүгийн гол харьцаанууд	2019	2020	2021	2022
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	35.2%	27.2%	23.0%	39.0%
Хөрөнгийн өгөөж (ROA)	29.1%	13.9%	15.3%	23.2%
Нийт ашгийн маржин	14.2%	10.9%	10.0%	12.0%
Цэвэр ашгийн маржин	9.1%	5.7%	4.7%	6.9%
Өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцаа (D/E)	0.21	0.96	0.50	0.68
Мөнгө, богино хугацаат өр төлбөрийн харьцаа	1.76	0.74	0.76	0.85
Эргэлтийн харьцаа (Current ratio)	4.93	2.01	3.12	2.35


Санхүүгийн харьцаануудаас харахад тус Монложистикс Группийн өөрийн хөрөнгийн өгөөж буюу өөрийн хөрөнгийг ашиглан ашиг олох чадвар өндөр байна. Түүнчлэн өр төлбөрийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа сайжирч 2022 онд 0.68 болсон байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг илтгэх мөнгө, богино хугацаат өр төлбөрийн харьцаа сүүлийн 3 жил дараалан тогтмол байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг илтгэх эргэлтийн харьцаа тогтмол сайн үзүүлэлттэй байгаа нь группийн хэмжээнд бизнесийн үйл ажиллагаа тогтворжсоныг илтгэж байна.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК





Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд суурилсан хандлага, Орлогын хандлагыг авч үзэв.

ҮОУС-д заасан үнэлгээний мэргэжлийн нэр томъёо, тодорхойлолтыг Хавсралт 2-т үзүүлэв.

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээ

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээг Монгол улсын зах зээл болон олон улсын зах зээл гэсэн хоёр үндсэн бүлэгт авч үзлээ.

Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байхгүй тул бид эзэмшигчийн өмчийн хэмжээ ойролцоо, хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг компанийг сонгох, мөн өөрийн хөрөнгийн өгөөжтэй нь харьцуулсан регрессийн шинжилгээ хийх зэргээр дүн шинжилгээ хийв.

Ойролцоо хэмжээний эзэмшигчдийн өмчтэй компанийн үнэлгээний гол үржүүлэгчид болох PE, PB харьцааг тодорхойлж тухайн үнэлж буй компанийн үнэ цэнийн түвшинг тодорхойлохыг зорьсон.

Олон улсын ложистикийн салбарын хувьд үнэлгээний гол үржүүлэгчид болох PE болон PB харьцааг шинжилж үзэв. Улсуудыг сонгохдоо Дэлхийн банкнаас гаргасан улс орнуудыг орлогын түвшнээр ангилалсан ангилал бүрээс тус ангиллыг төлөөлөх улсуудыг сонгон шинжилгээ хийв.


Өндөр орлоготой зах зээлийн төлөөлөл болгон АНУ, дунджаас дээш орлоготой зах зээлийн төлөөлөл болгон БНХАУ, Малайз, Тайланд улсуудыг, Монгол улстай ижил ангиллын дунджаас доош орлоготой улсын төлөөлөөр Индонез улсыг тус тус сонгосон. Эдгээр улсуудыг сонгохдоо тээвэр, ложистикийн зах зээлийн мэдээллийн олдоцтой байдлыг харгалзан үзэв.

Олон улсын компаниудын PE, PB харьцаа

Сонгосон улсуудын хувьд ложистикийн салбарын орлогын ДНБ-д эзлэх хувийг 2017-2021 онуудын хооронд авч үзэв. Монгол Улсын 1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 2022 онд 4,541 ам.доллар байгаа нь Индонези улстай ойролцоо байна. Тайланд улсын хувьд ложистикийн салбарын орлогын мэдээлэл олдоогүй тул тээвэр болон агуулахын салбарын орлогын статистик мэдээллийг нэгтгэв.

Улсууд	1 хүнд ногдох ДНБ, US\$	2017	2018	2019	2020	2021
АНУ	75,179	8%	8%	8%	7%	7%
БНХАУ	12,970	11%	10%	10%	10%	9%
Малайз	13,107	8%	7%	7%	7%	7%
Тайланд	7,630	9%	9%	9%	10%	10%
Индонез	4,691	5%	5%	5%	5%	5%





Харьцуулалтаас харахад өндөр орлоготой болон дунджаас дээш орлоготой орнуудын хувьд ложистикийн салбарын орлого харьцангуй өндөр буюу ДНБ-ий 7-10%-ийг эзэлж байна. Дунджаас доош орлоготой Индонези улсын хувьд энэ харьцаа 5% орчим байна.

Олон улсын ложистикийн салбарын хөгжлийн чиг хандлага болон засгийн газраас авч хэрэгжүүлж буй алхмуудыг нэгтгэн авч үзээд дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

Цахим худалдаа: Цахим худалдааны өсөлт нь ложистикийн салбарт томоохон нөлөө үзүүлж байна. Ложистикийн компаниуд онлайн захиалга, хүргэлтийн үйлчилгээний өсөлтийг хангахын тулд нийлүүлэлтийн сүлжээгээ өөрчлөх шаардлагатай болж байна.

Технологи: Ложистикийн салбар нь автоматжуулалт, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернет (IoT) зэрэг салбарт томоохон шинэчлэлийг хийж байна. Эдгээр технологи нь бизнесийн үр ашгийг дээшлүүлэх, зардлыг бууруулах, нийлүүлэлтийн сүлжээг илүү оновчтой удирдахад туслах ач холбогдолтой.

Тогтвортой байдал: Ложистикийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх ойлголт улам бүр нэмэгдэж, тогтвортой үйл ажиллагаа явуулах шаардлага үүсч байна. Олон компаниуд хүлэмжийн хийг бууруулах, тээврийн сүлжээг оновчтой болгох, сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах арга замыг судалж байна.

Нийлүүлэлтийн гинжин хэлхээний уян хатан байдал: Ковид-19 цар тахлын улмаас үүссэн тээвэр, ложистикийн сүлжээний тасалдал нь дэлхий даяар худалдааг сааруулахад хүргэсэн тул нийлүүлэлтийн сүлжээг илүү уян хатан болгох шаардлагатай тулгарсан. Олон компаниуд нийлүүлэлтийн сүлжээгээ дахин үнэлж, илүү уян хатан үйлчилгээг үзүүлж, орон тооны цомхотгол хийх зэрэг арга замыг авч хэрэгжүүлж байна.

Дэд бүтцийн хөрөнгө оруулалт: Эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийлүүлэлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор боомт, хурдны зам, төмөр замын сүлжээ зэрэг ложистикийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Хятад: Хятад улс нь Ази, Европыг холбосон “Торгоны зам” санаачлагын хүрээнд ложистикийн үйл ажиллагааг оновчтой болгох, зардлыг бууруулахын тулд шинэ чөлөөт худалдааны бүс байгуулах зэргээр нийлүүлэлтийн сүлжээний нэгдмэл байдлыг сайжруулахаар ажиллаж байна.

Малайз: Малайз улсын засгийн газар сүүлийн жилүүдэд ложистикийн дэд бүтцэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, ложистикийн салбарын өсөлтийг дэмжих зорилгоор боомт, нисэх онгоцны буудал, хурдны зам зэрэг бүтээн байгуулалт хийж байна. Засгийн газраас “Ложистик ба худалдааг хөнгөвчлөх мастер төлөвлөгөө”, “Үндэсний цахим худалдааны стратеги” гэсэн санаачлагуудыг хэрэгжүүлж байна.

Тайланд: Тайландын засгийн газар улсынхаа ложистикийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хэд хэдэн санаачилга гаргасан бөгөөд үүний дотор “Зүүн эдийн засгийн коридор (ЕЕС)” төсөл нь өндөр технологийн аж үйлдвэрийн зангилаа улс болох, хөрш орнуудтай тээврийн харилцааг сайжруулах зорилготой юм.

Индонез: Индонезийн засгийн газар шинэ нисэх онгоцны буудал, далайн боомт, хурдны зам зэрэг дэд бүтцийн төслүүдэд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна. Гэвч зарим бүс нутагт



СХУ
ОН 2023 СЭР 2 8200
БҮРТГЭВ
№

логистикийн өндөр өртөг, нийлүүлэлтийн үр ашиггүй сүлжээ, тээврийн дэд бүтэц хангалтгүй зэрэг шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна.

Монгол: Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн тэргүүлэх зорилтод “Боомтын сэргэлт” орж байна.

Монгол Улс нийт 39 боомттой бөгөөд үүнээс агаарын замын 6, авто замын 27, төмөр замын 6 боомт байдаг. ОХУ-тай хиллэдэг 16 боомтоос 10 боомтоор, БНХАУ-тай хиллэдэг 17 боомтоос 13 боомтоор ачаа тээвэр, зорчигч хөдөлгөөн тасралтгүй явагдаж байна. Ачаа болон зорчих тээврийн дийлэнх хувийг Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд боомт эзэлдэг. Жилд Гашуунсухайтын боомтоор 21.6 сая тн ачаа, Шивээхүрэнгийн боомтоор 14.7 сая тн, Замын-Үүд боомтоор 10 сая тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай.

“Боомтын сэргэлт” бодлогын үндсэн зорилтыг доорх зургаар¹¹ үзүүлэв.

Зураг 13. “Боомтын сэргэлт” бодлогын үндсэн зорилт



Сонгосон улсуудын зах зээлийн дундаж харьцаанууд

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

АНУ-ын ДНБ 2021 онд 23.3 их наяд ам.доллар байсан бол 2022 онд урьдчилсан дүнгээр 2.9 хувиар өсөж 24 их наяд долларт хүрэхээр тооцоолж байна. АНУ-д үйл ажиллагаа явуулж буй, мэдээллийн олдоц сайтай тээвэр логистикийн компаниудын хувьд PE болон PB харьцаа дараах байдалтай байна.¹²

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS YJX XXX
МАНДАЛ САЙТА
MARKETS.YJX
parliament.mn/nn/18715/
finance.yahoo.com
БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ
MONGOLIAN STOCK EXCHANGE
25



Хүснэгт 10. Үнэлгээний харьцаанууд, АНУ

Симбол	Компанийн нэр	ЗЗУ, USD	PE	PB
DPSGY	Deutsche Post AG	53.678B	9.18	2.16
FDX	FedEx Corporation	52.844B	16.40	2.13
DSDVY	DSV A/S	39.827B	16.77	2.97
KHNGF	Kuehne + Nagel International AG	31.642B	10.13	8.34
ZTO	ZTO Express (Cayman) Inc.	22.61B	23.68	2.97
JBHT	J.B. Hunt Transport Services, Inc.	19.773B	20.69	5.59
EXPD	Expeditors International of Washington, Inc.	17.817B	11.79	5.35
CHRW	C.H. Robinson Worldwide, Inc.	12.138B	13.94	9.00
LSTR	Landstar System, Inc.	6.504B	15.39	7.29
MFGHF	Mainfreight Limited	4.894B	17.55	4.60
HUBG	Hub Group, Inc.	3.159B	9.14	1.74
ROYMF	International Distributions Services plc	2.727B	9.00	0.48
FWRD	Forward Air Corporation	2.678B	14.10	3.98
CGJTF	Cargojet Inc.	1.759B	7.94	2.71
BPOSY	bpost NV/SA	1.125B	4.37	0.95
PSTNY	PostNL N.V.	1.056B	17.25	7.04
RLGT	Radiant Logistics, Inc.	269.603M	7.25	1.43
	Min		4.4	0.5
	Max		23.7	9.0
	Медиан		13.9	3.0
	Дундаж		13.2	4.0

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)

БНХАУ-ын ДНБ 2021 онд 17.7 их наяд ам.доллар байсан бол ДНБ-ий өсөлт 2022 онд 3% байхаар гэж тооцоолж байна. БНХАУ-д үйл ажиллагаа явуулж буй, мэдээллийн олдоц сайтай тээврийн ложистикийн компаниудын хувьд PE болон PB харьцаа дараах байдалтай байна.^{12,13}

Хүснэгт 11. Үнэлгээний харьцаанууд, БНХАУ

Симбол	Компанийн нэр	ЗЗУ, USD	PE	PB
600233.SS	YTO Express Group Co.,Ltd.	69.102B	17.2	2.7
002120.SZ	YUNDA Holding Co., Ltd.	42.054B	25.4	3.8
600057.SS	Xiamen Xiangyu Co., Ltd.	25.606B	10.1	1.2
601156.SS	Eastern Air Logistics Co., Ltd.	24.941B	6.0	1.9
603565.SS	Shanghai Zhonggu Logistics Co., Ltd.	23.654B	7.4	2.8
600179.SS	Antong Holdings Co., Ltd.	14.726B	8.2	3.2
603128.SS	CTS International Logistics Corporation Ltd	13.566B	14.2	3.4
603871.SS	Jiayou International Logistics Co.,Ltd	11.781B	22.5	2.3
600787.SS	CMST Development Co.,Ltd.	11.334B	16.0	1.1
600575.SS	Huaihe Energy (Group) Co.,Ltd	9.56B	13.5	0.9
300873.SZ	Hichain Logistics Co.,Ltd.	7.103B	16.3	3.2
600180.SS	CCS Supply Chain Management Co., Ltd.	6.48B	9.5	1.1
600278.SS	Orient International Enterprise, Ltd.	6.405B	15.8	1.0
603535.SS	Guangzhou Jiacheng International Logistics Co.,Ltd.	4.492B	23.6	2.4
603967.SS	China Master Logistics Co., Ltd.	3.675B	15.4	1.9



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК





002889.SZ	Shenzhen Easttop Supply Chain Management Co., Ltd.	3.472B	15.6	1.9
603836.SS	Bondex Supply Chain Management Co., Ltd.	3.419B	9.2	1.5
603648.SS	Shanghai Shine-Link International Logistics Co., Ltd.	3.41B	23.0	1.8
300240.SZ	Jiangsu Feiliks International Logistics Inc.	2.877B	21.3	2.3
	Min		6.0	0.9
	Max		25.4	3.8
	Медиан		15.6	1.9
	Дундаж		15.3	2.1

Малайз улс

Малайз улсын ДНБ 2021 онд 399 тэрбум ам.доллар байсан бол ДНБ-ий өсөлт 2022 онд 7% байхаар тооцоолж байна. Малайз улсад үйл ажиллагаа явуулж буй, мэдээллийн олдоц сайтай тээврийн ложистикийн компаниудын хувьд PE болон PB харьцаа дараах байдалтай байна.¹²

Хүснэгт 12. Үнэлгээний харьцаанууд, Малайз улс

Симбол	Компанийн нэр	ЗЗҮ, USD	PE	PB
0078.KL	GDEX Bhd	261.48M	N/A	3.3
5140.KL	TASCO Bhd	163.59M	7.8	1.3
4634.KL	POS Malaysia Bhd	101.46M	N/A	0.7
2062.KL	Harbour-Link Group Bhd	98.43M	2.6	0.7
5303.KL	Swift Haulage Bhd	93.46M	7.7	0.6
7210.KL	FM Global Logistics Holdings Bhd	76.21M	6.6	0.8
7117.KL	CJ Century Logistics Holdings Bhd	62.30M	9.3	0.8
0080.KL	Straits Energy Resources Bhd	26.32M	16.7	1.0
0199.KL	Tri-Mode System (M) Bhd	15.4M	6.7	0.7
	Min		2.6	0.6
	Max		16.7	3.3
	Медиан		7.7	0.8
	Дундаж		8.2	1.1

Тайланд улс

Тайландын Вант Улсын ДНБ 2021 онд 529 тэрбум ам.доллар байсан бол ДНБ-ий өсөлт 2022 онд 4.6% байна гэж таамаглаж байна. Тайланд улсад үйл ажиллагаа явуулж буй, мэдээллийн олдоц сайтай тээврийн ложистикийн компаниудын хувьд PE болон PB харьцаа дараах байдалтай байна.¹²

Хүснэгт 13. Үнэлгээний харьцаанууд, Тайланд улс

Симбол	Компанийн нэр	ЗЗҮ, USD	PE	PB
WICE.BK	Wice Logistics Public Company Limited	190.9M	12.12	4.10
LEO-R.BK	Leo Global Logistics Public Company Limited	108.4M	12.49	4.27
SONIC.BK	Sonic Interfreight Public Company Limited	58.9M	7.45	1.62
	Min		7.5	1.6
	Max		12.5	4.3
	Медиан		12.1	4.1
	Дундаж		10.7	3.1



СЗХ
ОН Индонези улс
БҮРТГЭВ

Индонези улсын ДНБ 2021 онд 1.25 их наяд ам.доллар байсан бол ДНБ-ий өсөлт 2022 онд 5.4%-иар өсөх төсөөлөлтэй байна. Индонези улсад үйл ажиллагаа явуулж буй, мэдээллийн олдоц сайтай тээврийн ложистикийн компаниудын хувьд PE болон PB харьцаа дараах байдалтай байна.¹⁴

Хүснэгт 14. Үнэлгээний харьцаанууд, Индонези улс

Симбол	Компанийн нэр	33Y, USD	PE	PB
JAYA.JK	PT Armada Berjaya Trans Tbk	190.9M	13.4	0.7
SAPX.JK	PT Satria Antarana Prima Tbk	108.4M	13.9	3.4
IPCC.JK	PT Indonesia Kendaraan Terminal Tbk	58.9M	7.4	1.0
	Min		7.4	0.74
	Max		13.9	3.43
	Медиан		13.4	1.00
	Дундаж		11.5	1.72

Дүгнэлт

Харьцуулсан шинжилгээнд сонгосон 5 улсын хувьд PE болон PB харьцааны хамгийн их болон бага утга хоорондоо зөрүү өндөртэй байна.

Хүснэгт 15. Үнэлгээний харьцаанууд, Улсуудын дундаж дүн

Улсууд	PE					PB				
	АНУ	БНХАУ	Малайз	Тайланд	Индонези	АНУ	БНХАУ	Малайз	Тайланд	Индонези
Min	4.4	6.0	2.6	7.5	7.4	0.48	0.92	0.64	1.62	0.74
Max	23.7	25.4	16.7	12.5	13.9	9.00	3.76	3.30	4.27	3.43
Медиан	13.9	15.6	7.7	12.1	13.4	2.97	1.94	0.77	4.10	1.00
Дундаж	13.2	15.3	8.2	10.7	11.5	4.04	2.12	1.10	3.33	1.72

Өндөр орлоготой АНУ-ын хувьд дундаж PE харьцаа 13.2, PB харьцаа 4.04 байна. Дунджаас дээш орлоготой БНХАУ, Малайз болон Тайланд улсын хувьд дундаж PE харьцаа 11.4, PB харьцаа 2.19, Монгол улстай ижил дунджаас доош орлоготой Индонези улсын хувьд PE харьцаа 11.5, PB харьцаа 1.72 байна. Үүнээс харахад PB харьцаа нь тухайн улсын орлогын түвшинтэй шүүд хамааралтай байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Дотоодын компаниудын PE, PB харьцаа

Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж буй ижил чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компани байхгүй тул бид эхлээд эзэмшигчийн өмчийн хэмжээ ойролцоо бөгөөд илэвхтэй арилжаалагддаг компаниудын хувьцааг сонгож дүн шинжилгээ хийлээ.

<https://finance.yahoo.com/screener/unsaved/ba6c840f-88c7-47f6-ae25-3a57322c6778>

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Ингэснээр Монложистикс Групптэй ойролцоо хэмжээний эзэмшигчийн өмчтэй компаниудын дундаж үнэлгээ дотоодын зах зээл дээр хэрхэн тогтож байгааг олж тогтоохыг зорив.

2022 онд МХБ дээр арилжаалагдсан хувьцааны ширхэг болон үнийн дүнгээрээ идэвхтэй ажилласан I болон II ангиллын 30 орчим компаниас 2022 оны жилийн эцсийн байдлаарх эзэмшигчийн өмчийн дүн нь Монложистикс Групптэй ойролцоо байгаа Мандал даатгал ХК, Ард Кредит ББСБ ХК, ЛэндМН ББСБ ХК, Монос хүнс ХК гэсэн 4 компанийг сонгосон шинжилсэн болно.

Хүснэгт 16. Эздийн өмч ойролцоо компаниудын PE, PB харьцаа

№	Компанийн нэр	Цэвэр ашиг, мян төг	Эздийн өмч, мян төг	Зах зээлийн үнэлгээ	PE	PB	ROE
1	Мандал Даатгал ХК	4,084,407	29,101,102	52,547,466	12.9	1.8	14.0%
2	Ард кредит ББСБ ХК	2,105,904	18,096,101	36,009,850	17.1	2.0	11.6%
3	ЛэндМН ББСБ ХК	5,524,981	24,229,901	22,874,259	4.1	0.9	22.8%
4	Монос хүнс ХК	3,187,337	17,290,663	51,000,002	16.0	2.9	18.4%
	Min				4.1	0.9	11.6%
	Max				17.1	2.9	22.8%
	Медиан				14.4	1.9	16.2%
	Дундаж				12.5	1.9	16.7%

Сонгогдсон компаниудын PE харьцааны дундаж 12.5, PB харьцааны дундаж 1.9 байна. Эдгээр компаниуд нь хэдийгээр эздийн өмчийн дүнгээр Монложистикс Групптэй ойролцоо байгаа боловч өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтээр өөр байгаа тул харьцуулсан үнэлгээнд шууд ашиглах нь тохиромжгүй юм.

Учир нь Хүснэгт 9. Монложистикс Группийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 2019-2022 он-д үзүүлсний дагуу Монложистикс Группийн ROE харьцаа 2019 – 2021 онуудад дундажаар 50% орчим байсан ба 2022 онд 36.5%-тай байна. Харин харьцуулсан компанийн ROE үзүүлэлт 11.6% - 22.8% хооронд байна.


Иймд ROE болон PB харьцаануудын хоорондын хамаарлын регрессийн шинжилгээ хийж үнэлгээнд ашиглав.

ROE ба PB харьцааны регрессийн шинжилгээ

Түүврийг сонгохдоо МХБ-ийн I болон II ангиллын нийт 63 компаниас мэдээлэл нь бүрэн 36 компанийг сонгож, 2022 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээс ROE болон PB харьцаануудыг тооцоолж регрессийн шинжилгээнд хэрэглэв. Өгөгдөлд завсарын квантилыг (interquartile range) ашиглан тухайн түүврээс ихээхэн ялгаатай өгөгдөл (outlier) хасах замаар цэвэрлэгээ хийсэн болно.



Зураг 14. ROE болон PB харьцааны регрессийн үр дүн



Регрессийн шинжилгээгээр ROE болон PB харьцаанууд хоорондоо эерэг хамаарлыг үзүүлж, ROE-ийн коэффициент нь 4.2 байгаа нь ROE нэг хувиар өсөхөд PB харьцаа 0.67 нэгжээр өсөх дундаж тооцоолол гарсан. Стандарт алдаа 0.075 байгаа нь тухайн загварт нийцэл сайн байгааг харуулна. Вариаци шинжилгээ (ANOVA)-г доор үзүүлэв.

Soucre of variance	Degree of freedom (df)	Sum of Squares (SS)	Mean Square (MS)	F-statistic	Significance F
Regression	1	0,075051532	0,075051532	13,93544457	0,000691015
Residual	34	0,183112357	0,005385658		
Total	35	0,258163889			

Регрессийн ач холбогдлын түвшин (significance level) 0.05-аас бага, $p=0,00069$ утгатай F-статистик нь 13.93 байна. Үүнээс бид тэг (null) таамаглалыг үгүйсгэж, ROE болон PB хооронд мэдэгдэхүйц шугаман хамаарал байна гэж дүгнэж болно.

Регрессийн тэгшитгэл нь: $P/B \text{ харьцаа} = 0.6715 + 4.2364 * ROE$

Монложистикс Группийн 2022 оны эцсийн байдлаарх ROE харьцаа нь 36.5% байгаа нь PB үржүүлэгч 2.22 байх үр дүнг өгч байна.

R квадрат 0.29 утга нь загвар өгөгдөлд хангалттай нийцэж байгааг харуулж байгаа боловч PB харьцааны өөрчлөлтийг тайлбарлах бусад хүчин зүйлүүд байж болохыг үгүйсгэхгүй болно.

Дүгнэлт

Монложистикс Группийг МХБ дээр хувьцаа нь идэвхитэй арилжаалагддаг компаниудтай харьцуулсан шинжилгээний үр дүнд сонгосон компаниудын дундаж PE харьцаа 12.5, ROE ба PB харьцааны хоорондын хамаарлыг ашиглан тооцсон дундаж PB харьцаа 2.3 байна

Үнэлж буй болон харьцуулж буй компаниудын үйл ажиллагаа, санхүүгийн байдал өөр түл зах зээлийн харьцуулалтын аргыг ашиглан гаргасан үнэ цэнээр бизнесийн үнэ цэнийг тогтооход учир дутагдалтай. Зах зээлийн харьцуулалтын аргын үндсэн зорилго нь тухайн компани МХБ дээр нийтэд нээлттэй болсны дараах үеийн хөрөнгө оруулагчдын хүлээлт, хэвдлагыг баримжаалан тооцоолоход оршино.



ХХК
Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Монложистикс Группийн биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай болно.

Холдинг компанийн онцлогоос хамаарч Монложистикс Холдинг ХХК тусдаа компанийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтад хамаарахгүй цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулав.

Үнэлгээнд хамрагдсан компаниудын хөрөнгө болон өр төлбөрүүдийг үнэлгээний зориулалтаар дараах байдлаар хувааж үнэлэв. Үүнд:

1. Эргэлтийн бус хөрөнгө:
 - Үндсэн хөрөнгө
 - Биет бус хөрөнгө
2. Эргэлтийн хөрөнгө:
 - Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
 - Авлага
 - Бараа материал
 - Урьдчилж төлсөн зардал
3. Өр төлбөр:
 - Дансны өглөг болон бусад өглөг
 - Урьдчилж орсон орлого

Үнэлгээчид нь Монложистикс Холдинг ХХК болон түүний охин компаниудын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгүүдийг хамруулсан хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар тооцоолох үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэн “Хөрөнгийн үнэлгээ”-ний тайлангаар хүргүүлсэн.

Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтүүдэд үзүүлэв. Үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг дээр дурдсан хөрөнгийн үнэлгээний тайлангаас танилцахыг зөвлөж байна.

Охин компаниудын цэвэр хөрөнгийн үнэ цэнэ

Монложистикс Холдинг ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар нийт 8 охин компанитай бөгөөд үүнээс Монложистикс Россия Холдинг ХХК нь Монложистикс Транс Сервис ХХК-ийн 90% хувьцаа эзэмшдэг бөгөөд цэвэр холдинг компанийн зохион байгуулалтаар ажилладаг. Мөн Монложистикс Экүйпментс ХХК, Монложистикс Экспресс ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар үйл ажиллагаа эхлүүлээгүй байсан тул эдгээр компанийн цэвэр хөрөнгийн дүнг материаллаг биш гэж үзэн үнэлгээнд “тэг” дүнгээр авсан болно.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК





Хүснэгт 17. Үндсэн ба биет бус хөрөнгийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Дүн, төгрөгөөр
Импорт	662,659,610
Экспорт	15,800,597
Транзит	81,568,691
Бусад	757,737,993
Нийт	1,517,766,891

Монложистикс Холдинг ХХК-ийн охин компаниудын үндсэн ба биет бус хөрөнгүүдийн нийт үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 1,517,766,890 төгрөгөөр тооцоолов.

Бусад эргэлтийн бус хөрөнгөд санхүүгийн хөрөнгүүд, хойшлогдсон татварын хөрөнгө зэргийг авч үзэв. 2022 оны эцсийн аудитын тайланд орсон дүнгээр тус компаниудын бусад эргэлтийн бус хөрөнгө 791,049,227 төгрөг байна.

Хүснэгт 18. Бусад эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Дүн, төгрөгөөр
Импорт	750,046,536
Экспорт	15,503,941
Транзит	17,650,065
Бусад	7,848,684
Нийт	791,049,227

2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх аудитлагдсан санхүүгийн тайланд тус компанийн нийт эргэлтийн хөрөнгө 39,849,000,270 төгрөг байхаар туссан байна.

Хүснэгт 19. Эргэлтийн хөрөнгийн үнэлгээ

Үйл ажиллагаа	Дүн, төгрөгөөр
Импорт	27,092,422,654
Экспорт	5,965,011,263
Транзит	4,671,098,736
Бусад	2,120,467,617
Нийт	39,849,000,270

2022 оны эцсийн санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт өр төлбөр 19,055,176,588 төгрөг байна.

Хүснэгт 20. Өр төлбөр

Үйл ажиллагаа	Дүн, төгрөгөөр
Импорт	11,362,080,975
Экспорт	5,745,918,926
Транзит	326,617,232
Бусад	1,620,559,455
Нийт	19,055,176,588



СХХ
Монложистикс Холдинг ХХК-ийн тусдаа компанийн хөрөнгө

ОН 2023 сар 14 өдөр
БҮРТГЭВ

Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтад хамаарахгүй цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулав. Цэвэр хөрөнгийн үнэлгээнд тус компанийн тусдаа санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг ашигласан ба хөрөнгө болон өр төлбөрийн дүнгээс охин компаниудтай холбоотой ажил гүйлгээг хасаж цэвэрлэн цэвэр хөрөнгө болон өр төлбөрийн дүнг тодорхойлов.

Хүснэгт 21. Монложистикс Холдинг ХХК (тусдаа), цэвэр хөрөнгийн үнэ цэнэ

Үзүүлэлтүүд, сая төгрөгөөр	Дүн	Холбоотой талуудын гүйлгээ	Цэвэр дүн
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	964.1	-	964.1
Авлага	3,876.5	2,443.0	1,433.5
Бусад эргэлтийн хөрөнгө	91.5	-	91.5
Үндсэн хөрөнгө	142.4	-	142.4
Биет бус хөрөнгө	73.9	-	73.9
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,046.6	5,046.6	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	437.4	-	437.4
Нийт хөрөнгө	10,632.4	7,489.7	3,142.7
Богино хугацаат өглөг	372.8	-	372.8
Богино хугацаат өр төлбөр	3,058.4	3,000.8	57.6
Бусад богино хугацаат өр төлбөр	82.7	-	82.7
Урт хугацаат өр төлбөр	16.2	-	16.2
Нийт өр төлбөр	3,530.2	3,000.8	529.4
Эздийн өмч	7,102.2	4,488.9	2,613.3

Монложистикс Холдинг ХХК (тусдаа)-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 2,613,333,400 төгрөг байхаар тооцоолов.

Цэвэр хөрөнгө


Хөрөнгөд сүүрилсан аргаар бизнесийг үнэлэхэд нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөд үндэслэн тооцоолов.

Хүснэгт 22. Монложистикс Холдинг ХХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ

Үйл ажиллагаа	Цэвэр хөрөнгө, группийн хэмжээнд	Цэвэр хөрөнгө, МЛХ-ийн эзэмшил
Импорт	17,143,047,827	17,143,043,928
Экспорт	250,396,875	135,609,406
Транзит	4,443,700,260	2,636,185,994
Бусад	3,878,828,238	3,687,749,302
Импорт	17,143,047,827	17,143,043,928
Нийт	25,715,973,200	23,602,588,630

Дээрх тооцооллоор Монложистикс Холдинг ХХК-ийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 23,602,588,630 төгрөг болж байна. Энэ аргаар Монложистикс Холдинг ХХК-ийн үнэ цэнийг тодорхойлоход учир дутагдалуудтай. Учир нь тооцоололд тус компанийн ирээдүйн





орлого олох чадварт чухал нөлөө үзүүлэх гоодвилл, барааны тэмдэгт, менежментийн үр чадвар зэрэг биет бус хөрөнгүүд ороогүйтэй холбоотой.



Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ

Монложистикс ХХК нь группын хэмжээнд 2021, 2022 онуудад харгалзан 3.9 тэрбум төгрөг, 9.7 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Үнэлгээнд Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity)-ний загварыг ашиглав.

Энэ арга нь өмчийн эздэд хамаарах ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр бизнес өмчлөлийн үнэ цэнийг илэрхийлдэг.

Энэхүү аргаар үнэлгээг тооцоолоход дараах 2 хүчин зүйлээс хамаарч бизнесийн үнэ цэнэ хэр зэрэг үнэн бодитой гарах эсэх нь шалтгаална. Үүнд:

- Ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөл болон төсөөлж буй хугацааны эцэст үлдэх өртөг буюу Терминал үнэ цэнэ,
- Хорогдуулалтын хувийг оновчтой сонгох зэрэг орно.

Үнэлгээнд ашигласан орц, төсөөллүүд болон үндсэн тооцооллыг доор тайлбарлав.

Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл


Монгол Улсын эдийн засгийн төсөөллийг ОУВС-ын 2022 оны 10 дугаар сарын төсөөлөлд¹⁵ үндэслэн хийж гүйцэтгэв. 2022 оны ам.доллар/төгрөгийн дундаж ханш 3,191.33 байсан бөгөөд тус төсөөлөлд 2023 оны дундаж ханшийг 3,511.43 байхаар тооцоолсон байна. Харин бодит гүйцэтгэлээр ам.доллар/төгрөгийн ханш үнэлгээний өдөр буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,444.60, тайлангийн өдрийн байдлаар 3,524.75 болж өссөн тул ОУВС-ийн төсөөллийг дундаж ханшийн өөрчлөлтөөр шинэчилж үнэлгээнд ашиглав.

Шинэчилсэн төсөөлөлд 2023 оны ам.доллар/төгрөгийн дундаж ханшийг 3602.00 төгрөг байхаар авсан бөгөөд үүнтэй үялдуулан худалдан авах чадварын тэнцэл (Purchasing Power Parity)-д үндэслэн 2023 оны дундаж инфляцийг 2.45 нэгж хувиар өсгөж авав. Үнэлгээнд ашигласан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 23. Эдийн засгийн үзүүлэлтүүд, 2022 – 2027 он

Үзүүлэлтүүд	2022	2023	2024	2025	2026	2027
ДНБ, оны үнээр, тэрбум ₮	50,167.7	58,275.7	68,124.0	77,677.6	87,640.5	97,975.6
ДНБ, оны үнээр, тэрбум \$	15.7	16.6	18.6	20.4	22.1	23.8
Импортын бараа, тоон өсөлт	6.9%	7.1%	8.3%	5.0%	7.0%	4.8%
Экспортын бараа, тоон өсөлт	-2.6%	15.5%	13.7%	9.3%	7.5%	3.7%
Ам.долларын ханш, \$/₮	3,191.3	3,602	3,767	3,910	4,061	4,219
Инфляци, %		15.9%	9.5%	8.2%	7.3%	6.5%





Урт хугацаанд Монгол Улсын дундаж инфляци жилийн 6%, АНУ-ын дундаж инфляци 2% байхаар тус тус төсөөлөв.



Монложистикс Группийн ирээдүйн орлогын төсөөлөл

Үнэлгээний өдрийн байдлаар группийн охин компаниудаас Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Карго ХХК, Монложистикс Транзит ХХК, Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Экүйпментс ХХК, Монложистикс Транс Сервис, Каус Аустралис ХХК зэрэг 7 компанийн үйл ажиллагаа идэвхитэй өрнөж байна.

Монложистикс Группийн ирээдүйн орлогын төсөөллийг үйл ажиллагааны чиглэлд дараах байдлаар ангилан авч үзэх ба үүнд:

1. Импортын тээвэр - Монложистикс Ворлдвайд ХХК болон Монложистикс Карго ХХК
2. Экспорт тээвэр - Каус Аустралис ХХК
3. Транзит тээвэр - Монложистикс Транзит ХХК
4. Бусад тээвэр - Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Экүйпментс ХХК болон Монложистикс Транс Сервис гэж ангилан доор үзүүлэв.

1. ИМПОРТЫН ТЭЭВЭР

Импортын тээврийн ангилалд Монложистикс Ворлдвайд ХХК болон Монложистикс Карго ХХК-ийн үйл ажиллагааг авч үзэв.

Монгол Улсын гаалийн импортын мэдээгээр 2022 онд тээвэр ложистикийн компаниуд нийт 280 орчим мянган тээвэр зохион байгуулсан бөгөөд Монложистикс групп нь зах зээлийн ойролцоогоор 4%-ийг эзэлсэн үзүүлэлтээр салбартаа тэргүүлж байна. Тээвэр ложистикийн аль нэг компаниар дамжуулахгүйгээр иргэд, аж ахуйн нэгж өөрсдөө зохион байгуулсан тээврийн тоо жил ирэх бүр бүүрч байгаа бөгөөд 2022 он нийт тээврийн 30 орчим хувийг эзэлж байна¹⁶.

Монложистикс групп нь Хятад улсын CRIMT (China Railway International Multi Modal Transportation Co Ltd) тээвэр ложистикийн компанитай хамтарч ажиллаж байгаа бөгөөд түс компанийн олон улсын тээврийн Монгол Улс дахь тээврийн зохион байгуулагчаар ажиллаж эхлээд байна. Үнэлгээний өдрийн байдлаар CRIMT компани нь Монголын 3 тээвэр ложистикийн компанитай гэрээтэй ажиллаж байгаа бөгөөд Монложистикс групп нь 2022 онд CRIMT компанийн 50 орчим хувийн ачаа тээврийг Монголд зохион байгуулж ажилласан байна.

Хятад улсаас онлайн бараа захиалга, хүргэлт хийдэг энэхүү бизнесийн үйл ажиллагааны суурь дэд бүтэц болох захиалгын цахим хуудас (<https://cheepah.mn>), "TMall" худалдааны платформуос захиалсан барааг Хятад улсын Эрээн хотод хүргэх тээвэр, Эрээн хотоос Монгол Улсад хүргэх тээвэр, цаашлаад Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт захиалгын барааг хүргэх тээврийн дэд бүтцийн хөгжүүлэлтийг 2022 онд амжилттай хийж, бизнесийн үйл ажиллагааг 2022 онд амжилттай эхлүүлээд байна.



¹⁶ Монложистикс Холдинг ХХК-ийн дотоод мэдээллийн сан

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Монложистикс Группийн зүгээс онлайн бараа захиалгын үйлчилгээний цахим дэд бүтцийн технологийг илүү боловсронгуй болгох, хэрэглэгчдэд бараа худалдан авахад зээлийн шийдлийг банкүүд, банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран бий болгох, Хятадаас Монгол хүртлэх ложистикийн шийдлийг хөгжүүлж Эрээн хотод агуулахтай болох ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цаашид импортын барааны тоон үзүүлэлт өсөх, мөн олон улсын жишгийн дагуу тээвэр нь тээвэр ложистикийн компаниар дамжих тохиолдол нэмэгдэх нөхцөл байдалд үндэслэн Монложистикс Группийн 2025 он хүртлэх тээврийн тоон төлөвлөлтийг үндэслэлтэй гэж Үнэлгээчид дүгнэсэн болно. Тухайлбал, Үйлчлүүлэгчийн энэхүү төлөвлөлт нь иргэд аж ахуйн нэгжийн тээвэр ложистикийн компаниар дамжуулахгүй, өөрсдөө зохион байгуулах тээврийн тоо буурч 2025 онд 15% орчим болох, харин Монложистикс Группийн ирэх жилүүдэд зах зээлд эзлэх хувиа алдахгүй байх хувилбартай ойролцоо гарч байгаа нь төлөвлөлт үндэслэлтэй болохыг харуулж байна.

2026, 2027 онуудад тээврийн тоо нь ОУВС-гийн төсөөлсөн² Монгол Улсын импортын барааны тоон өсөлттэй ижил хувиар өсөхөөр авав.

Ирээдүйн орлогын төсөөлөл

Монложистикс Группийн 2027 он хүртлэх хугацааны цэвэр орлогын төсөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 24. Орлогын төсөөлөл, Импортын ангилал, 2022 – 2027 он

Үзүүлэлтүүд	2022	2023	2024	2025	2026	2027
Нийт орлого, сая \$	33.8	40.1	47.2	56.4	61.0	63.8
Нийт орлого, сая ₮	106,515.3	144,311.2	177,830.2	220,695.6	247,630.8	269,367.6

2. ЭКСПОРТЫН ТЭЭВЭР

Экспортын тээврийн ангилалд **Каус Аустралис ХХК**-ийн үйл ажиллагааг авч үзэв.

Монложистикс групп нь 2022 онд нийт 67.0 мянга орчим тоон нүүрс төмөр замаар тээвэрлэж 7,122.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.


Монложистикс Группийн хувьд уул уурхайн бүтээгдэхүүний төмөр замын тээвэрлэлт, ялангуяа нүүрсний тээвэрлэлт нь бизнесийн өсөлт авчрах үндсэн үйл ажиллагаа бөгөөд энэ үйл ажиллагааг үндсэндээ **Каус Аустралис ХХК** дээр зохион байгуулахаар төлөвлөж байна.

Монложистикс Группийн хэмжээнд авч үзвэл 2022 онд 5 цуваа вагоныг Монголоос, түрээслэн ажиллуулсан ба цаашид хувьцааны болон зээлийн санхүүжилтээр өөрийн эзэмшлийн 100 вагон (2 цуваа)-г нүүрсний тээвэрт оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Ингэснээр нүүрс тээврийн үйл ажиллагааг өргөжүүлж 2023 онд 200 орчим мянган тонн, 2024 онд 300 орчим мянган тонн, 2025 онд 400 орчим мянган тонн нүүрс тээвэрлэхийг зорин ажиллаж байна.



205



Монгол Улс 2022 онд нийт 31.8 сая тонн нүүрс экспортод гаргасан бөгөөд 2023 оны 1-р сард 3.6 сая тонн нүүрс экспортлоод байна.¹⁷ 1-р сард 3.6 сая тонн нүүрс экспортод гаргасан нь өмнөх оны 1-р саруудтай харьцуулахад түүхэн өндөр хэмжээ бөгөөд өмнө хамгийн ихдээ 2017 оны 1-р сард 2.6 сая тонн нүүрс экспортолсноос даруй 1.0 сая тонноор өндөр үзүүлэлт болно. Энэ нь Монгол Улс төмөр замыг ашиглалтад оруулж нүүрсний тээвэрт ашиглаж эхэлсэнтэй шууд холбоотой гэж үзэж болно.

Монгол Улс нүүрсний экспортыг нэмэгдүүлэхээр, тэр дундаа нүүрсний тээврийг төмөр замаар хийхийг зорьж байгаа өнөөгийн бодит нөхцөл, мөн Монложистикс Группийн нүүрсний тээврийг үйл ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байгаа стратеги, төлөвлөлт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдэд үндэслэн Каус Аустралис ХХК-ийн төлөвлөсөн нүүрсний тээврийн зорилт нь биелэх боломжтой төлөвлөлт гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.

Хүснэгт 25. Орлогын төсөөлөл, Экспортын ангилал, 2022 – 2027 он

Үзүүлэлтүүд	2022	2023	2024	2025	2026	2027
Нийт орлого, сая \$	2.3	7.7	11.5	17.2	18.9	20.0
Нийт орлого, сая ₮	7,122.1	27,580.3	43,265.2	67,364.6	76,674.5	84,234.5

3. ТРАНЗИТ ТЭЭВЭР

Экспортын тээврийн ангилалд **Монложистикс Транзит ХХК**-ийн үйл ажиллагааг авч үзэв.

Транзит тээврийн тоо

Монложистикс групп нь 2022 онд Монголын коридороор нийт 11,354 транзит чингэлэг тээврийг зохион байгуулсан бөгөөд үүнээс 7,541 тээвэр буюу 66% нь Баруун зүгт чиглэсэн (Westbound) тээвэр, 3,813 буюу 34% нь Зүүн зүгт чиглэсэн (Eastbound) тээвэр тус тус эзэлж байна.

Монложистикс Групп нь Хятад улсын SWIFT Transportation Group¹⁸ компанитай стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг бөгөөд SWIFT Transportation Group нь Монложистикс Транзит ХХК-ийн 40%-ийг эзэмшиж байна.

SWIFT компани нь Хятад улсын Тяньжин хотод 2007 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд ОХУ болон Хятад улсын хооронд бүх төрлийн чингэлэг тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилладаг Хятад улсын томоохон компани болно. Одоогоор Москва, Манжуур, Шанхай, Циндао болон Гуанжоу хотуудад салбартай.


Монложистикс Групп нь 2023, 2024 онуудад 15.0 мянга орчим чингэлэг тээвэр, 2025-2027 онуудад дундажаар 20.0 орчим мянган чингэлэг тээврийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ОХУ болон Хятад улсын хоорондох худалдаа өсөн нэмэгдэж байгаа, үүнтэй уялдаад SWIFT компанийн чингэлэг ачаа тээвэр нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд энэ төлөвлөлт нь биелэх боломжтой төлөвлөлт гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК





Ирээдүйн орлогын төсөөлөл

2022 онд Монголын коридороор Баруун зүгт чиглэсэн (Westbound), Зүүн зүгт чиглэсэн (Eastbound) тээврийн нийт 21.6 тэрбум төгрөг буюу 6.9 сая ам.долларын борлуулалтын цэвэр орлоготой ажилласан байна.

Монложистикс Групп нь транзит чингэлэг тээврийн тоо болон нэгж тээврийн орлогод үндэслэн 2027 он хүртэл цэвэр орлогын төлөвлөлтийг гаргаад байна.

Хүснэгт 26. Орлогын төсөөлөл, Транзит ангилал, 2022 – 2027 он

Үзүүлэлтүүд	2022	2023	2024	2025	2026	2027
Нийт орлого, сая \$	6.9	6.1	6.2	8.2	8.6	9.0
Нийт орлого, сая ₮	21,612.0	21,937.8	23,530.5	31,991.0	34,884.2	38,056.5

4. Бусад тээвэр

Бусад тээвэрт Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Экүйпментс ХХК болон Монложистикс Транс Сервис-ийн үйл ажиллагааг нэгтгэн авч үзэв.

Монложистикс Групп нь ОХУ-аар дамжих Европын авто тээврийн сувгийг 2022 онд амжилттай түршсан бөгөөд цаашид илүү хөгжүүлж нийт борлуулалтын 25%-д хүргэхийг зорин ажиллаж байна. ОХУ болон Европын орнуудын хооронд үүссэн улс төрийн орчин нь энэ төрлийн тээврийг нэмэгдүүлэх боломжтой нөхцөл байдлыг бий болгоод байна. Цаашлаад, Турк улсын тээврийн сувгийг хөгжүүлэх, группийн бусад компаниудтай хамтран ОХУ болон Хятад улсын хоорондох транзит авто тээвэр, нүүрсний дотоод тээвэр хийх сувгуудыг эхлүүлэх зэрэг ажлууд хөгжүүлэлтийн ажлыг стратегийн түвшинд хөгжүүлэн ажиллаж байна.

Монложистикс Групп нь ОХУ-аас воган худалдан авах тусгай зориулалтаар Монложистикс Экүйпмент ХХК-ийг 2022 онд үүсгэн байгуулсан. Монложистикс Групп нь 2023 онд IPO санхүүжилтээр татах хөрөнгөөс 8.0 тэрбум төгрөг болон 15.2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт, нийт 23.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр ОХУ-аас 100 ширхэг вагон худалдан авч Каус Аустралис ХХК-д түрээслүүлэхээр зорин ажиллаж байна.

Үнэлгээний өдрийн дундаж ханшаар 23.2 тэрбум төгрөг нь ойролцоогоор 500 сая рубльтэй тэнцэнэ. 2022 оны 9-р сарын байдлаар ОХУ-д тавцан вагоны дундаж үнэ 4.9 сая рубль¹⁹ байгаа бөгөөд 100 вагоны нийт үнэ ойролцоогоор 490 орчим сая рубль болно. Нийт худалдан авах вагоны 1 цуваа буюу 50 вагоныг 2023 онд үлдсэн вагоныг 2024 онд багтаан Монгол Улсад авчирч түрээсийн үйл ажиллагаанд оруулахаар төлөвлөж байна.


Монгол Улсын төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс болон уул уурхайн бусад түүхий эдийг төмөр замаар тээвэрлэхийг дэмжих төрийн бодлого, тээврийн вагоны хүрэлцээ, нийлүүлэлтийн дутагдал зэрэг өнөөгийн нөхцөлд Монложистикс Экүйпментс ХХК-ийн вагоны түрээсийн орлогын төлөвлөлт нь вагон худалдан авалтыг төлөвлөсөн хугацаанд хийж чадсан тохиолдолд биелэх боломжтой төлөвлөлт гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



207



Монложистикс Группийн зүгээс БНХАУ болон ОХУ-ын тээвэр, ложистикийн томоохон компаниудтай хамтран ажиллаж ОХУ болон БНХАУ-ын хооронд хийгдэх тээвэр, тэр дундаа зөвхөн Монгол Улсаар дамжин өнгөрөхөөс гадна Алс дорнод болон Монголын баруун талаар хийгдэх тээврийн үйл ажиллагаанд оролцохоор ажиллаж байна.

Орос Украйны дайнаас үүдэн ОХУ болон БНХАУ-ын хоорондын худалдаа, үүнтэй уялдаад тээврийн хэмжээ ихсэх өнөөгийн нөхцөл байдалд Монложистикс Группийн үйл ажиллагааг өргөжүүлэх бодит боломж байна гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.

Хүснэгт 27. Орлогын төсөөлөл, Бусад тээврийн ангилал, 2022 – 2027 он

Үзүүлэлтүүд	2022	2023	2024	2025	2026	2027
Нийт орлого, сая \$	2.7	5.0	7.1	7.3	7.4	7.6
Нийт орлого, сая ₮	8,383.4	17,999.7	26,851.9	28,729.6	30,127.3	32,003.1

Монложистикс Группийн ирээдүйн зардлын төсөөлөл

Монложистикс Группийн ирээдүйн зардлын төсөөллийг охин компани бүр дээр зардлын үндсэн ангилал бүрээр авч үзэн, өнгөрсөн хугацааны гүйцэтгэлтэй харьцуулах байдлаар шинжилж, шаардлагатай гэж үзсэн тохируулгыг хийж үнэлгээнд ашиглав.

1. Борлуулалтын өртгийн тооцоолол

Монложистикс Группийн охин компаниудын ирэх 3 жилд тооцоолсон нийт ашгийн маржинг компани бүрийн хувьд өнгөрсөн жилүүдийн нийт ашгийн маржингийн бодит гүйцэтгэлтэй харьцуулсан шинжилгээ хийв.


Үйл ажиллагаа нь харьцангуй жигдэрсэн компаниуд болох Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Транзит ХХК, Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Транс Сервис ХХК-иудын хувьд ирэх жилүүдийн нийт ашгийн маржинг өмнөх онуудын дундажтай ойролцоо эсвэл дундажаас доогуур төсөөлсөн байна. Иймд эдгээр компанийн 2025 он хүртлэх нийт ашгийн маржинг Үнэт цаас гаргагчийн төсөөлсөн хувиар, 2026-2027 онуудад 2025 оны дүнтэй ижил түвшинд байхаар авч үнэлгээнд ашиглав.

Монложистикс Карго ХХК-ийн хувьд 2022 оны гүйцэтгэлээр нийт ашгийн маржин 14.4% байсан нь гадаад тээврийн зардал харьцангуй өндөр буюу 104.6 сая төгрөг байсантай холбоотой. Тус компанийн орлого тээврийн орлого болон үйлчилгээний орлогоос бүрдэх бөгөөд 2022 онд ачаа тээврийн болон захиалгын үйлчилгээний цахим дэд бүтцийн хөгжүүлэлт хийж гүйцэтгээд байна.

Цаашид нийт орлогын 40 орчим хувийг тээврийн орлого, 50 гаруй хувийг үйлчилгээний орлого, үлдсэн хэсгийг хүргэлтийн орлого байхаар төлөвлөн ажиллаж байна. Үйлчилгээний орлогын борлуулалтын өртөг харьцангуй бага буюу 24 орчим хувь тул цаашид орлогод эзлэх үйлчилгээний орлогын хэмжээ өссөнөөр ашгийн маржин өсөх боломжтой.

Монложистикс Карго ХХК нь нийт ашгийн маржинг 2023 онд 62.8%, 2024 онд 60.9%, 2025 онд 58.9% тус тус байхаар төлөвлөж байгаа нь тус компанийн бизнесийн бизнес хөгжлийн үе шат,





стратеги төлөвлөлт, өнөөгийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд нийцтэй байна гэж Үнэлгээчид дүгнэсэн болно.

Монложистикс Экүйпментс ХХК-ийн ажиллах бизнес загварын дагуу тус компанийн борлуулалтын өртөг нь зөвхөн вагоны засвар үйлчилгээний зардал байхаар төлөвлөсөн байна. Монгол Улсад вагоны хугацаат болон капитал засвар үйлчилгээг УБТЗ ХНН хийж гүйцэтгэдэг бөгөөд зардлын хэмжээг дундажаар жилийн борлуулалтын 1.0% байхаар тооцоолсон байна.

Үнэлгээчдийн хийсэн судалгаагаар ОХУ-д вагоны засвар үйлчилгээг 160 мянган км тутамд хийх шаардлагатай ба нэг вагонын чанартай, сайн урсгал засварын зардалыг 2019 онд 72 мянган рубль гэж тооцсон байна²⁰. ОХУ-ын Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний операторуудын холбооны тооцоолсноор 2021 оны байдлаар вагоны дундаж урсгал засвар 80 – 100 мянган рубль, капитал засвар 110 – 130 мянган рубль байсан байна.

Үнэлгээчид дээрх баримжаа зардлын дүнг ашиглан Монложистикс Группийн Цогтцэций Эрээний хооронд төмөр замын нүүрс тээврийн төлөвлөгөөнд үндэслэн баримжаа тооцоо хийхэд вагоны засвар үйлчилгээний зардал нь Үнэт цаас гаргагчийн төсөөлөл дотор гарч байгаа тул үндэслэлтэй гэж дүгнэсэн болно.

Каус Аустралис ХХК-ийн нийт ашгийн маржин 2022 онд 19.4% байсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь цаашид 30 орчим хувь болж өсөхөөр төлөвлөсөн байна. Тус бизнесийн үйл ажиллагааны онцлогтой үялдуулан үнэлгээнд ашгийн маржинг 2022 оны гүйцэтгэлээр буюу 19.4% байхаар тооцож үнэлгээнд ашиглав.

Монложистикс Группийн нийт ашгийн маржин болон борлуулалтын өртгийн төсөөллийг охин компани бүрийн хувьд доор үзүүлэв.

Хүснэгт 28. Нийт ашгийн маржин, борлуулалтын өртөг, 2022 – 2027 он

Тээврийн ангиллаар, сая төгрөг	2022	2023	2024	2025	2026	2027
Импортын тээвэр						
Нийт ашгийн маржин	11.1%	10.4%	11.6%	12.8%	12.7%	12.7%
Борлуулалтын өртөг	94,640.1	129,267.8	157,177.8	194,923.9	216,366.9	235,484.2
Экспортын тээвэр						
Нийт ашгийн маржин	19.4%	19.4%	19.4%	19.4%	19.4%	19.4%
Борлуулалтын өртөг	5,737.7	22,219.2	34,855.3	54,270.3	61,770.5	67,861.0
Транзит тээвэр						
Нийт ашгийн маржин	12.2%	11.0%	10.7%	9.8%	9.8%	9.8%
Борлуулалтын өртөг	18,966.7	19,524.3	21,019.3	28,842.3	31,450.8	34,310.8
Бусад тээвэр						
Нийт ашгийн маржин	11.6%	21.3%	37.4%	34.7%	34.5%	35.1%
Борлуулалтын өртөг	7,407.6	14,168.9	16,807.7	18,746.9	19,729.7	20,771.0
Нийт						
Нийт ашгийн маржин	11.8%	12.6%	15.3%	15.6%	15.5%	15.5%
Борлуулалтын өртөг	126,752.0	185,180.2	229,860.1	296,783.4	329,317.9	358,427.0



2. Үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардал

Үйл ажиллагааны зардлыг зардлын үндсэн ангилал бүрийн хувьд охин компани бүр дээр хийж гүйцэтгэн холбогдох тохируулгыг хийж үнэлгээнд ашиглав.

Зардлын шинжилгээг дараах үндсэн аргачлалаар хийж гүйцэтгэсэн болно.

- 1) Оффис түрээс, харилцаа холбоо, даатгал, маркетинг, үйл ажиллагааны бус зардал зэрэг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөх боломжтой зардлуудыг 2025 он хүртэл Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөтэй уялдаатай эсэхийг нягталж, цаашид инфляциар өсөхөөр,
- 2) Ажиллагсадтай холбоотой зардал, найдваргүй авлагын зардал зэрэг борлуулалттай шууд хамааралтай зардлуудыг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулсан шинжилгээ хийж, зардлын өсөлтийн хандлагыг дагуулж холбогдох тохируулга хийх аргыг ашиглав.

Монложистикс Группийн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус орлого, зардлын тооцоолсон нийт дүнг компани бүрээр доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 29. Үйл ажиллагааны болон бусад зардал, 2023 – 2027 он

Тээврийн ангиллаар, сая төгрөг	2023	2024	2025	2026	2027
Импортын тээвэр	8,109.1	10,341.4	14,276.6	16,213.8	18,164.3
Экспортын тээвэр	462.8	577.2	638.4	736.1	801.2
Транзит тээвэр	1,168.8	1,395.6	1,686.6	1,801.2	1,925.0
Бусад тээвэр	2,960.9	5,308.4	4,864.0	4,409.3	3,950.0
Нийт	12,701.6	17,622.6	21,465.6	23,160.3	24,840.5

Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувь

Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн тооцооллыг өргөтгөсөн Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвар (CAPM) ашиглан хийж гүйцэтгэв. Харин CAPM аргыг шууд хэрэглэхэд манай улсын хөрөнгийн зах зээлийн мэдээлэл хангалттай биш тул хөгжиж байгаа орнуудад элбэг хэрэглэгддэг арга буюу хөгжсөн зах зээлтэй харьцуулж үнэлдэг аргыг хэрэглэв.²¹ Аргыг товч тайлбарлавал:

$$k_e = R_f + \beta_e MMERP + \lambda_e CDS + SRP + CSRP + CRP$$

энд,

k_e -	cost of equity capital
R_f -	risk-free reference rate in a developed country
MMERP -	mature market equity risk premium
β_e -	exposure to market risk
CDS -	country's credit default spread
λ_e -	exposure to country risk
SRP	Size risk premium
CSRP	Company specific risk premium
CRP	Currency risk premium



²¹ https://scielo.conicyt.cl/scielo.php?script=sci_arttext&pid=S0719-04332016000100006#n6

ШТК0162 9021070414 5212487

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



СЗХ

он Монложистик Группийн охин компаниудын ирээдүйн мөнгөн урсгалтай холбоотой эрсдэл нь
БҮГД НУХАЙН компанийн ажиллаж байгаа салбар, бизнес хөгжлийн үе шатаас хамаарч өөр өөр
байгаа тул хөрөнгө оруулагчийн шаардах өгөөжийг компани бүрийн хувьд дараах байдлаар
тооцоолов.

Үзүүлэлтүүд	МЛВ	МЛК	МЛТр	МЛТ	МЛЭ	МЛТС	КА	Тайлбар #
$R_f =$	4.14%	4.14%	4.14%	4.14%	4.14%	4.14%	4.14%	(1)
$MMERP =$	5.94%	5.94%	5.94%	5.94%	5.94%	5.94%	5.94%	(2)
$\beta_e =$	1.06	1.06	1.55	1.11	1.11	1.11	1.11	(3)
Industry	Transportation	Trucking		Transportation (Railroads)				
CDS =	7.95%	7.95%	7.95%	7.95%	7.95%	9.17%	7.95%	(4)
$\lambda_e =$	1	1	1	1	1	1	1	(5)
CSRP	0.0%	2.5%	0.0%	0.0%	1.0%	0.0%	2.3%	(6)
SRP =	-	-	-	-	-	-	-	(7)
$k_{e(usd)} =$	18.38%	20.93%	21.27%	18.67%	19.66%	19.90%	21.01%	(8)
CRP =	4.64%	4.74%	4.76%	4.65%	4.69%	4.70%	4.75%	(9)
$k_{e(mnt)} =$	23.0%	25.7%	26.0%	23.3%	24.4%	24.6%	25.8%	

Тайлбар

(1): 20 year US Treasury Rate, 31 December, 2022²²

(2): USA Equity risk premiums²³

(3): Салбарын дундаж бета²⁴

(4): Country rating-based Default Spreads²³

(5): Гадаад тээврийн үйл ажиллагаа тул улсын эрсдэлтэй хамаарал өндөртэй гэж үзэв.

(6): Компаниудын тусгайлсан эрсдэлийн нэмэгдэл (CSRP)-ийн Монложистикс Ворлдвайд ХХК-тай харьцуулан дараах байдлаар тооцоолов.

Компаниуд	МЛВ-тэй харьцуулсан эрсдэлийн зөрүү	Эрсдэлийг хэмжих	Компанийн тусгайлсан эрсдэл
МЛВ	-	-	-
МЛТ	Үндсэн үйл ажиллагаа нь төмөр замын тээвэр	Төмөр замын тээврийн бета ашигласан тул эрсдэлийн зөрүүг илэрхийлнэ	0.0%
МЛТр	Үндсэн үйл ажиллагаа нь авто тээвэр	Авто тээврийн салбарын бета ашигласан тул эрсдэлийн зөрүүг илэрхийлнэ	0.0%
МЛК	Цахим худалдааны салбарын эрсдэлд өртөх	Цахим худалдааны салбарын эрсдэл ба тээврийн салбарын эрсдэлийн зөрүүгээр CSRP-г хэмжих	2.5%
МЛЭ	Вагон түрээсийн эрсдэлд өртөх	Машин механизмын салбарын эрсдэл ба тээврийн салбарын эрсдэлийн зөрүүгээр CSRP-г хэмжих	1.0%
МЛТС	ОХУ-д үйл ажиллагаа явуулдаг	ОХУ-ын зээлжих зэрэглэлд суурилсан эрсдэлийн нэмэгдлийг ашигласан тул зөрүүг илэрхийлнэ.	0.0%
КА	Нүүрсний салбарын эрсдэлд эрсдэлд өртөх	Нүүрсний салбарын эрсдэл ба тээврийн салбарын эрсдэлийн зөрүүгээр CSRP-г хэмжих	2.3%



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Монложистик Группийн толгой компани болон охин компаниудын удирдлагын баг нь үндсэндээ ижил, шууд удирдлагын хэв шинжтэй, оролцоо өндөртэй ажилладаг тул дотоод хүчин зүйлээс хамааралтай эрсдэл группийн хэмжээнд ижил гэж үзэв.

(7): Монложистик Групп нь 2022 онд нэгтгэсэн үзүүлэлэлтээр 2022 онд 140.1 тэрбум төгрөгийн борлуулалттай, 9.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь Монголын Хөрөнгийн Биржийн TOP20 индексэд хамаарах компаниудтай цар хүрээний хувьд ижил түвшинд байгаа тул компанийн хэмжээтэй холбоотой эрсдэлийг нэмэлтээр аваагүй болно.

(8): Хөрөнгө оруулалтын шаардах өгөөжийн ам.доллараар илэрхийлсэн дүнг дээр үзүүлсэн томъёогоор тооцоолов.

(9): Монгол төгрөг ба ам.долларын ханшийн эрсдэлийн нэмэгдлийг Худалдааны Чадварын Харьцаа (PPP)-г ашиглан инфляцийн зөрүүгээр тохируулга хийж ингэхдээ Монгол Улсын урт хугацааны инфляцийг 6%, АНУ-ын урт хугацааны инфляцийг 2%-иар тус тус авч тооцоолов.

Монложистик Группийн охин компаниудын хувьд тооцоолсон хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувийг компаниудын ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын дүнгээр жинлэсэн дундаж өгөөж 24.4% байх тооцоолол гарсан болно.

Урт хугацааны өсөлтийн хувь

Монложистик Группийн бизнесийн үнэлгээнд урт хугацааны өсөлтийн хувийг тухайн улсын урт хугацааны ДНБ-ний өсөлтийн хувиас хэтрүүлэхгүй авахыг зөвлөдөг.²⁵ Хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн бодит өсөлт 10-аад жилийн өмнө дунджаар 7% байсан бол 2020 онд 5% болон буурч цаашид 2050 он гэхэд 2.5% болно гэж төсөөлж байна.²⁶ 1980 оноос хойших дэлхийн бүх улсуудын дундаж инфляци 2019 онд 2.15%, 2020 онд 1.94% байсан.²⁷

Үнэлгээнд Монложистик Группийн цэвэр орлогын урт хугацааны өсөлтийн хувийг 2028 оноос хойш жилд дундажаар 5.0 % байхаар авч ашиглав.

Ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл

Монложистик Группийн нэгтгэсэн дүнгээрх цэвэр мөнгөн урсгалын ирэх 5 жилийн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийн үндсэн хувилбарыг дараах байдлаар тооцоолов.

Хүснэгт 30. Монложистик Группийн орлогын төсөөлөл, 2023 – 2027 он

Орлогын үзүүлэлтүүд, сая төг	2023	2024	2025	2026	2027
Цэвэр борлуулалт	211,829.0	271,477.9	348,780.8	389,316.9	423,661.7
Борлуулалтын өртөг	(185,180.2)	(231,057.6)	(296,793.8)	(330,392.0)	(359,492.9)
Нийт ашиг	26,648.8	40,420.3	51,987.0	58,924.9	64,168.9
Үйл ажиллагааны болон бусад зардал	(12,701.6)	(17,622.6)	(21,465.6)	(23,160.3)	(24,840.5)
Татварын өмнөх ашиг	13,947.16	22,797.65	30,521.35	35,764.53	39,328.40
Орлогын татвар	(1,503.9)	(2,947.0)	(4,791.7)	(5,705.9)	(6,460.8)
Татварын дараах ашиг	12,443.3	19,850.6	25,729.7	30,058.6	32,867.6

MANDAL CAPITAL
MARKETS
LLC

²⁵ https://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/valquestions/stablegrowthrate.htm
²⁶ <https://www.oecd.org/economy/lookingto2060long-termglobalgrowthprospects.htm>
²⁷ <https://www.macrotrends.net/countries/WLD/world/inflation-rate-cpi>

Монложистик Холдинг
HOLDING
ATAS2995 E 01251
902101013

212

СХ
ОН
БҮРГЭЭ
№

Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгалын загвар (Free Cash flow Equity Model) -т ирэх жилүүдэд төлөвлөсөн капитал зардал (Capex), цэвэр зээл болон мөнгөн бус гүйлгээ болох элэгдэл хорогдлын зардал, ажлын капиталын өөрчлөлт (Changes in non-cash working capital)-ийг тооцоолж авч үзэв.

Капитал зардал

Монложистикс Группийн хэмжээнд капиталын үндсэн зардалд Монложистикс Экүйпмент ХХК дээр ОХУ-аас худалдан авах 100 ширхэг вагон орох ба энэ зардал 2023 онд 23.2 тэрбум төгрөг байхаар төлөвлөж байна.

Монложистикс Карго ХХК нь бизнес төлөвлөлттэй уялдуулан ирэх жилүүдэд програм хангамжийн зардалд жилд 110 – 120 орчим сая төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.

Бусад компаниудын хувьд капитал зардалд үндсэндээ бизнесийн өдөр тутмын оффис хэрэгцээнд ашиглагдах тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл орж байна.

Монложистикс Тракинг ХХК нь ирэх жилүүдэд капитал зардалд төсөвлөөгүй бөгөөд бид тус компанийн бизнесийн онцлогт уялдуулан үнэлгээний зориулалтаар тус компанийн тээврийн хэрэгслийн капитал зардлыг тооцоолсон элэгдлийн зардалтай тэнцүү байхаар авч үнэлгээнд ашиглав.

Монложистикс Группийн капитал зардлын ирэх жилүүдийн тооцооллыг зардлын ангиллаар доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 31. Монложистикс Группийн капитал зардлын тооцоолол, 2023 – 2027 он

Хөрөнгүүд, сая төг	2023	2024	2025	2026	2027
Тавилга, эд хогшил	113.5	13.0	-	63.6	79.7
Компьютер дагалдах хэрэгсэл	91.6	60.4	21.7	74.3	92.7
Тээврийн хэрэгсэл	83.5	79.2	79.2	79.2	79.2
Програм хангамж бусад	110.0	120.0	120.0	171.0	243.7
Вагон худалдан авалт	23,211.9	-	-	-	-
Нийт	23,610.5	272.6	220.9	388.1	495.3

Цэвэр ажлын капиталын өөрчлөлт

Бэлэн бус ажлын капиталын өөрчлөлтийг компани бүрийн хувьд борлуулалтын орлоготой уялдуулж шинжилгээ хийв.

Ажлын капиталын цэвэр өөрчлөлт нь МЛВ, МЛТ, МЛК, МЛТС компаниудын хувьд борлуулалтын орлогын төлөвлөгөөний тодорхой хувиар харьцангуй тогтворжих хандлагатай байгаа тул 2026 – 2027 оны цэвэр ажлын капиталын дүнг 2025 оны борлуулалтын орлогод эзлэх хувьтай ижил хувиар авав.

МЛТр компанийн 2023 – 2025 оны, КА компанийн 2024-2025 оны бэлэн бус ажлын цэвэр капиталын өөрчлөлт сөрөг дүнтэй буюу цэвэр мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх байдлаар нөлөөлөхөөр группийн удирдлагын баг төсөөлж байна.

MARKETS SC
LLC

ATAA 09 0001251
30 10 2023

213

МЛТР компанийн хувьд тус компани цаашид дансны авлагыг бууруулж ажиллахаар төлөвлөж байгаатай холбоотой байна. Харин 2026-2027 онуудад ажлын капиталын хөрөнгө, өр төлбөрийг тусад нь 2025 оны борлуулалтын орлогод эзлэх хувиудтай ижил хувиар тооцож үнэлгээнд ашиглав.

Каус Аустралис ХХК-ийн бизнесийн үйл ажиллагаа, бизнес хөгжлийн үе шаттай уялдуулан бэлэн бус ажлын цэвэр капиталын өөрчлөлтийг 2024 – 2027 онд “тэг” дүнтэй буюу тус компанийн мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх байдлаар үзүүлэх удирдлагын багийн тооцооллыг үнэлгээнд оруулаагүй болно.

Монложистикс Экүйпмент ХХК-ийн бизнесийн онцлогтой уялдуулан ажлын капиталын өөрчлөлтийг тус компанийн бизнес төлөвлөлтөд туссан дүнгээр авав.

Хүснэгт 32. Монложистик Группийн ажлын капиталын өөрчлөлт, 2023 – 2027 он

Бэлэн бус ажлын капиталын өөрчлөлт	2023	2024	2025	2026	2027
Цэвэр өөрчлөлт, сая төгрөг	4,567.8	331.7	1,257.8	1,318.8	1,648.2
Борлуулалтад эзлэх хувь	2.2%	0.1%	0.4%	0.3%	0.4%

Цэвэр зээл

Монложистикс группийн нэгтгэсэн байдлаар 2022 оны эцсийн байдлаарх зээлийн үлдэгдэл, болон 2027 он хүртэл төлөвлөсөн зээлийн санхүүжилтын дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 33. Монложистик Группийн цэвэр зээл, 2023 – 2027 он

Зээлийн үлдэгдэл, сая төгрөгөөр	2022	2023	2024	2025	2026	2027
Зээлийн нийт үлдэгдэл	2,816.7	15,221.2	12,495.0	9,768.8	7,042.7	4,316.5
Цэвэр зээл		12,404.6	(2,726.2)	(2,726.2)	(2,726.2)	(2,726.2)

Элэгдлийн зардал

Элэгдэл, хорогдлын зардлыг 2025 он хүртэл удирдлагын багийн тооцоолсноор 2026 – 2027 онуудад удирдлагын багийн тооцоололд үндэслэн тооцоолж үнэлгээнд ашиглав.

Үйл ажиллагааны бус хөрөнгө

Хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар бизнесийн үнэ цэнийг тооцоолоход тухайн бизнесийн үйл ажиллагаанд үл ашиглагдах хөрөнгүүдийн үнэ цэнийг нэмэлтээр тооцох шаардлагатай байдаг. Энэ хөрөнгөд илүүдэл бэлэн мөнгө, хөрөнгийн болон мөнгөний захиас худалдан авсан хөрөнгө оруулалтууд, бизнесийн үйл ажиллагаанд үл ашиглагдах газар, үл хөдлөх хөрөнгө зэрэг орно.

Монложистик Группийн хувьд охин компаниуд дээрх илүүдэл бэлэн мөнгө (Cash surplus) нь үйл ажиллагааны бус хөрөнгө болох бөгөөд өөр үйл ажиллагааны бус ямар нэг хөрөнгө байхгүй байна.

Монложистикс Группийн 2022 оны эцсээрх нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нийт 14.2 тэрбум төгрөг, үүнээс толгой компанид 1.0 тэрбум орчим төгрөг, үлдсэн 13.2 тэрбум



СЗХ
ОН
САР
ЭДЭЭ
БҮГД
ТАЙВ
№ 1

төгрөг нь охин компаниудад байна. Удирдлагын баг нь 2023 оны 1-р сараас эхлэн сар бүрийн хувьд группийн нэгтгэсэн үзүүлэлтээр мөнгөн урсгалын дутагдалд орохгүй гэж төлөвлөж байна.

Харин Үнэлгээчид аливаа бизнесийн бэлэн мөнгөний нөөцийг тодорхой тооны сарын үйл ажиллагааны зардлыг төлөх чадвартай байвал зохистой гэдэг²⁸ баримжаалсан дүрмийг баримтлан илүүдэл бэлэн мөнгөний дүнг тооцоолов. Монложистикс Группийн бизнесийн үйл ажиллагааны онцлог, өнгөрсөн хугацааны гүйцэтгэлд үндэслэн бэлэн мөнгөний нөөцийг 3 сарын үйл ажиллагааны зардалтай тэнцүү дүнгээр авч группийн хэмжээний илүүдэл мөнгийг 10,582.5 сая төгрөг байхаар тооцоолов.

Охин компаниуд	Бэлэн мөнгө 2022.12.31	Үйл ажиллагааны зардлын төсөв				Cash Surplus
		Jan-23	Feb-23	Mar-23	Нийт	
Total	13,225.3	(1,178.4)	(709.3)	(755.1)	(2,642.8)	10,582.5

Дээрх тооцооллуудад үндэслэн Монложистикс Группийн 7 охин компанийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 110,176,782,717 төгрөг байхаар тооцоолов.

Тооцооллыг үзүүлбэл:

Free Cash flow to Equity Model

Stable Equity Reinvestment Rate	7.6%	Cost of equity	24.3%
Stable FCFE Rate	92.4%	Stable growth rate	5.0%

MNT million

Free cash flow to Equity Model	2023	2024	2025	2026	2027	2028
Net income	12,443.3	19,850.6	25,729.7	30,058.6	32,867.6	34,510.9
Depreciation and amortization	1,137.2	1,893.0	2,019.9	2,173.9	2,360.8	
Changes in working capital	(4,567.8)	(331.7)	(1,257.8)	(1,318.8)	(1,648.2)	
Capital expenditure	(23,610.5)	(272.6)	(220.9)	(388.1)	(495.3)	
Net borrowings	12,404.6	(2,726.2)	(2,726.2)	(2,726.2)	(2,726.2)	
Free cash flow to Equity	(2,193.3)	18,413.1	23,544.7	27,799.5	30,358.6	
Terminal value						164,584.8
Total	(2,193.3)	18,413.1	23,544.7	27,799.5	194,943.4	

NPV of FCFE	99,594,235,511
Cash Surplus	10,582,547,206
Total Value	MNT 110,176,782,717

Цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээ

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS YUK ХХК
MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC
ШТК0162 9021070414 6213487

Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээнд тус компанийн охин компаниудад хийсэн хөрөнгө оруулалтад хамаарахгүй цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж үнэлгээнд хамруулав.

²⁸ <https://www.thebalancemoney.com/how-much-cash-should-your-business-have-on-hand-5202651>

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК
MONGOLIAN LOGISTICS
HOLDING CO., LTD.
ШТК0162 9021070414 6213487

Мон Ложистикс Холдинг ХХК (тусдаа)-ийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг Хүснэгт 21-д Монложистикс Холдинг ХХК (тусдаа), цэвэр хөрөнгийн үнэ цэнэ-д үзүүлсний дагуу үнэлгээний өдрийн байдлаар 2,613,333,400 төгрөг байхаар тооцоолов.

Үнэлгээний үр дүн

Монложистикс Холдинг ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анхлан санал болгоход тус компанийн хувьцааны үнийг тогтоох үндэслэл болгон ашиглах зориулалтаар хийгдэж байгаа үнэлгээний үр дүнг 2 үе шаттайгаар дараах байдлаар тооцоолов.

1. Монложистикс Холдинг ХХК-ийн хувь эзэмшилд хамаарах үнэ цэнэ

Монложистикс Холдинг ХХК-ийн хувь эзэмшилд хамаарах үнэ цэнийн тооцоолол хийхэд группийн охин компани тус бүрийн хувьд тооцоолсон цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн дүнг ашиглав.

д/д	Компаниуд	NPV of FCFE, төгрөгөөр	МЛХ-ийн эзэмшлийн үнэ цэнэ, төгрөгөөр
1	Импортын тээвэр	52,787,135,845	52,787,135,845
2	Экспортын тээвэр	39,943,541,205	20,371,206,015
3	Транзит тээвэр	7,187,215,453	4,312,329,272
4	Бусад тээвэр	10,258,890,215	10,150,097,427
	Нийт үнэ цэнэ	110,176,782,717	87,620,768,558
5	Монложистикс Холдинг ХХК (тусдаа)	2,613,333,400	2,613,333,400
	Нийт	112,790,116,117	90,234,101,958

Эхний шатанд Монложистикс Холдинг ХХК-ийн хувь эзэмшилд хамаарах нийт үнэ цэнийг 90,234,101,958 төгрөг байхаар тооцоолов.

2. Толгой компанийн хөнгөлөлтүүд

Татан буулгалтын хөнгөлөлт


Охин компаниудаас толгой компанид шилжих аливаа орлого, хөрөнгө нь татвар ногдох орлогод хамаарна. Ийм төрлийн ажил гүйлгээнд охин компаниас толгой компанид шилжүүлэх ногдол ашгийн орлого, охин компанийн хувьцааг бүтнээр болон хэсэгчлэн зарж борлуулснаас олсон орлого, охин компани татан буугдах тохиолдлын орлого, хөрөнгийн шилжүүлэг зэрэг ажил гүйлгээнүүд багтана.

Хөрөнгийн зах зээл хөгжсөн улсуудад охин компаниас толгой компанид шилжих ногдол ашгийн орлого татвараас чөлөөлөгддөг, харин бусад төрлийн орлого болон хөрөнгө шилжүүлэхэд татвар ногдуулдаг түршлага элбэг байна. Харин Монгол Улсын хувьд үнэлгээний өдрийн байдлаар охин компаниас толгой компанид шилжих дээр дурдсан бүх төрлийн орлого болон хөрөнгөд татвар ногдуулж байна.

Иймд Монложистикс Холдинг ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийн тооцоололд татан буулгалтын хөнгөлөлтийг 10% байхаар авав. Энэ хөнгөлөлт нь зөвхөн охин компанийн хувь эзэмшилд

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК





Огноо: 2023.08.14
БҮРТГЭВ-03
№ 11
хаммаарах бөгөөд үр дүнд Монложистикс Холдинг ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 81,472,025,102 төгрөг байхаар тооцоолов.

Хяналтгүйн хувь оролцооны болон борлуулах чадварын хөнгөлөлт

Компанийн бизнесийн үнэлгээнд, ялангуяа холдинг компанийн үнэлгээнд хяналтгүйн хувь оролцооны хөнгөлөлт болон борлуулах чадварын хөнгөлөлтийг авч үздэг. Эдгээр хөнгөлөлтийн хувь хэмжээг үнэлгээний тооцоололд үндэслэн тогтоохоос илүүтэй IPO хийх үеийн зах зээлийн нөхцөл байдалтай үялдуулах тогтоох нь элбэг байна.

Иймд Монложистикс Холдинг ХХК-ийн IPO зориулалтаар тооцоолсон тус бизнесийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийн дүгнэлтэд хяналтгүйн хувь оролцооны болон бусад хөнгөлөлт ороогүй болохыг анхаарна уу.

Хөнгөлөлтийн хувь хэмжээг IPO хийх үеийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлттэй үялдуулан Үнэт цаас гаргагч болон Андеррайтер хоорондоо зөвшилцөж шийдэх нь илүү тохиромжтой гэж Үнэлгээчид үзсэн болно.

3. Үнэлгээний дүгнэлт

Энэхүү үнэлгээ нь нэмэлт санхүүжилт орж ирсэний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно.

Монложистикс Холдинг ХХК нь өөрийн энгийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгож 11.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорин ажиллаж байна. Иймд олон нийтээс хөрөнгө татахаас өмнөх үеийн үнэлгээ (Pre money valuation) болон шинэ мөнгө орж ирсний дараах үеийн үнэлгээг (Post- money valuation) дараах байдлаар тооцохыг зөвлөж байна. Үүнд:

Олон нийтээс хөрөнгө татахаас өмнөх үнэлгээ = (Pre money valuation)	Олон нийтээс хөрөнгө татсаны дараах үнэлгээ - (Post money valuation)	Шинэ мөнгө буюу компанийн эздийн өмчийг нэмэгдүүлэх хөрөнгийн дүн (New money)
---------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------

Хүснэгт 34. Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээний үр дүн

Үзүүлэлтүүд	Дун, төгрөгөөр
Post-Money Valuation	81,472,025,102
New money	11,000,000,000
Pre-Money Valuation	71,472,025,102

Монложистикс Холдинг ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 81,472,025,102 (Наян нэгэн тэрбум дөрвөн зуун далан хоёр сая хорин таван мянга нэг зуун хоёр) төгрөг байхаар тооцоолов.

Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ



Зах зээлийн харьцуулалтын шинжилгээгээр тооцоолсон үнэлгээний үржүүлэгчийг ашиглан ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГҮҮДИЙГ ДООР ҮЗҮҮЛЭВ.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

Монложистикс Холдинг ХХК	Дүн, сая төгрөг
Эздийн өмч, Pre-Money	22,922.9
Эздийн өмч, Pos-Money	33,922.9
Цэвэр ашиг, 2022.12.31 (гүйцэтгэл)	8,374.5
Цэвэр ашиг, 2023.12.31 (төсөөлөл)	9,818.1

Хүснэгт 35. Зах зээлийн харьцуулсан үнэлгээ

Үзүүлэлтүүд	PB		PE		
	Ratio	Value	Ratio	Value at 2022.12.31	Value, forward at 2023.12.31
Өндөр орлоготой (АНУ)	4.0	137,048.5	13.2	110,543.4	129,598.7
Дундажаас дээш (Хятад, Малайз, Тайланд)	2.2	74,065.0	11.4	95,469.3	111,926.2
Дундажаас доош (Индонези)	1.7	58,347.4	11.5	96,306.8	112,908.0
Дотоод зах зээл	2.2	75,280.8	12.5	104,681.3	122,726.1

Үнэлгээний цэвэр ашгийн харьцаа (PE)-г ашиглан тооцоолсон үнэлгээ нь эздийн өмчийн харьцаа (PB) харьцааг ашиглан тооцоолсон үнэлгээнээс өндөр гарч байгаа нь Монложистикс Холдинг ХХК-ийн ашигт ажиллагаа бусад компаниудтай харьцуулахад илүү сайн байгааг илэрхийлнэ.

Монложистикс Холдинг ХХК-ийг МХБ дээрх компаниудтай харьцуулсан шинжилгээний PB харьцаагаар тус компанийн үнэ цэнэ 75,280.8 сая төгрөг, PE харьцаагаар 104,681.3 сая төгрөг байх баримжаа үр дүн гарч байна. Монложистикс Холдинг ХХК-ийн зах зээлийн үнэ цэнийг 81,472.0 сая төгрөг байхаар тооцоолсон нь зах зээлийн харьцуулалтын шинжилгээ үнэлгээний үр дүнтэй нийцтэй байна гэж Үнэлгээчид дүгнэв.

Мэдрэмжийн шинжилгээ

Үнэлгээний үр дүнгийн мэдрэмжийг шинжилгээг Монложистикс Холдинг ХХК-ийн үнэлгээний үр дүнд хамгийн өндөр нөлөө үзүүлэх боломжтой нүүрсний тээврийн борлуулалт болон хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувьд хийж гүйцэтгэв.

Нүүрсний тээврийн орлогын мэдрэмжийн шинжилгээ

Монложистикс Групп:

Нүүрсний тээврийн орлого	Үндсэн хувилбар			Мэдрэмж		
+/- өөрчлөлт	0.0%	15.0%	10.0%	0.0%	-10.0%	-15.0%
Үнэ цэнэ, тэрбум төгрөгөөр	110.2	116.8	114.6	110.2	105.7	103.5
Үнэ цэнийн өөрчлөлт, %	0.0%	6.0%	4.0%	0.0%	-4.0%	-6.1%

Каус Аустралис ХХК-ийн нүүрсний тээврийн борлуулалтын орлого +/- 15%-иар өөрчлөгдөхөд Монложистикс Группийн үнэ цэнийн өөрчлөлт харгалзан +/- 6.1% буюу 2.5 дахин бага хувиар өөрчлөгдөж байгаа нь группийн үнэ цэнэ нүүрсний тээврийн борлуулалтын орлогод харьцангуй бага мэдрэмжтэй байгааг илэрхийлнэ.

MANDAL CAPITAL
MARKETS SZ
LLC

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

Энэ нь Монложистикс Группийн хувьд төмөр замын нүүрсний тээврийн үйл ажиллагаа нь бизнесийн өсөлтийг авч ирэх үндсэн хөтөч (value drive) боловч энэхүү үйл ажиллагааны 2023 - 2027 оны төлөвлөсөн нийт цэвэр борлуулалтын орлого группийн нэгтгэсэн орлогын 18 орчим хувь, цэвэр ашгийн 35 орчим хувийг тус тус эзэлж байгаатай холбоотой.

Монложистикс Групп нь төмөр замын нүүрсний тээврийн үйл ажиллагааг Каус Аустралис ХХК дээр хэрэгжүүлж байгаа бөгөөд Монложистикс Холдинг ХХК нь Каус Аустралис ХХК-ийн 51%-ийг эзэмшиж байна. Иймд нүүрсний тээврийн орлогын өөрчлөлтөөс үүдэн Монложистикс Холдинг ХХК-ийн үнэ цэнийн өөрчлөгдөх байдал харьцангуй бага мэдрэмжтэй байна.

Монложистикс Холдинг ХХК:

Нүүрсний тээврийн орлого	Үндсэн хувилбар			Мэдрэмж		
+/- өөрчлөлт	0.0%	15.0%	10.0%	0.0%	-10.0%	-15.0%
Үнэ цэнэ, тэрбум төгрөгөөр	81.5	83.2	82.6	81.5	80.3	79.7
Үнэ цэнийн өөрчлөлт, %	0.0%	2.1%	1.4%	0.0%	-1.4%	-2.1%

Каус Аустралис ХХК-ийн цэвэр борлуулалт +/- 15%-иар өөрчлөгдөхөд Монложистикс Холдинг ХХК-ийн үнэ цэнэ харгалзан +/-2.1 орчим хувиар өөрчлөгдөж байгаа нь мэдрэмж харьцангуй бага болохыг илэрхийлж байна.

Хорогдуулах хувийн мэдрэмжийн шинжилгээ

Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн мэдрэмжийн шинжилгээг Монложистикс Группийн цэвэр мөнгөн үрсгалын нэгтгэсэн үзүүлэлтүүдэд үндэслэн хийж гүйцэтгэсэн түл Монложистикс Холдинг ХХК-ийн болон группийн хувьд адил байна.

Хорогдуулах хувийн шинжилгээ	Үндсэн хувилбар			Мэдрэмж		
+/- өөрчлөлт	0.0%	1.0%	0.5%	0.0%	-0.5%	-1.0%
Хорогдуулах хувь	24.5%	25.5%	25.0%	24.5%	24.0%	23.5%
Үнэ цэнэ, сая төгрөгөөр	81.5	76.5	78.7	80.9	83.3	85.8
Үнэ цэнийн өөрчлөлт, %	0.0%	-6.1%	-3.5%	-0.7%	2.2%	5.3%

Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөж 1.0%-иар өсөх, буурахад үнэлгээний үр дүн 76.5 – 85.8 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа нь үнэлгээний үндсэн хувилбартай ойролцоо мужид байна гэж үзэж болно.



МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Б. ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ 1: Монложистикс Групп компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбарууд

ХАВСРАЛТ 2: Тодорхойлолт ба үнэлгээний аргачлал

ХАВСРАЛТ 3: Үнэлгээчдийн сертификатын хуулбар



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



ХАВСРАЛТ 1: МОНЛОЖИСТИКС ГРУПП КОМПАНИУДЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР

СЭХ
ОН СНО ЭДЭЭ
БҮРТЭЭ
№ 03

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭГТЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
002216281

2026.12.24 001784927
Мон Логистикс Холдинг ХХК Хялгаргасант хөрөнгийн эзэн

Мон Логистикс Холдинг ХХК-ийн захирал
Дорно
Төрийн захирал

Хувиартай 7 95,041.22

Утас-факс: Хан-Уул, Төр захирлын хороо, дотоод хэлтэс, 404 хаяг, Улаанбаатар, Уул-2, 7-ноц

2023 оны 09 сар 14 өдөр

Хуулийн этгээдийн үзүүлэлт бэлтгүүлэх баримт баримт оруулсан хэмжээ өөрчлөлтөө бүртгэл

Д/д	Нэвтрэн ороогчдын нэр	Өмч	Ажлын хэргийн төрөл
1	Говьсүмбэр аймаг, Увс сум, Увс сумын захирал Говьсүмбэр аймаг, Увс сумын захирал	2014.12.28	Н.Дорно
2	Дорнод аймаг, Увс сум	2017.08.07	Н.Дорно
3	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
4	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
5	Дорнод аймаг, Увс сум, Увс сумын захирал	2023.09.14	Г.Дорно
6	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
7	Дорнод аймаг, Увс сум, Увс сумын захирал	2023.09.14	Г.Дорно
8	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
9	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
10	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
11	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
12	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭГТЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
00154355

2026.11.27 001528721
Мон Логистикс Холдинг ХХК Хялгаргасант хөрөнгийн эзэн

Мон Логистикс Холдинг ХХК-ийн захирал
Дорно
Төрийн захирал

Хувиартай 8 100,000.3

Утас-факс: Хан-Уул, Төр захирлын хороо, дотоод хэлтэс, 404 хаяг, Улаанбаатар, Уул-2, 7-ноц

2023 оны 09 сар 14 өдөр

Хуулийн этгээдийн үзүүлэлт бэлтгүүлэх баримт баримт оруулсан хэмжээ өөрчлөлтөө бүртгэл

Д/д	Нэвтрэн ороогчдын нэр	Өмч	Ажлын хэргийн төрөл
1	Говьсүмбэр аймаг, Увс сум, Увс сумын захирал Говьсүмбэр аймаг, Увс сумын захирал	2014.12.28	Н.Дорно
2	Дорнод аймаг, Увс сум	2017.08.07	Н.Дорно
3	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
4	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
5	Дорнод аймаг, Увс сум, Увс сумын захирал	2023.09.14	Г.Дорно
6	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
7	Дорнод аймаг, Увс сум, Увс сумын захирал	2023.09.14	Г.Дорно
8	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
9	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
10	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
11	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
12	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
13	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
14	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно
15	Увс сумын захирал, урьдчилсан гэрээний үндсэн дээр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр 2023.09.14 өдөр	2023.09.14	Г.Дорно

МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК
MONGOL LOGISTICS SC
LLC

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК
MONGOL LOGISTICS HOLDING CO., LTD.
2023 оны 09 сар 14 өдөр
АТА5169 4 601251
002101093

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ
 MONGOLIAN STOCK EXCHANGE
 ГЭРЭГ
 2023-06-14
 БҮРТГЭВ-03

СХ
 01
 БҮРТГЭВ
 № 01

МОНГОЛ УЛС
 ХӨРӨНГИЙН БИРХ
 БҮРТГЭВ
 00107143

2023.06.14
 01
 2023.09.21

2
 1,371,100.00

Урьдчилсан, багцан Дүнгийн Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт
 100% Хувь 00107143, Уулс, Ажлын 00107143

2023.06.14 өдөр 11:45:50

Хувийн өртөгдлийн үргэлж байгуулах Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт

№	Хөрөнгөтний үзүүлэлт	Бүртгэв	
		Өртөг	Ажлын үнэ
1	Урьдчилсан, багцан Дүнгийн Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт	1,371,100.00	2,000,000.00
2	Дүнгийн Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт	0.00	0.00

МОНГОЛ УЛС
 ХӨРӨНГИЙН БИРХ
 БҮРТГЭВ
 00107143

2023.06.14
 01
 2023.09.21

2
 1,371,100.00

Урьдчилсан, багцан Дүнгийн Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт
 100% Хувь 00107143, Уулс, Ажлын 00107143

Хувийн өртөгдлийн үргэлж байгуулах Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт

№	Хөрөнгөтний үзүүлэлт	Бүртгэв	
		Өртөг	Ажлын үнэ
1	Урьдчилсан, багцан Дүнгийн Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт	1,371,100.00	2,000,000.00
2	Дүнгийн Төлөөлөгчид ХХК-ийн Хөрөнгөтний Хүснэгт	0.00	0.00

МАНДАЛ КАПИТАЛ
 MARKETS SC LLC
 БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
 ХХК
 ATASUN 10810
 93

202

СЗХ
№ 01
БҮРТГЭВ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭГТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
00210205

2021.02.05
Хуулийн өөрчлөлт

901824676
Хуулийн өөрчлөлт

482396
Хуулийн өөрчлөлт

Мөн хэрэгжих журмыг
Хуулийн өөрчлөлт

Хууль
Хуулийн өөрчлөлт

Шалгаруу
01
2021.02.05
Хуулийн өөрчлөлт

4810
Хуулийн өөрчлөлт
Хуулийн өөрчлөлт

Хууль
1
1,000.00
Хуулийн өөрчлөлт

Хуулийн өөрчлөлт
Хуулийн өөрчлөлт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
ХУУЛИЙН ЭГТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хуулийн өөрчлөлт үзүүлж байгаагүй бөгөөд бүртгэв эргэлт өөрчлөлтөд оруулахаар өргөдөг

Д/А	Намт өөрчлөлтгүй агуулга	Бүртгэв	
		Огноо	Хуулийн өөрчлөлт
1	Хуулийн өөрчлөлт өргөдөггүй бөгөөд бүртгэв эргэлт өөрчлөлтөд оруулахаар өргөдөг	2021.02.05	Хуулийн өөрчлөлт
2	Хуулийн өөрчлөлт өргөдөггүй бөгөөд бүртгэв эргэлт өөрчлөлтөд оруулахаар өргөдөг	2021.02.05	Хуулийн өөрчлөлт
		2021.02.05	Хуулийн өөрчлөлт
		2021.02.05	Хуулийн өөрчлөлт

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭГТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
00210205

2022.11.28
Хуулийн өөрчлөлт

801146197
Хуулийн өөрчлөлт

6927447
Хуулийн өөрчлөлт

Мөн хэрэгжих журмыг
Хуулийн өөрчлөлт

Хууль
Хуулийн өөрчлөлт

Шалгаруу
01
2022.11.11
Хуулийн өөрчлөлт

4810
Хуулийн өөрчлөлт
Хуулийн өөрчлөлт

Хууль
1
1,000.00
Хуулийн өөрчлөлт

Хуулийн өөрчлөлт
Хуулийн өөрчлөлт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
ХУУЛИЙН ЭГТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хуулийн өөрчлөлт үзүүлж байгаагүй бөгөөд бүртгэв эргэлт өөрчлөлтөд оруулахаар өргөдөг

Д/А	Намт өөрчлөлтгүй агуулга	Бүртгэв	
		Огноо	Хуулийн өөрчлөлт
1	Хуулийн өөрчлөлт өргөдөггүй бөгөөд бүртгэв эргэлт өөрчлөлтөд оруулахаар өргөдөг	2022.11.28	Хуулийн өөрчлөлт

MANDAL CAPITAL
MARKET SC
LTD
ШТН0162 901146197 4213487

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ
ХХК
Logistics
HOLDING
ATA5299 6381251 54
902102093



ВЫДІСКА
из Единого государственного реестра юридических лиц
№ К0109051-02-161880094

Настоящая выписка сформирована в соответствии с ИИС
ОБЩЕСТВО С ОГРАНИЧЕННОЙ ОТВЕТСТВЕННОСТЬЮ "МОНЛОЖИСТИКС ТРАНС СЕРВИС"

ОСНОВНЫЕ ДАННЫЕ
заключенные в Единый государственный реестр юридических лиц по состоянию на
« 07 » октября 2022 г.

126	Дата документа	18.08.2022
127	Наименование документа	ПРОТОКОЛ
128	Номер документа	2
129	Дата документа	18.08.2022

Документ сформирован в соответствии с требованиями информационного сайта ФНС России и сайта Минэкономразвития России: <http://egr.nalog.ru>



№ п/п	Наименование показателя	Уточненные показатели
1	2	3
Наименование		
1	Полное наименование на русском языке	ОБЩЕСТВО С ОГРАНИЧЕННОЙ ОТВЕТСТВЕННОСТЬЮ "МОНЛОЖИСТИКС ТРАНС СЕРВИС"
2	УИН и дата внесения в ЕГРЮЛ выписки, содержащей уточненные сведения	0203000004040 24.06.2021
3	Сокращенное наименование на русском языке	ООО "МОНЛОЖИСТИКС ТРАНС СЕРВИС"
4	УИН и дата внесения в ЕГРЮЛ выписки, содержащей уточненные сведения	0213000014141 14.06.2021
Место нахождения и адрес юридического лица		
5	Место нахождения юридического лица	Иркутская область, г.о. ИРКУТСК, г. ИРКУТСК
6	УИН и дата внесения в ЕГРЮЛ выписки, содержащей уточненные сведения	0203000014141 24.06.2021
7	Адрес юридического лица	664074, Иркутская область, г.о. ИРКУТСК, г. ИРКУТСК, УЛ ЛЕВАНТОВА, д. 78, ОФИС 406
8	УИН и дата внесения в ЕГРЮЛ выписки, содержащей уточненные сведения	0213000014141 24.06.2021



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



225

МОНЛОЖИСТИКС ГРУПП КОМПАНИУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАР

СЭД 8/20P
БҮРЭГЭВ
№ 1

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



ГААЛИЙН ЗУУЧЛАГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ГЭРЧИЛГЭЭ


Дугаар 14034

Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 78 дугаар тушаалыг үндэслэн "Монложистикс корлд байл" ХХК-д /2685940/ "ГААЛИЙН ЗУУЧЛАГЧ"-ийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгов.

ДАРГА  О.ГАНБАТ

УЗАНБААТАР ХОТ

Гэрчилгээнд оруулсан төлөв, өөрчлөлтийн бүртгэл:

№	Төгсөлт, өөрчлөлтийн агуулга, сүүлцэл	Бүртгэл	
		огноо	Гэрчилгээний үнэмлэх
1	Сангийн Сайдын 2017 оны 297 дугаар тушаалыг үндэслэн "Монложистикс корлд байл" ХХК-д 3 жилийн хугацаатай зөвшөөрөл олгогдсон.		

МОНГОЛ УЛС
ЗАМ, ТЭВЭРИЙН ХӨРӨНГИЙН ЯАМ
MINISTRY OF ROAD AND TRANSPORT
DEVELOPMENT OF MONGOLIA

ТЭВЭР ЗАМЫН ТЭВЭРИЙН АЖУУЛГҮЙ БАЙДАЛТАЙ
ХӨРӨНГӨТӨЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ГЭРЧЭЭГЭЭ
Special Permit for Railway Safety Facility

Код Т.Б. _____ № 201422203

Байгууллагын нэр: "Монложистикс транзит" ХХК РД: 6446549
Name of organization:

Байгууллагын хаяг: Улаанбаатар, Санхүүжилт, 9-р хороо, Төвдүн нуурын
Address of organization: гудамж 24, Рамын байрныг 10 дугаар, 1032 үеет

Үйл ажиллагааны нэр, төрөл: Төвдүн замын тээвэр зориулалт
Type of activity:

Төвдүн замын тээврийн тухай хууль, төвдүн замын тээврийн нийтлэг бэлд дүрэм, үндэстэй холбогдох стандартын нийцэл, шаардлагы хангасан тул энэ үйл ажиллагааг эрхлэхийг зөвшөөрөв. Бусад шалгууртанд нийцсэн.

THIS certificate is issued for the purpose of maintaining railway safety activity on condition of compliance to requirements specified in the Law on Railway Transport, set of common rules for railway transport and related national standards of Mongolia. This certificate is not transferable.

Огцролын өдөр, сар, агаар: 2022.02.01
Date of issue

Дуусмаар болох өдөр, сар, агаар: 2025.01.31
Date of expiration

СЭД 8/20P
БҮРЭГЭВ
№ 1

МОНГОЛ УЛС
ЗАМ, ТЭВЭРИЙН ХӨРӨНГИЙН ЯАМ
MINISTRY OF ROAD AND TRANSPORT
DEVELOPMENT OF MONGOLIA

ТЭВЭР ЗАМЫН ТЭВЭРИЙН АЖУУЛГҮЙ БАЙДАЛТАЙ
ХӨРӨНГӨТӨЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ГЭРЧЭЭГЭЭ
Special Permit for Railway Safety Facility

Код Т.Б. _____ № 201422115

Байгууллагын нэр: "Монложистикс корлд байл" ХХК РД: 2685945
Name of organization:

Байгууллагын хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 11-р хороо, Дундговьны 14, Зайсан
Address of organization: суурь тас, 404 тоот

Үйл ажиллагааны нэр, төрөл: Төвдүн замын тээвэр зориулалт
Type of activity:

Төвдүн замын тээврийн тухай хууль, төвдүн замын тээврийн нийтлэг бэлд дүрэм, үндэстэй холбогдох стандартын нийцэл, шаардлагы хангасан тул энэ үйл ажиллагааг эрхлэхийг зөвшөөрөв. Бусад шалгууртанд нийцсэн.

THIS certificate is issued for the purpose of maintaining railway safety activity on condition of compliance to requirements specified in the Law on Railway Transport, set of common rules for railway transport and related national standards of Mongolia. This certificate is not transferable.

Огцролын өдөр, сар, агаар: 2022.02.01
Date of issue

Дуусмаар болох өдөр, сар, агаар: 2025.01.31
Date of expiration

ТТХЭНГ ҮТГ-ЫН ХАХИРАГ
АЛСҮНЭГЭМ ХХК

МАНЖИСТ ИХ
МАНЖИСТ ХХК
MANDAL
MANDAL
LLC
ШТХЭНГ ҮТГ-ЫН ХАХИРАГ

208



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН
ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023.02.01

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар : 2685949
Нэр : МОНЛОЖИСТИКС ВОРЛД ВАЙД



Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

Авсан өгсөө : 2019-12-09
Дууссан өгсөө : 2023-07-05
Хүчинтэй зөвхөн : Хүчинтэй
Тусгай зөвшөөрлийн нэр : ГААЛИЙН ЗУУЧЛАГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудад шаардлагатай мэдээллийг төгсөн авч байсныг шалгуур болгон шалгах байгаа бөгөөд QR кодыг уншуулж үед тухайн мэдээлүүдийг хангасан эсэхээ хялбархан зэрчилсэний төлөө өөрчлөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу.

21:02, 9:22 AM

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ГЭРЭГЭЭ ЭСТИМЭГТ, ЦАХИМ СИСТЕМ - 2023

Төлөвлөгөө

Дугаар 7521443194355

Аж түүш үзэгийн нэр : МОНЛОЖИСТИКС ВОРЛД ВАЙД
Урсан бүртгэлийн дугаар : 2685949
Харуулагч хэлбэр : ХХК
Хэл, байршил :
Учрагын өсөл нэр : АНГАЙН СЭГЭРЭН

Тусгай материал, гэрчилгээ

Бүртгэлийн дугаар	Эрхийн гэрэл	Өгсөөний өгсөө	Дууссан өгсөө
19/042/11	Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ	2019-02-19	2022-01-31
22/А/22/115	Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ	2022-02-07	2025-02-07

QR код



7521443194355

Үүсгэлт үеэсхэн 2023 оны 02 сарын 06, 09 цаг 20 минут

Хүчинтэй хугацаа 2023 оны 03 сарын 03, 09 цаг 20 минут



27

СЭХ

ОН
БҮРТГЭВ

ХАВСРАЛТ 2: ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Тодорхойлолтууд

Үнэлгээний зарим нэр томъёог өөр өөр утгаар ойлгож болох талтай байдаг. Ийм нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх зорилгоор үнэлгээнд хэрэглэсэн зарим нэр томъёог Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), RICS мэргэжлийн олон улсын стандарт ("Улаан ном") болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсны дагуу дараах байдлаар үзүүлэв.

Идэвхитэй зах зээл [СТОУС 13] – Үнийн мэдээллээр тогтмол хангахад хүрэлцэхүйц давтамж, дүнгээр хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгддэг зах зээл.

Үнэ цэн [ҮОУС 2022] – ҮОУС 104 Үнэ Цэнийн Сууриуд - д заасан үнэ цэнийн сууриудын аль нэгэнд нийцүүлэн тухайн тооцоолсон дүнгийн талаар үнэлгээний гаргасан шүүн тунгаалтын илэрхийлэл.

Үнэ цэнийн суурь [ҮОУС 2022] – Тухайн тайлагнах үнэ цэнийг үндэслэн гаргах суурь урьдчилсан нөхцөлүүд.

Өртгийн хандлага [ҮОУС 2022] – Зохисгүй хугацаа, тохиромжтой бус байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлс нь хамааралтай биш л бол худалдан авагч нь худалдан авсан эсвэл барьж байгуулсан эсэхээс үл хамааран ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг олж бэлтгэх өртгөөс илүү дүнг тухайн хөрөнгийн хувьд төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчмыг баримтлан өртгийн хандлага нь үнэ цэнийн үзүүлэлтийг тооцон гаргадаг.

Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ [СТОУС 13] – Боломжит ирээдүйн мөнгөн гүйлгээг магадлалаар жинлэсэн дундаж (өөрөөр хэлбэл тархалтын дундаж дүн).

Бодит үнэ цэн [СТОУС 13] – Хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ юм.

Хамгийн сайн ашиглалт [СТОУС 13] – Хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө буюу бүлэг хөрөнгө, өр төлбөр (бизнесийн хувьд)-ийн үнэ цэнийг дээд түвшинд байлгах зах зээлд оролцогчдын санхүүгийн бус хөрөнгө ашиглалт.

Орлогын хандлага [СТОУС 13] – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнд суурилна.

Орц-мэдээлэл [СТОУС 13] – Энэ нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтооходоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг хэлэх бөгөөд үүнд дараах эрсдэлийн таамаглал багтана:

- (a) Бодит үнэ цэнийг хэмжихэд хэрэглэсэн үнэлгээний тодорхой арга аргачлалаас шалтгаалан үүссэн эрсдэл (тухайлбал, үнэ тогтоох загвар); ба
- (b) Үнэлгээний арга, аргачлалын дагуу ашиглагдаж буй орц мэдээллээс шалтгаалан үүссэн эрсдэл.

Орц мэдээлэл нь бэлэн олдоцтой буюу ажиглагдах эсвэл үл ажиглагдах байж болно.

Хөрөнгө оруулалтын зориулалттай өмч [Улаан ном 2020] – Доорх (a), (б)-оос бусад зорилгоор капиталын үнэ цэнийг өсгөх, эсвэл түрээсийн орлого олох, эсвэл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй өмч (газар, барилга, эсвэл барилгын хэсэг, эсвэл аль нь

- (a) бараа үйлчилгээний үйлдвэрлэлт, нийлүүлэлт болон захиргааны зорилгоор ашиглаж байгаа эсвэл
- (b) бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулах зориулалттай.

Нэгдүгээр түвшний орц-мэдээлэл [СТОУС 13] – Аж ахуйн нэгжийн хэмжилт хийж буй өдрөөр ашиглах боломжтой, ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг (тохируулаагүй) үнэ.

Хоёрдугаар түвшний орц-мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөртэй холбоотой шууд ба шууд бусаар гаргаж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад орц мэдээлэл.

Гуравдугаар түвшний орц-мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө ба өр төлбөрийн талаарх үл ажиглагдах орц мэдээлэл.

Зах зээлийн хандлага [ҮОУС 2022] – Тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиг болох (өөрөөр хэлбэл төсөөтэй) хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтээр хангадаг.



СЭХ
2023.06.14
ОН
БҮРТГЭВ
№ 31

Зах зээлээр баталгаажсан мэдээлэл [СТОУС 13] – Корреляци болон бусад аргын тусламжтайгаар зах зээлд бэлэн байгаа мэдээллээр баталгаажсан буюу түүнээс гаргаж авсан орц мэдээлэл.

Зах зээлийн түрээсийн төлбөр [YOUC 2022] – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа түрээслүүлэгч ба түрээслэгчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр зохих түрээсийн нөхцөлийн дагуу үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог түрээслэвэл зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Зах зээлийн үнэ цэн [YOUC 2022] – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө буюу өр төлбөрийг арилжвал зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Бэлэн олдох орц мэдээлэл [СТОУС 13] – Тодорхой үйл явдал, ажил гүйлгээний талаар олон нийтэд нээлттэй байгаа мэдээлэл гэх мэт зах зээлийн тоон мэдээг ашиглан боловсруулсан орц мэдээллийг хэлэх бөгөөд үүнд хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохын тулд зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг тусгана.

Үндсэн зах зээл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийг хамарсан хамгийн өндөр дүнтэй болон хамгийн олон арилжаа хийгдсэн зах зээл юм.

Үл хөдлөх өмчийн хувь оролцоо [YOUC 2022] – Газар ба барилгын өмчлөл, хяналт, ашиглалт буюу эзэмшлийн эрх.

Тусгай төсөөллүүд [Улаан ном 2022] – Үнэлгээний өдрөөр бий болсон нөхцөл байдлаас ялгаатай нөхцөл байдлыг авч үзэж буй төсөөлөл эсвэл үнэлгээний өдөр зах зээлийн жирийн оролцогч хийхгүй байх үйлдэл.

Тусгай үнэ цэн [Улаан ном 2022] – Хөрөнгийн хувийн шинж чанарыг тусгаж байдаг, зөвхөн тусгай худалдан авагчдад бий болох үнэ цэн.

Өргөжилтийн хэмнэлтийн үнэ цэн [YOUC 2022] – Хоёр буюу хэд хэдэн хөрөнгө эсвэл хувь оролцоог нэгтгэн нийлүүлсэн бөгөөд үг нэгдсэн үнэ цэн нь тэдгээрийн тус тусын үнэ цэнүүдийн нийлбэрээс илүү байх зөрүү р дүн.

Худалдах зориулалт бүхий өмч [Улаан ном 2022] – Тухайн бизнесийн арилжаалагдах боломжийг өмчийн үнэ цэн нь илэрхийлж байдаг тусгай бизнест зориулагдсан үл хөдлөх өмчийн аливаа төрөл.

Эрсдэлийн шагнал [СТОУС 13]– Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн гүйлгээний тодорхой байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг хүлээсний эцэст хүртэх ашиг. Үүнийг мөн "эрсдэлийн залруулга" хэмээн нэрэлдэг.

Тооцооны нэгж [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд уг хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэх буюу задлан жижигрүүлэх СТОУС-ын хэмжүүр.

Үл ажиглагдах орц мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтооходоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалын талаарх боломжит хамгийн сайн мэдээллийг ашиглан боловсруулсан буюу зах зээлд бэлэн байдаггүй орц мэдээлэл.

Үнэлгээний өдөр [Улаан ном 2022]– Үнэлгээний үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр.

Үнэлгээний тайлангийн өдөр [Улаан ном 2022] – Үнэлгээний тайланд гарын үсэг зурсан өдөр.

Бодит болон зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт

СТОУС 13 Бодит Үнэ Цэнийн Хэмжилт-д Бодит үнэ цэн гэдэгт хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь YOUC-д Бодит үнэ цэн-ийг тодорхойлсноос ялгаатай бөгөөд тэрхүү тодорхойлолтыг санхүүгийн тайлагналаас бусад зорилгоор нийтлэг хэрэглэдэг.

СТОУС-д тодорхойлсон бодит үнэ цэн нь YOUC-д тодорхойлсон зах зээлийн үнэ цэн-ийн ойлголттой ерөнхийдөө нийцдэг. Иймд тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ихэнх

БИЗНЕСИЙН ҮНЭЛТЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



СЗХ

практик ажилд УОУС-ийн зах зээлийн үнэ цэн нь СТОУС 13-д тодорхойлсон бодит үнэ цэн-ийн шаардлагыг хангана гэж үздэг.

ОН-ийн СЭР-ийн өндөр
БҮРТГЭВ

Зах зээлийн үнэ цэн гэдэгт хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан, арилжаанд бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд зохих маркетинг хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө болон өр төлбөрийг солилцож болох, тухайн үнэлгээний өдрөөр тооцоолсон дүнг ойлгоно.

Зах зээлийн үнэ цэн нь хөрөнгийн хамгийн сайн ашиглалтыг тусгасан байна. Хамгийн сайн ашиглалт гэдэг нь тухайн хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ. Хөрөнгийн одоогийн ашиглалт эсвэл өөр хувилбарт ашиглалтын аль нь ч хамгийн сайн ашиглалт байж болно. Энэ нь зах зээлийн оролцогч хөрөнгийн үнийг тооцоолохдоо өөртөө төсөөлж байгаа тэр ашиглалтаар тодорхойлогдоно.

Үнэлгээний арга зүй

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын тодорхойлолт, тайлбарыг доор үзүүлэв. Эдгээр хандлагууд нь үнийн тэнцвэр, үр ашгийн хүлээлт, орлуулалт зэрэг эдийн засгийн зарчмуудад тулгуурладаг. Үнэлгээний үндсэн хандлагуудад:

- (а) Зах зээлийн хандлага,
- (б) Орлогын хандлага,
- (в) Өртгийн хандлага.

Үнэлгээний эдгээр үндсэн хандлага бүр нь хэрэглээний өөр өөр нарийвчилсан аргуудтай байдаг.

УОУС 2020-ын 105 Үнэлгээний хандлага болон аргууд бүлэгт зааснаар хөрөнгийн хувьд үнэлгээний хандлага болон аргуудыг сонгох зорилго нь тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг олох явдал байдаг. Боломжит нөхцөл байдал бүрд тохирох нэг арга гэж байдаггүй. Сонголтын процесст наад зах нь дараах хүчин зүйлсийг харгалзан авч үзвэл зохино:

- (а) үнэлгээний гэрээт ажлын нөхцөлүүд болон зорилгоор тодорхойлогдох үнэ цэнийн тохиромжтой суурь (сууриуд) ба үнэ цэнийн урьдчилсан нөхцөл (нөхцөлүүд),
- (б) үнэлгээний боломжит хандлагууд ба аргуудын тус тусын давуу ба сул талууд,
- (в) хөрөнгийн шинж чанарыг харгалзан үзсэнээр тогтоосон арга тус бүрийн тохиромжтой байдал ба хамаарах зах зээлд оролцогчдын ашиглах хандлагууд буюу аргууд, ба
- (г) тухайн аргыг (аргуудыг) хэрэглэхэд шаардлагатай найдвартай мэдээллийн бэлэн, олдоцтой байдал.

Хөрөнгийн үнэлгээний хувьд, ялангуяа үнэлгээчин нь тухайн үнэлгээний гэрээт ажлын бодит байдал ба нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр нэг аргыг үнэн зөв бөгөөд найдвартай гэдэгт өндөр түвшний итгэлтэй байгаа тохиолдолд нэгээс олон арга ашиглахыг үнэлгээчнээс шаарддаггүй. Гэвч ялангуяа нэг аргын хувьд бодит баримтын буюу ажиглалтын хангалттай орцууд байхгүй тохиолдолд үнэлгээчин нь найдвартай дүгнэлт гаргахын тулд олон хандлагууд ба аргуудын хэрэглээг, мөн түүнчлэн үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахдаа харгалзан үзвэл зохистой ба ашиглаж болох нэгээс олон хандлага буюу аргыг авч үзвэл зохино. Нэгээс олон хандлага ба аргыг эсвэл нэг хандлагын хүрээн дэх олон аргуудыг ашигласан тохиолдолд тэдгээр олон хандлагууд ба/буюу аргуудад үндэслэсэн үнэ цэнийн дүгнэлт нь үл үндэслэлтэй байвал зохистой бөгөөд үнэлгээчин нь тэдгээр өөр өөр үнэ цэнүүдийг дундажлахгүйгээр, харин шинжилж, тохируулах замаар нэг дүгнэлтэд хүргэсэн үйл явцаа үнэлгээний тайланд тусган илэрхийлбэл зохино.

Өөр өөр хандлагууд ба/буюу аргууд нь үнэ цэнийн ихээхэн ялгаатай үзүүлэлтүүдийг гаргах тохиолдолд үнэ цэнийн хоёр буюу хэд хэдэн ялгаатай үзүүлэлтүүдийг хялбархнаар дундажлан жинлэх нь ерөнхийдөө тохиромжтой биш тул үнэлгээчин нь яагаад уг үнэ цэнийн үзүүлэлтүүд өөр өөр байгааг ойлгохын тулд горимуудыг гүйцэтгэвэл зохино. Ийм тохиолдолд тэдгээр хандлагууд/ аргуудын нэг нь үнэ цэнийн илүү сайн буюу найдвартай үзүүлэлтээр хангах эсэхийг тодорхойлохын тулд үнэлгээчин нь дээр дурдсан удирдамжийг дахин харгалзан үзвэл зохино.

Үнэлгээчин нь гурван хандлагуудын хувьд холбогдох зах зээлийн ажиглалтын мэдээллийн хэрэглээг хамгийн их байлгавал зохино. Үнэлгээнд ашигласан орцууд болон төсөөллүүдийн эх сурвалжаас үл хамааран үнэлгээчин нь тэдгээр орцууд ба төсөөллүүдийг, түүнчлэн үнэлгээний зорилгод тэдгээрийн тохиромжтой байдлыг үнэлэхийн тулд зохих шинжилгээг гүйцэтгэх ёстой.



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ: МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК



Зах зээлийн хандлага

Зах зээлийн хандлага нь тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтийг тодорхойлдог.

Дараах нөхцөл байдалд зах зээлийн хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино:

- (а) Тухайн үнэ цэнийн суурийн дагуу харгалзан үзэхэд тохиромжтой тийм ажил гүйлгээгээр уг үнэлж буй хөрөнгийг саяхан борлуулсан байх,
- (б) Үнэлж буй хөрөнгийг эсвэл түүнтэй ихээхэн ижил төсөөтэй хөрөнгийг нийтэд идэвхтэй арилжаалдаг байх,
- (в) Ихээхэн ижил төстэй хөрөнгийн хувьд байнга эсвэл сүүлийн үед гарсан ажиглаж болох ажил гүйлгээнүүд байх.

Зах зээлийн хандлагыг ашиглах эсвэл жигнэхдээ илүү ач холбогдол өгөх хэрэгтэй тохиолдлыг дээр дурдсан. Зах зээлийн хандлагыг ашиглах, жигнэхдээ илүү ач холбогдол өгч болох нэмэлт тохиолдлуудыг доор дурдав. Доор дурдсан тохиолдолд зах зээлийн хандлагыг ашиглаж байгаа тохиолдолд үнэлгээчин нь зах зээлийн хандлагыг ашиглан тодорхойлсон үнэ цэнийг бататгах зорилгоор өөр хандлагыг ашиглан үнэлэх, мөн жигнэж болох эсэхийг бодолцох хэрэгтэй. Үүнд:

- (а) Зах зээл дэх хэлбэлзэл болон идэвхийн түвшнийг харгалзан үнэлгээний хөрөнгө эсвэл ижил төстэй хөрөнгө нь ойрын хугацаанд арилжаанд ороогүй бол
- (б) Үнэлгээний хөрөнгө эсвэл ижил төстэй хөрөнгө нь олон нийтэд нээлттэй борлогддог, гэхдээ идэвхитэй биш бол
- (в) Зах зээлийн мэдээллийн олдоцтой, гэвч харьцуулж буй хөрөнгө нь үнэлгээний хөрөнгөөс мэдэгдэхүйц ялгаатай, их хэмжээгээр тохируулга хийх шаардлагатай бол
- (г) Ойрын хугацааны арилжааны мэдээлэл нь найдвартай биш бол
- (д) Хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлох чухал бүрэлдэхүүн хэсэг нь түүний нөхөн сэргээх өртөг эсвэл орлого бүрдүүлэх чадвар бус зах зээл дээр хүрч болох үнэ бол

Жиших ажил гүйлгээний арга

Зэрэгцүүлэх ажил гүйлгээний арга гэж бас нэрлэгдэх жиших ажил гүйлгээний арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй хөрөнгөтэй холбоотойгоор гарсан ажил гүйлгээнүүдийн талаархи мэдээллийг ашигладаг.

Нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга

Нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй, нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн талаархи мэдээллийг ашигладаг.

Орлогын хандлага

Орлогын хандлага гэдэгт тухайн хөрөнгийн өмчлөлөөс олохоор тооцоолсон эсвэл олсон мөнгөн урсгалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог ерөнхий зарчимтай олон аргуудыг багтаан үзэж болно.

Дараах нөхцлүүд биелж байвал орлогын хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино.

- (а) Хөрөнгийн орлого олох чадвар нь оролцогчийн талаас авч үзэхэд хөрөнгийн үнэ цэнд нөлөөлөх маш чухал элемент байх
- (б) Үнэлж буй хөрөнгийн хувьд түүний ирээдүйн орлогын дүн ба хугацааны талаар үндэслэлтэй прогнозыг хийх боломжтой, харин холбогдох зах зээлийн жиших хөрөнгө цөөхөн байх


Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга

Энэ аргын дагуу, тухайн прогнозчилсон мөнгөн гүйлгээг үнэлгээний өдөр рүү буцаан хорогдуулах бөгөөд үр дүн нь уг хөрөнгийн өнөөгийн үнэ цэн болно.

Хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг тогтооход дараах элементүүдийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

- (а) Түрээсийн ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолох
- (б) Тухайн мөнгөн гүйлгээтэй хамааралтай үүсэх тодорхойгүй байдлыг илэрхийлэх мөнгөн гүйлгээний дүн болон цаг хугацаанд гарч болзошгүй өөрчлөлтийн талаарх дүгнэлт
- (в) Хөрөнгө эзэмшигч талд цаг хугацааны хувьд тодорхойгүй байдал үүсдэггүй бөгөөд гэрээ зөрчигдөх эрсдэл тулгарэхгүй бол үргэлжлэх хугацаа ба дуусгавар өдөр нь мөнгөн зарлагын гүйлгээний хугацаанд





эрсдэлгүй мөнгөн хөрөнгийн хувь хэмжээ (өөрөөр хэлбэл эрсдэлгүй хүүний түвшин)-ээр илэрхийлэгдсэн мөнгөний цаг хугацааны үнэ цэн
(Г) Мөнгөн гүйлгээтэй хамааралтай үүсэх тодорхойгүй байдлыг давж гарах үнэ (өөрөөр хэлбэл-эрсдлийн шагнал)
(Д) Тухайн нөхцөл байдалд зах зээлд оролцогчдын анхаарч үзэх бусад хүчин зүйлс зэрэг орно.

Орлогын капиталжуулалтын арга

Урт хугацаанд ашиглах буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай хөрөнгийн зарим нөхцөл байдалд хорогдуулсан мөнгөн гүйлгээ нь төсөвлөсөн тодорхой хугацааны эцэс дэх уг хөрөнгийн үнэ цэнийг илэрхийлэх терминал үнэ цэнийг багтаасан байж болно. Зарим нөхцөл байдалд төсөвлөсөн тодорхой хугацаагүйгээр зөвхөн терминал үнэ цэнийг ашигласнаар хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж болдог бөгөөд үүнийг орлогын капиталжуулалтын арга гэдэг.

Өртгийн хандлага

Энэ хандлага нь худалдан авагч үнэлэгдэж буй хөрөнгөд төлөх үнэ нь (цаг хугацаа, тохиромжгүй байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлийг эс тооцвол) тэнцүү чанартай хөрөнгийг худалдан авах эсвэл барьж байгуулах зардлаас илүүгүй байна гэсэн зарчимд үндэслэнэ.

Дараах нөхцөл байдлуудад өртгийн хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино.

- (а) Оролцогчид нь зохицуулалтын буюу хуулийн саад хязгаарлалтгүйгээр үнэлж буй хөрөнгөтэй бараг ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг дахин бий болгох боломжтой байх бөгөөд үнэлж буй хөрөнгийг нэн даруй ашиглах боломжит байдлын төлөө мэдэгдэхүйц урамшуулал төлөхгүйгээр тухайн хөрөнгийг маш хурдан дахин бий болгох боломжтой байх
- (б) Хөрөнгө нь орлогыг шууд бий болгодоггүй бөгөөд тухайн хөрөнгийн өвөрмөц онцлог нь орлогын хандлага эсвэл зах зээлийн хандлагыг ашиглах ямар ч боломжгүй болгодог байх
- (в) Хэрэглэж буй үнэ цэнийн суурь нь орлуулалтын үнэ цэн гэх мэт орлуулалтын өртөгт үндсэндээ суурилсан байх



СЭХ
ОН
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ 3: ҮНЭЛГЭЭЧИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
ОСТИМОТ
2023-06-14
БҮРТГЭВ-03

САНГИЙН ЯАМ Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар заагаагт

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 051100154

Иргэний ургийн овог: _____
 Иргэний овог нэр: _____
 Иргэний үндэстэний дугаар: _____
 Иргэний бүртгэлийн дугаар: _____
 Үнэлгээний гэрчилгээний дугаар: _____
 Иргэний хаяг: _____
 Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: _____

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан адрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Ажигүйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3 дань хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг худалд, залуулах бусад төлөвлөгөөнд байрлуулах, багасгах, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД  / **УЛААНБААТАР** /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ
 Сангийн сайдын 2015 оны 344 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
 2015 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгаа.
 САНГИЙН САЙД  / **Б.БОЛОР** /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ
 Сангийн сайдын 2018 оны 284 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
 2018 оны 12-р сарын 18-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгаа.
 САНГИЙН САЙД  / **Ч.ХҮРЭЛБААТАР** /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ
 Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
 20... оны ...-р сарын ...-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгаа.
 САНГИЙН САЙД / /

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК

 MON LOGISTICS HOLDING
 АТАСНУ 4 6761251
 902-041093 64

СЭХ
с.с. сэр сагш
БҮРТГЭВ
№ 01

САНГИЙН ЯАМ

Саяны байдал 2010 оны 10 сунд
тувшмын 3 дугаар хэсэгтэй

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

Иргэний ургэйн овог: Халуун
Иргэний овог, нэр: Дорнод улсын Галханзад
Иргэний уномлохний дугаар:
Иргэний бүртгэлийн дугаар: 0077112572
Үндэслэлийн гэрчилгээний дугаар:
Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо, хөвдөр буудал А-111 зөв

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 1 дугаар сарын 14-ний өдрийн 7 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгаан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Ал ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3 дэхь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийн хуульд заагч бусад тохиолдолд буудал, эзлэл, байрлал, барьцаагаар зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД

Х. ХҮРЭЛБААТАР
ХААНБААТАР ХТД

Х. ХҮРЭЛБААТАР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
20... оны 12... сарын 17... ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгал.

САНГИЙН САЙД

Х. ХҮРЭЛБААТАР

Х. ХҮРЭЛБААТАР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
20... оны ... сарын ... ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгал.

САНГИЙН САЙД

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг
20... оны ... сарын ... ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгал.

САНГИЙН САЙД

МАНДАЛ КАПИТАЛ
MARKETS LLC
ШТМ0162 9021070474 9213427

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК
ATA5299 4 181251

2023-06-14

БҮТЭГ-03

СЭХ
ОН-сар-өдөр
БҮРТГЭЛ
№ 01

САНГИЙН ЯАМ

Саяны өдөр 2010 оны 19 дугаар
тушаалын 3 дугаар хэсэгт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 121200001

Сектор

Иргэний ургийн овог: Гүжээ овогийн Хамгун

Иргэний овог, нэр: ЧР 79091761

Иргэний үнэмлэхний дугаар: УБ Чингэлтэй дүүрэг 4-р хороо Баян тосгон 17-61 тоот

Иргэний бүртгэлийн дугаар: Саяны өдөр 2012/12/07-ны өдөр 255 тоот тушаал

Үнэмлэхний гэрэлзэлийн дугаар: УБ Чингэлтэй дүүрэг 4-р хороо Баян тосгон 17-61 тоот

Иргэний хаяг: Саяны өдөр 2012/12/07-ны өдөр 255 тоот тушаал

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Саяны өдөр 2012/12/07-ны өдөр 255 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бүтээгчид захирах, барьцаалах зэргээр нөлөөгүй үл болно.

САНГИЙН САЙД

Улаанбаатар

Ч.УЛААН

УЛААНБААТАР ХОТ



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022.05.09

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар: **чр*****61**
Нэр: **ХАВИУН**



Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

Авсан огноо: 2021-12-18
Дуусах огноо: 2024-12-18
Хүчинтэй эсэх: Хүчинтэй
Тусгай зөвшөөрлийн нэр: **ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаварлалатай мэдээллийг татан авч байнгын шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамгааран гэрчилгээний төлөгөөр өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харгахыг анхаарна уу

**MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC**

ШТК0162 9021070414 5213487

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

**MON LOGISTICS
HOLDING**

АТА5299 9021070414 9021070414

2023-06-14

БҮРТГЭВ-03



2023 оны 4-р сарын 28

“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГС” ХХК-ИАС НИЙТЭД АНХ УДАА
САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААТАЙ ХОЛБООТОЙ

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүрэг, 1-р хороо,
Олимпын гудамж-5, Аюуд Тауэр;

И-мэйл: info@khanlex.mn

Утас: (976)7747-1122



2023-06-14

БҮРТГЭВ-03



АГУУЛГА

1. Удиртгал болон дүгнэлтийн хүрээ.....	3
1.1 Хууль зүйн дүгнэлт	3
1.2 Дүгнэлтийн хүрээ	3
1.3 Дүгнэлт боловсруулсан арга, аргачлал	4
1.4 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг	4
1.5 Хязгаарлалт.....	4
1.6 Мэдэгдэл.....	5
1.7 Дүгнэлт гаргахад ашигласан хууль тогтоомж.....	6
2. Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар	8
3. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ	9
3.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх тухай.....	9
3.1.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх талаар.....	9
3.1.2. Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх талаар.....	9
3.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, “Монголын компанийн засаглалын кодексе”-т заасан шаардлага хангаж байгаа эсэх тухай.....	10
3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд, хувьцаат компанийн дүрмийн төсөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх тухай.....	12
3.3.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа баримталж буй дүрэм, журмууд.....	12
3.3.2. Үнэт цаас гаргагчийн өөрчлөн байгуулагдсаны дараа баримтлах дүрэм, журмын төслүүд.....	23
3.4. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх тухайд, мөн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх тухайд.....	24
3.4.1. Үнэт цаас гаргагчийн байгуулсан гэрээ хэлцлүүд.....	24





3.4.2. Үнэт цаас гаргагчийн охин компани болох Ворлдайдын байгуулсан гэрээнүүд	33
3.4.3. Үнэт цаас гаргагчийн охин компани болох Экүйлментсийн байгуулсан гэрээнүүд	43
3.5. Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх тухай	43
3.5.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл	43
3.5.2. Их хэмжээний хэлцэл	46
3.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх тухай	49
3.6.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх талаар	49
3.6.2. Зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх талаар	53
3.7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх тухай	56
3.7.1. Үнэт цаас өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар	56
3.7.2. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар	57
3.7.3. Авто тээврийн хэрэгсэл болон бусад хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар	57
3.8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх тухай	59
3.9. Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлдэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох нь	60
3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай	62
3.10.1. Иргэний хэргийн маргаан	62



2023-06-14

БҮРТГЭВ-03



3.10.2. Захиргааны хэргийн маргаан	63
3.10.3. Эрүүгийн хэргийн маргаан	63
3.11. Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх тухай	63
ХАВСРАЛТ № 1 - КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ	66
ХАВСРАЛТ № 2 - “МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК-ААС ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БҮЙ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ	75
ХАВСРАЛТ № 3 -ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР ТӨРИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГААС АВСАН ЛАВЛАГАА, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	108
ХАВСРАЛТ №4-ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР “МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК-ИАС ХҮЛЭЭН АВСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ	110





1.1 Хууль зүйн дүгнэлт

Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд болох “Монложистикс Холдинг” ХХК (РД: 6381251) (цаашид “Компани”, эсхүл “Үнэт цаас гаргагч” гэх)-аас нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцаагаа арилжаалахтай холбоотойгоор хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт (цаашид “Дүгнэлт” гэх) гаргуулах тухай хүсэлтийг Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН (цаашид “ХаанЛекс”, эсхүл “Бид”, эсхүл “Хуулийн фирм” гэх)-д тавьсны дагуу Үнэт цаас гаргагч болон ХаанЛекс нар нь 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 23/УАГ/02 тоот “Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид “Гэрээ” гэх) байгуулсан ба уг гэрээний дагуу энэхүү Дүгнэлтийг бэлтгэсэн болно.

ХаанЛекс нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 338 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх этгээдээр бүртгэгдсэн тул Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6-д заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухай дүгнэлт гаргах бүрэн эрхтэй болно.

1.2 Дүгнэлтийн хүрээ

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаастай холбоотой энэхүү Дүгнэлтийг СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “СЗХ-ны Бүртгэлийн журам” гэх)-ын 11.14 дэх хэсэг болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК (цаашид “МХБ” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” (цаашид “Биржийн бүртгэлийн журам” гэх) -ын 2.6 дахь хэсэгт тус тус заасан агуулгын хүрээнд бэлтгэсэн.


Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон дээр дурдсан зохицуулагч байгууллагын журмуудад үнэт цаас гаргагчийн охин компаниудтай холбогдуулан хуулийн дүгнэлт боловсруулахыг шаарддаггүй боловч Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллийн дагуу үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийн тодорхой хувийг Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компаниуд болох “Монложистикс Ворлдвайд” ХХК (цаашид “Ворлдвайд” гэх) болон Монложистикс Экүйпментс” ХХК (цаашид “Экүйпментс” гэх)-ийн үйл ажиллагаанд зарцуулахаар байх тул Бид Үнэт цаас гаргагчаас гадна Ворлдвайд болон Экүйпментсийг Дүгнэлтийн шаардлагатай гэж үзсэн зарим хэсэгт хамааруулан авч үзсэн болно.

ХаанЛекс нь энэхүү Дүгнэлтийг боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх асуудал багтаагүй болно.



2023-06-14

БҮРТГЭВ-03



1.3 Дүгнэлт боловсруулсан арга, аргачлал

Хуулийн фирмийн зүгээс энэхүү Дүгнэлтийг Үнэт цаас гаргагчтай Гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн болно.

Дүгнэлтийг бэлтгэхдээ хараат бус байх зарчмыг баримталсан бөгөөд ашиглах эх сурвалжаар Хавсралт № 3 болон Хавсралт № 4-г жагсаасан, Үнэт цаас гаргагчийн зүгээс Бидэнд ирүүлсэн баримт бичиг болон гуравдагч этгээдээс олгосон лавлагаа, тодорхойлолт, баримт бичгийг сонгож ажилласан.

Түүнчлэн хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо үгийн хэл зүйн шууд утгаар болон Монгол Улсын дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, Иргэний хуулийн тайлбарт тусгагдсаны дагуу ойлгосон бөгөөд утгыг тодорхойлох боломжгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухааны түгээмэл тогтоосон зарчим, онолын дагуу агуулгыг ойлгож Дүгнэлт бэлтгэсэн болно.

1.4 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн дараах баримт бичиг, мэдээлэл (цаашид “**Баримт бичиг**” гэх)-д үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

- ХаанЛексийн хүсэлтийн дагуу Компаниас гаргаж өгсөн, энэ Дүгнэлтийн Хавсралт № 4-д жагсаасан баримт бичгүүд;
- Энэ Дүгнэлтийг гаргахтай холбоотойгоор төрийн холбогдох байгууллагаас авсан бөгөөд тус Дүгнэлтийн Хавсралт № 3-д жагсаасан лавлагаа, тодорхойлолтууд;

1.5 Хязгаарлалт

Энэхүү Дүгнэлт нь хөндлөнгийн, хууль зүйн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд аливаа гуравдагч этгээдийн өмнө эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй ба хууль зүйн туслалцаа зөвлөгөө өгсөнд тооцогдохгүй.

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор боловсруулсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх, Биднээс тухайлан олгосон зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Дүгнэлт гаргах явцад Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох этгээд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, худал мэдээлсэн зэрэг нөхцөлд үүсэх үр дагаврыг ХаанЛекс хариуцахгүй.

Дүгнэлтийг энд дурдсан хүрээ хязгаарын дотор зөвхөн хууль зүйн асуудлаар бэлтгэсэн бөгөөд Бид үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зах зээлийн мэдээ, бизнес,



2023-06-14

БҮРТГЭВ-03

СЗХ

Эдийн засаг, санхүү, технологи гэх мэт хуульчаас өөр тусгай мэргэжил, мэргэшил шаардагдах асуудлаар дүгнэлт гаргах эрхгүй буюу хариуцлага хүлээхгүй болно.

№: 1

Үнэт цаас гаргагч болон холбогдох бусад этгээдээс ирүүлсэн лавлагаа, тодорхойлолт, албан бичиг зэргийн огноо нь харилцан адилгүй өөр байгаа бөгөөд тэдгээр баримт бичигт үндэслэн тухайн асуудлаар бидний гаргасан Дүгнэлтийн хугацаа нь тухайн баримт бичгийн огноогоор хязгаарлагдана. Тухайн лавлагаа, тодорхойлолтын огнооноос хойших үйл явдалд Хуулийн фирм нь Дүгнэлт хийгээгүй бөгөөд түүнд Хуулийн фирмийн зүгээс ямар нэгэн баталгаа гаргахгүй болно.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаастай холбоотой энэхүү Дүгнэлтийг СЗХ болон МХБ-д хүргүүлж зохих зөвшөөрлийг авсан өдрөөс хойш холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсон зэрэг бусад үйл ажиллагаатай холбогдуулан Бид нэмэлт хууль зүйн Дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй болно.

Энэхүү Дүгнэлтийг энд дурдсан хүрээ хязгаарын дотор зөвхөн хууль зүйн асуудлаар бэлтгэсэн бөгөөд Дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт тусгагдсан мэдээлэлд Дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хууль тогтоомжоор МХБ, СЗХ зэрэг төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамааруулсан болон эдгээр байгууллагаас зохих зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийж, Дүгнэлт гаргаагүй болно.


Жич: Энэхүү Дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.

1.6 Мэдэгдэл

Бид энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа дараах төсөөлөл буюу хүлээн зөвшөөрөл (assumption) дээр үндэслэсэн бөгөөд дор дурдсан уг нөхцөлүүдийг хангагдсанд тооцсон болно. Үүнд:

- (i) Баримт бичгүүд дэх огноо, гарын үсэг, тамга, тэмдэг нь үнэн зөв, хүчин төгөлдөр, баримт бичигт гарын үсэг зурсан этгээд нь гарын үсэг зурах, батлах бүрэн эрхтэй;
- (ii) Баримт бичгийн хуулбарыг хүлээн авсан бол тэр нь эх хувийн үнэн зөв, бүрэн хуулбар мөн;
- (iii) Хэрвээ бид Баримт бичгийн төслийг хүлээн авсан бол уг баримт бичиг нь тус төслийн дагуу үйлдэгдэнэ;
- (iv) Бидэнд ирүүлсэн Баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт ороогүй, эсхүл тэдгээр нь хүчингүй болоогүй;





- (v) Компани болон бусад оролцогч талууд нь Баримт бичгийг үйлдэх бүрэн эрхтэй бөгөөд түүнийг зохих журмын дагуу үйлдсэн буюу байгуулсан ба түүгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ;
- (vi) Аливаа этгээд нь санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээрээ төөрөгдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаанд оролцоогүй. Аливаа этгээд нь энэхүү Дүгнэлтийн аливаа хэсгийг буруу болгох ямарваа үйл ажиллагаанд оролцоогүй буюу оролцохгүй;
- (vii) Үнэт цаас гаргагч, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд, бусад эрх бүхий байгууллага болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн баримт, мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр.
- (viii) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан болон хавсаргагдсан андеррайтер, аудитор болон мэргэжлийн бусад оролцогчдын гаргасан судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
- (ix) Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үйл баримт, мэдээлэл нь ирээдүйд хэрэгжих тохиолдолд тус үйл баримт, мэдээлэл нь хуулийн дагуу зохих ёсоор биелэгдэнэ.

1.7 Дүгнэлт гаргахад ашигласан хууль тогтоомж

1.7.1 Судалсан хууль тогтоомжууд:

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013 он;
- Компанийн тухай хууль, 2011 он;
- Иргэний хууль, 2002 он;
- Зохиогчийн эрхийн тухай хууль, 2021 он;
- Оюуны өмчийн тухай хууль, 2020 он;
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, 2009 он
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, 2015 он;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он;
- Зөвшөөрлийн тухай хууль, 2022 он;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2003 он;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он;
- Бусад хууль тогтоомж.

1.7.2 Судалсан дүрэм журмууд:






- МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам, 2018 он;
- МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, 2018 он;
 - “ҮЦГХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 6 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам, 2019 он;
 - Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, 2020 он;
 - Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар батлагдсан “Оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн санг үүсгэх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журам”;
 - СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, 2021 он;
 - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”, 2021 он;
 - МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 8 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам, 2022 он;
 - СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, 2022 он.



2023-06-14

БҮРТГЭВ-03



2. Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар

Дүгнэлтэд хаалтад тодорхойлсноос гадна дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

“Ворлдвайд” гэж Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Ворлдвайд” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг;

“Иргэний хууль” гэж 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Монгол Улсын Иргэний хууль;

“Компанийн засаглалын кодексе” гэж СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодексе”-ийг;

“МХБ” гэж “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг;

“СЗХ” гэж Санхүүгийн зохицуулах хороог;

“ТУЗ” гэж төлөөлөн удирдах зөвлөлийг;

“УБЕГ” гэж Улсын бүртгэлийн ерөнхий газрыг;

“ХК” гэж хувьцаат компанийг;

“ХХК” гэж хязгаарлагдмал хариуцлагатай компанийг;

“ХЭУБГ” гэж УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрыг;

“ХЭХ” гэж хувьцаа эзэмшигчдийн хурлыг;

“Экүйпментс” гэж Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох Монложистикс Экүйпментс” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг.





3. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

3.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх тухай

3.1.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх талаар

Компани нь Иргэний хуулийн 25.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд болохынхоо хувьд тус хуулийн 26.1 дэх хэсэг болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт тус тус зааснаар улсын бүртгэлд бүртгүүлснээр эрх зүйн чадвар үүснэ.


Компанийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийг шинээр байгуулах замаар байгуулж болдог бөгөөд энэ тохиолдолд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулахаар байна. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид болох Монгол Улсын дөрвөн иргэн нь 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хуралдан, компанийг “Эм Эл Холдинг” ХХК (одоогийн “Монложистикс Холдинг” ХХК) гэх оноосон нэртэйгээр үүсгэн байгуулах асуудлыг 100 хувийн ирцтэйгээр, хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хэлэлцэн шийдвэрлэсэн байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан “Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн ... байж болно”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасан “... бүх үүсгэн байгуулагч оролцсоноор компани үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болох бөгөөд уг хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана” гэсэн шаардлагуудад тус тус нийцэж байна.

Энэхүү тогтоолыг үндэслэн Үнэт цаас гаргагч нь 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хувийн хэргийн 9011784027, регистрийн 6381251 тоот дугаар тус тус авч Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн болох нь Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр олгосон 23900002001925 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар нотлогдож байх тул Үнэт цаас гаргагчийг хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байна гэж дүгнэлээ.

3.1.2. Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх талаар

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 болон 62.4 дэх хэсэгт заасны дагуу зарласан хувьцааны тоонд өөрчлөлт оруулан хувьцаа нэмж гаргах, компанийн хэлбэрийг өөрчлөх асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарч байна. Иймд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Компанийн тухай хуулийн 60.1 дэх хэсгийг үндэслэн Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, компанийн хэлбэр өөрчлөх, хэлбэр өөрчлөхтэй холбоотой хувьцаа нэмж гаргах, нийтэд санал болгох





хувьцааны нөхцөлийг тогтоох, үнэт цаасны танилцуулга батлах зэрэг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлэхээр тогтсон байна. Энэхүү тогтоолд Компанийн тухай хуулийн 60.2 дахь хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрт заавал тусгах асуудлуудыг бүрэн тусгасан байх бөгөөд Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.3 болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 8.5.1 дэх хэсэгт заасан компанийн ээлжит хурлыг хуралдуулах тухай хугацааны шаардлагад нийцэж байх тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шийдвэр нь хуульд нийцсэн гэж үзлээ.

Дээрх тогтоолын дагуу Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр хуралдан Компанийн хэлбэрийг нээлттэй хувьцаат болгох замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, нэмж гаргах хувьцааны тоо, нөхцөлийг хурлын тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 23/ХЭХ/13 тоот тогтоолд Компанийн тухай хуулийн 42.1 дэх хэсэгт заасан агуулга бүрэн тусгагдсан байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/ХЭХ-Т/13 тэмдэглэлээс үзвэл компанийн хэлбэрийг өөрчлөх, түүнтэй холбоотой авах зарим арга хэмжээг хэлэлцэх тухай ээлжит хуралд Компанийн бүх хувьцаа эзэмшигчид оролцож, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэсэн байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7 болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 8.7 дахь хэсэгт тус тус нийцсэн байна.

Иймд үнэт цаас гаргах тухай шийдвэр нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцсэн гэж дүгнэлээ.

3.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, “Монголын компанийн засаглалын кодексе”-г заасан шаардлага хангаж байгаа эсэх тухай

Компанийн тухай хуулийн 84.2-т заасны дагуу Компани нь эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг дүрэмдээ тухайлан заах шаардлагатай байна. Энэхүү заалтын дагуу Үнэт цаас гаргагч нь дүрмийнхээ 11.1 дэх хэсэгт “Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх заалтад заасан албан тушаалын тодорхой нэр заасан этгээдүүд болон компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.”, мөн дүрмийн 11.2 дахь хэсэгт “ТУЗ нь энэ дүрмийн 11.1 дэх заалтыг үндэслэн компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдох ажлын байрыг тодорхойлж, энэ тухай шийдвэр гаргана.” гэж тус тус заасан байна. Дүрмийн 11.2 дахь хэсгийн дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 20-005-2022BOD/20221107 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ложистик эрхэлсэн захирал, стратеги бизнес хөгжил эрхэлсэн захирал, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, ерөнхий нягтлан бодогч гэсэн албан тушаалтнуудыг эрх бүхий албан тушаалтнаар тогтоон шийдвэрлэсэн байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84.1-т заасан шаардлагад нийцэж байна гэж үзлээ.





Компани нь 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23/ЗХНХ/127 тоот албан бичгээр Хуулийн фирмд Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтыг ирүүлсэн ба дараах этгээдийг эрх бүхий албан тушаалтанд хамруулсан байна. Үүнд:

Хүснэгт №1 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалт

№	Овог нэр	Албан тушаал	Төмилөгдсөн/ сонгогдсон огноо
1	Лувсанжамба овогтой Ганзоригт	ТУЗ-ийн дарга	2021.12.24
2	Бааст овогтой Тэлэнгэд	ТУЗ-ийн гишүүн	2021.12.24
3	Санжаа овогтой Сайнбат	ТУЗ-ийн гишүүн	2022.06.06
4	Ганзоригт овогтой Хишигбат	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	2023.02.17
5	Балдан овогтой Энхтүвшин	ТУЗ-ийн гишүүн	2023.02.17
6	Эрэндоо овогтой Оюунбилэг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2022.06.06
7	Готов овогтой Цэрэнпүрэв	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2023.02.17
8	Энхбаатар овогтой Нарангарвуу	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	2023.04.10
9	Амгалан овогтой Одгэрэл	Ложистик эрхэлсэн захирал	2022.12.29
10	Заанхүү овогтой Шинэ-Од	Санхүү эрхэлсэн захирал	2023.02.06
11	Эрхэмбаатар овогтой Элдэв- Очир	Стратеги, бизнес хөгжил эрхэлсэн захирал	2022.12.29
12	Баатар овогтой Азжаргал	Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	2022.12.29
13	Муратай овогтой Майгүл	Ерөнхий нягтлан бодогч	2023.03.29

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 84.3, СЗХ-ны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 2.1.2-г



2023-06-14

БҮРЭГЭВ-03



тус тус заасан шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал зэрэг тодорхой албан тушаалтнуудын хувьд тус журмын нийтлэг шаардлагаас гадна Компанийн тухай хуульд заасан нэмэлт шаардлагыг мөн хангасан байх ёстой.

Бид эрх бүхий албан тушаалтнууд нь дээр дурдсан журам болон хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх тухай дүгнэлтийг дээр заасан шалгууруудын дагуу нэг бүрчлэн шалгахад эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэгт заасан “компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх” шаардлагаас бусад хуульд заасан шаардлагыг бүрэн хангаж байсан болно. Тодруулбал, Компанийн ТУЗ-ийн зарим гишүүд нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, зохих гэрчилгээ аваагүй байсан тул Бид энэ тухай Үнэт цаас гаргагчид мэдэгдэн, уг шаардлагыг хангуулах тухай зөвлөсөн болно.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх тухай дүгнэлтийн дэлгэрэнгүйг Хавсралт № 1-ээс үзнэ үү.

3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд, хувьцаат компанийн дүрмийн төсөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх тухай

3.3.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа баримталж буй дүрэм, журмууд

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 23/ЗХНХ/59, 23/ЗХНХ/60 тоот албан бичгээр тус тус үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлдэг нийт 72 дотоод дүрэм, журмын жагсаалтыг ирүүлсэн бөгөөд Хуулийн фирм нь тус жагсаалт дахь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дотоод дүрэм, журам болон хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдсаны дараагаар дагаж мөрдөгдөх холбогдох дүрэм, журмын төслийг хянан, дараах байдлаар хууль зүйн дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд:

3.3.1.1. Үнэт цаас гаргагчийн дүрэм

Үнэт цаас гаргагчийн дүрэм нь хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлын 02-2019 тоот шийдвэрийн хавсралтаар батлагдсан байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дараах тогтоолын хавсралтын дагуу нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит бус хурлын 20201214 тоот шийдвэрийн хоёрдугаар хавсралт;
2. Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын 202102-1/ЭБ03/20210315-1 тоот шийдвэрийн нэгдүгээр хавсралт;
3. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хурлын 1-002-2022ХЭХ/20220321 тоот шийдвэрийн хоёрдугаар хавсралт;



2023-06-14

БҮРТГЭЭ-03

БҮ 4. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн ээлжит бус хурлын
 № 3-005-2022ХЭХ/20221111 тоот шийдвэрийн нэгдүгээр хавсралт;

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит бус хурлын 23/ХЭХ/03 тоот шийдвэрийн нэгдүгээр хавсралт;
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын 23/ХЭХ/12 тоот шийдвэр.

Компанийн дүрмийг батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрх нь Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд хадгалагдаж байх тул дээрх тогтоолууд нь энэхүү шаардлагад нийцэж байна. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн дүрэм нь ХЭУБГ-т 2023 оны 4 дугаар сарын 13-ны өдөр бүртгэгдэн, УБЕГ-ын тамга, тэмдгээр баталгаажсан байх тул Компанийн тухай хуулийн 17.9-д заасны дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн, хүчин төгөлдөр дүрэм байна.

Компанийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ёстой. Үнэт цаас гаргагчийн дүрэм нь агуулгын хувьд компанийн эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хувь нийлүүлсэн хөрөнгө, гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан нийт 15 зүйлээс бүрдэх бөгөөд Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан нийтлэг шаардлагад нийцсэн байна. Гэхдээ Хуулийн фирмээс Компанийн дүрмийг хянаад цаашид Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах зүйлсийг анхаарч, засан сайжруулалтыг дүрэмд тусгах нь зүйтэй гэж зөвлөсөн. Үүнд:

- Компанийн дүрмийн 9.8 дахь хэсэгт ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг ХЭХ-аас батална гэж заажээ. Компанийн тухай хуулийн 76.1.13 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг ТУЗ хуралдан шийдвэрлэх нь зүйтэй байх тул уг заалтыг Компанийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.
- Компанийн дүрмийн 11.7 дахь хэсэгт “Компани нь эрх бүхий албан тушаалтны учруулсан аливаа хохирлыг толох, нохон толох, гэм хорыг арилгах үүрэг хүлээхгүй” гэж тусгагджээ. Иргэний хуулийн 498.1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогч нь ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг хүлээх үүрэгтэй байх бөгөөд тус хуулийн 498.5 дахь хэсэгт заасны дагуу ажил олгогч нь хожим тодорхой нөхцөлд буруутай этгээдээс хохирлоо шаардах эрхтэй байна. Иймд дүрмийн уг заалтыг Иргэний хуульд нийцүүлэн өөрчлөн найруулах шаардлагатай.

Дээр дурдсан зүйлс нь Үнэт цаас гаргагчийн дүрмийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй боловч бидний зүгээс цаашид дээрх зөвлөмжийг анхаарч, ХК-ийн дүрмийг батлахдаа холбогдох өөрчлөлтийг дүрэмд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.





3.3.1.2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 14-005-2022BOD/20221107 тоот шийдвэрийн дагуу батлагдсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 болон 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэгт тус тус заасан шаардлагад нийцэж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь зорилго, ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх, ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр, ТУЗ-ийн төсөв, хяналт зэргийг зохицуулсан нийт 16 бүлгээс бүрдэх бөгөөд агуулгын хувьд Компанийн тухай хуулийн 75 – 82 дугаар зүйл болон Компанийн засаглалын кодекст нийцэж байна. Гэхдээ Хуулийн фирмийн зүгээс ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд цаашид дараах нэмэлт сайжруулалтыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Журмын 5.3 дахь хэсэгт “ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томило” гэж тусгагджээ. Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1. дэх хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилохоор байх тул энэхүү заалтыг хуульд нийцүүлэн цаашид засан сайжруулах шаардлагатай.

Дээр дурдсан үл нийцэл нь тус журмын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй боловч бидний зүгээс цаашид дээрх зөвлөмжийг анхаарч, холбогдох өөрчлөлтийг уг журамд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

3.3.1.3. Дотоод аудитын бодлого, журам


Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 05/2020 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Дотоод аудитын бодлого”, хоёрдугаар хавсралтаар “Дотоод аудитын журам”-ыг тус тус баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт нийцсэн байна.

Дотоод аудитын журмын 1.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн дотоод хяналтыг ТУЗ-өөс томилогдсон бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулдаг дотоод аудитын баг хэрэгжүүлж байх бөгөөд тус журмын 3.1 дэх хэсэгт заасны дагуу Группийн гүйцэтгэх захирлууд нь аудитын багийн гишүүн байхыг хориглосон байх тул Компанийн засаглалын кодексийн 4 дүгээр зарчим болох “Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.” гэх зарчимд нийцэж байна гэж үзлээ.

Дотоод аудитын журмын 3.2 дахь хэсэгт заасны дагуу дотоод аудитын багийн гишүүд нь нягтлан бодох бүртгэл, засаглал болон хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэй байх шаардлагатай байх бөгөөд Дотоод аудитын бодлогын 4.1.6 дахь хэсэгт заасны дагуу дотоод аудитын баг нь аудитын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, зөвлөмжийг нэгтгэн ТУЗ-д дэлгэрэнгүй тайланг боловсруулан танилцуулдаг байгаа нь Компанийн засаглалын кодексийн 4.3 дахь хэсгийн тайлбар 2-т заасан “Дотоод аудитын



2023-06-14



нэгжцийн удирдлага нь зохих мэдлэг, чадвар, туршилагатай байх ба төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороотой шууд харилцаж, тайлагнана.” гэх шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

Үнэт цаас гаргагчийн Дотоод аудитын бодлогоор дотоод аудитын зарчим, үйл ажиллагаа, хяналт, сайжруулалт зэрэг ТУЗ болон дотоод аудитын чиг үүрэгтэй холбоотой нийтлэг харилцааг, Дотоод аудитын журмаар Дотоод аудитын багийн бүтэц, зохион байгуулалт, үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан харилцааг тус тус зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцэж байна.

3.3.1.4. Шүгэл үлээх бодлого

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 11 дүгээр сарын 7-ний өдрийн 14-005-2022BOD/20221107 тоот тогтоолоор “Шүгэл үлээх бодлого”-ыг баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт заасан шаардлагад нийцсэн байна. Шүгэл үлээх бодлого нь Үнэт цаас гаргагч, түүний охин компаниудын бүх шатны ажилтнуудын хүрээнд мөрдөгддөг байх бөгөөд тус бодлогоор аливаа ажилтан хууль бус үйлдлийг дотоод аудитад мэдээлэх үйл явц, хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авч, шалгах үйл явц, мэдээллийн нууцлалыг хадгалахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн Шүгэл үлээх бодлогыг хянаад тус бодлогын зүйл, заалтууд нь Компанийн тухай хуулийг зөрчөөгүй байх бөгөөд Компанийн засаглалын кодексийн 8 дугаар зарчимд “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно”, тус кодексийн 8.2 дахь хэсэгт “Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.” гэж тус тус заасантай нийцэж байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

3.3.1.5. Цалин урамшууллын бодлого

Үнэт цаас гаргагчийн Цалин урамшууллын бодлого нь ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн ээлжит хурлын 14-005-2022BOD/20221107 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт нийцсэн байна. Тус бодлогоор компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчим, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, менежментийн багийн гишүүдэд цалин урамшуулал олгохтой холбоотой нийтлэг харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн байна гэж дүгнэлээ.


3.3.1.6. Сонирхлын зөрчлөөс сэргийлэх, бизнесийн үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйн журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2019 оны 01/2019 тоот тогтоолоор “Сонирхлын зөрчлөөс сэргийлэх, бизнесийн үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйн журам”-ыг баталсан байх



2023-06-14

БҮРТГЭГ-03



бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт нийцсэн байна. Тус журам нь компанийн үнэт зүйлс, хувьцаа эзэмшигчид болон нийт ажилтнуудын баримтлах зарчим, ашиг сонирхлын зөрчил, түүнээс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, түүнийг мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 9 бүлгээс бүрдэж байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хуулийг зөрчөөгүй, Компанийн засаглалын кодексийн 8 дугаар зарчимд заасан “Толоолон удирдах зовлолийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно” гэх шаардлагад нийцэж байх тул хуульд нийцэж байна гэж дүгнэлээ. Гэхдээ Бидний зүгээс цаашид тус журамд Компанийн ТУЗ-өөс ёс зүйн журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд хянах, уг журмыг зөрчсөн эсэхийг эрх бүхий этгээдээс шийдвэрлэх ажиллагаа болон ёс зүйн журмын талаарх дотоод сургалтыг тогтмол зохион байгуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг нэмж тусгах замаар холбогдох засан сайжруулалтыг хийх нь компанийн сайн засаглалын хувьд ач холбогдолтой гэж үзэж байна.

3.3.1.7. Нийцлийн журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь компанийн үйл ажиллагаанд хамаарах Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох, бүртгэх, хууль эрх зүйн хэм хэмжээний нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр мэдээлж бүртгэх, хуулийн нийцлийг үнэлж, бүртгэх үйл явцтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Нийцлийн журмыг баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт нийцсэн байна. Тус журмын 1.3.2 дахь хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагч нь компанийн хэмжээнд мөрдөх хууль, эрх зүйн хэм хэмжээний нэгдсэн бүртгэлийг хөтөлж, алба, хэлтсээс хууль, эрх зүйн хэм хэмжээний биелэлт, нийцлийн тайланг хүлээн авч, журмын хэрэгжилтэд жилд хоёроос доошгүй удаа хяналт тавих чиг үүрэг бүхий комплайнсын ажилтантай байх бөгөөд тус журмын 5 дугаар зүйлд заасны дагуу дотоод аудит болон комплайнсын ажилтан нь нийцлийн үнэлгээний дүгнэлт, журмын хэрэгжилтийг ТУЗ-д танилцуулахаар зохицуулсан байгаа нь Компанийн засаглалын кодексийн 5.4 дэх хэсэгт заасан шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

3.3.1.8. Жендерийн талаар баримтлах бодлого

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 11 дүгээр сарын 7-ний өдрийн 14-005-2022BOD/20221107 тоот тогтоолоор “Жендерийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт нийцсэн байна. Тус журмаар жендерийн тэгш байдалтай холбоотойгоор компаниас баримтлах чиглэл, жендерийн тэгш байдлыг сайжруулах алхам үе шат, үнэлэлт, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн холбогдох зүйл, заалтад нийцсэн байна.

3.3.1.9. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/2019 тоот шийдвэрийн 6 дугаар хавсралтаар Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг





баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэгт нийцэж байна. Тус журам нь гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, түүний эрх зүйн байдал, баталгаа, хориглох үйл ажиллагаа, үйл ажиллагааны тайлагналтай холбоотой харилцааг зохицуулсан нийт 10 бүлгээс бүрдэж байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

3.3.1.10. Гүйцэтгэх удирдлагын тайлагналын журам

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлагын тайлагналын журам нь ТУЗ-ийн 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 05/2020 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 болон 76.1.18 дахь хэсэгт нийцсэн байна. Тус журмаар гүйцэтгэх удирдлагаас Компанийн болон Компанийн нэгдлийн оролцогчдын тайланг нэгтгэн ТУЗ-д хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд Компанийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.3.1.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хорооны журам

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэг болон Компанийн засаглалын кодексийн 2.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ нь өөрийн тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороотой байж болох тул Үнэт цаас гаргагч нь компанийн стратегийн төлөвлөлтийн бүтэц, үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийг оновчтой болгох талаар зөвлөмж, дүгнэлт гаргах, компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, стратегийн асуудлаар ТУЗ, гүйцэтгэх удирдлага хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байнгын хороог ТУЗ-ийн дэргэд байгуулсан байна.

Компанийн засаглалын кодексийн 2.5 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороод нь үйл ажиллагааны журамтай байх шаардлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь уг шаардлагыг хангах үүднээс 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 10-004-2022BOD/20220729 тоот тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хорооны журмыг баталсан байна.

Тус журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хорооны чиг үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны тайлагнал, хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагаа явуулах хэлбэр, давтамж зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн 2.5 дахь хэсэгт тус тус нийцсэн байна.


3.3.1.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны журам

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг болон Компанийн засаглалын кодексийн хоёрдугаар зарчимд тус тус заасны дагуу хувьцаат компанийн ТУЗ-ийн хувьд дэргэдээ цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороотой байх шаардлагатай байна. Үнэт цаас гаргагч нь дээрх хоёр хорооны чиг үүргийг нэгтгэж компанийн ТУЗ-ийн



2023-06-14

БҮРТГЭЭВ-03



гишүүн болон гүйцэтгэх удирдлагад зохих ур чадвар, мэдлэг боловсрол, туршлагатай этгээдийг дэвшүүлэх, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог байгуулсан байна.

Компанийн засаглалын кодексийн 2.3 болон 2.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороод нь үйл ажиллагааны журамтай байх шаардлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь уг шаардлагыг хангах үүднээс 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 10-004-2022BOD/20220729 тоот тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны журмыг баталсан байна.

Тус журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх стратеги бизнес хөгжлийн хорооны чиг үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны тайлагнал, хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагаа явуулах хэлбэр, давтамж зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Компанийн засаглалын кодексийн 2.3 болон 2.4 дэх хэсэгт тус тус заасан шаардлагад нийцэж байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

3.3.1.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн аудит, эрсдэлийн удирдлагын хорооны журам

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг болон Компанийн засаглалын кодексийн хоёрдугаар зарчимд тус тус заасны дагуу хувьцаат компанийн ТУЗ-ийн хувьд дэргэдээ аудитын хороотой байх шаардлагатай байх бөгөөд Үнэт цаас гаргагч нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах үндсэн чиг үүрэг бүхий аудит, эрсдэлийн удирдлагын хороог ТУЗ-ийн дэргэд байгуулсан байна.

Компанийн засаглалын кодексийн 2.2 дахь хэсэгт заасны дагуу аудитын хороо нь үйл ажиллагааны журамтай байх шаардлагатай бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь уг шаардлагыг хангах үүднээс 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 10-004-2022BOD/20220729 тоот тогтоолын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудит, эрсдэлийн удирдлагын хорооны журмыг баталсан байна.

Тус журмаар аудит, эрсдэлийн хорооны чиг үүрэг, хариуцлага, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа явуулах хэлбэр, давтамж, хөндлөнгийн аудиторыг сонгох хамтран ажиллах, компанийн эрсдэлийн үйл ажиллагааг тогтмол хянахтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Компанийн засаглалын кодексийн 2.2 болон 4.1 дэх хэсэгт тус тус заасан шаардлагад нийцэж байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

3.3.1.14. Ногдол ашгийн бодлогын төсөл



2023-06-14

БҮРТГЭВ-03



Журмын 6 дугаар хэсэгт: “Компанийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдах бөгөөд захирлын дэргэд зөвлөх эрхтэй удирдлагын баг ажиллана” гэж заасан нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т “Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ”, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 10.1-д “Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ. Түүнийг компанийн Гүйцэтгэх захирал гэж нэрлэнэ” гэж заасантай нийцсэн байна.


Түүнчлэн, Журмаар ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амрах, эсвэл илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ажилтанд хувийн чөлөө олгох, цалин хөлс олгох, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болох, ажилтныг ажлаас чөлөөлөх, халах үндэслэл, сахилгын арга хэмжээ, шийтгэлийн төрөл, түүнийг ногдуулах журам болон эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл зэрэг Хөдөлмөр эрхлэлтийн харилцааны чухал зохицуулалтуудыг тусгасан байна.

Тодруулбал, Журмын 13, 14 дүгээр зүйлд ажилтны, 15, 16 дугаар зүйлд ажил олгогчийн эдлэх эрх, хүлээх үүргийг зохицуулсан байх бөгөөд энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасантай нийцэж байна.

“Илүү цаг, шөнийн цаг, амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр” журмын 2-т: “Удирдлагын санаачилгаар өдөрт ажиллуулах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна”, 5-д: “Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 1.2 дахин тооцож олгоно”, 6-д: “ердийн ажлын өдөр болон 7 хоногийн амралтын өдөр илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амрах эсхүл 1.5 дахин нэмэгдүүлсэн цалин хөлс, нийтээр амрах баярын өдөр илүү цагаар ажиллуулсан бол нөхөн амрах эсхүл 2 дахин нэмэгдүүлсэн цалин хөлс олгох” гэж зохицуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4, 109 дүгээр зүйлийн 109.1, 109.2, 109.3, 109.4 дүгээр зүйлд тус тус заасантай зохицуулалтад нийцсэн байна.

“Ээлжийн амралт”-ын журмын 1-д: “ажилтанд жил бүр ээлжийн амралтыг жил бүр биеэр эдлүүлнэ”, 5-д: “ээлжийн амралтын үндсэн хугацаа нь 15 хоног байна”, 8-д: “компанид анх ажилд орсон ажилтны ажилласан хугацаа нийт 6 сар хүрсэн тохиолдолд ээлжийн амралт эдлэх эрх үүснэ”, 12-т: “Ээлжийн амралтад эсирэмсний болон амаржсаны амралт, хөдөлмөрийн чадвар түр алдсан ажил олгогчоос албан ёсны чөлөөтэй байсан хугацааг оруулахгүй” гэж заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1, 99.2, 99.4 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 2.7 дахь хэсэгт заасантай тус тус нийцсэн байна.






Түүнчлэн, Компани нь нэгж, ажилтан бүрийн зорилго, зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэх явцыг хянах, гүйцэтгэлийг үнэлэх үүднээс Гүйцэтгэлийн удирдлагын журмыг дотооддоо мөрдөн ажиллаж байх бөгөөд ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 80%-иас дээш үнэлэгдсэн ажилтанд урамшуулал олгох, гүйцэтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр үнэлэхээр зохицуулсан нь онцлууштай ажилтны хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, урамшуулсан зохицуулалт болсон байх бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 42.2.1, 42.2.2, 43.1.3 дахь хэсгүүдэд заасантай, Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар батлагдсан “Чөлөө”-ний журмаар ажилтан нь School police хийх тохиолдолд 4 цагийн чөлөө олгох, үндсэн ажилтны төрсөн өдрөөр 1 өдрийн цалинтай чөлөө олгох зэрэг ажилчдаа дэмжсэн онцлог зохицуулалтуудыг тусгасан байх бөгөөд уг журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлд заасантай, “Сул зогсолт”-ын журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасантай тус тус нийцсэн байна.

Компани нь хүний нөөцтэй холбоотойгоор шинэ ажилтныг дадлагажуулах, жинхлэх үүднээс “Дадлагажигч ажилтан”-ы журмыг баталсан байх бөгөөд шинэ ажилтныг хамт олонд танилцуулах, Компанийн дүрэм, журам, ажил үүргийг танилцуулах үүднээс “Чиглүүлэх”, тухайн ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, дадлага олгох үүднээс “Дасан зохицох” хөтөлбөрүүдийг уг журмын хүрээнд хэрэгжүүлж байгаа нь шинэ ажилтныг дэмжсэн, жинхлэх боломжоор хангасан онцлог журам болсон төдийгүй Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан туршилтаар ажиллуулах зохицуулалттай нийцсэн байна.

“Ажлын цаг”-ийн журмын 2-т: “Ажилтны ердийн ажлын цаг нь долоо хоногт 40 цагаас илүүгүй, ердийн ажлын өдрийн үргэлжлэл нь 8 цагаас илүүгүй байна”, 3-т: “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” гэж заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хангасан байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.2-д “...Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болон хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заана”, 123.1-д “Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг сахилгын зөрчилд тооцно” гэж заасны дагуу ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журамдаа хөдөлмөрийн сахилгын зөрчлийн зохицуулалтыг тусгах шаардлагатай ба энэ хүрээнд “Ажилтанд хариуцлага тооцох” буюу хөдөлмөрийн сахилгын зөрчлийн журам, Хөдөлмөрийн дотоод журам дахь ажилтан, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, журам, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахтай холбогдох зохицуулалтууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79, 80, 123 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцсэн байна.





Дүгнэвэл. Үнэт цаас гаргагчийн дотоодод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, хүний нөөцийн удирдлагын газрын үйл ажиллагаанд хамаарах дээрх журмууд нь Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байна гэж дүгнэлээ.

3.3.1.16. Нууц хадгалах журам

Байгууллагын нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Компани нь нууцын мэдээлэлд хамаарах баримт бичиг, нууц алдагдахаас урьдчилан сэргийлэх, нууц алдагдсан тохиолдолд авах арга хэмжээг зохион байгуулахтай холбоотойгоор байгууллагын нууц бичиг баримтыг боловсруулах, хадгалах, нууц алдагдсантай холбоотойгоор албан тушаалтны хүлээх үүрэг, байгууллагын нууцтай танилцах дараалал, хариуцлагын арга хэмжээг зохицуулсан “Нууц хадгалах журам”-ыг Гүйцэтгэх захирлын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/005 тоот тушаалаар батлан, мөрдүүлэн ажиллаж байна.

Тус журмын нэгдүгээр хавсралтаар Компанийн бичиг баримтын жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар Компанийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтууд, гэрээ хэлцлүүдийг зохицуулсан байх ба Компани нь ажилтан бүртэй нууц хадгалах гэрээ байгуулах бөгөөд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байхаар зохицуулсан байна. Уг гэрээнд зааснаар ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалтыг тусгасан байна.

Хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд Компанийн нууцад хамааруулсан мэдээлэл нь Байгууллагын нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан нууцлахыг хориглосон мэдээлэлд хамаарахгүй байгаагийн дээр тус журмын бусад зохицуулалтууд нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

3.3.1.17. Албан хэрэг хөтлөлтийн ерөнхий журам

Компани нь Гүйцэтгэх захирлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/023 тоот тушаалын хавсралтаар “Албан хэрэг хөтлөлтийн ерөнхий журам”-ыг баталсан байх бөгөөд энэ нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 2.1.2-г: “Байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг энэ журамд нийцүүлэн баталж мөрдүүлнэ.” гэсэн шаардлагад нийцэж байна. Тус журмаар захиргаа, бичиг хэргийн ажилтны эрх, үүрэг, Компанийн үйл ажиллагаанд явцад боловсруулан, хөтлөгдөж буй албан баримт бичгийн агуулга, бүтэц, албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн бүрдэл, хадгалалт, ашиглалт зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр зохицуулалт нь хууль тогтоомж, Засгийн газраас батлан мөрдүүлж буй дээр дурдсан журамд нийцсэн байна.



СЗХ

он сар өдөр

БҮРТГЭЛЭГ
3.3.2.2 Үнэт цаас гаргагчийн өөрчлөн байгуулагдсаны дараа баримтлах дүрэм, журмын
№ 01
төслүүд

3.3.2.1. Хувьцаат компанийн дүрмийн төсөл

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд “ХХК” хэлбэртэй компани болон “ХК” хэлбэртэй компани нар нь харилцан адилгүй эрх зүйн зохицуулалттай байх тул Компани өөрчлөн байгуулагдан, ХК болсноос хойш хүчин төгөлдөр болон хэрэгжих Компанийн дүрмийн төслийг Үнэт цаас гаргагчаас боловсруулан, Хуулийн фирмд ирүүлсэн байна.

Компанийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ёстой. Үнэт цаас гаргагчийн дүрэм нь агуулгын хувьд компанийн эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хувь нийлүүлсэн хөрөнгө, төлөөлөн удирдах зөвлөл, тэдгээрийн дэргэдэх хороод, гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудын бүрэн эрх, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан нийт 16 зүйлээс бүрдэх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

3.3.2.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журмын төсөл

Компанийн засаглалын кодексийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг тогтоох, хурлын зар хүргүүлэх, хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох баримт, мэдээлэлтэй урьдчилан судалж, танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, хурлыг удирдан явуулах санал хураах, хурлын шийдвэрийг баримтжуулах, хадгалах, тэмдэглэл хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэр болон тэмдэглэлтэй танилцах боломжийг олгох зэрэг асуудлыг зохицуулсан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тусгайлсан журмыг батлан мөрдөх шаардлагатай байх бөгөөд Компани нь энэхүү шаардлагыг хангах зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын төслийг боловсруулан, Хуулийн фирмд ирүүлсэн болно. Тус төсөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар хүргэх, мэдээлэх, хурлаас шийдвэр гаргах зэрэг харилцааг зохицуулсан нийт 12 бүлгээс бүрдэж байх бөгөөд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, СЗХ-ны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд тус тус нийцсэн байх тул журмын төсөл энэ хэвээрээ батлагдах нөхцөлд Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.3.2.3. Мэдээллийн ил тод байдлын журмын төсөл

СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.4, Компанийн засаглалын кодексийн 3 дугаар хэсэгт тус тус заасны дагуу хувьцаат компани нь мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан үйл ажиллагааны журамтай байх шаардлагатай бөгөөд Үнэт цаас





гаргагч нь энэхүү шаардлагыг хангах зорилгоор Мэдээллийн ил тод байдлын журмын төслийг боловсруулан, Хуулийн фирмд ирүүлсэн.

Хувьцаат компани хэлбэртэй компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 56 дугаар зүйл, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10 дугаар бүлэг, Компанийн засаглалын кодксийн 7.3 дугаар зүйл, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 21 дүгээр зүйл, МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам, Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх зааварт тус тус заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах ёстой. Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журмаар Үнэт цаас гаргагчаас тухай бүр болон тогтмол мэдээлэх мэдээлэл, түүнийг боловсруулах, түгээх журам, мэдээллийг нийтэд хүргэхэд тавигдах хязгаарлалттай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байх бөгөөд тус журам нь дээр дурдсан хууль тогтоомж, СЗХ болон МХБ-ийн журамд нийцэж байна.

Нэгтгэн дүгнэвэл: Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд, хувьцаат компанийн дүрмийн төсөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3.4. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх тухайд, мөн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх тухайд

3.4.1. Үнэт цаас гаргагчийн байгуулсан гэрээ хэлцлүүд

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Баримт бичгээс үзвэл Компанийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 3.4 дэх хэсэгт заасан агуулгад хамаарах дараах 26 гэрээ байна. Үүнд:

Хүснэгт №2. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан гэрээний мэдээлэл

№	Гэрээний нэр	Огноо	Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлд хамаарагдах эсэх	5%-ийн гэрээ
Худалдах, худалдан авах гэрээ				
1	Пут опционы гэрээ	2022.10.10	Үгүй	Тийм
Зээлийн гэрээ				
2	Зээлийн гэрээ	2022.01.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

3	Зээлийн гэрээ	2022.04.06	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
4	Зээлийн гэрээ	2022.08.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
5	Зээлийн гэрээ	2022.08.15	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
6	Зээлийн гэрээ	2022.05.19	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
7	Зээлийн гэрээ	2022.10.20	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
8	Зээлийн гэрээ	2022.11.10	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
9	Зээлийн гэрээ	2022.09.20	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
Үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээ				
10	Менежментийн гэрээ	2023.02.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
11	Менежментийн гэрээ	2023.02.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
12	Менежментийн гэрээ	2023.02.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
13	Менежментийн гэрээ	2023.02.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
14	Менежментийн гэрээ	2023.02.01	Сонирхлын зөрчилтэй хэлцэл	Тийм
15	Хувьцаа эзэмшигчдийн гэрээ	2023.04.10	Үгүй	Үгүй
16	Хувьцаа эзэмшигчдийн гэрээ	2020.01.16	Үгүй	Үгүй
5%-ийн бусад гэрээ				
17	Орон сууц захиалгын гэрээ	2022.07.19	Үгүй	Тийм
18	Орон сууц захиалгын гэрээ	2022.07.21	Үгүй	Тийм
19	Орон сууц захиалгын гэрээ	2022.07.25	Үгүй	Тийм
20	Орон сууц захиалгын гэрээ	2022.08.09	Үгүй	Тийм
21	Орон сууц захиалгын гэрээ	2022.01.26	Үгүй	Тийм





22	Түрээсийн гэрээ	2022.08.29	Үгүй	Тийм
23	Veritech ERP системийн дэмжлэг үйлчилгээний гэрээ	2022.10.01	Үгүй	Тийм
24	Аудитын үйлчилгээний гэрээ	2022.09.09	Үгүй	Тийм
25	Аудитын үйлчилгээний гэрээ	2022.09.09	Үгүй	Тийм
26	Ажлын байрны түрээсийн гэрээ	2021.03.17	Үгүй	Тийм

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 100,944,000 (нэг зуун сая есөн зуун дөчин дөрвөн мянга) төгрөг байх бөгөөд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 5,047,200 (таван сая дөчин долоон мянга хоёр зуун) төгрөг ба түүнээс дээш мөнгөн дүн байна.

Тасалбар болгох өдрийн байдлаар (буюу 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар) Үнэт цаас гаргагчийн байгуулсан хувьцаа эзэмшигчдийн гэрээнээс бусад дээрх хэлцлүүд нь Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээ (буюу 5,047,200 төгрөг ба түүнээс дээш хэмжээ)-ний үүрэг хүлээсэн хэлцэлд хамаарахаар байна.

Хуулийн фирм нь дээр дурдсан гэрээнүүдийг нэг бүрчлэн дараах байдлаар хянаад холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ. Тухайлбал:


Жич: Дээр заасан зарим гэрээнүүд нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байгаа тул тус хэлцлүүдтэй холбоотой дүгнэлтийг 3.5 дахь хэсгээс үзнэ үү.

3.4.1.1. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах-худалдан авах гэрээ буюу Пут опционы гэрээ хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

“Мандал Праявит Экүити Хувийн ХОС” ХХК (“Худалдагч”) болон Үнэт цаас гаргагч (“Хувьцаа авагч”) нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан **** тоот “Пут опционы гэрээ” гэрээ байгуулагдсан байна. Пут опционы гэрээний агуулгаас харах юм бол тус гэрээ нь Иргэний хуульд заасан нөхцөл заасан худалдах-худалдан авах гэрээний төрөлд хамаарахаар байна.

Энэхүү гэрээгээр Үнэт цаас гаргагчийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэг болох “Мандал Праявит Экүити Хувийн ХОС” ХХК буюу Худалдагч нь эзэмшиж буй тодорхой тооны энгийн хувьцаагаа Үнэт цаас гаргагчид буцаан худалдах эрх эдлэх ба тус гэрээгээр Худалдагч буцаан худалдах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, буцаан худалдах хувьцааны үнэ,





Б нөхцөл ямар байх талаар болон Үнэт цаас гаргагч тус хувьцааг буцаан худалдан авах үүрэг хүлээх талаар зохицуулсан байна. Тухайлбал, Худалдагч нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 2 хувьтай тэнцүү тооны хувьцааг Үнэт цаас гаргагчид буцаан худалдах эрхээ хэрэгжүүлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцааг заавал эргүүлэн худалдан авах үүрэг хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн Хуулийн фирмд ирүүлсэн Баримт бичигт болон Худалдагч талаас ирүүлсэн тодорхойлолтод дурдагдсанаар Худалдагч нь Пут опцион гэрээнд заасан эрхээ IPO-ийн дараа хэрэгжүүлнэ гэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 2 хувьтай тэнцүү тооны энгийн хувьцааг эргүүлэн худалдан авч халаасалж, “Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд ажилчдад худалдахаар төлөвлөж байна. “Мандал Праявит Эквити Хувийн ХОС” ХХК нь Үнэт цаас гаргагчийн 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй тул Пут опцион гэрээ нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй болно.

Пут опцион гэрээ нь Иргэний хуулийн 44 дүгээр зүйлд заасан болзол тавьж хийсэн хэлцэлд хамаарагддаг бөгөөд тус гэрээний хувьд Иргэний хуулийн 45 дугаар зүйлд заасан болзол тавьж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх нөхцөл байхгүй, Компанийн тухай хуулийн 40.2 дахь хэсэгт заасан нөхцөлүүд гэрээнд тусгагдсан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ.

Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд тус гэрээ нь хуульд нийцсэн бөгөөд Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байх тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй байна гэж дүгнэлээ.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон Баримт бичигт дурдагдсаны дагуу Тасалбар болгох өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь дээрхээс өөр хүчин төгөлдөр ямар нэгэн худалдах, худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулаагүй байна.

3.4.1.2. Үнэт цаас гаргагчийн байгуулсан зээлийн гэрээнууд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар


Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллийн дагуу Үнэт цаас гаргагч нь дараах хүснэгтэд дурдсан зээлийн гэрээ байгуулсан байна. Тухайлбал:

Хүснэгт №3 Үнэт цаас гаргагчаас өөрийн охин компаниуд болон тэдгээрийн зарим ажилтнуудтай байгуулсан зээлийн гэрээний талаарх мэдээлэл

№	Зээлдэгч	Гэрээ байгуулсан огноо	Зээлийн хэмжээ (төгрөгөөр)	Хүүгийн хэмжээ (жилээр)	Зээлийн хугацаа (сараар)
---	----------	------------------------	----------------------------	-------------------------	--------------------------



2023-06-14



1	Э.Сэргэлэн	2022.09.20	40,000,000	0%	36
2	Н.Эрдэнэбилэг	2022.01.01	113,379,873.10	0%	24
3	Н.Алтанзул	2022.04.06	500,000,000	0%	12
4	И.Цогбаяр	2022.08.01	60,000,000	0%	24
5	“Монложистик карго” ХХК	2022.08.15	100,000,000	14.4%	24
6	“Каус аустралис” ХХК	2022.05.19	1,500,000,000	0%	12
7	“Монложистик Карго” ХХК	2022.10.20	100,000,000	14.4%	24
8	“Монложистик Карго” ХХК	2022.11.10	50,000,000	14.4%	24

Үнэт цаас гаргагчийн зүгээс өөрийн охин компаниуд болон тэдгээрийн ажилтнуудтай байгуулсан дээрх зээлийн гэрээнүүд нь Иргэний хуулийн 281.1 дэх хэсэгт заасан зээлийн гэрээнд хамаарах ба Иргэний хуулийн 186.1, 282.1 дэх хэсгүүдэд тус тус заасны дагуу зээлийн гэрээг хүүтэй эсхүл хүүгүй байхаар талууд тохиролцон байгуулж болдог тул зарим гэрээг хүүтэй зарим гэрээг хүүгүй байгуулсан байна. Дээрх зээлийн гэрээнүүд нь Иргэний хуулийн 196.1.1, 282, 283.4 дахь хэсгүүдэд заасантай тус тус нийцсэн бөгөөд Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд тодорхойлсон хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байх тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй гэж дүгнэлээ.


Дээрх зээлийн гэрээнүүдэд Үнэт цаас гаргагч нь зээлдүүлэгч тал болон оролцсон байх бөгөөд Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулалт татах зорилгоор бусадтай аливаа зээлийн гэрээ байгуулаагүй байна. Дээрх зээлийн гэрээнүүд нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотой дүгнэлтийн дэлгэрэнгүйг энэхүү Дүгнэлтийн 3.5 дахь хэсгээс үзнэ үү.

3.4.1.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээнүүд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

3.4.1.3.1. Үнэт цаас гаргагчийн байгуулсан менежментийн гэрээнүүд

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллийн дагуу Үнэт цаас гаргагч нь дараах охин компаниудтай Менежментийн гэрээ байгуулсан байна. Үүнд:





1. Үнэт цаас гаргагч (“Үйлчилгээ үзүүлэгч”) болон Монложистикс Транзит ХХК (“Үйлчлүүлэгч”) нарын хооронд 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан 23/ҮАГ/06 тоот Менежментийн гэрээ;
2. Үнэт цаас гаргагч (“Үйлчилгээ үзүүлэгч”) болон Монложистикс Ворлдвайд ХХК (“Үйлчлүүлэгч”) нарын хооронд 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан 23/ҮАГ/07 тоот Менежментийн гэрээ;
3. Үнэт цаас гаргагч (“Үйлчилгээ үзүүлэгч”) болон Монложистикс Тракинг ХХК (“Үйлчлүүлэгч”) нарын хооронд 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан 23/ҮАГ/08 тоот Менежментийн гэрээ;
4. Үнэт цаас гаргагч (“Үйлчилгээ үзүүлэгч”) болон Каус Аустралис ХХК (“Үйлчлүүлэгч”) нарын хооронд 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан 23/ҮАГ/09 тоот Менежментийн гэрээ;
5. Үнэт цаас гаргагч (“Үйлчилгээ үзүүлэгч”) болон Монложистикс Карго ХХК (“Үйлчлүүлэгч”) нарын хооронд 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан 23/ҮАГ/10 тоот Менежментийн гэрээ.

Дээр дурдсан Менежментийн гэрээгээр нэг талаас Үйлчилгээ үзүүлэгч (буюу Үнэт цаас гаргагч) нь өөрийн хуримтлуулсан мэдлэг, өргөн туршлагад үндэслэн, өөрийн хүний нөөц болон техник технологийн хүчин чадлыг ашиглан Үйлчлүүлэгчийн зардлаар гэрээнд заасан менежментийн үйлчилгээг үзүүлэх, Үйлчлүүлэгч нь гэрээгээр тохирсон төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Үнэт цаас гаргагчийн 2022 оны борлуулалтын орлогын 1.32 хувийг эдгээр Менежментийн гэрээнүүд бүрдүүлдэг, түүнчлэн Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасан гол үйл ажиллагаа болох Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохицуулж буй гэрээ тул чухал ач холбогдол бүхий гэрээ гэж үзсэн болно.

Менежментийн гэрээ нь Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан Хөлсөөр ажиллах гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Түүнчлэн, энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд Менежментийн гэрээнүүд нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байх тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй гэж дүгнэлээ.

3.4.1.3.2. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Үнэт цаас гаргагч нь дараах Хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас гаргагчийн одоогийн зарим хувьцаа эзэмшигчид болох Л.Ганзоригт, Б.Тэлэнгэд, Г.Хишигбат, А.Одгэрэл, Л.Эрдэнэсоёл, Н.Алтанзул,





Н.Эрдэнэбилэг нарын хооронд 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр байгуулагдсан Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигчдийн хамтын ажиллагаатай харилцааг зохицуулсан “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” (цаашид “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ №1” гэх^{*});

- Үнэт цаас гаргагч болон Тянь Жин Хай Тие Лянь Жие Олон Улсын Тээврийн Ложистикс ХХК нарын хооронд 2020 оны 1 сарын 16-ны өдөр байгуулагдсан Монложистикс Транзит ХХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” (цаашид “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ-2” гэх).

Хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр компанийн хувьцаа эзэмшигчид нь компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотойгоор талуудын хүлээх эрх үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Тухайлбал, Хувьцаа эзэмшигчдийн гэрээ №1-ээр тус гэрээнд тал болон оролцсон хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарласан буюу тус хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн 5 хувиас дээш хэмжээний хувьцаагаа захиран зарцуулах бол гэрээний тал болсон хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид санал болгох үүрэгтэй байдлаар зохицуулсан байна. Түүнчлэн, тус гэрээний нэг дэх хэсэгт заасны дагуу тус хувьцаа эзэмшигчдийн гэрээ нь зөвхөн гэрээ байгуулагч талуудад хамааралтай буюу анхдагч зах зээлийн арилжааны үеэр болон түүний дараагаар Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах ирээдүйн хөрөнгө оруулагч нар тус гэрээний дагуу аливаа үүрэг хүлээхээргүй байна. Харин Хувьцаа эзэмшигчдийн гэрээ №2-ын хувьд Үнэт цаас гаргагч нь 50 хувийн хувьцааг нь эзэмшдэг охин компани болох Монложистикс Транзит ХХК-ийн нөгөө хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээ байх ба тус гэрээгээр компанийн үйл ажиллагаа, хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцаа эзэмшлийн бүтэц, талуудын хүлээх үүрэг, амлалт, удирдлага зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.1 дэх хэсэгт заасан хамтран ажиллах гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна.

Түүнчлэн, дээрх 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр тус гэрээний тал болон оролцсон хувьцаа эзэмшигчдийн 5 буюу түүнээс дээш хувийн хувьцааг ирээдүйд худалдан авах гуравдагч этгээдэд тавигдах нэмэгдүүлсэн шаардлагыг зааж өгсөн байх бөгөөд Иргэний хуулийн гэрээний эрх чөлөөт байдлын зарчимд заасны дагуу ийм агуулга бүхий гэрээг байгуулах боломжтой гэж үзлээ.

Энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд Хувьцаа эзэмшигчдийн гэрээ нь хуульд нийцсэн. Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр

* Жич: Энэхүү хувьцаа эзэмшигчдийн гэрээ нь Тасалбар болгох огноонд хамаарахгүй боловч хувьцаа эзэмшигчдийн гэрээг шинэчлэн байгуулсантай холбоотойгоор тус гэрээг нэмэлтээр хянаж өгөх хүсэлтийг Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсний дагуу Бид дээрх гэрээг хянасан болно.



2023-06-14

БҮРТГЭВ-03



бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байх тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар бий болоогүй гэж дүгнэв.

3.4.1.4. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх талаар

3.4.1.4.1. Үнэт цаас гаргагчийн байгуулсан орон сууц захиалгын гэрээ

Үнэт цаас гаргагчийн зүгээс ирүүлсэн дараах орон сууц захиалгын гэрээг ирүүлсэн болно. Үүнд:

- 1) Үнэт цаас гаргагч болон **** ХХК нарын хооронд 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдөр байгуулагдсан **** тоот Орон сууц захиалгын гэрээ;
- 2) Үнэт цаас гаргагч болон **** ХХК нарын хооронд 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр байгуулагдсан **** тоот Амины орон сууц захиалгын гэрээ;
- 3) Үнэт цаас гаргагч болон **** ХХК нарын хооронд 2022 оны 7 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан **** тоот Орон сууц захиалгын гэрээ;
- 4) Үнэт цаас гаргагч болон **** ХХК нарын хооронд 2022 оны 8 дугаар сарын 09-ний өдөр байгуулагдсан **** тоот Орон сууц захиалгын гэрээ;
- 5) Үнэт цаас гаргагч болон **** ХХК нарын хооронд 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн **** тоот Орон сууц захиалгын гэрээ.

Компанийн байгуулсан дээрх 5 гэрээ нь Орон сууц захиалгын гэрээ гэж нэрлэсэн байх хэдий ч гэрээний шинж чанар, гэрээнд тусгагдсан талуудын эрх, үүргээс үзвэл гэрээний нэг тал нь орон сууцны барилгыг тодорхой хугацаанд барьж ашиглалтад хүлээлгэн өгөх, үүний хариуд тохиролцсон байдлаар хөлсийг бетон зуурмаг, бараа материал нийлүүлэх байдлаар төлөхөөр заасан байгаа нь Монгол Улсын Иргэний хуулийн 343.1 дэх хэсэгт заасан ажил гүйцэтгэх гэрээний шинжийг агуулж байна.


Гэрээнүүдийн хувьд Иргэний хуулийн 195.3 дахь хэсэгт заасны дагуу ажил гүйцэтгэх гэрээний гол нөхцөлүүд болох гэрээний үнэ болон гэрээний зүйлийг тусгасан байна. Түүнчлэн, талуудыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан байгаа нь Иргэний хуулийн 40.1 дэх хэсэг, 62.1 дэх хэсэг, 196.1.2 дахь хэсэгт нийцсэн, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзвэл Иргэний хуулийн 56 дугаар зүйлээс 60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, гэрээ хууль тогтоомжид нийцэж байх ба Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй болно.

3.4.1.4.2. Хөлсөөр ажиллах гэрээ



2023-06-14

БҮРТГЭВ-03



**** ХХК (“Нийлүүлэгч”) болон Үнэт цаас гаргагч (“Үйлчлүүлэгч”) нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 1-ны өдөр байгуулсан **** тоот VERITECH ERP системийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулагдсан байна.

VERITECH ERP системийн дэмжлэг үзүүлэх гэрээ нь Үнэт цаас гаргагч (“Үйлчлүүлэгч”) болон **** ХХК (“Нийлүүлэгч”) нарын хооронд 2022 оны 10 дугаар сарын 1-ны өдөр байгуулагдсан байна. Энэхүү гэрээгээр нэг талаас Нийлүүлэгч нь “Санхүү, нягтлан бодох бүртгэл, Цалингийн удирдлагын систем, Цаг бүртгэлийн систем, Core HR систем, хүний нөөцийн сонгон шалгаруулалтын систем”-үүдийг ашиглах хүрээнд мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, Үйлчлүүлэгч нь харилцан тохиролцсон хөлс төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Тус гэрээ нь Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Түүнчлэн, энэхүү дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд тус гэрээнд Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцэж байх ба Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй болно.

3.4.1.4.3. Үнэт цаас гаргагч (“Үйлчлүүлэгч”) болон ** ХХК (“Аудитор-1”) нарын хооронд 2022 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан **** тоот “Аудитын үйлчилгээний гэрээ” мөн Үнэт цаас гаргагч (“Үйлчлүүлэгч”) болон **** ХХК (“Аудитор-2”) нарын хооронд 2022 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан **** тоот “Аудитын үйлчилгээний гэрээ”**

Дээрх 2 аудитын гэрээнүүдийн дагуу Аудитор нь Үнэт цаас гаргагч болон түүний компанийн нэгдлийн оролцогч компаниудын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргах, нөгөө талаас Үнэт цаас гаргагч нь харилцан тохиролцсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээснээс үзвэл уг гэрээ нь Иргэний хуулийн 359.1 дэх хэсэгт тусгагдсан хөлсөөр ажиллах гэрээнд хамаарахаар байна. Талуудын хооронд байгуулагдсан дээрх гэрээ нь Иргэний хуульд заасан хөлсөөр ажиллах гэрээнд тусгавал зохих гол нөхцөлийг тусгасан байхаас гадна Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан гол нөхцөлийг бүрэн тусгасан байна. Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд Аудитын гэрээнүүдэд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна.

Түүнчлэн, энэхүү дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд тус гэрээнд Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцэж байх ба Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй болно.





Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Үнэт цаас гаргагч (“Түрээслэгч”) нь дараах түрээсийн гэрээг байгуулсан байна. Үүнд:

- 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн МГ-21/12 тоот Ажлын байрны түрээсийн гэрээ;
- 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн Түрээсийн гэрээ.

Дээр заасан түрээсийн гэрээнүүдийн дагуу нэг талаас түрээслүүлэгч нь Түрээслэгчийн эзэмшил ашиглалтад тодорхой эд хөрөнгийг шилжүүлэх, Түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд Иргэний хуулийн 318 дугаар зүйлд заасан түрээсийн гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байна. Түүнчлэн, Иргэний хуульд үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг бичгээр байгуулж, эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлэхээр заасан хэдий ч үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг буюу талбай түрээслэх тохиолдолд түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн шаардлага тавигдахгүй тул Үнэт цаас гаргагчийн байгуулсан дээрх гэрээнүүд нь улсын бүртгэлд бүртгэгдэх шаардлагагүй болохыг дурдах нь зүйтэй байна.

Иймд эдгээр түрээсийн гэрээ нь Иргэний хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ. Энэхүү дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд тус гэрээнүүд нь Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцэж байх ба Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй болно.

3.4.2. Үнэт цаас гаргагчийн охин компани болох Ворлдвайдын байгуулсан гэрээнүүд

Ворлдвайд нь Хуулийн фирмд ирүүлсэн мэдээлэл болон Баримт бичигт дурдагдсанаар компанийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах 46гэрээний мэдээллийг ирүүлсэн болно. Үүнд:


Хүснэгт №4. Ворлдвайдын бусадтай байгуулсан гэрээний мэдээлэл

№	Гэрээний нэр	Огноо	Гэрээний тоо	5%-ийн гэрээ
Худалдах, худалдан авах гэрээ				
1.	Өрийн хэрэгсэл худалдах-худалдан авах гэрээ	2022.07.08	21	Тийм



2023-06-14

БҮРТГЭЭВ-03



2.	Өрийн хэрэгсэл худалдах-худалдан авах гэрээ	2022.07.29	9	Тийм
Зээлийн гэрээ				
3.	Зээлийн гэрээ	2021.12.20	1	Тийм
4.	Зээлийн нэмэлт гэрээ	2022.06.23	1	Тийм
5.	Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээ	2023.04.05	1	Тийм
6.	Овердрафтын эрх нээх гэрээ	2021.12.20	1	Тийм
7.	Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны нэмэлт гэрээ	2023.04.05	1	Тийм
Үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээ				
8.	Олон улсад олон төрлийн контейнер тээвэрлэх тухай агентын гэрээ	2023.01.01	1	Үгүй
9.	Олон улсад олон төрлийн контейнер тээвэрлэх тухай агентын гэрээний нэмэлт гэрээ	2023.01.01	1	Үгүй
10.	Ачаа тээвэрлэлтийн гэрээ	2022.05.10	1	Үгүй
11.	Салбар зам, гаалийн хяналтын талбайд ажил үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо хийх тухай гэрээ	2022.08.12	1	Үгүй
12.	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	2022.11.23	1	Үгүй
13.	Салбар зам, гаалийн хяналтын талбайд ажил үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо хийх тухай гэрээ	2023.01.27	1	Үгүй
14.	Менежментийн гэрээ	2023.02.01	1	Үгүй
5%-ийн бусад гэрээ				
15.	Даатгалын гэрээ	2022.12.22	1	Тийм
16.	Ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах гэрээ	2022.05.06	1	Тийм
17.	Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх мастер гэрээ	2021.10.08	1	Тийм
18.	Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ	2022.05.02	1	Тийм



2023-06-14

БҮРТГЭВ-03



Хуулийн фирм нь дээр дурдсан гэрээнүүдийг нэг бүрчлэн дараах байдлаар хянаад холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэлээ. Тухайлбал:

3.4.2.1 Худалдах-худалдан авах гэрээ хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

Ворлдвайдаас 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах нийт 21 гэрээ (буюу бонд гаргах гэрээ), 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах нийт 9 гэрээ (буюу бонд гаргах гэрээ)-г ирүүлсэн байна.

Эдгээр гэрээ нь МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 8 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдаж, СЗХ-ны даргын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 168 дугаар тушаалаар батламжлагдсан Биржийн бус зах зээлийн тухай журмын 2.1.1 дэх хэсэгт заасан санхүүгийн хэрэгслийг харилцан шууд худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан байна.

Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээний хувьд андеррайтерын компани нь зуучлагч, зохицуулагчийн хувиар оролцдог, тодорхой хүү тооцож хуваарийн дагуу төлөлт хийдэг онцлог зохицуулалттай гэрээ байдаг.

Эдгээр гэрээнүүдийг нэгтгэн дүгнэвэл худалдагчаас бонд худалдах, худалдан авагч нь төлбөрийг хэсэгчлэн тодорхой хуваарийн дагуу төлөхөөр зохицуулсан байгаа нь Монгол Улсын Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгт заасан худалдах-худалдан авах гэрээний шинжийг хангаж байна. Тодруулбал, худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээсэн харилцаа байдаг. Худалдах-худалдах авах гэрээнд талууд Иргэний хуулийн 198.2 дахь хэсэгт заасны дагуу гэрээний чөлөөт байдлын зарчмын хүрээнд үнийг хэсэгчлэн болон бүтнээр төлөхөөр тохиролцож болно.

Худалдах, худалдан авах гэрээний хувьд Иргэний хуулийн 195.3 дахь хэсэгт заасны дагуу гэрээний гол нөхцөлүүд болох гэрээний үнэ болон гэрээний зүйлийг тусгасан байна. Түүнчлэн, талуудыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирал, нөгөө талаас тухайн худалдагч авагч, андеррайтер компанийн гүйцэтгэх захирал нар нь хэлцэлд гарын үсэг зурсан байгаа нь Иргэний хуулийн 40.1 дэх хэсэг, 62.1 дэх хэсэг, 196.1.2 дахь хэсэгт нийцсэн байна.

Түүнчлэн, МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 22/41 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.4.1, 3.4.4 дэх хэсэгт заасны дагуу Ворлдвайд нь өрийн хэрэгслээ баталгаа эсхүл барьцааны гэрээгээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүднээс



2023-06-14

БҮРТГЭВ-03

СЗХ

он сар өдөр

дээрх гэрээнүүдэд холбогдох 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн Б/22/09 тоот Батлан даалтын гэрээгээр нь Ворлдвайдын гаргасан өрийн хэрэгслийн гэрээгээр тогтоосон төлбөрийн үүргийг Ворлдвайд нь гүйцэтгэж чадах болохыг Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж, гүйцэтгэхгүй бол өөрийн эд хөрөнгө, аливаа дансанд дахь мөнгөн хөрөнгөөр хариуцах үүрэг хүлээсэн байна. Дээрх үүргийн гүйцэтгэлийг хангах арга нь Иргэний хуулийн 234 дэх хэсэгт заасантай нийцсэн байх ба энэхүү гэрээний дүгнэлтийг Ворлдвайдын байгуулсан их хэмжээний хэлцэлд холбогдох дүгнэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Аж ахуйн нэгжийн бусадтай байгуулсан гэрээ нь хэрэв нэг талаас урьдчилан тогтоосон гэрээний нөхцөлөөр байгуулагдсан тохиолдолд Иргэний хуулийн 200.1 стандарт нөхцөл болох бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 202.1, 202.2 дахь хэсэгт заасны дагуу харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байх шаардлага тавигддаг. Үүнийг шалгавал эдгээр гэрээнүүд нь нэг талд хэт хохиролтой буюу шударга ёс, тэгш эрхийн зарчимд харш нөхцөл тусгагдаагүй байгаагаас гадна Иргэний хуулийн 56-60 дахь хэсэгт заасан хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох нөхцөл тусгагдаагүй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3.4.2.2 Ворлдвайдын бусадтай байгуулсан зээлийн гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

3.4.2.2.1 Зээлийн гэрээний талаар

(i) Ворлдвайд нь Худалдаа хөгжлийн банктай 2,500,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий зээлийг “эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх” зорилгоор зээлэхээр тохиролцож 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **** тоот зээлийн гэрээг байгуулсан байна.

2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай **** тоот гэрээ байгуулж зээлийн хэмжээг 1,000,000,000 төгрөг болгож бууруулан, үүргийн гүйцэтгэлийг хангах барьцааны дүнд мөн өөрчлөлт оруулсан байна.

Уг гэрээнд зээлдэгч буюу Ворлдвайд нь зээлийг, хүүгийн хамт гэрээнд заасан хугацаанд төлөх, хэрэв хуваарийн дагуу зээлийг төлөөгүй тохиолдолд нэмэгдүүлсэн хүүт төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүднээс байгуулсан барьцааны гэрээ, гэрээг цуцлах үндэслэл, журмын талаар зохицуулсан байна.


Ворлдвайдын арилжааны банктай байгуулсан дээрх зээлийн гэрээ нь Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1 болон 452.2, мөн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгүүдэд заасантай тус тус нийцсэн байна.

(ii) Ворлдвайдын эргэлтийн хөрөнгийн дутагдал болон санхүүгийн түр зуурын хэрэгцээг хангах зориулалтаар Ворлдвайдын дансанд 300,000,000 төгрөгийн үнийн дүн



2023-06-14

БҮРТГЭВ-03



бүхий овердрафтын эрх нээх гэрээг Ворлдвайд болон Худалдаа хөгжлийн банк нар 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна.

Уг гэрээнд банк нь Ворлдвайддын харилцах дансанд овердрафтын эрх нээх, түүний хугацаа, хүүгийн болон нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг тохиролцох, Ворлдвайд нь овердрафтын эрхийн дагуу тохиролцсон хэмжээнд зээл авах буюу өөрийн харилцах дансны үлдэгдлээс хэтрүүлж бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Ворлдвайддын арилжааны банктай байгуулсан дээрх гэрээ нь Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, 452.2, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгүүдэд заасан зээлийн гэрээний шинжийг агуулж байх тул хуульд заасан шаардлагыг хангаж байна.

Ворлдвайд нь дээрх Зээлийн гэрээнүүдийн мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах үүднээс Иргэний хуулийн 231 дүгээр зүйлийн 231.1.4 дэх хэсэгт тусгагдсан дараах барьцааны гэрээг байгуулсан байна. Үүнд: Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээнүүдийн дагуу 2,500,000,000 төгрөг болон 300,000,000 төгрөгийн борлуулалтын болон дансны орлогыг тус тус барьцаалсан байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээгээр барьцаалуулагчийн борлуулалтын болон дансны орлого зэрэг нь барьцааны зүйл байхаар заасан нь Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.3 дахь хэсэгт: *“Барьцаа үүсэх үед тодорхойлж болох ирээдүйд бий болох, болзол тавьсан шаардлагыг, эсхүл талуудын харилцан тохиролцсон аливаа үүргийг хангахад барьцааг хэрэглэж болно.”*, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт: *“Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хоронгө, нь барьцааны зүйл байж болно.”* хэмээн заасантай тус тус нийцэж байна. Барьцаа нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу зохих ёсоор улсын бүртгэлд бүртгэгдсэн байх тул барьцааны эрх баталгаажсан байна. Барьцааны гэрээнд тусгагдсан барьцааг баталгаажуулах талаарх холбогдох зохицуулалт Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд тодорхойлсон хэлцэл хүчин төгөлдөр бус байх эсхүл хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл илрээгүй, гэрээний хэрэгжилт хэвийн байна.

Түүнчлэн, дээрх зээлийн гэрээ, тэдгээрийн барьцаа гэрээнүүд нь Ворлдвайддын хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээнд хамаарч байна.

Иймд Ворлдвайддын арилжааны банктай байгуулсан Зээлийн гэрээ болон холбогдох барьцааны гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцсэн байна.





Дүгнэвэл, сүүлийн 3 жилийн байдлаар Ворлдвайд нь дээрх 2 зээлийн гэрээнээс өөр аливаа зээлийн гэрээг арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллага эсхүл бусад аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнтэй байгуулаагүй байна.

3.4.2.3 Ворлдвайдын бусадтай байгуулсан чухал ач холбогдол бүхий гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар

Ворлдвайдаас нийт 11 гэрээ ирүүлснээс Тасалбар болгосон өдрийн байдлаар чухал ач холбогдол бүхий нийт 9 гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгааг Хуулийн фирм нь хянан дүгнэсэн болно. Үүнд:

3.4.2.3.1 Тээвэрлэлтийн гэрээ

Хуулийн фирм нь Ворлдвайдын бусадтай байгуулсан i) Ворлдвайд (“Тээвэрлэгч”) болон **** ХХК нарын хооронд 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан **** тоот Ачаа тээвэрлэлтийн гэрээг хянасан болно.

Энэхүү гэрээгээр Тээвэрлэгч нь Улаанбаатар хот дотор тодорхой заасан, тохиролцсон маршрутад тээвэрлэгчийн тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг шуурхай, найдвартай, чанартай зохион байгуулах, үүний хариуд тохиролцсон үйлчилгээний хөлс төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байх бөгөөд гэрээний зохицуулалтууд нь Иргэний хуулийн 380 дугаар зүйлд заасан тээвэрлэлтийн гэрээний зохицуулалтад нийцэж байна. Тээвэрлэлтийн гэрээнд анз, торгууль тооцох нь тухайн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох эрсдэл үүсгэдэг онцлог гэрээ тул энэхүү шаардлагыг зайлшгүй шалгах шаардлагатай бөгөөд энэхүү гэрээнд Иргэний хуулийн 232 дугаар зүйлд заасан анз тооцоогүй, мөн Иргэний хуулийн 397.2-д заасны дагуу тээвэрлэлтийн эрсдэлийн талаарх илгээгчийн хийлгэх даатгалын талаар зохицуулсан буюу Гэрээний 4.3-т тээвэрлэгч тал нь ачаа тээврийн хариуцлагын даатгалд хамрагдсан байхаар зохицуулсан нь хуульд нийцсэн байна.

Түүнчлэн, гэрээнд талуудыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирлууд гарын үсэг зурж, тамгаар баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 40.1 дэх хэсэг, 62.1 дэх хэсэг, 196.1.2 дахь хэсэгт нийцсэн байна. Талууд тээвэрлэлтийн гэрээнд тусгах шаардлагатай гэрээний гол нөхцөл болох тээвэрлэлтийн зүйл, нөхцөл, гэрээний үнийг тусгасан байгаа нь Иргэний хуулийн 195.3 дахь хэсэгтэй нийцэж байна.

Иймд Ворлдвайдын бусадтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсэхээргүй байна гэж дүгнэлээ.

Дээрх тээвэрлэлтийн гэрээнүүдээс гадна Үнэт цаас гаргагч нь гадаадын тээврийн компани, агентуудтай i) 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн **** тоот Олон улсад олон төрлийн контейнер тээвэрлэх тухай агентын гэрээ, ii) 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн **** тоот Олон улсад олон төрлийн контейнер тээвэрлэх тухай агентын



2023-06-14

БҮРТГЭВ-03

СЗХ

Ом Сар Өдөр

гэрээний нэмэлт гэрээ №1 гэрээг байгуулсан байх бөгөөд эдгээр гэрээнүүд нь гадаад улсын хууль тогтоомжоор зохицуулагдахаар заасан байх тул Хуулийн фирмийн зүгээс дээрх зээлийн гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дүгнэх боломжгүй болно.

3.4.2.3.2 Гаалийн хяналтын талбайд ажил үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо хийх тухай гэрээ


Хуулийн фирм нь (i) Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан **** тоот **** ХХК-ийн эзэмшлийн салбар зам, гаалийн хяналтын талбайд ажил үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо хийх тухай гэрээ; (ii) Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан **** тоот Үйлчилгээ үзүүлэх гэрээ, iii) Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан **** тоот Үйлчилгээ үзүүлэх тухай гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ эсэхэд дүгнэлт хийсэн болно.

Дээрх гэрээнүүдэд Үйлчлэгчийн эзэмшлийн салбар зам, гаалийн хяналтын талбай, гаалийн баталгаат агуулах, техник тоног төхөөрөмжийг ашиглан ажил үйлчилгээ үзүүлэх, нөгөө талаас Үйлчлүүлэгч буюу Үнэт цаас гаргагч нь хөлс төлөхөөр тохиролцсон харилцааг зохицуулсан байна. Ворлдвайддын бизнесийн үндсэн үйл ажиллагаа нь олон улсын тээвэр зуучлал, төмөр замын тээвэр зуучлал, гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа, автомашинаар ачаа тээвэрлэх үйл ажиллагаа тул эдгээр үйлчилгээ үзүүлэх гэрээнүүд нь Ворлдвайддын өдөр тутмын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх чухал ач холбогдолтой гэрээнүүд болно. Үйлчилгээ үзүүлэх гэрээнүүд нь Гаалийн тухай хуулийн 3.1.18, 260.1 дэх хэсэг, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/294 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналтын бүсийн журам”-ын 3.3.2 дахь хэсэгт заасан гаалийн хяналтын бүсэд аж ахуйн нэгж байгууллагын бараа, тээврийн хэрэгсэл хадгалах, ачих, буулгах, бараа ялгах ангилах талбай, агуулах үйлчилгээг үзүүлэхээр байгуулагдсан гэрээ байна.

Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн 189.5 дахь хэсгийн дагуу Иргэний хуульд тусгагдсан аль нэг гэрээний төрөлд хамаарагдахгүй, нэрлэгдээгүй гэрээ байх бөгөөд гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг харилцан тэнцвэртэй зохицуулсан нь гэрээний эрх зүйн суурь зарчим болон Иргэний хуулийн 56-60 дахь хэсэгт тусгагдсан хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцогдох үндэслэл байхгүй байна.

Үүргийн гүйцэтгэлийг хангах аргын хувьд (ii) Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан **** тоот Үйлчилгээ үзүүлэх гэрээний хувьд үйлчлүүлэгч нь тогтоосон хугацаанд үйлчилгээний хөлсөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.5%-ийн алданги төлөх, (i) Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан **** тоот **** ХХК-ийн эзэмшлийн салбар зам, гаалийн хяналтын талбайд





ажил үйлчилгээ үзүүлэх, төлбөр тооцоо хийх тухай гэрээний хувьд дансанд байршуулсан дүн нь дуусаж хасах руу орсон тохиолдолд байршуулагдаагүй үнийн дүнгээс хоног тутамд 0.3%-ийн алданги төлөхөөр зохицуулсан нь Иргэний хуулийн 232.4, 232.6 дахь хэсэгт заасан анз, алдангийн талаарх хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

Иймд дээрх гэрээнүүдийг нэгтгэн дүгнэвэл Гаалийн тухай хууль, “Гаалийн хяналтын бүсийн журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр, Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсээгүй байна.

3.4.2.3.3 Менежментийн гэрээ

“Монложистикс холдинг” ХХК болон Ворлдвайд болох “Монложистикс Ворлдвайд” ХХК-уудын хооронд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан Менежментийн гэрээг Үнэт цаас гаргагчийн байгуулсан менежментийн гэрээнүүдийг хянасан дүгнэлтэд дүгнэсэн байх тул уг гэрээний хууль тогтоомжид нийцсэн, Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эсэх талаарх дүгнэлтийг Үнэт цаас гаргагчийн байгуулсан менежментийн гэрээнүүд хэсгээс үзнэ үү.

Нэгтгэн дүгнэвэл, Ворлдвайдын бусадтай байгуулсан чухал ач холбогдол бүхий дээрх гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр, Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсэхээргүй байна гэж дүгнэсэн болно.

3.4.2.4 Ворлдвайдын хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн бусад гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх талаар

ХЭУБГ-ийн лавлагаагаар Ворлдвайдын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Тасалбар болгох өдрийн байдлаар 3,277,451,079 (гурван тэрбум хоёр зуун далан долоон сая дөрвөн зуун тавин нэгэн мянга далан есөн төгрөг) төгрөг байх ба Ворлдвайдын хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 163,872,553 (нэг зуун жаран гурван сая найман зуун далан хоёр мянга таван зуун тавин гурван төгрөг) төгрөг ба түүнээс дээш мөнгөн дүн байна.

Тасалбар болгох өдрийн байдлаар Ворлдвайд нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээ (буюу 163,872,553 төгрөг ба түүнээс дээш хэмжээ)-ний үүрэг хүлээсэн дараах гэрээг байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт №5. Ворлдвайдын хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээний мэдээлэл



2023-06-14

№	Гэрээний нэр	Үнэ	Гэрээ байгуулсан огноо	Хэрэгжиж буй эсэх
1	Даатгалын гэрээ	4,885,000,000	2022.12.22	Тийм
2	Ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах гэрээ	220,000,000	2022.05.06	Тийм
3	Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх мастер гэрээ	Тухай бүр нэхэмжлэх	2021.10.08	Тийм
4	Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ	Тухай бүр захиалгын хуудас	2022.05.02	Тийм

Ворлдвайдаас бусадтай байгуулсан Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээг дүгнэвэл:

3.4.2.4.1 Даатгалын гэрээ

Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр **** тоот Байгууллагын ерөнхий хариуцлага, тээвэр зуучлагчийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулагдсан байна.

Дээрх гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчийн буюу Ворлдвайдын бусад учруулсан хохирлыг арилгахад шаардлагатай, хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүрэгтэй байх бөгөөд гэрээг Иргэний хуулийн 431.3 дахь хэсэгт заасны дагуу бичгээр байгуулсан.

Түүнчлэн, Иргэний хуулийн 431.4 дэх хэсэгт заасан даатгалын гэрээнд зайлшгүй тусгах нөхцөлүүдийг тус гэрээнд тусгасан байх тул хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ. Тасалбар болгох өдрийн байдлаар Компаниас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзэхэд хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцсэн, Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй болно.

3.4.2.4.2 Ивээн тэтгэгчийн гэрээ

Ворлдвайд болон **** ХХК нарын хооронд 2022 оны 5 дугаар сарын 06-ны өдөр **** тоот Ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулагдсан байна.

Уг гэрээ нь Ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах гэрээ гэж нэрлэсэн байх хэдий ч гэрээний шинж чанар, гэрээнд тусгагдсан талуудын эрх, үүргээс үзвэл энэхүү гэрээгээр гэрээний нэг тал **** телевиз нь **** реалити шоу нэвтрүүлгийн ивээн тэтгэгчээр хамтран





ажиллах ивээн тэтгэгчийн сурталчилгаа, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв нэвтрүүлэх, ивээн тэтгэгч нь харилцан тохиролцсон төлбөрийг төлөх, нэвтрүүлэгт оролцогчдын бүртгэлийг зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж төлбөрийг 100 хувь өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр төлж барагдуулахаар заасан байгаа нь Монгол Улсын Иргэний хуулийн 359.1 дэх хэсэгт тусгагдсан хөлсөөр ажиллах гэрээнд хамаарахаар байна.

Талуудын хооронд байгуулагдсан дээрх гэрээ нь хөлсөөр ажиллах гэрээнд тусгавал зохих гол нөхцөлийг тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Түүнчлэн үүргийн гүйцэтгэлийг хангах аргын хувьд аль нэг тал нь гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-ийн алданги тооцохоор тусгасан нь Иргэний хуулийн 232.4, 232.6 дахь хэсэгт заасан алдангийн хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

Ворлдвайдаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний агуулгаас үзвэл Иргэний хуулийн 56 дугаар зүйлээс 60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцсэн, Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй байна.

3.4.2.4.3 Тээвэр зуучлалын гэрээ

Ворлдвайдаас ирүүлсэн мэдээллээс үзвэл Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа дараах тээвэр зуучлалын гэрээ хэрэгжиж байна. Үүнд:

- i) 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн Г-22/013 тоот Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ;
- ii) 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх мастер гэрээ.

Эдгээр гэрээгээр Ворлдвайдыг төлөөлөн улс хоорондын болон орон нутгийн ачаа тээврийг шуурхай, найдвартай, чанартай зохион байгуулах, үйлчлүүлэгч нь гэрээнд заасны дагуу төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байх бөгөөд гэрээний зохицуулалтууд нь Иргэний хуулийн 380 дугаар зүйлд заасан тээвэрлэлтийн гэрээний зохицуулалтад нийцэж байна. Тээвэрлэлтийн гэрээ нь анз, торгууль тооцох нь тухайн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох эрсдэл үүсгэдэг онцлог гэрээ энэхүү шаардлагыг зайлшгүй шалгах шаардлагатай бөгөөд энэхүү гэрээнд Иргэний хуулийн 232 дугаар зүйлд заасан анз тооцоогүй, мөн Иргэний хуулийн 397.2-д заасны дагуу тээвэрлэлтийн эрсдэлийн талаарх илгээгчийн хийлгэх даатгалын талаар зохицуулсан байна.





Түүнчлэн, гэрээнд талуудыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирлууд гарын үсэг зурж, тамгаар баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 40.1 дэх хэсэг, 62.1 дэх хэсэг, 196.1.2 дахь хэсэгт нийцсэн байна. Талууд тээвэрлэлтийн гэрээнд тусгах шаардлагатай гэрээний гол нөхцөл болох тээвэрлэлтийн зүйл, нөхцөл, гэрээний үнийг тусгасан байгаа нь Иргэний хуулийн 195.3 дахь хэсэгтэй нийцэж байна.

Иймд Ворлдвайдын бусадтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй, гэрээний хэрэгжилт хэвийн, хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Ворлдвайдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл илрээгүй гэж дүгнэлээ.

3.4.3. Үнэт цаас гаргагчийн охин компани болох Экүйпментсийн байгуулсан гэрээнүүд

Экүйпментсээс Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээс үзвэл 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар тус компанийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аливаа гэрээ, хэлцэл байхгүй байна.

3.5. Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх тухай

3.5.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон Баримт бичигт дурдсаны дагуу Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхол бүхий этгээдтэй тус хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан дараах сонирхлын зөрчил бүхий хэлцлүүдийг байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт №6. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй гэрээний мэдээлэл

№	Гэрээний нэр	Гэрээ байгуулагч тал, түүний сонирхлын зөрчлийн хамаарал	Гэрээ байгуулсан огноо	Баталсан шийдвэр
1	Батлан даалтын гэрээ	Охин компанийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор “Мандал капитал маркетс ҮЦК” ХХК-тай байгуулсан. Хэлцлийн үр шимийг Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани	2022.05.02	ТУЗ-ийн 2022 оны 4 сарын 28-ны өдрийн 8-002-2022BOD/20220428 болон 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоолууд



2023-06-14

БҮРТГЭВ-03



		болох Ворлдвайд хүртэж байгаа хэлцэл		
2	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Карго” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Э.Сэргэлэнтэй байгуулсан хэлцэл	2022.09.20	ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
3	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, мөн “Монложистикс Транзит” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Н.Эрдэнэбилэгтэй хийсэн хэлцэл	2022.01.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
4	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, мөн “Монложистикс Тракинг” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Н.Алтанзултай хийсэн хэлцэл	2022.04.06	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
5	Зээлийн гэрээ	“Монложистикс Ворлдвайд” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан И.Цогбаяртай хийсэн хэлцэл	2022.08.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
6	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Карго” ХХК-тай байгуулсан хэлцэл	2022.08.15	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
7	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Каус Аустралис” ХХК-тай байгуулсан хэлцэл	2022.05.19	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
8	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани	2022.10.20	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн



2023-06-14

БҮРТГЭЭ-03




	№ 01	болох “Монложистикс Карго” ХХК-тай байгуулсан хэлцэл		23/ТУЗ/09 тоот тогтоол
9	Зээлийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Карго” ХХК-тай байгуулсан хэлцэл	2022.11.10	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
10	Менежментийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Каус Аустралис” ХХК-тай байгуулсан хэлцэл	2023.02.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
11	Менежментийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Карго” ХХК-тай байгуулсан хэлцэл	2023.02.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
12	Менежментийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Тракинг” ХХК-тай байгуулсан хэлцэл	2023.02.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
13	Менежментийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох “Монложистикс Транзит” ХХК-тай байгуулсан хэлцэл	2023.02.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол
14	Менежментийн гэрээ	Үнэт цаас гаргагчийн 100 хувийн охин компани болох Ворлдвайдтай байгуулсан хэлцэл	2023.02.01	2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоол

Дээр байгуулсан 14 хэлцэл нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгийн дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байх тул мөн зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүд батлах шаардлагатай.

Хуулийн фирмийн зүгээс дээрх хэлцлийг хянан шалгахад хуульд заасан журмыг баримтлан байгуулаагүй байсан тул Үнэт цаас гаргагчид эдгээр хэлцлийг Компанийн тухай хуулийн 92.1 дэх хэсэгт заасан журмаар батлуулах тухай зөвлөмж хүргүүлсний дагуу Үнэт





цаас гаргагчийн ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй гишүүд нь 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 23/ТУЗ/09 тоот тогтоолоор дээр дурдсан 14 хэлцлийг хожим дэмжин хүлээн зөвшөөрч шийдвэрлэсэн болно. Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасны дагуу эрх олгогдоогүй этгээдийн хийсэн үйлдлийг бүрэн эрх бүхий этгээд хожим дэмжин хүлээн зөвшөөрснөөр тухайн үйлдлийг хүчин төгөлдөр гэж үзэх тухай зохицуулалт байдаг тул дээрх сонирхлын зөрчил бүхий хэлцлийг зохих ёсоор хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан гэж дүгнэлээ.

Дээрх хүснэгтийн 1 дэх хэсэгт заасан Батлан даалтын гэрээний талаарх дэлгэрэнгүй дүгнэлтийг 3.5.2 дахь хэсэг, харин 2-14 дэх хэсэгт заасан гэрээнүүдийн талаарх дэлгэрэнгүй дүгнэлтийг 3.4 дэх хэсгээс тус тус үзнэ үү.

3.5.2. Их хэмжээний хэлцэл

Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн мэдээлэл, Баримт бичигт дурдсанаар Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн балансын активын 25 хувийн тоон үзүүлэлт дараах байдалтай байна. Тухайлбал:

Хүснэгт №7. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн балансын активын 25%-ын тоон үзүүлэлт.

№	Хугацаа	Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр)	Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр)
1	2019 оны дөрөвдүгээр улирал	209,397,253.16	52,349,313.29
2	2020 оны нэгдүгээр улирал	2,323,685,566.46	580,921,391.62
3	2020 оны хоёрдугаар улирал	2,205,672,370.95	551,418,092.74
4	2020 оны гуравдугаар улирал	2,318,859,751.32	579,714,937.83
5	2020 оны дөрөвдүгээр улирал	2,342,947,606.77	585,736,901.69
6	2021 оны нэгдүгээр улирал	3,574,713,308.14	893,678,327.04
7	2021 оны хоёрдугаар улирал	4,845,037,813.01	1,211,259,453.25
8	2021 оны гуравдугаар улирал	4,788,825,210.17	1,197,206,302.54
9	2021 оны дөрөвдүгээр улирал	7,846,117,965.34	1,961,529,491.34
10	2022 оны нэгдүгээр улирал	9,901,268,614.91	2,475,317,153.73
11	2022 оны хоёрдугаар улирал	10,592,028,718.13	2,648,007,179.53





2023-06-14

12	2022 оны гуравдугаар улирал	10,881,663,479.93	2,720,415,869.98
13	2022 оны дөрөвдүгээр улирал	10,632,364,650.24	2,658,091,162.56

БҮРТГЭВ-03

Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд 87.1.1 дэх хэсэгт: “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/”; мөн хуулийн 87.1.2 дахь хэсэгт: “компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг” гэж тус тус тодорхойлсон байдаг.

Иймд Үнэт цаас гаргагч нь Тасалбар болгох өдрийн байдлаар сүүлийн 3 жилийн хугацаанд дараах их хэмжээний хэлцлүүдийг байгуулсан байна. Үүнд:

1. “Мандал капитал Маркетс ҮЦК” ХХК (“Үүрэг гүйцэтгүүлэгч”), “Монложистикс Ворлдвайд” ХХК (“Үнэт цаас гаргагч”), “Монложистикс Карго” ХХК, “Монложистикс Транзит” ХХК, “Монложистикс Тракинг” ХХК, “Монложистикс Россия Холдинг” ХХК болон Үнэт цаас гаргагч (“Батлан даагч”) нарын хооронд 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдсан Батлан даалтын гэрээ;
2. Мандал Прайвит Экүйти Хувийн ХОС” ХХК (“Хувьцаа худалдагч”) болон Үнэт цаас гаргагч (“Хувьцаа худалдан авагч”) нарын хооронд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байгуулагдсан Хувьцаа худалдах-худалдан авах гэрээ.

Хуулийн фирм нь дээрх хэлцлийг Компанийн тухай хуулийн 88.1 дэх хэсэгт заасныг үндэслэл болгон дараах байдлаар дүгнэлээ. Үүнд:

3.5.2.1. Батлан даалтын гэрээ

2022 оны 5 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдсан дээрх Батлан даалтын гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь өөрийн охин компани болох Ворлдвайддын биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл (буюу бонд) гаргасантай холбоотойгоор Ворлдвайддын гаргасан өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр, Андеррайтерийн гэрээгээр тогтоосон төлбөрийн үүргийг Ворлдвайд гүйцэтгэж чадах болохыг Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж, гүйцэтгэхгүй бол өөрийн эд хөрөнгө, аливаа данс дахь мөнгөн хөрөнгөөр хариуцах үүрэг хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 8-002-2022BOD/20220428 тоот шийдвэрээр дээрх хэлцлийг батлах зөвшөөрлийг санал нэгтгэйгээр гаргасны дагуу Үнэт цаас гаргагч (“Батлан даагч”) нь 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдөр





“Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК (“Үүрэг гүйцэтгүүлэгч”) болон Ворлдвайд (*Үнэт цаас гаргагч*)-тай **** тоот Батлан даалтын гэрээг байгуулсан байна.

Хожим тус гэрээнд 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн **** тоот “Батлан даалтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ”-ний дагуу нэмэлт өөрчлөлт орсон байна. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Үнэт цаас гаргагч нь Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийг өөрийн охин компаниуд болох “Монложистикс Карго” ХХК, “Монложистикс Транзит” ХХК, “Монложистикс Тракинг” ХХК, “Монложистикс Россия Холдинг” ХХК нартай хамтран батлан даах үүрэг хүлээсэн байна. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 10-001-2022BOD/20220630 тоот тогтоолоор санал нэгтэй баталсан байх тул Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцлийг батлах журмын дагуу зохих ёсоор байгуулагдсан гэж дүгнэлээ.

Түүнчлэн, Батлан даалтын гэрээ нь агуулгын хувьд Иргэний хуулийн 45 дугаар бүлэгт заасан нийтлэг шаардлагад харшлаагүй, гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг бүрэн тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ.

Иймд Батлан даалтын гэрээ нь хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулагдсан гэж дүгнэлээ.

3.5.2.2. Хувьцаа худалдах-худалдан авах гэрээ

Энэхүү Хувьцаа худалдах-худалдан авах гэрээгээр нэг талаас Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан энгийн хувьцааны 8 хувьтай тэнцүү хэмжээний хувьцааг гэрээнд заасан үнээр эргүүлэн худалдан авах, нөгөө талаас Хувьцаа худалдагч нь тус хувьцааг шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд агуулгын хувьд тус гэрээ нь Иргэний хуулийн 243 дугаар зүйл болон Компанийн тухай хуульд заасан нийтлэг агуулгад нийцсэн, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажин, нотариатаар гэрчлэгдсэн байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан гэж үзлээ.

Түүнчлэн, уг хэлцэл нь хувьцаа шилжүүлэхтэй холбоотой хэлцэл учир хэлцлийг батлах шийдвэрийг ТУЗ-ийн хурлаар биш харин Компанийн тухай хуулийн 49.10-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх нь зохимжтой. Иймд Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 2-005-2022ХЭХ/20221111 тоот хурлын шийдвэрээр санал нэгтэйгээр баталсан байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.10, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт заасан шаардлагад тус тус нийцсэн байх тул хуульд заасан журмын дагуу байгуулагдсан гэж дүгнэлээ.



2023-06-14

БҮРТГЭЭВ-03



Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн гэж дүгнэлээ.

3.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх тухай

3.6.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх талаар

3.6.1.1. Үнэт цаас гаргагчийн тухайд:

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 2.12 дахь хэсэг болон ХЭУБГ-ын 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 23900002001925 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

1. Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
2. Бизнесийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
3. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй дээрх үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй буюу Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байна. Харин Үнэт цаас гаргагч нь ХЭУБГ-рт бүртгэгдсэнээр дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой болох ба энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь хүчинтэй, ХЭУБГ-т бүртгэгдсэн компанийн дүрэм болон лавлагаагаар үйл ажиллагааг хугацаагүй эрхэлж байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа дуусгавар болоогүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл үүсээгүй байна.

3.6.1.2. Ворлдвайдын тухайд:

Ворлдвайдын дүрмийн 1.6 дахь хэсэг болон ХЭУБГ-ийн 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 23250002002096 тоот лавлагаанаас үзвэл тус Ворлдвайд нь дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

1. Автомашинаар ачаа тээвэрлэх;
2. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа;
3. Төмөр замын тээвэр зуучлал;





Дээрхээс үзвэл Ворлдвайд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг байх бөгөөд тус компанийн эрхэлдэг бусад үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй байна. Тодруулбал:

3.6.1.2.1. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа:


Хүснэгт №8. Ворлдвайдны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж буй үйл ажиллагааны мэдээлэл

№	Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны нэр	Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр/тогтоолын огноо, дугаар	Гэрчилгээний дугаар	Хугацаа
1	Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа	Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 78 дугаар тушаал	14/34	2023.7.5

Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдал: Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэгт заасны дагуу гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд гаалийн байгууллага хяналт тавих бүрэн эрхтэй байх бөгөөд Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 2-2/491 тоот албан бичгээс үзвэл тус албан бичиг гарах өдрийн байдлаар дээрх тусгай зөвшөөрөлтэй холбоотой ямар нэгэн гомдол маргаан байхгүй, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна. Иймд тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл байхгүй гэж дүгнэлээ.

Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх: Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19 дэх хэсэгт: “Хуульд зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн 18-д зааснаас бусад зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно.” гэж, Гаалийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 дэх хэсэгт: “Энэ хуулийн 66.2-т заасан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.” гэж тус тус зааснаас үзвэл гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх барьцаалах зэргээр аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах боломжгүй байна. Түүнчлэн, Ворлдвайдаас Хуулийн фирмд ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 382 тоот “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичгээр





тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээгээгүй тухайгаа мэдэгдсэн тул Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээлгээгүй байна.

Тусгай зөвшөөрлийн хугацаа: Зөвшөөлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Гаалийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт заасны дагуу гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгодог байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухай бүр хугацааг сунгуулдаг байна. Тусгай зөвшөөрлийн цахим системээс 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр олгосон Тусгай зөвшөөрлийн тодорхойлолтоос үзвэл тусгай зөвшөөрөл нь 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд хүчинтэй байх бөгөөд хэрэв хуульд заасан шаардлага болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байх нөхцөлд дээр заасны дагуу Ворлдвайд нь тусгай зөвшөөрлийн хугацааг тухай бүр сунгуулах боломжтой байна.

Нэгтгэн дүгнэвэл Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байх бөгөөд тус тусгай зөвшөөрөл цуцлагдах аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэрэг нөхцөл байдал бидэнд мэдэгдээгүй тул Ворлдвайдны үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй гэж дүгнэв.

3.6.1.2.2. Төмөр замын тээвэр зуучлал:

Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа биш байх боловч Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалын арван нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”-ын 2.2.9 дэх хэсэгт заасны дагуу энэхүү үйл ажиллагаа нь гэрчилгээний үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа байх тул тусгай зөвшөөрөлтэй адилтган авч үзэж доорх байдлаар дүгнэлээ. Тодруулбал:

Хүснэгт №9. Ворлдвайдны гэрчилгээний үндсэн дээр эрхэлж буй үйл ажиллагааны мэдээлэл

№	Гэрчилгээний үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны нэр	Гэрчилгээ олгосон шийдвэр/тогтоолын огноо, дугаар	Гэрчилгээний дугаар	Хугацаа
1	Төмөр замын тээвэр зуучлал	Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 2 дугаар зүйлийн 7-ны өдрийн А/22 дугаар тушаал	22/A22/115	2025.1.31



2023-06-14

БҮРТГЭЭВ-03



Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний хүчин төгөлдөр байдал:

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмын 1.4, 6.2 болон 6.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох үндэсний үндэсний стандартад нийцүүлэн гэрчилгээжүүлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлдэг байна. Иймд Хуулийн фирм нь Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэхийг холбогдох эрх, бүхий байгууллагаас тодруулах замаар дүгнэсэн болно. Тухайлбал, Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн 2023 оны 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 08/904 тоот албан бичиг болон Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвөөс ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 60 тоот албан бичгээс тус тус үзвэл эдгээр байгууллагуудад компанийн тусгай зөвшөөрлийг цуцлах нөхцөл байдал бүртгэгдээгүй байна. Иймд тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд цуцлагдах үндэслэл байхгүй гэж дүгнэлээ.

Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээтэй холбоотойгоор аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх:

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмын 5.1.8 дахь хэсэгт: “энэхүү журмын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.” гэж заасан байх тул төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх барьцаалах зэргээр аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах боломжгүй байна. Түүнчлэн, Ворлдвайд нь 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 382 тоот “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичгээр гэрчилгээтэй холбоотой аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээгээгүй тухайгаа Хуулийн фирмд мэдэгдсэн тул Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээлгээгүй байна.

Гэрчилгээний хугацаа:

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмын 4.8 дахь хэсэгт заасны дагуу төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээг 3 жилийн хугацаагаар олгодог байх бөгөөд тус журмын 5.2.1 дэх хэсэгт заасан журмын дагуу гэрчилгээ эзэмшигч нь тухай бүр хугацааг сунгуулдаг байна. Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгосон 22/A22/115 тоот Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээнд заасны дагуу Ворлдвайдын төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ нь 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хүчинтэй байх бөгөөд дээр заасны дагуу Ворлдвайд нь хууль болон зөвшөөрлийн нөхцөл шаардлагат тусгагдсан шаардлагыг хангаж байх нөхцөлд тусгай зөвшөөрлийн хугацааг тухай бүр сунгуулах боломжтой байна.





Нэгтгэн дүгнэвэл төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ нь хүчин төгөлдөр байх бөгөөд тус гэрчилгээ цуцлагдах аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэрэг нөхцөл байдал бидэнд мэдэгдээгүй тул Ворлдвайдын үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй гэж дүгнэв.

3.6.1.3 Экуйпментсийн тухайд:

Экуйпментсийн дүрмийн 1.6.1 дэх хэсэг болон ХЭУБГ-ын 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 23900002000486 тоот лавлагаанаас үзвэл тус компани нь дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

1. Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.

Экуйпментсийн эрхэлж буй дээрх үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй буюу тус компани нь үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байна. Иймд Экуйпментс нь ХЭУБГ-рт бүртгэгдсэнээр дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой болох ба энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Экуйпментсийн үйл ажиллагаа нь хүчинтэй, ХЭУБГ-рт бүртгэгдсэн компанийн дүрэм болон лавлагаагаар үйл ажиллагааг хугацаагүй эрхэлж байна. Экуйпментсийн үйл ажиллагаа дуусгавар болоогүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл үүсээгүй байна.

3.6.2. Зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бүй эсэх талаар

3.6.2.1. Үнэт цаас гаргагчийн тухайд:

Оюуны өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт: “Зохиогч сайн дурын үндсэн дээр өөрийн бүтээлийн мэдээллийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж болно.”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт: “Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохих журмын дагуу энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3 дахь хэсэгт заасан зүйлийг бүртгэж патент, 7.1.4, 7.1.5 дахь хэсэгт заасан зүйлийг бүртгэж гэрчилгээ тус тус олгоно.” хэмээн тус тус заасны дагуу Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн зохиогчийн эрх болон түүнд хамаарах бүтээл, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээ бий эсэх, байгаа бол тэдгээр патент, гэрчилгээ нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар үүрэг хүлээсэн эсэхийг нягталсан болно.





2023-06-14

БҮРТГЭЭЖ А/07-03

Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн санг үүсгэх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт: “Оюуны өмчийн газар нь цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл бүртгэх, хөтлөх, шинэчлэх, мэдээллийн нэгдсэн сангаас оюуны өмчийн холбогдох хууль, журамд нийцүүлэн мэдээллийг түгээх, цахимаар хэвлэн нийтлэх үйл ажиллагааг зохион байгуулна.” хэмээн заасны дагуу (i) Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн <https://publish.ipom.mn> цахим сан, (ii) Зохиогчийн эрхийн цахим мэдээллийн <http://copyright.ipom.mn> цахим сангаас Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмчийн эрхийн талаар бидний зүгээс судалгаа хийсэн болно. Мөн Оюуны өмчийн газраас ирүүлсэн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/144 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Компанийн нэр дээр бүртгэгдсэн зохиогчийн эрхэд хамаарах бүтээл болон патент олгосон шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар байхгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн нэр дээр нийт 1 (нэг) барааны тэмдэг бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт №10. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдэж эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдгийн мэдээлэл

№	Барааны тэмдэг	Анхдагч огноо	Хүчинтэй байх хугацаа
1.		2021.05.20	2031.05.20

Хуулийн фирм нь дээр дурдсан барааны тэмдэгт нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэхийг Оюуны өмчийн газраас ирүүлсэн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/144 тоот “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн 2023 оны 4 дүгээр сарын 25-ний өдрийн 23/ЗХНХ/125 тоот албан бичиг болон нийтэд нээлттэй мэдээллүүдийг ашиглан дараах байдлаар дүгнэлээ. Тодруулбал:

Хүчин төгөлдөр байдал:

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй барааны тэмдгийн хүчинтэй байх хугацаа дуусаагүй, Үнэт цаас гаргагч татан буугдаагүй, эрх нь бусад этгээдэд шилжээгүй, Үнэт цаас гаргагч барааны тэмдгийг хүчингүй болгуулах хүсэлт гаргаагүй байх тул Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг эзэмшигчийн эрх Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр байна.

Барьцааны үүрэг үүссэн эсэх тухайд:





эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд хийсэн судалгаагаар энэхүү Дүгнэлтийг бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй оюуны өмчийн эрхүүдэд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн албан бичигт Үнэт цаас гаргагч нь тус барааны тэмдэгтэд аливаа үүрэг ногдуулаагүй, барьцаалаагүй талаар мэдэгдсэн болно. Иймд Үнэт цаас гаргагчийн барааны тэмдэгтэд аливаа үүрэг ногдуулаагүй, барьцаалаагүй байна.

Оюуны өмчийн эрхүүдтэй холбоотой хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа эсэх тухайд:

Шүүхийн тусгай архивын 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 1/375 тоот лавлагаа, Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба олон улсын арилжааны арбитрын 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А-23/12 тоот тодорхойлолт, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 4/206 тоот тодорхойлолт болон Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 163 тоот тодорхойлолтоос үзвэл Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй дээр дурдсан оюуны өмчийн эрхтэй холбоотой хүчин төгөлдөр арбитрын болон шүүхийн шийдвэр байхгүй байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн дээр дурдсан оюуны өмчийн эрх нь хүчин төгөлдөр байх бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй байна.

3.6.2.2. Ворлдвайдын тухайд:

(i) Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн <https://publish.ipom.mn> цахим сан, (ii) Зохиогчийн эрхийн цахим мэдээллийн <http://copyright.ipom.mn> цахим сангаас Ворлдвайдын нэр дээр бүртгэгдсэн, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмчийн эрхийн талаар бидний зүгээс хийсэн судалгаа болон Оюуны өмчийн газраас ирүүлсэн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/142 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Ворлдвайдын нэр дээр бүртгэгдсэн зохиогчийн эрхэд хамаарах бүтээл болон аж үйлдвэрийн өмч байхгүй байна.

Иймд тус компанийн болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болохуйц хүчин зүйл байхгүй гэж дүгнэлээ.


3.6.2.3. Экүйпментсийн тухайд:

(i) Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн <https://publish.ipom.mn> цахим сан, (ii) Зохиогчийн эрхийн цахим мэдээллийн <http://copyright.ipom.mn> цахим сангаас Экүйпментсийн нэр дээр бүртгэгдсэн, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмчийн эрхийн



2023-06-14

БҮРТГЭЭС-03



Талаар бидний зүгээс хийсэн судалгаа болон Оюуны өмчийн газраас ирүүлсэн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/143 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Экүйпментсийн нэр дээр бүртгэгдсэн зохиогчийн эрхэд хамаарах бүтээл болон аж үйлдвэрийн өмч байхгүй байна.

Иймд тус компанийн болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд бодитой нөлөөлж болохуйц хүчин зүйл байхгүй гэж дүгнэлээ.

Нэгтгэн дүгнэвэл:

Үнэт цаас гаргагч, түүний охин компаниуд болох Ворлдвайд болон Экүйпментсийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, Зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмч нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй байна.

3.7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх тухай

Хуулийн фирмийн зүгээс энэхүү хэсгийн Дүгнэлтийг (i) үнэт цаас, (ii) үл хөдлөх эд хөрөнгө, (iii) бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл болон аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан хөдлөх эд хөрөнгө гэсэн 3 хүрээнд хуваан бэлтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчаас гадна түүний охин компаниуд болох Ворлдвайд” ХХК болон Экүйпментс нарыг хамруулан доорх байдлаар дүгнэсэн болно. Үүнд:

3.7.1. Үнэт цаас өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар

Хуулийн фирм нь үнэт цаас гэдгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасан санхүүгийн хэрэгслүүдийн хүрээнд авч үзсэн болно. Үнэт цаас гаргагчаас болон холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн доорх баримт бичгээс үзвэл Үнэт цаас гаргагч, түүний охин компаниуд болох Ворлдвайд болон Экүйпментс нар нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасан аливаа үнэт цаас эзэмшээгүй байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 23/ХН/64 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг;
- Ворлдвайдын 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 419 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг;
- Экүйпментсийн 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 23/ТЗ/21 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 1/315 тоот албан бичиг;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 1/316 тоот албан бичиг;



2023-06-14

БҮРТГЭВ-03



• Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 1/317 тоот албан бичиг.

3.7.2. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар

Үнэт цаас гаргагч, түүний охин компаниуд болон холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн доорх баримт бичгээс үзвэл Үнэт цаас гаргагч, түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нарын эзэмшил, өмчлөлд аливаа газрын эрх, бусад үл хөдлөх эд хөрөнгө байдаггүй байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн 2023 оны 02 дугаар сарын 1-ний өдрийн 23/ХН/64 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг;
- Ворлдвайддын 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 419 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг;
- Экүйпментсийн 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 23/Ј3/21 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг;
- УБЕГ-ийн 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 02/08-1 тоот Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаа;
- УБЕГ-ийн 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 02/08-2 тоот Эд хөрөнгө бүртгэлгүй тухай лавлагаа;
- УБЕГ-ийн 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 02/08-3 тоот Эд хөрөнгө бүртгэлгүй тухай лавлагаа.

3.7.3. Авто тээврийн хэрэгсэл болон бусад хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар

3.7.3.1. Үнэт цаас гаргагчийн тухайд:

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон Авто тээврийн үндэсний төвийн 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр авто тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байна.

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 23/3ХНХ/103 тоот Мэдээлэл хүргэх тухай албан бичгээс үзвэл 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар Компани нь нийт 1,106,846,020.91 (нэг тэрбум нэг зуун зургаан сая найман зуун дөчин зургаан сая хорин төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөдлөх бусад эд хөрөнгө (тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгсэл гэх мэт)-тэй байна. Үнэт цаас гаргагчийн хөдлөх эд хөрөнгө (тухайлбал, оффисын хэрэглээ, ахуйн хэрэглээ, тоног төхөөрөмж гэх мэт)-ийн өмчлөх эрхийг холбогдох байгууллагад бүртгэдэггүй тул хөндлөнгийн байр сууринаас баталгаажуулах боломжгүй байна.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд хийсэн судалгаагаар 2023 оны 4





2023-06-14

7-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй дээрх дүгээр сарын хөдлөх эд хөрөнгөнд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн аливаа хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүднээс бусдад барьцаалсан, үүрэг хүлээсэн зүйл байхгүй болохыг Үнэт цаас гаргагч 2023 оны 2 дугаар сарын 1-ны өдрийн 23/ХН/64 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичгээр Хуулийн фирмд мэдэгдсэн болно.

Иймд Үнэт цаас гаргагчийн хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр байгаа бөгөөд тэдгээртэй холбоотой аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн, барьцаалсан зүйл байхгүй байна гэж дүгнэлээ.

3.7.3.2. Ворлдвайдын тухайд:

Авто тээврийн үндэсний төвийн 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн лавлагаанаас үзвэл Ворлдвайдын нэр дээр дараах авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Үүнд:

Хүснэгт №11. Ворлдвайдын өмчлөл дэх авто тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн улсын дугаар	Марк/ модель	Үүрэг ногдуулсан хэлцэл бий эсэх
1.	44 84 УБР	Honda Pilot	Үгүй
2.	84 01 УАО	Toyota Hiace	Үгүй
3.	84 02 УАО	Hino Ranger U-GD3HJAA	Үгүй

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1[†] дэх хэсэгт заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд бүртгүүлдэг ба уг бүртгэлд хийсэн судалгаанаас үзвэл 2023 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Ворлдвайдын нэр дээр бүртгэлтэй дээрх тээврийн хэрэгслүүдийг барьцаалсан мэдэгдэл тус цахим санд бүртгэгдээгүй байна.

Ворлдвайдын 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Хуулийн фирмд ирүүлсэн ГЗ/527 тоот албан бичгээс үзвэл 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар тус компани нь дээр дурдсан авто тээврийн хэрэгслийг оролцуулан нийт 9,110,823,052.33 (есэн тэрбум нэг зуун арван сая найман зуун хорин гурван мянга тавин хоёр тогрог гучин гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөдлөх бусад эд хөрөнгө (машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгсэл гэх мэт) бүртгэлтэй байна. Ворлдвайдын санхүүгийн тайланд тусгагдсан хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг холбогдох

[†] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг: "Цахим мэдээллийн санд бүртгэгдсэн барьцааны мэдэгдэл нийтэд нээлттэй болсон үеэс хүчин төгөлдөр болно."



2023-06-14

байгууллагад бүртгэдэггүй тул хөндлөнгийн байр сууринаас баталгаажуулах боломжгүй байна.

Ворлдвайдын 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 419 тоот албан бичиг болон хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд бүртгэгдсэн мэдээллээс үзвэл 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар Ворлдвайдын ирээдүйд олох 2 тэрбум 800 сая төгрөгийн орлогыг барьцаалснаас бусад хөдлөх эд хөрөнгөнд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна. Тодруулбал Ворлдвайд нь өөрийн ирээдүйд дансаар болон борлуулалтаас ирээдүйд орж ирэх 2 тэрбум 800 сая төгрөгийн орлогыг Худалдаа хөгжлийн банкинд 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр барьцаалсан байна.

Иймд Ворлдвайдын хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр байгаа бөгөөд тус компани нь ирээдүйн 2 тэрбум 800 сая төгрөгийн орлогоос бусад эд хөрөнгөтэй холбоотой аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн, барьцаалсан зүйл байхгүй байна гэж дүгнэлээ.

3.7.3.3. Экүйпментсийн тухайд:

Экүйпментсээс ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн 23/J3/21 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг болон Авто тээврийн үндэсний төвийн 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн лавлагаанаас үзвэл Экүйпментсийн нэр дээр авто тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байх бөгөөд тус компани нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан мөнгөн хөрөнгө болох арван сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна.

Экүйпментсээс ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн 23/J3/21 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг болон хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд бүртгэгдсэн мэдээллээс үзвэл 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар тус компанийн нэр дээр бүртгэлтэй дээрх мөнгөн хөрөнгөнд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна.

Иймд Экүйпментсийн хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр байгаа бөгөөд тэдгээртэй холбоотой аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн, барьцаалсан зүйл байхгүй байна гэж дүгнэлээ.

3.8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх тухай

Үнэт цаасны танилцуулга нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, СЗХ-ны Бүртгэлийн журмын 3.5, Биржийн бүртгэлийн журмын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой.





Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны танилцуулга нь нийт үндсэн 5 бүлгээс бүрдэх бөгөөд үнэт цаасны танилцуулгад заавал тусгах суурь мэдээллийг бүрэн багтаасан байх тул холбогдох хууль, журамд нийцэж байна гэж үзэж болохоор байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг оролцогч этгээдүүдийн үүсгэн байгуулах болон бусад баримт бичиг, мөн холбогдох хууль тогтоомж, журамтай тулган шалгах, оролцогч этгээдүүд болон төрийн эрх бүхий байгууллагаас тодруулга, лавлагаа авах замаар шалгахад түүнд тусгагдсан хууль зүйн мэдээллүүд нь тухайн баримт бичигтэй нийцэж байх тул үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан хууль зүйн мэдээллийг хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна гэж дүгнэлээ. Үнэт цаасны танилцуулгатай холбоотой дэлгэрэнгүй хууль зүйн шишжилгээ, дүгнэлтийг Хавсралт №2-оос үзнэ үү.

3.9. Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох нь


Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гэдэгт хэнийг хамааруулан тооцох талаар тодорхойлон зааж өгөөгүй байдаг. Түүнчлэн, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулиар хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч гэдэгт компанийн хяналтыг хэрэгжүүлж буй этгээдийг агуулгын хувьд хамруулан авч үзсэн байна. Иймд Хуулийн фирмийн зүгээс компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд болон эцсийн өмчлөгчийг агуулгын хувьд нэгтгэн авч үзэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль болон УБЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/1270 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам”-ын хүрээнд тодорхойлон дүгнэсэн болно.

ХЭУБГ-ын 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр олгосон 23900002001925 тоот лавлагаа болон 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр бүртгэгдсэн Үнэт цаас гаргагчийн дүрмээс үзвэл Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №12. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Хувьцаа эзэмшигч	Тоо ширхэг	Нийт үнэ	Дүрмийн санд эзлэх хувь
1	Л.Ганзоригт	110,520,000	33,156,000	32.85%
2	Б.Тэлэнгэд	110,520,000	33,156,000	32.85%
3	Г.Хишигбат	31,560,000	9,468,000	9.38%
4	А.Одгэрэл	31,560,000	9,468,000	9.38%
5	Л.Эрдэнэсоёл	15,000,000	4,500,000	4.46%
6	Н.Алтанзул	15,000,000	4,500,000	4.46%





2023-06-14

БҮРТГЭВ-01

7 01	Н.Эрдэнэбилэг	15,000,000	4,500,000	4.46%
8	"Мандал праявит экүйти хувийн ХОС" ХХК	7,320,000	2,196,000	2.18%


Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт: "эцсийн өмчлөгч" гэдэгт "харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг" ойлгохоор тусгасан. Мөн хуулийн 4¹ хэсэгт компанийн эцсийн өмчлөгчийг тогтоох дарааллыг зохицуулсан байх бөгөөд 4^{1.1.1} дэх хэсэгт: "хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг" гэж заасан байх бөгөөд Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журмын 3.1.1 дэх хэсэгт "тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа этгээд"-ийг эцсийг өмчлөгчид тооцон бүртгэхээр заасан байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа этгээдийг компанийн хяналтыг хэрэгжүүлэгч мөн эцсийн өмчлөгч этгээд гэж тооцсон болно. Хөрөнгийн дийлэнх хэсэг гэдэгт Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 4.3 дахь хэсэгт заасны дагуу "нийт хувьцааны 33 хувь буюу түүнээс дээш хувь"-ийг авч үзлээ.

Үнэт цаас гаргагчийн дүрэм, ХЭУБГ-ын 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр олгосон 23900002001925 лавлагаа, Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэгдлээс үзвэл дараах этгээдүүд нь Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч мөн эцсийн өмчлөгч байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчид болох Л.Ганзоригт болон Г.Хишигбат нар.
Үндэслэл: Л.Ганзоригт болон Г.Хишигбат нар нь гэр бүлийн гишүүд байх бөгөөд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 4.5.2 дахь хэсэгт тусгагдсаны дагуу гэр бүлийн нэг гишүүний эзэмшиж байгаа хувийг гэр бүлийн бусад гишүүдийн эзэмшиж байгаа хувьтай нэгтгэн бүхэлд нь авч үзэх нь зүйтэй байна. Иймд Л.Ганзоригт болон Г.Хишигбат нар нь хамтдаа Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 42.23 хувийг эзэмшиж байх тул Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч мөн эцсийн өмчлөгч этгээдүүд мөн гэж үзэв.
2. Хувьцаа эзэмшигч Б.Тэлэнгэд.





2023-06-14

Үндэслэл: Б.Тэлэнгэд нь дангаар Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 32.85 (≈33) хувь буюу бүхэл оронд хөрвүүлбэл 33 хувийг эзэмшиж байх тул Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээд мөн гэж үзлээ.

3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай


Үнэт цаас гаргагч болон түүний нэгдлийн оролцогч компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нар нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай доорх дүгнэлтийг Хуулийн фирм нь холбогдох эрх, бүхий байгууллагаас лавлагаа мэдээлэл авах замаар бэлтгэсэн болно.

3.10.1. Иргэний хэргийн маргаан

- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 4/205, 4/206, 4/207 тоот тодорхойлолтоос үзвэл тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нар нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.
- Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба олон улсын арилжааны арбитрын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А-23/10, А-23/11, А-23/12 тоот тодорхойлолтуудаас үзвэл Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нар нь тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 1/374, 1/375, 1/376 тоот лавлагаанд дурдсанаар Үнэт цаас гаргагч болон Ворлдвайд, Экүйпментс нар нь сүүлийн гурван жилийн байдлаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 0005248, 0005247, 0005246 тоот лавлагаанд дурдсанаар Үнэт цаас гаргагч болон Ворлдвайд, Экүйпментс нар нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй байна.

Иймд дээрх мэдээллийн хүрээнд Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нар нь аливаа иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд





2023-06-14

БАНГАР-03

оролцож байгаагүй буюу хариуцагчаар татагдаж шийдвэрлэгдсэн аливаа маргаан байхгүй байна.

3.10.2. Захиргааны хэргийн маргаан

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 163, 164, 165 тоот тодорхойлолтуудаас үзвэл Үнэт цаас гаргагч болон Ворлдвайд, Экүйпментс нар нь сүүлийн гурван жилийн хугацаанд тус шүүхэд хянан шийдвэрлэгдсэн захиргааны хэрэгт нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр оролцож байгаагүй байна.

3.10.3. Эрүүгийн хэргийн маргаан

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээний шуурхай удирдлагын албанаас ирүүлсэн 2023 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай болон хүлээж байгаа эсэх тухай лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч болон Ворлдвайд, Экүйпментс нар нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүйн дээр тодорхойлолт гаргах өдрийн байдлаар эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байна.

3.10.4. Өрсөлдөөний хууль зөрчсөн үндэслэлээр аливаа торгууль оногдуулсан эсэх

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нар нь Өрсөлдөөний тухай хуулийг зөрчиж захиргааны хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах зорилгоор нэмэлт судалгаа хийсэн бөгөөд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 03-04/170, 03-04/171, 03-04/172 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч болон Ворлдвайд, Экүйпментс нар нь зах зээлд давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоогдоогүй бөгөөд Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн үндэслэлээр аливаа захиргааны хариуцлага хүлээж байгаагүй байна.


Дээрхээс дүгнэвэл: Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй байна.

3.11. Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ор төлбөртэй эсэх тухай

3.11.1. Үнэт цаас гаргагч

Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 0005248 тоот тодорхойлолт, Гаалийн ерөнхий газрын 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тухай тодорхойлолт, Монголын татварын албаны 2023





оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 22.1003.d145b811-7a2f-4331-b34e-48a3909e3b60 тоот Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолт, 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Аж ахуй нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх O2321/15K260023134396 тоот тодорхойлолтод тус тус дурдсанаар Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.

3.11.2. Ворлдвайд

Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 0005246 тоот тодорхойлолт, Гаалийн ерөнхий газрын 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тухай тодорхойлолт, Монголын татварын албаны 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 22.1003.10855d2a-be58-4d81-b987-77dc9c7e66e6 тоот Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолт, 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Аж ахуй нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх O2337/18G00000632635 тоот тодорхойлолтод тус тус дурдсанаар Ворлдвайд нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.

3.11.3. Экүйпментс

Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 0005247 тоот тодорхойлолт, Гаалийн ерөнхий газрын 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тухай тодорхойлолт, Монголын татварын албаны 2023 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 22.1003.629d3f6a-f56f-4f9b-9724-4f629e2e0797 тоот Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолт, 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Аж ахуй нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх ON2345Q44Z28000967688 тоот тодорхойлолтод тус тус дурдсанаар Экүйпментс нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.

Нэгтгэн дүгнэвэл: Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд болох Ворлдвайд, Экүйпментс нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.



2023-06-14

БҮРТГЭВ-03



Гомбосүрэнгийн Батжаргал
Хуульч, нөхөрлөлийн гишүүн

Идэрхангайн Учралбаяр

Гүйцэтгэх захирал, хуульч, нөхөрлөлийн гишүүн

2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр



65

303






Grant Thornton



Нэгтгэсэн Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

“Мон Ложистикс Холдинг” ХХК

2022 оны 12 дугаар сарын 31





Агуулга

Группийн талаарх мэдээлэл	1
Удирдлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	7
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)	8
Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	9
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)	12
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд	13
1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл	13
2. Монголын бизнесийн орчин	13
3. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал	14
4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	17
5. Салбар компанид оруулсан хөрөнгө оруулалт	28
6. Сегментийн тайлагнал	29
7. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр	29
8. Бусад эргэлтийн бус хөрөнгө	30
9. Урт хугацаат хөрөнгө оруулалт	31
10. Биет бус хөрөнгө	31
11. Үндсэн хөрөнгө	32
12. Бараа материал	32
13. Урьдчилж төлсөн зардал/тооцоо	33
14. Дансны болон бусад авлага	33
15. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	33
16. Капитал ба нөөц	35
17. Санхүүгийн түрээс	36
18. Хойшлогдсон татварын хөрөнгө	37
19. Бусад богино хугацаат өр төлбөр	37
20. Зээл	38
21. Урьдчилж орсон орлого	39





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

22. Дансны ба бусад өглөг	39
23. Орлого	39
24. Өртөг	40
25. Бусад орлого	40
26. Борлуулалт, маркетингийн зардал	40
27. Ерөнхий ба удирдлагын зардал	40
28. Бусад зардал	41
29. Санхүүгийн зардал болон орлого	41
30. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	42
31. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	42
32. Орлогын татварын зардал	42
33. Холбоотой талын ажил гүйлгээ	43
34. Болзошгүй өр төлбөр	44
35. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл	44
36. Бодит үнэ цэнийн хэмжилт	47
37. Капиталын удирдлагын бодлого, журам	48
38. Тайлагналын үеийн дараах үйл явдал	48
39. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт	49



306





Группийн талаарх мэдээлэл

Группийн нэр:	Мон Ложистикс Холдинг ХХК	
Төлөөлөн удирдах зөвлөл	Дарга	"Мон Ложистикс Холдинг" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Ганзориг
	Гишүүд	"Монложистикс Транзит" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Тэлэнгэд
		"Мандал санхүүгийн нэгдэл" ХХК-ийн ТУЗ-н дарга Ө.Ганзориг
		Х.Амгалан
Хараат бус гишүүд	"Оллоо" ХХК-ийн ТУЗ-н гишүүн, "Ариг банк" ХХК-ийн ТУЗ-н гишүүн С.Сайнбат	
	Монголын ногоон санхүүжилтийн корпорацийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Э.Оюунбилэг "Мандал ассет менежмент" ХХК-ийн Ерөнхий захирал Б.Баатаржав	
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирал	Г.Хишигбат
	Санхүү хариуцсан захирал	З.Шинэ-Од
	Ерөнхий нягтлан бодогч	Б.Туул
Хаяг:	Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нью Хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот	
Регистрийн дугаар:	6381251	
Үйл ажиллагаа:	Менежментийн зөвлөх үйлчилгээ	
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага	



507





Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь Нэгтгэсэн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Группийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

"Мон Ложистикс Холдинг" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Ганзоригт, гүйцэтгэх захирал Г.Хишигбат болон ерөнхий нягтлан бодогч Б.Туул бид энэхүү тайлангийн 4-9 дүгээр хуудсанд үзүүлсэн Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Л.Ганзориг
Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн дарга
Огноо:
2023.03.13

Г.Хишигбат
Гүйцэтгэх захирал
Огноо:
2023.03.13

З.Шинэ-Од
Санхүү хариуцсан
захирал
Огноо:
2023.03.13





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

Мон Ложистикс Холдинг ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Мон Ложистикс Холдинг" ХХК (цаашид "групп" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан,
- Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Мон Ложистикс Холдинг" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Аудитын цар хүрээ Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд "Мон Ложистикс Холдинг" ХХК болон түүний охин 9 компанийн санхүүгийн тайланг хамруулсан.

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 823,407.18 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт орлогын 1%-иар тооцсон.
- Групп нь санхүүгийн тайлангийн гол хэрэглэгчид нь хувьцаа эзэмшигчид бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хувьд ногдол ашигт нөлөөлөх компанийн нийт орлого нь чухал үзүүлэлт байдаг тул нийт орлогыг суурь үзүүлэлтээр сонгосон. Группийн дотоод ажилчдын асуулгын үр дүн, өмнөх аудитын зөвлөмж, тайланд үндэслэн эрсдлийг дундаж гэж үнэлэн хувь хэмжээг 1%-иар тооцсон.

Материаллаг байдал





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл Группийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь Нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Группийн удирдлага эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь Нэгтгэсэн санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах Группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс Нэгтгэсэн санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ Нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас Нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.



320





Grant Thornton

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж Нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд групп доторх аж ахуй нэгжүүд, бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай аудитын нотлох баримтыг цуглуулах. Бид группийн аудитын чиглэл, хяналт, гүйцэтгэлийг хариуцна. Бид аудитын дүгнэлтийг бүрэн хариуцах болно.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 95.1-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Улаанбаатар хот, Монгол улс
2023 оны 3 дугаар сарын 13





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)
Хөрөнгө				
Эргэлтийн бус хөрөнгө				
Бусад эргэлтийн бус хөрөнгө	8	908,768	296,200	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9	14,000	14,000	14,000
Биет бус хөрөнгө	10	163,386	63,432	45,921
Үндсэн хөрөнгө	11	1,285,530	1,153,063	330,097
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		2,371,684	1,526,695	390,018
Эргэлтийн хөрөнгө				
Бараа материал	12	103,381	18,066	381
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13	5,661,575	4,470,539	2,102,783
Дансны ба бусад авлага	14	19,504,042	13,629,939	13,689,353
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15	14,198,308	5,815,535	9,277,264
Эргэлтийн хөрөнгийн дүн		39,467,306	23,934,079	25,069,781
Нийт хөрөнгийн дүн		41,838,990	25,460,774	25,459,799
Өр төлбөр ба эздийн өмч				
Эздийн өмч				
Хувьцаат капитал	16.1	106,268	100,000	100,000
Халаасны хувьцаа	16.2	(3,001,050)	(60,000)	(60,000)
Нэмж төлөгдсөн капитал	16.3	2,233,733	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		(138,547)	1	-
Хуримтлагдсан ашиг	16.4	23,722,504	15,347,906	11,851,857
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох өмч		22,922,908	15,387,907	11,891,857
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох өмч		1,944,287	1,548,411	1,151,219
Эздийн өмчийн дүн		24,867,195	16,936,318	13,043,076





Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны	2021 оны
			12 сарын 31-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)	01 сарын 01-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)
Урт хугацаат өр төлбөр				
Санхүүгийн түрээсийн урт хугацаат өр төлбөр	17	105,002	98,211	-
Хойшлогдсон татварын өр	18	88,210	622	-
Урт хугацаат зээл	20	16,667	750,000	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		209,879	848,833	-
Богино хугацаат өр төлбөр				
Бусад богино хугацаат өр төлбөр	19	921,930	333,876	49,838
Санхүүгийн түрээсийн богино хугацаат өр төлбөр	17	82,701	215,966	-
Богино хугацаат зээл	20	2,800,000	750,000	-
Урьдчилж орсон орлого	21	1,558,095	337,448	-
Дансны болон бусад өглөг	22	11,399,190	6,038,333	12,366,885
Богино хугацаат өр төлбөрийн дүн		16,761,916	7,675,623	12,416,723
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		41,838,990	25,460,774	25,459,799

Уг Нэгтгэсэн санхүүгийн тайланг 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр батлав:

Г.Хишигбат

З.Шинэ-Од

Гүйцэтгэх захирал

Санхүү хариуцсан захирал

Энэхүү Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 13-с 49 дүгээр хуудсан дах Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.





Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Орлого	23	140,122,679	82,340,718
Өртөг	24	(123,260,301)	(74,066,342)
Нийт ашиг		16,862,378	8,274,376
Бусад орлого	25	58,883	280,916
Борлуулалт, маркетингийн зардал	26	(803,713)	(92,584)
Ерөнхий ба удирдлагын зардал	27	(5,439,876)	(3,503,848)
Бусад зардал	28	(340,625)	(314,882)
Үйл ажиллагааны ашиг		10,337,047	4,643,978
Санхүүгийн орлого (зардал)	29	(385,106)	2,044
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	30	1,401,012	(41,354)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	31	(3,266)	(26,197)
Татвар төлөхийн өмнөх ашиг		11,349,687	4,578,471
Орлогын татварын зардал	32	(1,658,525)	(686,011)
Тайлант үеийн цэвэр ашиг		9,691,162	3,892,460
Үүнээс: Толгой компанийн хувьцаа эзэмшигчид		8,374,598	3,496,049
Хяналтын эрхгүй хувь оролцоо		1,316,564	396,411
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		343	152
Бусад дэлгэрэнгүй орлого			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		(138,548)	1
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй орлого		9,552,614	3,892,461

Энэхүү Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 13-с 49 дүгээр хуудсан дах нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.





Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	100,000	(60,000)	-	-	11,851,857	11,891,857	1,151,219	13,043,076
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	3,496,049	3,496,049	396,411	3,892,460
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	781	781
Халаасны хувьцаа	-	-	-	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	1	-	1	-	1
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	100,000	(60,000)	-	1	15,347,906	15,387,907	1,548,411	16,936,318
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	8,374,598	8,374,598	1,316,564	9,691,162
Өмчид гарсан өөрчлөлт	6,268	-	-	-	-	6,268	200	6,468
Халаасны хувьцаа	-	(2,941,050)	-	-	-	(2,941,050)	-	(2,941,050)
Нэмж төлөгдсөн капитал	-	-	2,233,733	-	-	2,233,733	-	2,233,733
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	(138,548)	-	(138,548)	291	(138,257)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(921,179)	(921,179)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	106,268	(3,001,050)	2,233,733	(138,547)	23,722,504	22,922,908	1,944,287	24,867,195

Энэхүү Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 13-с 49 дүгээр хуудсан дах нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



2023-06-14

БҮРТГЭВ-03



Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	141,812,653	81,446,353
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	139,279,541	79,711,416
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	181,270	122,613
Буцаан авсан албан татвар	562	-
Бусад мөнгөн орлого	2,351,280	1,612,324
Мөнгөн зарлагын дүн	132,430,402	87,690,084
Ажиллагчдад төлсөн	3,809,575	2,622,931
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,208,101	632,735
Бараа материал худалдан авахад төлсөн	13,976	378,508
Ашиглалтын зардалд төлсөн	9,418	101,070
Хүүний төлбөрт төлсөн	241,086	64
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн	111,634,384	74,257,932
Татварын байгууллагад төлсөн	3,753,137	1,825,442
Даатгалын төлбөрт төлсөн	243,194	200,290
Бусад мөнгөн зарлага	11,517,531	7,671,112
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,382,251	(6,243,731)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	221,405	2,753,085
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	3,110	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	154,517	2,724,819
Хүлээн авсан хүүний орлого	63,778	28,266
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн	1,453,428	3,501,176





Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	133,637	857,510
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	117,283	13,168
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	978,551
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,202,508	1,651,947
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,232,023)	(748,091)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	7,155,916	3,608,436
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,012,225	3,119,118
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,308,325	489,318
Бусад санхүүгийн мөнгөн орлого	835,366	-
Мөнгөн зарлагын дүн	7,648,086	80,149
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,621,389	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	337,383	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	3,001,050	-
Төлсөн ногдол ашиг	852,898	80,149
Бусад санхүүгийн мөнгөн зарлага	835,366	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(492,170)	3,528,287
Валютын ханшийн зөрүү	724,715	1,806
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,382,773	(3,461,729)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,815,535	9,277,264
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,198,308	5,815,535

Энэхүү Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 13-с 49 дүгээр хуудсан дах нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



317





Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Мон Ложистикс Холдинг ХХК нь анх 2019 онд Эм Эл Холдинг ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, 6381251 тоот регистр бүхийн 9011784027 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Компанийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн шийдвэрээр компанийн нэрийг "Мон Ложистикс Холдинг" болгож өөрчилсөн.

Компани нь нэг бүр нь 4,358.45 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 24,382 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд үүнээс 1,950 ширхэг хувьцаа нь халаасны хувьцаа байна. Группийн үндсэн үйл ажиллагаа нь охин компаниудад менежментийн үйлчилгээ үзүүлдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 10 компанийн санхүүгийн мэдээллийг нэгтгэсэн. Эдгээр компаниудын үйл ажиллагааны чиглэлийг доорхи хүснэгтээр харуулав.

Группийн нэр	Үндсэн үйл ажиллагаа
1. Мон Ложистикс Холдинг ХХК	• Менежментийн зөвлөх үйлчилгээ
2. Монложистикс Транзит ХХК	• Монголын нутгаар дамжин өнгөрөх транзит тээвэр зохион байгуулах
3. Монложистикс Ворлдвайд ХХК	• Олон улсын тээвэр зохион байгуулалт, ложистикийн үйлчилгээ • Гадаад, дотоод худалдаа • Гаалийн зуучлалын үйл ажиллагаа • Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч • Гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа • Олон улсын буухиа шуудан
4. Монложистикс Тракинг ХХК	• Авто машинаар ачаа тээвэрлэх
5. Монложистикс Карго ХХК	• Ачаа хүргэлтийн үйлчилгээ
6. Монложистикс Россия Холдинг ХХК	• Менежментийн зөвлөх үйлчилгээ
7. Монложистикс Транс Сервис ООО	• Авто машинаар ачаа тээвэрлэх
8. Каус Аустралис ХХК	• Олон улсын тээвэр зохион байгуулалт, ложистикийн үйлчилгээ
9. Монложистикс Экүйпментс ХХК	• Бөөний худалдаа
10. Монложистикс Экспресс ХХК	• Бөөний худалдаа

Групп нь 2022 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон тайлант жилд дунджаар 155 (2021 онд: 142) ажилтантай байна.

Албан хаяг: Групп нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нью Хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

2. Монголын бизнесийн орчин

Монгол Улсын улс төр, эдийн засгийн орчны өөрчлөлт, хууль эрх зүй, татвар, хууль тогтоох тогтолцооны хөгжил тасралтгүй үргэлжлэх шинж чанартай байгаа ба Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил нь эдгээр өөрчлөлтөөс ихээхэн хамаардаг.





2023-06-14

Ковид 19 цар тахлын улмаас эдийн засагт гарч буй хямрал, олон улсын цэрэг улс төрийн хурцадмал байдал, дэлхий нийтийг хамарсан тээвэр ложистикийн хүндрэл манай улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлсээр байна. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай холбоотой хямралын дараа Монголын эдийн засаг тогтвортой сэргэх үе шатанд орсон.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2022 онд 2.4 хувьд хүрэх төлөвтэй бөгөөд энэхүү өсөлтөд КОВИД-19 цар тахалтай холбоотой хязгаарлалтуудыг цуцалсан, хөдөө аж ахуйн салбар эрчтэй сэргэсэн, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зэрэг Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ болон өрхийн хэрэглээний өсөлт нь дотоод эрэлтэд эергээр нөлөөлж байна. Бизнесийн орчныг сайжруулах, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг нэн тэргүүнд сэргээн босгож хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын хүчин чармайлт, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны өргөтгөсөн төлөвлөгөө нь Монголын эдийн засгийн тогтвортой байдал, хөгжилд зохих хувь нэмэр оруулах төлөвтэй байна.

Мөн 2022 онд Монгол улсын Засгийн Газраас дэвшүүлсэн "Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэх юм.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэх болно. Үүнд:

- Боомтын сэргэлт
- Эрчим хүчний сэргэлт
- Аж үйлдвэржилтийн сэргэлт
- Хот, хөдөөгийн сэргэлт
- Ногоон хөгжлийн сэргэлт
- Төрийн бүтээмжийн сэргэлт

3. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал

Эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-д нийцүүлэн бэлтгэсэн болно.

Эдгээр Нэгтгэсэн санхүүгийн тайланг Групп нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын удирдлага баталсан. (Тодруулга 39-г харна уу).

3.1 Тасралтгүй үйл ажиллагаа


НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн өргөн төлөлтийн хуваарь, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавхи зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.





"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ үүсгэх томоохон үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой дараах тодорхойгүй байдал байхгүй байна.

3.2 Санхүүгийн тайлангийн дахин тайлагнал

Групп нь алдаа илрүүлсний дараа нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт болон өмнөх үеийн алдааны залруулгыг анх баталсан санхүүгийн тайланд буцаж хэрэгжүүлдэг ба ингэхдээ алдаа гарсан өмнөх хугацаанд толилуулсан харьцуулагдах дүнг дахин тайлагнах, эсвэл толилуулсан хамгийн эхний хугацаанаас өмнө алдаа гарсан бол уг толилуулсан хамгийн эхний хугацааны хөрөнгө, өр төлбөр ба өмчийг дахин тайлагнадаг. Санхүүгийн тайланг өмнөх хугацааны харьцуулагдсан мэдээллийн хамт залруулга хийх шаардлага гарсан хугацаандаа хийгдсэн мэтээр толилуулна. Тийм учраас толилуулсан хугацаа бүрд холбогдох залруулгын дүн нь тухайн хугацааны санхүүгийн тайланд багтана.

2021 оны санхүүгийн тайланд хийгдсэн залруулгын нөлөөлөл дараах байдалтай байна. Үүнд:

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31	Дахин тайлагналын залруулга	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)
Татварын авлага	110,502	562	111,064
Цалингийн өглөг	72,775	634,663	707,438
НДШ өглөг	5,263	64,466	69,726
ААНОАТ өглөг	479,813	(36,295)	443,518
Бусад богино хугацаат өр төлбөр	262,211	71,665	333,876
Тайлант үеийн ашиг	4,626,394	(733,937)	3,892,460

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31	Дахин тайлагналын залруулга	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)
Өртөг (1)	72,117,905	1,948,437	74,066,342
Ерөнхий удирдлагын зардал (2)	4,681,493	(1,177,645)	3,503,848
Орлогын татварын зардал	722,866	(36,855)	686,011
Нийт дүн		733,937	

(1) Тээврийн үйлчилгээний орлого олохтой холбоотой гарсан 1,836,256.5 мянган төгрөгийн өртөгийг Ерөнхий удирдлагын зардлаар тайлагнасан байсныг дахин ангилалаар залруулав.

(2) 2021 оны цалингийн урамшуулалын 770,791.9 мянган төгрөгийн зардлыг 2022 оны тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрсөнийг залруулав.

Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

3.3.1 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

Групп нь 2022 оны 1-р сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр болсон зарим стандарт, нэмэлт өөрчлөлтийг анх удаа хэрэгжүүлсэн. Хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй өөрчлөлт оруулсан стандарт ба түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд байгаа ба

Групп нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа болно.

2022 онд анх удаа хэрэгжүүлсэн группийн Нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт байхгүй.

2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх мэдэгдлүүд байгаа бөгөөд тэдгээр нь группийн санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нөлөө үзүүлэхээргүй байна.



320



2023-08-14

БҮРТГЭВ-03

Мон Ложистикс Холдинг ХХК

Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд

2022 оны 12 сарын 31-нээр дуусаар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

СЗХ
ОН 2023-08-14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Группд хамааралтай дараах стандарт болон нэмэлт өөрчлөлт нь 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж эхэлсэн. Үүнд:

- СТОУС 3 "Бизнесийн нэгдэл"-д орсон нэмэлт өөрчлөлт - Суурь үзэл баримтлалын хүрээний зөвлөмж
- СТОУС 16 "Түрээс"-д орсон нэмэлт өөрчлөлт - Ковид 19-тэй холбоотой 2021 оны 6 сарын 30-наас хойш үйлчлэх Түрээсийн хөнгөлөлтийн нэмэлт өөрчлөлт
- НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-д орсон нэмэлт өөрчлөлт-Үндсэн хөрөнгө: Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого
- НББОУС 37 "Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө"-д орсон нэмэлт өөрчлөлт - Алдагдалтай гэрээ: Гэрээг биелүүлэх өртөг
- Жил бүрийн сайжруулалтууд (2018-2020 оны мөчлөг):
 - СТОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт-анх удаа хэрэгжүүлсэн охин компани
 - СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл – Санхүүгийн өр төлбөрийг хэрэгсэхгүй болгох '10' -тай тэнцэх төлбөрийн хураамжийн тест
 - СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт - Түрээсийн урамшуулал
 - НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт - Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар

3.3.2 Компанийн мөрдөж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУС3-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Компани нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Удирдлага нь тухайн бүх өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусган мөрдөж эхлэхээр төлөвлөж байна.

Удирдлага нь эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлтөөс шалтгаалан банкны санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлэхийг урьдчилан тооцоолоогүй бөгөөд тэдгээрийг доор үзүүлэв (энэ хэсгийг харилцагч бүрийн санхүүгийн тайланд тохируулан өөрчлөх шаардлагатай).

- СТОУС 17 "Даатгалын гэрээ"
- СТОУС 17 "Даатгалын гэрээ"-нд оруулсан нэмэлт өөрчлөлт (СТОУС 17 ба СТОУС 4-д оруулсан нэмэлт өөрчлөлт)
- НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-д орсон нэмэлт өөрчлөлт - Өр төлбөрийн богино болон урт хугацааны ангилал
- НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-д орсон нэмэлт өөрчлөлт – НББОУС3-өөс 2021 оны 2-р сард НББОУС 1 болон СТОУС-ын практик мэдэгдэл 2 "Материал байдлын талаар үнэлэмж гаргах"-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг сайжруулах зорилготой юм.
- НББОУС 12 "Орлогын татвар" -т орсон нэмэлт өөрчлөлт - Нэг удаагийн гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар
- НББОУС 8 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа"-д орсон нэмэлт өөрчлөлт - 2021 оны 2-р сард НББОУС3-өөс НББОУС 8-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ өөрчлөлтөөр тайлагнагч байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс хэрхэн ялгах ёстойг илүү тодорхой болгож өгсөн.





"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

4.1. Бүртгэлийн суурь

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг аккруаль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

4.2. Нэгтгэлийн суурь

Групп нь толгой компани болон түүний охин компаниудын 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангуудыг нэгтгэсэн. Бүх охин компаниудын санхүүгийн тайлагналын жил нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болдог. Нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахад компани хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ болон дотоодын ажил гүйлгээнээс үүссэн аливаа хэрэгжээгүй олзыг устгана. Компани хоорондын хөрөнгө борлуулалтаас үүсэн хэрэгжээгүй алдагдлыг группийн нэгтгэлээс устгахад, группийн тайлагналын зорилгоор тухайн хөрөнгөнд үнэ цэнэ бууралтын шинжилгээ хийнэ. Охин компаниудын баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь группийн бодлогоос зөрүүтэй бол группийн бодлогод нийцүүлэх тохируулга хийнэ.

Шинээр худалдан авсан болон борлуулсан охин компанийн ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогыг худалдан авалт эсвэл борлуулалт хүчин төгөлдөр болсон өдрөөр хүлээн зөвшөөрнө.

Групп нь охин компаниудын нийт дэлгэрэнгүй орлого болон алдагдлыг эзэмшлийн хувьд уялдуулан эзэмшигчид болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилна.

4.3. Бизнесийн нэгдэл

НББ-ийн худалдан авалтын аргыг Групп охин компани худалдаж авахад ашиглана. Охин компанийн хяналтыг авахад төлсөн нийт төлбөрт худалдан авалтын өдрөөрх шилжүүлсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ, холбогдох өр төлбөр болон группийн өмчийн хэсэг болон хөрөнгө болон өр төлбөрийн болзошгүй тохиролцоог хамруулж тооцно. Худалдан авалтын зардлыг гарсан дүнгээр нь зардлаа хүлээн зөвшөөрнө. Худалдан авсан хөрөнгө болон өр төлбөрийг худалдан авалтын өдрөөрх зах зээлийн үнээр хэмжинэ.

4.4. Хараат болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт

Өмчийн аргын дагуу хараат компани болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Хараат компани болон хамтарсан үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэ нь тэдгээрийн ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын Группд хамаарах хувиар есч эсвэл буурч, мөн нягтлан бодох бүртгэлийн аливаа ялгаатай бодлогын тохируулгыг хийснээр бүртгэгдэнэ.

Хараат компани болон хамтарсан үйлдвэрлэлтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн бодит бус олзыг Группийн оруулсан хөрөнгө оруулалтын эсрэг устгана.

4.5. Гадаад валют хөрвүүлэлт

Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Монгол төгрөгөөр илэрхийлэгддэг ба толгой компанийн үйл ажиллагааны валюттай ижил юм.

Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн амдоллантай харьцах ханш 3,444.60 байв. (2021 оны 12 дугаар сарын 31-нд 1 ам.доллар 2,848.80 төгрөг) Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн





"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлнэ)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2022.08.14

БҮРТГЭВ-03

мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн зөрүүнийн олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана. Тийм мөнгөн бус зүйлсийн хувьд олз, гарзын аливаа ханшийн зөрүүний хэсгийг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

Гадаад үйл ажиллагаа

Группийн Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд үндсэн валютаас бусад валютаар илэрхийлэгдсэн бүх хөрөнгө, өр төлбөр болон ажил гүйлгээг тайлагналын өдрөөрх ханшаар хөрвүүлнэ. Гадаадын аж ахуй нэгжийг худалдан авсантай холбоотой үүссэн гүдвилл болон зах зээлийн үнийн тохируулгыг тухайн аж ахуй нэгжийн хөрөнгө өр төлбөрөөр бүртгэх ба тайлагналын өдрийн хаалтын ханш ашиглан хөрвүүлнэ. Тайлант хугацаанд гарсан орлого болон зардлыг тайлант үеийн дундаж ханш ашиглан хөрвүүлнэ. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй оролгын өмчид гарсан валютын ханшийн тэгшитгэлийн нөөц дансанд хүлээн зөвшөөрнө. Гадаад аж ахуй нэгжийг борлуулах үед түүнд хамаарах хуримтлагдсан ханшийн зөрүүг ашиг алдагдлаар дахин ангилал ба борлуулалтын олз, гарзын нэг хэсгээр хүлээн зөвшөөрнө.

4.6. Сегментийн тайлагнал

Групп нь 6 төрлийн үйл ажиллагааны сегменттэй. Группийн удирдлага үйл ажиллагааны сегментээ тодорхойлохдоо Группээс гаргадаг гол бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөөлдөг үйлчилгээний шугамыг баримталдаг.

Дээрх үйл ажиллагааны сегментүүдийн үйлчилгээний шугам өөр өөр технологи, нөөц болон маркетингийн хандлага шаардагддаг учраас тус тусад нь эрхэлдэг. Сегмент хооронд бараа, ажил үйлчилгээ солилцохдоо ижил төстэй бараа, ажил үйлчилгээг холбоогүй талд борлуулах үнээр тооцон бүртгэдэг.

Удирдлагын зорилгоор Групп нь Нэгтгэсэн санхүүгийн тайланд ашигласантай ижил хэмжилтийн бодлогыг ашигладаг.

4.7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол [Групп / Компани] нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

4.8. Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Групп нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт

Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй дансны авлага болон СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэхээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хөйджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нагтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023 06 14

БҮРТГЭВ-03

- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БУЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БУЦАА)

Ангиллыг тодорхойлохдоо:

- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин дансны авлагын үнэ цэнийн бууралтыг бусад зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БУЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнийн бууралтын хасагдуулга болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БУЦАА)

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал компани/групп дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно. Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

Дээрх сонголтыг бүх ижил төстэй ажил гүйлгээнд мөрдөх шаардаагүй. Харин энэ нь илүү мэдээлэл бий болгож байгаа тохиолдолд банк сонгож болох хувилбар юм.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БУЦБДО)

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо илүү ирээдүйд чиглэсэн мэдээлэлд суурилах болсон ба үүнийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын аргачлал гэж нэрлэдэг.





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХЭРЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2022-06-14

БҮРТГЭВ-03

Энэхүү шаардлагын дагуу хорогдсон өртгөөр болон БҮЦБДО-оор хэмжигдэх зээл, бусад өрийн төрлийн санхүүгийн хөрөнгүүд, дансны авлага, СТОУС 15-ын дагуу хүлээн зөвшөөрөгдөн, хэмжигдсэн гэрээний хөрөнгө, зээлийн үүрэг болон БҮЦАА-аар хэмжигддэггүй зарим санхүүгийн баталгааны гэрээг хамруулна.

Зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхөд Групп нь зээлийн алдагдал үүсэх нөхцөл бий болохыг хүлээх шаардлагагүй болсон. Үүний оронд Групп нь зээлийн эрсдэлийг үнэлэх болон хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал, хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй цуглуулгад нөлөөлөх үндэслэлтэй дэмжигдэхүйц тамааглал зэрэг мэдээллийг харгалзан үздэг.

Тус аргачлалыг ашиглахад дараах зүйлсийг ялгаж харах шаардлагатай. Үүнд:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрснөөс хойш түүний зээлийн эрсдэл их хэмжээгээр нэмэгдээгүй, тайлант хугацааны үеэр бага эрсдэлтэй байгаа бол (Шатлал 1)
- Анхны хүлээн зөвшөөрөлтөө хойш зээлийн чанар мэдэгдэхүйц муудсан, зээлийн эрсдэл бага биш байгаа санхүүгийн хэрэглүүрүүд (Шатлал 2)
- Шатлал 3 нь тайлагналын өдөр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо олдсон санхүүгийн хөрөнгүүдийг хамруулна.

Дараагийн 12 сард хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Шатлал 1-д, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Шатлал 2-д хүлээн зөвшөөрнө.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд зээлийн алдагдлын магадлалын жингийн тооцооллоор тодорхойлно.

Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгө

Групп нь дансны болон бусад авлагын авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг бөгөөд алдагдлын нөөцийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын аргаар бүртгэдэг. Эдгээр нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны аль ч үед дефолт болох магадлалыг харгалзан үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм. Нөөцийн матрицыг ашиглан хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо Групп нь өөрийн түүхэн туршлага, гадаад хүчин зүйлс, ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Групп нь дансны авлагын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо хугацаа хэтэрсэн өдрүүдээр нь бүлэглэн зээлийн эрсдэлийн шинж чанарт ангилан үнэлнэ. СТОУС 9-ийн үнэ цэнийн бууралтын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар нарийвчилсан шинжилгээг тодруулга 36-аас үзнэ үү.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт

Группийн санхүүгийн өр төлбөрт зээл, дансны болон бусад өглөг, бусад санхүүгийн хэрэглүүрүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэнийн олз гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бүх хүүтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

4.9. Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Бараа материалын өртөг тусгай тэмдгэлгээний аргын зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно



325





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14

БҮРТГЭВ-03

4.10. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулан урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зардлуудыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

4.11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөр болон зогсоосон үйл ажиллагаа

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг уг ангилалд оруулахын яг өмнөх дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан дүнгийн аль багаар хэмжинэ. Ийм хөрөнгийг элэгдүүлж, хорогдуулахгүй. Харин санхүүгийн хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө зэрэг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг ердийнхөөр хэмжинэ. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн ангилалд орсон хөрөнгөнд элэгдэл хорогдол тооцохгүй.

4.12. Үндсэн хөрөнгө

Барилга, компьютер дагалдах хэрэглүүр болон бусад тоног төхөөрөмжийг зэрэг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүдийг барилга болон компьютер дагалдах хэрэглүүрийн адил бүртгэнэ. Ажил үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн зорилгоор ашиглаж буй хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер, түүний эд анги, программ хангамж	2 жил
Бусад хөрөнгө	10 жил

4.13. Бусад биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд программ хангамж хамаарна.

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авалт хийсэн өдөр өртгөөр нь бүртгэнэ. Өртөг нь төлсөн мөнгөний дүн, өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ, гарсан өр төлбөрт төлөх дүнгийн өнөөгийн үнэ цэнэ эсвэл хувьцаа гаргалтын хувьд хүлээн авсан санал бодлын зах зээлийн үнэ цэнээр хэмжигддэг.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд судалгаа хөгжүүлэлтийн зардлаас бусад өртөг зардлыг биет бус хөрөнгийн өртөгт капиталжуулдаг. Дотоодод бий болсон (үүссэн) гудвиллыг хөрөнгө гэж бүртгэхгүй.

Биет бус хөрөнгийг хувьцаа болон өөр бусад мөнгөн бус хөрөнгөөр солилцох замаар олж бэлтгэж болно. Энэ тохиолдолд биет бус хөрөнгийн өртгийг шилжүүлэн өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ хоёрын аль тодорхой байгаа үнээр үнэлнэ.

Дотооддоо хөгжүүлсэн програм хангамж

Мэдээлэл технологийн, харилцаа холбооны системийн зорилгоор шинээр хөгжүүлж буй програм хангамжийн судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хөгжүүлэлтийн үе шатанд гарсан зардлыг дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд биет бус хөрөнгөнд хуримтлуулан бүртгэнэ. Үүнд:





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРХ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023-06-14
БҮРТГЭВ-03

- Хөгжүүлэлтийн зардлыг бодитоор хэмжиж болох
- Төслийн техникийн болон арилжааны үр дүн амжилттай болох нь тодорхой
- Групп нь тухайн төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай хангалттай нөөцтэй
- Тухайн программыг ашиглах эсвэл борлуулах боломжтой
- Тухайн программаас ирээдүйн эдийн засгийн өгөөж ирэх нь тодорхой

Дээрх капиталжуулалтын шаардлагыг хангаагүй зардлууд нь зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Холбогдох зардлуудад програм хөгжүүлэхтэй холбоотой гарсан ажилчдын зардал, зээлийн өртөг болон нэмэгдэл зардлууд нь хөгжүүлэлтэд хамаарах хэмжээгээр хуваарилагдана.

Дараа үеийн хэмжилт

Ашиглах хугацаа нь тодорхой дотооддоо хөгжүүлэн капиталжуулсан програм зэрэг биет бус хөрөнгүүдийг өртгийн аргаар бүртгэх ба ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэх өртөг болон ашиглах хугацааг тайлант жил бүр дахин тооцно. Мөн үнэ цэнийн бууралтын тест хийнэ. Биет бус хөрөнгүүдийн ашиглах хугацаа нь:

- Програм хангамж 20 жил

Капиталжуулж буй хөгжүүлэлт нь дуусаагүй програм хангамжийг хорогдуулахгүй боловч үнэ цэнэ бууралтын тест хийнэ.

Хорогдуулгын зардлыг санхүүгийн бус хөрөнгийн элэгдэл, хорогдол, үнэ цэнэ бууралтын дансанд бүртгэнэ.

Програм хангамж болон бренд нэртэй холбоотой дараа үед гарах засварын зардлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг борлуулснаас үүсэх олз гарзыг борлуулалтын үнэ болон дансны үнийн зөрүүгээр хүлээн зөвшөөрч, бусад орлого болон зардлын дансанд ашиг болон алдагдлаар бүртгэнэ.

4.14. Гүүдвил, биет бус хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тест

Хөрөнгүүдийг үнэ цэнийн бууралтын зорилгоор тусдаа мөнгөний урсгалд (мөнгөн бий болгогч нэгж)-д суурилан боломжит хамгийн жижиг бүлгүүдэд хуваадаг. Үүний үр дүнд зарим хөрөнгийн үнэ цэнийн бууралт дангаараа хийгддэг бол зарим хөрөнгүүд мөнгө бий болгогч нэгжийн төвшинд үнэлэгддэг.

Гүүдвил хуваарилсан мөнгө бий болгогч нэгжүүдэд (Тухайн нэгжийг группийн удирдлага үйл ажиллагааны сегменттэй ижил төвшинд авч үздэг) дор хаяж жилд нэг удаа үнэ цэнийн бууралтын тест хийдэг. Бусад бүх нэгж хөрөнгө болон мөнгө бий болгодог нэгжүүдийн үнэ цэнэ бууралтын тестийг дансны үнэ нь нөхөгдөх үнээсээ бага байх нөхцөл үүссэн үед хийнэ.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан дүнгийн аль өндрөөр тодорхойлогдоно. Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо удирдлага нь мөнгө бий болгогч нэгж бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг тооцох ба тухайн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцохын тулд зохих дискаунтын төвшинг тодорхойлдог. Үнэ цэнийн бууралтын тестэд ашигласан мэдээлэл нь ирээдүйд гарах зохион байгуулалтын өөрчлөлт, хөрөнгийн сайжруулалтын үр нөлөөг хамруулаагүй Группийн хамгийн сүүлд батлагдсан төсөвт үндэслэдэг.

Мөнгө бий болгогч нэгжид үнэ цэнэ бууралтын гарзыг хуваарилахдаа тухайн нэгжид хамаарах гүүдвиллийн үлдэгдлийг хамгийн эхэнд бууруулна. Үлдсэн гарзыг нь мөнгө бий болгогч нэгжид хамаарах хөрөнгүүдэд тэнцүүлсэн хэмжээгээр хуваарилна.

Гүүдвилээс бусад хөрөнгийн өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал цаашид байхгүй болох шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлдэг. Хөрөнгийн болон бэлэн мөнгө үүсгэх нэгжийн нөхөгдөх үнэ нь түүний дансны үнээс давсан тохиолдолд үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.





4.15. Түрээс

Групп нь түрээслэгч байх үед

Оффисийн түрээсийн гэрээг сунгах нөхцөлтэйгээр 2 жилийн хугацаагаар хийдэг. Групп нь борлуулаад, буцаан түрээслэх нөхцөлтэй хэлцэл хийдэггүй. Бүх түрээсийн гэрээг өөр өөр нөхцөлтэйгээр байгуулсан.

Тухайн гэрээ нь түрээс эсэх, эсвэл түрээсийг агуулсан эсэхийг компани/групп нь уг гэрээ үүссэн өдрөөр үнэлнэ. Хэрэв гэрээ нь төлбөрийн хариуд тухайн тодорхойлсон хөрөнгийн ашиглалтыг хянах эрхийг шилжүүлдэг бол уг гэрээ нь түрээс болно, эсвэл түрээсийг агуулсан байна.

Түрээслэгчийн түрээсийн хэмжилт болон хүлээн зөвшөөрөлт

Түрээс эхлэх өдрөөр Групп нь санхүүгийн байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхийн хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба энэ нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилт, Группийн зарцуулсан аливаа шууд зардал, түрээсийн хугацааны эцэст хөрөнгийг буулгах, нураахтай холбоотой тооцоолсон зардал болон түрээс эхлэх өдрөөс өмнө хийгдсэн урьдчилгаа төлбөрийн нийлбэр юм.

Групп нь ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхийн хөрөнгөнд үнэ цэнэ буурах нөхцөл бүрдсэн бол үнэ цэнийг бууруулна.

Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо Групп нь ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүний төвшинг (тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүний төвшинг) ашиглан дискаунтчилан тооцно.

Түрээсийн өр төлбөрийн тооцоололд тогтмол төлбөрүүд, индекс эсвэл ханш дээр суурилсан хувьсах төлбөрүүд, гэрээт хугацааны эцэст төлөх нь тодорхой болсон бусад төлбөрүүд хамаарна.

Дараа үеийн хэмжилтийн үед өр төлбөр нь төлсөн төлбөрөөр буурч, тооцоолсон хүүгээр өснө. Өр төлбөр нь гэрээлсэн тогтмол төлбөрт өөрчлөлт орох үед болон аливаа бусад төлбөрийн тооцоололд өөрчлөлт орох үед дахин тооцоологдоно.

Түрээсийн өр төлбөр дахин тооцоологдоход түүнд хамаарах ашиглах эрхийн хөрөнгөнд тохируулга хийгдэх ба хэрэв ашиглах эрхийн хөрөнгө үлдэгдэлгүй болсон бол ашиг алдагдалд тохируулга хийгдэнэ.

Групп нь богино хугацааны түрээс, бага өртөг бүхий хөрөнгийн түрээсийг өөрийн практик туршлагад үндэслэн ангилан бүртгэнэ. Тэдгээр хөрөнгүүдийг ашиглах эрхийн хөрөнгө болон түрээсийн өр төлбөр гэж бүртгэхгүй ба харин холбогдох төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр, түрээсийн өр төлбөрийг Дансны болон бусад өглөгөөр илэрхийлнэ.

Групп нь түрээслүүлэгч байх үед

Түрээслүүлэгчийн хувьд Групп түрээсийг үйл ажиллагааны болон санхүүгийн түрээс гэж ангилдаг.

Түрээс нь үндсэн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл, үр дүнг шилжүүлсэн тохиолдолд санхүүгийн түрээс гэж ангилагддаг бөгөөд бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээс гэж ангилагдана.

Дараа үеийн хэмжилт

Ашиглах эрхтэй хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.



2023-05-14

БҮРТГЭВ-03



4.16. Өмч, нөөц, ногдол ашгийн төлбөр

Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Халаасны хувьцаа нь Компани гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна.

Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно. Хувьцаа гаргахтай холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг холбогдох татвар суутгасан цэвэр дүнгээр нэмж төлөгдсөн капиталаас хасна.

Өмчийн бусад хэсэгт дараах зүйлс багтдаг. Үүнд:

- Дахин үнэлгээний нөөц нь дахин үнэлгээний олз, гарзаас бүрдэнэ.
- Хуримтлагдсан ашигт тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг багтана.

Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

4.17. Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлого ба олзыг дараах үйл ажиллагаанаас олдог:

1. Үндсэн үйл ажиллагааны орлого

- Менежментийн звелөх үйлчилгээ
- Олон Улсын Тээвэр зуучийн үйл ажиллагаа
- Транзит Тээвэр зуучийн үйл ажиллагаа
- Машин Тээвэр зуучийн үйл ажиллагаа
- Бусад орлого

2. Үндсэн бус үйл ажиллагааны орлого

- Хүүгийн орлого
- Ногдол ашиг, эрхийн шимтгэлийн орлого
- Торгуулийн орлого
- Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз
- Түрээсийн орлого
- Бусад орлого
- Бусад олз

Орлого хүлээн зөвшөөрөхдөө Групп нь дараах таван алхмыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг тодорхойлох
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хувиарлах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

Групп нь бараа, ажил үйлчилгээтэйгээ холбоотойгоор олон төрлийн ажил гүйлгээ хийдэг. Иймд гэрээний нийт үнийн дүн нь үүрэг хариуцлагын төрөл бүрт тус тусын үнийн дүнд харгалзуулан хуваарилагддаг. Гэрээний үнийн дүнд гуравдагч этгээдэд олгох төлбөрийг хамруулахгүй.

Орлогыг тохиролцсон барааг шилжүүлсэн болон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Хэрэгжээгүй үүрэгт хамаарах орлого орох үед гэрээний өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн байдлын тайланд бусад өр төлбөрөөр харуулна. Үүнтэй адилаар төлбөр ирэхээс өмнө тохиролцсон үүргийг биелүүлэх үед гэрээний хөрөнгө эсвэл авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгана.

Түрээсийн орлогод түрээслүүлэгчээс түрээслэгчид хөрөнгийг тодорхой хугацаанд, тодорхой төлбөртэйгээр ашиглуулах эрхийг шилжүүлэх тухай гэрээний дагуу түрээслүүлэгчийн хүлээн авах мөнгөн болон мөнгөн бус дүнг хамруулна.

Олон Улсын Тээвэр зуучийн үйл ажиллагаа: Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ аливаа харилцагчидтай байгуулсан олон улсын тээвэр ложистикийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу үүрэг хариуцлагыг тодорхойлон





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв) 4

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ-03

орлогыг хүлээн зөвшөөрөх цэгийг тодорхойлно. Харилцагчтай байгуулсан хамтран ажиллах ерөнхий гэрээний хүрээнд нэгж ачаа тээврийн захиалгын хуудас нь тухайн гэрээний салшгүй нэг хэсэг болох тул захиалгын хуудсанд заасан үйлчилгээний нөхцөл нь гэрээний үүргийг тодорхойлох юм.

Транзит Тээвэр зуучийн үйл ажиллагаа: Компанийн үндсэн үйл ажиллагаа нь транзит тээвэр буюу дамжин өнгөрөх тээвэр зуучын үйлчилгээ бол ачаа тээврийг нэг улсын цэгээс нөгөө улсын цэгт хүргэхтэй холбоотойгоор үүссэн орлогыг үндсэн үйл ажиллагааны борлуулалтанд хамааруулна.

Машин Тээвэр зуучийн үйл ажиллагаа: Байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь машин тээврийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд харилцагчид ачаа барааг хүргэж өгсөн буюу тээвэрлэж дууссан хугацаагаар орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана.

Хүүгийн орлого: Банканд хадгалуулсан хадгаламжийн хүүний орлого, харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүүг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Мөн бүх төрлийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын хүүний орлогыг аккруэл суурийн дагуу хүлээн зөвшөөрнө.

Ногдол ашиг, эрхийн шимтгэлийн орлого: Эрхийн шимтгэлийн орлогыг гэрээний дагуу олсон эсвэл олохоор тооцсон дүнгээр, ногдол ашиг ба түүнтэй адилтгах орлогыг байгууллагын төлбөр хүлээн авах эрх тодорхой болсон тохиолдолд тус тус хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Торгуулийн орлого: Хэрэглэгч болон харилцагч байгууллагууд гэрээний үүргээ биелээгүйн улмаас орж ирсэн орлогыг олсон тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз: Гадаад валютаар ажил гүйлгээ гарсан өдрийн ханш, авлага өглөг цугларах, барагдах өдрийн ханшаас их тохиолдолд ханшийн өөрчлөлтийн бодит ашиг, хаалтын ханшаар ханш өссөн үед бодит бус ашиг тус тус үүсэх бөгөөд аккруэл суурийн дагуу гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит ба бодит бус олзыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Түрээсийн орлого: Генераторын болон тоног төхөөрөмжийн түрээсийн орлогыг аккруэл суурийн дагуу хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Бусад орлого: Компанийн гүйцэтгэгч талын өмнөөс нийлүүлэгч талд цахилгаан, дулаан, даатгал зэрэг нийтлэг төлбөрүүдийг төлж нэгдсэн дүнгээр нэг НӨАТийн баримтыг өөрийн компани дээр авдаг. Харин гүйцэтгэгч тал бүрд тухайн зардлыг тодорхой суурь тогтоон хуваарилах ба ингэхдээ НӨАТ-тэй дүнгээр бусад орлого бүртгэдэг.

Бусад олз: Үндсэн хөрөнгө, бусад хөрөнгө данснаас хассаны болон бусад олзуудыг энэ дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гэдэг нь үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах, эсвэл данснаас хасах /худалдан борлуулах, устгах, солилцох/ үед үүсэх олзыг хөрөнгийн дансны үнэ ба данснаас хасах үед үүссэн цэвэр орлого хоёрын зөрүүгээр тодорхойлно. Үндсэн хөрөнгийн дансны үнэ гэдэг нь түүний анхны өртгөөс ашиглалтын хугацааны туршид байгуулсан элэгдэл буюу хуримтлагдсан.

4.18. Өртөг, зардал

Борлуулалтын өртгийг борлуулалтын орлоготой нь уялдуулж санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлыг нийт дүнгээр нь толилуулна.

4.19. Зээлийн өртөг

Групп нь бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг капиталжуулна. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.



330





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ-03

4.20. Ажилчдын богино хугацааны тэтгэмж

Богино хугацааны ажилчдын тэтгэмж

Ажилчдын богино хугацааны тэтгэмжид хамаарах амралтын мөнгө зэрэг тэтгэмжийг тэтгэмж болон бусад үүргийн дансанд дискаунтчлаагүй дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд дараахийг багтаана. Үүнд:

- (a) цалин урамшуулал;
- (b) ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- (c) нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөрүүд;

Урамшуулал

Групп зөвхөн өнгөрсөн үйл явдлын үр дүнд мөн үүрэг хариуцлагын найдвартай тооцоолол хийх боломжтой тохиолдолд тийм төлбөр хийх өнөөгийн хууль ёсны болон үүсмэл үүрэг хүлээсэн бол урамшууллын төлбөрийн хүлээгдсэн өртгийг хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үүрэг хариуцлага зөвхөн тухайн аж ахуйн нэгжид төлбөр хийхээс өөр бодитой хувилбар байхгүй тохиолдолд л оршино.

4.21. Нөөц, болзошгүй хөрөнгө, өр төлбөр

Шүүхийн маргаан, алдагдалтай гэрээ, зэрэг бусад төлбөрийг үүрэг өнгөрсөн үйл явдлыг үр дүнд бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардагдах магадлалтай бөгөөд мөнгөн дүнг найдвартай хэмжих боломжтой болсон үед нөөцөөр зөвшөөрнө.

Нөөцийг тайлангийн өдрөөр мэдэгдэж буй хамгийн найдвартай нотолгоонд үндэслэсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зардлын мэдээлэлд суурилан тооцно. Хэд хэдэн ижил төстэй үүрэг үүссэн үед, үүрэг хариуцлагын төрлөөр нь тэдгээрийг барагдуулахад шаардлагатай гарах урсгалын магадлалыг тооцдог. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөө үзүүлэхүйц бол нөөцийн өнөөгийн үнэ цэнийг дискаунтчлан тооцдог.

Группийн гуравдагч талаас авах нь тодорхой болсон нөхөн олговрыг тусд нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Тус дүн нь холбогдох нөөцийн дүнгээс ихгүй байна.

Тухайн үүргийг барагдуулахтай холбоотой эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь магадлалтай биш үед өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь бага дүнтэйгээс бусад үүссэн нөхцөлийг болзошгүй өр төлбөрөөр санхүүгийн тайланд тодруулна.

4.22. Засгийн газрын буцалтгүй тусламж

Засгийн газрын буцалтгүй тусламжийг уг тусламжийн нөхцөлийг Групп биелүүлэх ба тусламжийг хүлээж авна гэсэн үндэслэлтэй баталгаа бий болох хүртэл хүлээн зөвшөөрөхгүй.

Эргэлтийн бус хөрөнгийг худалдаж авах, барьж байгуулах эсвэл эзэмших шаардлагыг хангах гэсэн үндсэн нөхцөлтэй засгийн газрын буцалтгүй тусламжийг санхүү байдлын тайланд урьдчилж олсон орлогоор хүлээн зөвшөөрч холбогдох хөрөнгийн ашиглах хугацааны турш системтэй, оновчтой сууриар ашиг, алдагдал руу шилжүүлнэ.

Бусад засгийн газрын буцалтгүй тусламжийг системтэй сууриар холбоотой зардлыг харгалзан нөхөх байдлаар уг зардлыг хэрэгжих тайлангийн үеүдэд орлогоор хүлээн зөвшөөрнө. Группд өмнө нь учирсан гарз, хохирол буюу гарсан зардлыг нөхөн олгохоор тооцож авлага үүсгэсэн буцалтгүй тусламжи болон ирээдүйн зарлагын санхүүжүүлэх зорилгогүйгээр яаралтай тусламж болгон өгсөн засгийн газрын буцалтгүй тусламжийг авлага үүссэн тайлант үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

4.23. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.



331





"Мон Ложистикс Холдинг" ХХК

Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд

2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Охин, салбар, хараат компани дах хөрөнгө оруулалт болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой татварын түр зөрүүний хувьд Групп түр зөрүүний буцаалтад хяналт тавих боломжтой мөн уг түр зөрүү нь урьдчилан харж болох ирээдүйд буцаагдахгүй гэдэг магадлалтайгаас бусад тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалт болон хувь оролцоотой холбоотой хасагдах түр зөрүүнээс үүсч буй хойшлогдсон татварын хөрөнгийг зөвхөн түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед мөн түр зөрүү нь урьдчилан харж болох ирээдүйд буцаагдахаар хүлээгдэж буй тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ (болон татварын хууль)-нд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст Групп хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлдөг.

4.24. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын тодорхойгүй байдалд удирдлагын шүүн тунгаалтыг ашиглах нь

Группийн удирдлага Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардал хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шүүн тунгаалт, тооцоолол, таамаглал ашигладаг.

Удирдлагын томоохон тооцоолол, таамаглал

Групп нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо баримтлахад үүсдэг санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхүйц удирдлагын тооцоолол, таамаглалыг доор харуулав. Үүнд:

Үйлчилгээ болон тээврийн гэрээний орлого хүлээн зөвшөөрөлт

Борлуулалтын дараах үйлчилгээ, тээврийн гэрээ зэргээс орж ирэх орлогыг тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрөхөд тайлант онд хүлээн зөвшөөрөх орлогын дүн нь гэрээний үүрэг биелэлтийн мэдээлэлд үндэслэн хийгддэг. Борлуулалтын дараах засварын хувьд ижил төстэй гэрээ хэрэгжилтийн туршлагад үндэслэн, ирээдүйд үзүүлэх үйлчилгээний тоо хэмжээг тооцдог. Үүнтэй адилаар, тээврийн гэрээний орлогыг гүйцэтгэлийн шатанд уялдуулан тооцоход амласан ажлаа дуусгахад хичнээн цаг зарцуулах талаарх тооцооллыг хийх шаардлагатай болдог.

Дотооддоо хөгжүүлсэн програм хангамжийг капиталжуулах

Програм бүтээхтэй холбоотой судалгаа болон хөгжүүлэлтийн үе шатыг ялган, хөгжүүлэлтийн зардлыг капиталжуулах шаардлага хангагдсан эсэхийг тодорхойлоход удирдлагын шүүн тунгаалт ашигладаг. Группийн удирдлага капиталжуулалтын дараа үнэ цэнийн бууралт хийх нөхцөл үүссэн эсэх, мөн капиталжуулалтын шаардлага хангагдсаар байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөлт

Хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө шилжүүлсэн татварын алданги болон хасагдах түр зөрүү нь ирээдүйн татвар ногдох орлогоор нөхөгдөх магадлалын үнэлгээнд үндэслэнэ.





"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв) 4

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023 05 04

БҮРТГЭВ-03

Мөн татварын орчин дахь хууль эрх зүйн болон эдийн засгийн хязгаарлалт, тодорхойгүй байдлын нөлөөллийг үнэлж дүгнэдэг.

Тооцооллын тодорхойгүй байдал

Хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх, хэмжихэд хамгийн их нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалын талаарх мэдээллийг доор харуулав.

Элэгдэх хөрөнгийн ашиглагдах жил

Удирдлага нь элэгдэх хөрөнгөнд ашиглагдах жилийг хөрөнгийн ашиглалттай уялдуулан тайлант хугацаа бүрт тооцдог. Компьютер дагалдах хэрэглүүртэй холбоотой үүсч болзошгүй технологийн хоцрогдол нь тус тооцооллыг тодорхойгүй болгож болно.

Бараа материал

Удирдлага нь бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тайлагналын өдрөөрх хамгийн найдвартай нотолгоонд суурилан тооцдог. Технологи болон зах зээлийн өөрчлөлттэй хамааралтай борлуулах үнийн бууралт нь тус тооцоололд нөлөөлнө.

Бизнесийн нэгдэл

Удирдлага нь бизнесийн нэгдлийн үр дүнд бий болсон хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлгээний аргачлал ашигладаг. Болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнэ нь худалдагдсан компанийн ирээдүйн ашиг гэх зэрэг олон хувьсагчийн үр дүнгээс хамаардаг.

Тээврийн гэрээний орлого

Тээврийн гэрээний орлого болон авлагаар хүлээн зөвшөөрсөн дүн нь гэрээ бүрт гүйцэтгэлийн болон дуусгалтын үе шатанд хийсэн удирдлагын тооцоололд суурилдаг. Зарим ярвигтай гэрээнд гэрээг дуусгах хүртэлх зардал болон гэрээний ашиг зэрэг тодорхойгүй байх магадлал өндөр тооцоолол ашигладаг.

Бодит үнэ цэнийн хэмжилт

Удирдлага нь санхүүгийн хэрэглүүр болон санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлгээний арга ашигладаг. Зах зээлд оролцогчид уг хэрэглүүрийг хэрхэн үнэлж байгаатай уялдаатайгаар тооцоо, таамаглалыг боловсруулдаг. Удирдлага нь таамаглалыг байнга нээлттэй байдаггүй боломжит мэдээллүүдэд үндэслэдэг. Тооцоолсон бодит үнэ цэнэ нь тайлагналын өдрөөрх холбоогүй талуудын гүйлгээний бодит үнээс өөр байх магадлалтай.

Түрээс – түрээсийн өр төлбөрийг хэмжих дискаунтын хувийн тодорхойлолт

Групп/компани нь гуравдагч талтай түрээсийн гэрээ байгуулсан бөгөөд түрээслүүлэгчийн нуугдмал хүүгийн төвшинг тодорхойлох боломжгүй байсан. Иймээс групп/компани нь түрээс эхлэх өдрөөр түрээсийн өр төлбөрийг бүртгэхдээ өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн төвшинг дискаунтын хувь болгох ашигласан. Өсөн нэмэгдэх хүүгийн төвшин нь Групп/компани нь өөр ижил төстэй зээл авахад төлөх хүүгийн төвшин юм.

Групп нь Монголбанкны арилжааны банкны зээлийн жигнэсэн дундаж хувийг ашигласан.

5. Салбар компанид оруулсан хөрөнгө оруулалт

Группийн бүрэлдэхүүн

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах охин компаниудыг багтаасан. Үүнд:

2022.12.31	Эзэмшлийн хувь	Улс	Байгуулагдсан огноо	Үйлдвэрлэлийн салбар
Охин компани				
Монложистикс ворлдвайд ХХК	100%	Монгол	2005.11.27	ОУ-ын тээвэр зуучлал
Монложистикс транзит ХХК	60%	Монгол	2019.07.04	Транзит тээвэр
Монложистикс тракинг ХХК	100%	Монгол	2021.02.05	Авто машинаар ачаа тээвэрлэх
Монложистикс карго ХХК	100%	Монгол	2021.02.05	Хүргэлтийн үйлчилгээ




338





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



2022.12.31	Эзэмшлийн хувь	Улс	Байгуулагдсан огноо	Үйлдвэрлэлийн салбар
Охин компани				
Монложистикс Россия холдинг ХХК	90%	Монгол	2021.03.31	Менежментийн зөвлөх үйлчилгээ
Монложистикс транс сервис ХХК	90%	Орос	2021.06.24	Авто машинаар ачаа тээвэрлэх
Каус Аустралис ХХК	51%	Монгол	2019.07.30	Авто машинаар ачаа тээвэрлэх
Мон Ложистикс Экүйментс ХХК	100%	Монгол	2022.11.28	Бөөний худалдаа
Мон Ложистикс Экспресс ХХК	100%	Монгол	2022.11.28	Бөөний худалдаа

Тайлант хугацаанд шинээр Каус Аустралис ХХК-нд хөрөнгө оруулалт оруулж, Монложистикс Экүйментс ХХК, Монложистикс Экспресс ХХК-уудыг шинээр үүсгэн байгуулсан.

6. Сегментийн тайлагнал

Групп Тодруулга 1-д дэлгэрэнгүй тайлбарласан үйл ажиллагааны сегментүүдэд үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр үйл ажиллагааны сегмент хяналтад байдаг ба тохируулсан сегментийн үйл ажиллагааны үр дүнд суурилан стратегийн шийдвэрийг гаргадаг.

2022 оны 12-р сарын 31-нээр хувьд орлого, өртөгийг сегментээр нь харуулбал дараах байдалтай байна Үүнд:

Мянган төгрөгөөр	2022 он		
	Сегментийн орлогын дүн	Сегментийн өртөгийн дүн	Сегментийн үйл ажиллагааны ашиг
Тээврийн үйлчилгээ	133,861,631	118,491,434	15,370,197
Бусад үйлчилгээ	6,261,048	4,768,867	1,492,181
Нийт	140,122,679	123,260,301	16,862,378

2021 оны 12-р сарын 31-нээр хувьд орлого, өртөгийг сегментээр нь харуулбал дараах байдалтай байна Үүнд:

Мянган төгрөгөөр	2021 он		
	Сегментийн орлогын дүн	Сегментийн өртөгийн дүн	Сегментийн үйл ажиллагааны ашиг
Тээврийн үйлчилгээ	79,155,005	71,200,760	7,954,245
Бусад үйлчилгээ	3,185,713	2,865,582	320,131
Нийт	82,340,718	74,066,342	8,274,376

7. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ангилал

Тодруулга 4.8-д санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн ангилал бүрийн тайлбар, холбогдох бүртгэлийн бодлогыг тодруулсан. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь 2022 оны 12-р сарын 31-нээр ангилал тус бүрээр дараах байдалтай байна. Үүнд:

2022 оны 12 сарын 31	Хорогдуулсан өртөг	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгө	14,198,308	-	-	14,198,308
Дансны болон бусад авлага *	19,504,042	-	-	19,504,042



2022-09-14

БҮРТГЭВ-03



"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

2022 оны 12 сарын 31 Мянган төгрөгөөр	Хорогдуулсан өртөг	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө	Нийт
Бусад санхүүгийн хөрөнгө	634,356	274,412	-	908,768
Урт хугацаат хөрөнгө оруулалт	14,000	-	-	14,000
Санхүүгийн хөрөнгийн дүн	34,350,706	274,412	-	34,625,118
Санхүүгийн өр төлбөр				-
Урт хугацаат зээл	16,667	-	-	16,667
Богино хугацаат зээл	2,800,000	-	-	2,800,000
Дансны болон бусад өглөг *	11,399,190	187,703	-	11,586,893
Санхүүгийн өр төлбөрийн дүн	14,215,857	187,703	-	14,403,560

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь 2021 оны 12-р сарын 31-нээр ангилал тус бүрээр дараах байдалтай байна. Үүнд:

2021 оны 12 сарын 31 Мянган төгрөгөөр	Хорогдуулсан өртөг	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,815,535	-	-	5,815,535
Дансны болон бусад авлага *	13,516,065	-	-	13,516,065
Бусад хөрөнгө оруулалт	14,000	-	-	14,000
Санхүүгийн хөрөнгийн дүн	19,345,600	-	-	19,345,600
Санхүүгийн өр төлбөр				
Урт хугацаат зээл	750,000	-	-	750,000
Богино хугацаат зээл	750,000	-	-	750,000
Дансны болон бусад өглөг *	4,853,879	-	-	4,853,879
Санхүүгийн өр төлбөрийн дүн	6,353,879	-	-	6,353,879

Группийн эрсдэлийн удирдлагын зорилго, бодлого зэрэг санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлийн тодруулгыг тодруулга 36-с харна уу.

8. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Ашиглах эрхтэй хөрөнгө (Тодруулга 17-с харна уу)	162,898	296,200	-
Ажиллагсдаас авах зээлийн авлага (1)	217,494	-	-
Гадаад агентад байршуулсан барьцаа төлбөр (2)	528,376	-	-



Бусад урт хугацаат санхүүгийн хөрөнгийн дүн

908,768


296,200





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



(1) Групп нь ажилчдад орон сууц худалдан авахад дэмжлэг болгон 4 ажилтанд жилийн тэг хувийн хүүтэй 24-36 сарын хугацаатай, 263,380.0 мянган төгрөгийн зээлийг сар бүр гэрээний хавсралтад тусгасан хуваарийн дагуу төлж барагдуулах нөхцөлтэй олгосон бөгөөд зээлийн үлдэгдэл 217,493.5 мянган төгрөг байна.

9. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Урт хугацаат хөрөнгө оруулалт	14,000	14,000	14,000
Нийт урт хугацаат хөрөнгө оруулалтын дүн	14,000	14,000	14,000

2019 оны 10 дугаар сарын 7-нд "Монложистикс Ворлдвайд" ХХК нь "Үндэсний тээврийн корпораци" ХХК-ийн нэг бүр нь 1.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 14,000 ширхэн энгийн хувьцааг 14,000 мянган төгрөгөөр худалдан авсан.

10. Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Програм хангамж	Нийт
Өртөг		
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	47,095	47,095
Нэмэгдсэн	22,985	22,985
Хасагдсан	-	-
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	70,080	70,080
Нэмэгдсэн	110,790	110,790
Хасагдсан	-	-
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	180,870	180,870
Хуримтлагдсан хорогдуулга		
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(1,174)	(1,174)
Нэмэгдсэн	(5,474)	(5,474)
Данснаас хасагдсан	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(6,648)	(6,648)
Нэмэгдсэн	(10,836)	(10,836)
Данснаас хасагдсан	-	-
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(17,484)	(17,484)
Үлдэгдэл өртөг		
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	45,921	45,921
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	63,432	63,432
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	163,386	163,386

Хорогдуулгын зардлыг Орлогын тайлангийн 27 дугаар мөрөнд тусгасан байна. Тодруулга 27-с харна уу.





11. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Бусад үндсэн хөрөнгө	Нийт
Өртөг						
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	193,158	155,329	220,094	-	-	568,581
Нэмэгдсэн	828,994	121,153	138,669	-	-	1,088,816
Хасагдсан	(78,225)	(41,412)	(30,403)	-	-	(150,040)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	943,927	235,070	328,360	-	-	1,507,357
Нэмэгдсэн	166,699	99,498	212,251	500	15,685	494,633
Хасагдсан	(120,960)	(24,956)	(22,762)	-	-	(168,678)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	989,666	309,612	517,849	500	15,685	1,833,312
Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт						
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(52,711)	(50,258)	(135,515)	-	-	(238,484)
Тухайн жилийн өөрчлөлт	(56,305)	(17,596)	(95,496)	-	-	(169,397)
Данснаас хассан	18,288	6,348	28,951	-	-	53,587
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(90,728)	(61,506)	(202,060)	-	-	(354,294)
Тухайн жилийн өөрчлөлт	(93,781)	(24,201)	(132,737)	(142)	(778)	(251,639)
Данснаас хассан	17,577	24,496	16,078	-	-	58,151
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(166,932)	(61,211)	(318,719)	(142)	(778)	(547,782)
Үлдэгдэл өртөг						
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	140,447	105,071	84,579	-	-	330,097
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	853,199	173,564	126,300	-	-	1,153,063
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	822,734	248,401	199,130	358	14,907	1,285,530

Группийн 123,789.6 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр зээлийн барьцаанд байна. (2021 оны 12 дугаар сарын 31: 0 мянган төгрөг байна). 2022 оны нэмэгдсэн дүн нь 494,633.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (2021: 1,088,816.0 мянган төгрөг) байна. Элэгдлийн зардлыг Орлогын тайлангийн 24, 27 дугаар мөрөнд тусгасан.

12. Бараа материал

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Хангамжийн материал	21,326	18,066	381
Бэлэн бүтээгдэхүүн	82,055	-	-
Бараа материалын дүн	103,381	18,066	381

Тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын өртөг нь 11,309.6 мянган төгрөг (2021 онд: 25,990.1 мянган төгрөг) байна. 381.0 мянган төгрөгийн (2021 онд: 381.0 мянган төгрөг) бараа материалыг 12 сараас илүү хугацаанд ашиглагдана гэж үзэж байна. Өр төлбөрийн барьцаанд байгаа бараа материал байхгүй. Өр төлбөрийн барьцаанд байгаа бараа материал байхгүй.





13. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Тээврийн урьдчилгаа	5,429,178	3,984,678	1,997,425
Орон сууцны урьдчилгаа	-	198,750	-
Түрээсийн урьдчилгаа	18,621	28,512	27,785
Программын засвар, үйлчилгээний урьдчилгаа	-	7,022	22,256
Даатгалын урьдчилгаа	11,866	34,746	37,239
Бусад урьдчилгаа	201,910	216,831	18,078
Урьдчилж төлсөн зардал/тооцооны дүн	5,661,575	4,470,539	2,102,783

Урьдчилж төлсөн зардал/тооцооны хөдөлгөөн дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	4,470,539	2,102,784	596,539
Нэмэгдсэн	71,010,116	37,872,715	26,508,717
Хасагдсан (зардлаар хүлээн зөвшөөрсөн)	(69,676,656)	(35,485,657)	(24,960,973)
Хасагдсан (хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн)	(142,424)	(19,303)	(41,500)
Урьдчилж төлсөн зардал/тооцооны дүн	5,661,575	4,470,539	2,102,783

14. Дансны болон бусад авлага

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Дансны авлага	15,965,655	12,916,133	13,608,402
Найдваргүй авлагын хасагдуулга	(133,592)	-	-
Санхүүгийн хөрөнгийн дүн	15,832,063	12,916,133	13,608,402
Татварын авлага	501,060	111,064	19,245
НДШ-ийн авлага	13,777	2,810	941
Бусад авлага (1)	3,157,142	599,932	60,765
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	3,671,979	713,806	80,951
Дансны болон бусад авлагын дүн	19,504,042	13,629,939	13,689,353


Дансны болон бусад авлагууд нь бүгд богино хугацаатай байна. Дансны авлагын цэвэр дансны үнэ нь бодит үнэтэй ойролцоо гэж үзэж байна.

Дансны авлагад хүү тооцохгүй. Групп нь 365 өдрөөс дээш хугацаатай авлагад бүрэн нөөц байгуулсан байна. Хугацаа хэтэрсэн болон төлөгдөхгүй болсон нь удирдлагын шийдвэр болон хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон тохиолдолд найдваргүй авлагын зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

(1) Бусад авлага дансанд 100 хувь төлбөрийг хийж "Орон сууцны захиалгын гэрээ" байгуулсан дараах ашиглалтад ороогүй үл хөдлөх хөрөнгүүд байна.



"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



Захиалгын гэрээ байгуулсан компанийн нэр	Нийт үнэ
Тэсо пропертис ХХК	643,330
Оршил констракшн ХХК	187,486
Ай ди си проперти ХХК	170,742
Ай ди си проперти ХХК	117,370
Рио Виста төсөл	287,636
Нийт дүн	1,406,564

15. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Бэлэн мөнгө			
- Төгрөг	7,641	8,788	1,351,128
Банкны үлдэгдэл			
- Төгрөг	4,602,077	3,798,446	3,240,686
- Ам.доллар	6,145,784	1,976,111	4,598,727
- Рубль	405,772	27,316	416
- Юань	1,237,353	4,046	200
- Евро	80,852	828	86,107
- Фунт стерлинг	219	-	-
3 хүртэлх сарын хугацаатай хадгаламж			
- Төгрөг	1,718,610	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	14,198,308	5,815,535	9,277,264

Дараах нөхцөл бүхий хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө байна. Үүнд:

Банкны нэр	Эхэлсэн огноо	Дуусах огноо	Хүүний хувь жилийн	Дүн мянган төгрөгөөр
Худалдаа хөгжлийн банк	10/25/2022	1/25/2023	11.20%	500,000
Голомт банк	10/26/2022	1/26/2023	11.30%	509,074
Голомт банк	12/28/2022	3/28/2023	11.50%	509,536
Капитрон банк	11/28/2022	2/28/2023	10.20%+ Урамшуулал	200,000
Нийт дүн				1,718,610

Эдгээр нь бүгд төгрөгийн хадгаламж байна. Эдгээр хадгаламжуудыг дуусвар болох хугацаанаас нь өмнө татахыг хязгаарласан. Хэрэв хугацаанаас нь өмнө хадгаламжийн гэрээг цуцалбал, жилийн хүү нь 2.4%-3.2% болж буурах нөхцөлтэй. Гэрээний үүргийн биелэлтээр урамшуулал тооцон олгох хүү нь 1.4 хувиар хугацааны эцэст олгох нөхцөлтэй байна.



2023-06-14

БҮРТГЭВ-03

"Мон Ложистикс Холдинг" ХХК
Бүртгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөд илэсхийлэв)



16. Капитал ба нөөц

16.1 Хувьцаат капитал /дүрмийн сан/

Хувьцааны тоо өөрөөр заагаагүй бол	Энгийн хувьцаа		
	2022	2021	2020
Эхний үлдэгдэл (ширхэгээр)	22,944	22,944	22,944
Нэмж гаргасан хувьцаа (ширхэгээр)	1,438	-	-
Эцсийн үлдэгдэл (ширхэгээр)	24,382	22,944	22,944
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	4,358.45	4,358.45	4,358.45
Хувьцаат капиталын дүн /мянган төгрөгөөр/	106,268	100,000	100,000

Групп нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын №2-001-2022ХЭХ/20220131 тоот тогтоолоор нэгж хувьцааны зах зээлийн үнийг 943.4 мянган төгрөгөөр тогтоож 1,438 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах, 1,000 ширхэг халаасны хувьцааг эргэлтэд оруулахаар шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн ээлжит бус хурлын №1-005-2022ХЭХ/20221111 тоот тогтоолоор нэгж хувьцааны зах зээлийн үнийг 1,539.0 мянган төгрөгөөр тогтоож 1,950 ширхэг энгийн хувьцааг эргүүлэн татаж халааслахаар шийдвэрлэсэн байна.

16.2 Халаасны хувьцаа

Компаниуд гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан халаасны хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна. Халаасны хувьцаа нь гаргасан хувьцааны тоонд орж тооцогдох боловч эргэлтэнд байгаа хувьцааны тоонд орохгүй. Аж ахуйн нэгж нь гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах, борлуулах, гаргах, хүчингүй болгох үед үүссэн олз (гарз)-ыг ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрөхгүй.

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Халаасны хувьцаа	3,001,050	60,000	60,000
Халаасны хувьцааны дүн	3,001,050	60,000	60,000

Халаасны хувьцааны хөдөлгөөн дараах байдалтай байна. Үүнд:

	Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөг/	Зах зээлийн үнэ /төгрөг/	Халаасны хувьцаа /мянган төгрөг/	Халаасны хувьцаа НТК /мянган төгрөг/
Эхний үлдэгдэл	1000	4,358.45	60,000	60,000	-
Хасагдсан	1000	4,358.45	943,397	60,000	883,397
Нэмэгдсэн	1950	4,358.45	1,539,000	3,001,050	-
Эцсийн үлдэгдэл	1,950	4,358.45		3,001,050	883,397

16.3 Нэмж төлөгдсөн капитал

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Нэмж төлөгдсөн капитал - энгийн хувьцаа	1,350,336	-	-
Нэмж төлөгдсөн капитал – халаасны хувьцаа	883,397	-	-

Нэмж төлөгдсөн капиталын дүн

2,233,733



"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



16.4 Хуримтлагдсан ашиг

Үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэнэ.

17. Санхүүгийн түрээс

17.1 Ашиглах эрхтэй хөрөнгө

Мянган төгрөгөөр	Оффис	Нийт
Өртөг		
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	-	-
Нэмэгдсэн	673,109	673,109
Хасагдсан	(249,874)	(249,874)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	423,235	423,235
Нэмэгдсэн	164,189	164,189
Хасагдсан	(30,515)	(30,515)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	556,909	556,909
Хуримтлагдсан элэгдэл		
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	-	-
Нэмэгдсэн	(172,408)	(172,408)
Хасагдсан	45,373	45,373
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(127,035)	(127,035)
Нэмэгдсэн	(292,171)	(292,171)
Хасагдсан	25,195	25,195
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(394,011)	(394,011)
Үлдэгдэл өртөг		
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	296,200	296,200
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	162,898	162,898

17.2 Түрээсийн өр төлбөр

Түрээсийн өр төлбөрийг тусдаа санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар толилуулсан. Үүнд:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Богино хугацаат	82,701	215,966	215,966
Урт хугацаат	105,002	98,211	98,211
Нийт дүн	187,703	314,177	314,177

Дараах хүснэгтэд компанийн түрээсийн үйл ажиллагааг ашиглах эрхтэй хөрөнгийн төрөл тус бүрээр харуулав:

Ашиглах эрхтэй хөрөнгө	Түрээсэлсэн хөрөнгийн тоо	Түрээсийн хугацаа	Хугацааг сунгах сонголттой түрээсийн тоо	Худалдаж авах сонголттой түрээсийн тоо	Хувьсах төлбөрийн нөхцөлтэй түрээсийн тоо	Цуцлах сонголттой түрээсийн тоо
Оффис	3	24 сар	3	-	-	3



341





"Мон Ложистикс Холдинг" ХХК
 Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
 2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХЭРЭНГИЙН БИРЖ
 MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ-03

Түрээсийн өр төлбөр нь санхүүгийн түрээсийн дагуу эзэмшиж байгаа хөрөнгөөр баталгаажсан байна. Тайлант жилийн эцсээр санхүүгийн түрээсийн хамгийн бага төлбөр нь дараах байдалтай байна. Үүнд:

Мянган төгрөгөөр	1 жилийн дотор	1-2 жил	Нийт
2022 оны 12 сарын 31			
Түрээсийн төлбөр	82,701	105,002	187,703
Санхүүгийн зардал	(5,075)	(33,670)	(38,745)
Цэвэр өнөөгийн үнэ цэнэ	77,626	71,332	148,958

18. Хойшлогдсон татварын хөрөнгө

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	-	-	-
Ашиг, алдагдлыг өсгөсөн	39,463	-	-
Эцсийн үлдэгдэл	39,463	-	-

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хугацааны хойшлогдсон орлогын албан татвар нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн	Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн	2022 оны 01 дугаар сарын 01-ний үлдэгдэл
Хойшлогдсон татварын хөрөнгө				
Зээлийн авлага	39,463	-	39,463	-
	39,463	-	39,463	-
Хойшлогдсон татварын өр төлбөр				
Биет бус хөрөнгө	2,974	-	2,974	-
Гадаад валютын ханшийн зөрүү	38,021	-	38,021	622
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	86,678	-	86,056	-
	127,673	-	127,051	622
Цэвэр дүн – хойшлогдсон татварын өр төлбөр	(88,210)	-	(87,588)	(622)

19. Бусад богино хугацаат өр төлбөр

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Ажиллагсад өгөх өглөг	471,866	344	43,665
Баталгаа, барьцааны өглөг	103,916	159,666	-
Зээлийн хүүгийн өглөг	213,462	3,543	-
Бусад өглөг	132,886	170,323	6,173
Нийт дүн	921,930	333,876	49,838



342





20. Зээл

21.1 Богино болон урт хугацаат зээл

Мянган төгрөгөөр	Богино хугацаат		Урт хугацаат	
	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Баталгаатай банкны зээллэг (1)	800,000	750,000	16,667	750,000
Бондын өглөг (2)	2,000,000	-	-	-
Зээлийн дүн	2,800,000	750,000	16,667	750,000

(1) "Монложистикс ворлдвайд" ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Худалдаа хөгжлийн банктай 2 жилийн хугацаатай, жилийн 14.4%-ийн хүүтэй, 1,500,000.0 мянган төгрөгийн №3НГ/СС211217031/1 тоот эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээ байгуулсан байна. 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр зээлийн №3НГ/СС211217031/1-1 тоот нэмэлт гэрээгээр зээлийн хэмжээг 1,000,000.0 мянган төгрөг болгон бууруулсан. Банкны барьцаанд компанийн ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө болон харилцан хамаарал бүхий этгээдийн хадгаламж, үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан байна.

"Монложистикс тракинг" ХХК нь 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Худалдаа хөгжлийн банктай 2 жилийн хугацаатай, жилийн 10%-ийн хүүтэй, 300,000.0 мянган төгрөгийн №3Г/СС220114014-3 тоот эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээ байгуулсан байна. Банкны барьцаанд компанийн үндсэн хөрөнгө болох 4 автомашин, ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө барьцаалсан байна.

(2) Компани нь "Мандал капитал маркет ҮЦК" ХХК-тай Андеррайтерийн гэрээ байгуулан 2022 оны 7 дугаар сарын 9-ний өдөр "Транч-1"-т 1,000,000.0 мянган төгрөг, 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдөр "Транч-2"-т 1,000,000.0 мянган төгрөгийн нийт 2,000,000.0 мянган төгрөгийн бондыг амжилттай гаргасан. Бонд нь 12 сарын хугацаатай, хөвөгч хүүтэй буюу 8 хувийн хүү + урамшуулал олгох нөхцөлтэй. Бондын батлан даагчаар толгой компани "Мон Ложистикс Холдинг" ХХК, түүний охин компаниуд болох "Монложистикс карго" ХХК, "Монложистикс Транзит" ХХК, "Монложистикс тракинг" ХХК, "Монложистикс Россия холдинг" ХХК нар байна.

Зээлийг илэрхийлсэн валютын талаар тодруулга 36-с харна уу.

Зээлийн мэдээллийг дэлгэрэнгүй харуулбал:

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин (жилийн)	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 01 сарын 01
Баталгаатай банкны зээллэг						
Худалдаа хөгжлийн банк	төгрөг	14.4%	2021.12.20	2023.12.20	600,000	1,500,000
Худалдаа хөгжлийн банк	төгрөг	10.0%	2022.01.17	2024.01.17	300,000	-
Бондын өглөг						
Транч-1	Мандал капитал маркет ҮЦК ХХК	төгрөг 8%+Урамшуулал	2022.07.08	2023.07.07	72,000	-
	Иргэн	төгрөг 8%+Урамшуулал	2022.07.08	2023.07.07	928,000	-
Транч-2	Иргэн	төгрөг 8%+Урамшуулал	2022.07.29	2023.07.28	1,000,000	-

Бондын хүүг улирал тутам төлөх бөгөөд Урамшууллын хүү нь жилийн 17 хувиас хэтрэхгүй байх нөхцөлтэй байна.





"Мон Логистикс Холдинг" ХХК
 Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
 2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



21. Урьдчилж орсон орлого

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	337,449	-	-
Нэмэгдсэн	16,488,388	16,759	-
Хасагдсан (орлогоор хүлээн зөвшөөрсөн)	15,267,742	354,207	-
Урьдчилж орсон орлогын дүн	1,558,095	337,448	-

22. Дансны ба бусад өглөг

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01
Дансны өглөг	9,538,367	4,277,491	12,049,647
Цалингийн өглөг	471,425	707,438	114,435
Татварын өр (1)	1,306,566	983,678	191,305
НДШ - ийн өглөг	82,832	69,726	11,498
Нийт дүн	11,399,190	6,038,333	12,366,885

(1) Татвартай холбоотой өглөгийн дэлгэрэнгүйг харуулбал дараах байдлтай байна. Үүнд:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31 (дахин тайлагнасан)	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл
ААНОАТ-ын өр	906,298	443,550	110,099
НӨАТ-ын өр	119,892	146,191	62,766
Суутган татварын өр	280,576	393,937	18,440
Татварын өрийн дүн	1,306,566	983,678	191,305

Дансны өглөгт ямар нэгэн хүү тооцохгүй. Групп нь зээлийн хугацаанд бүх өглөгийг төлөх санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлоготой.

23. Орлого

Мянган төгрөгөөр	2022	2021
Тээврийн үйлчилгээний орлого	133,861,631	79,155,005
Бусад борлуулалт	6,261,048	3,185,713
Нийт борлуулалтын орлого	140,122,679	82,340,718

Группийн орлогыг хүлээн зөвшөөрөх онцлогоор нь задалж харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

2022 оны 12 сарын 31	Хүргэх цэгт буюу хугацааны тодорхой агшинд бүртгэсэн орлого	Цаг хугацааны явцад хүлээн зөвшөөрөх орлого	Нийт
Тээврийн үйлчилгээний орлого	133,861,631	-	133,861,631
Бусад борлуулалт	6,261,048	-	6,261,048
Бүгд	140,122,679	-	140,122,679



"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



2023.05.23

БҮРТГЭВ-03

2022 оны 12 сарын 31	Хүргэх цэгт буюу хугацааны тодорхой агшинд бүртгэсэн орлого	Цаг хугацааны явцад хүлээн зөвшөөрөх орлого	Нийт
2021 оны 12 сарын 31	Хүргэх цэгт буюу хугацааны тодорхой агшинд бүртгэсэн орлого	Цаг хугацааны явцад хүлээн зөвшөөрөх орлого	Нийт
Тээврийн үйлчилгээний орлого	79,155,005	-	79,155,005
Бусад борлуулалтын орлого	3,185,713	-	3,185,713
Бүгд	82,340,718	-	82,340,718

24. Өртөг

Мянган төгрөгөөр	2022	2021
Тээврийн үйлчилгээний өртөг	118,491,434	71,200,760
Бусад борлуулалтын өртөг	4,768,867	2,865,582
Бүгд	123,260,301	74,066,342

Борлуулалтын өртөгт гадаад болон дотоод тээврийн төлбөр, цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, талбайн зардал, ачиж буулгахтай холбоотой гарсан зардлууд, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, даатгалын зардал зэрэг зардлуудыг хуваарилж бүртгэсэн байна.

25. Бусад орлого

Мянган төгрөгөөр	2022	2021
Алданги торгуулийн орлого	-	1,841
Онцгой шинжтэй олз	43	246
Үндсэн үйл ажиллагааны бус бусад орлого	58,840	175,394
Засгийн газрын буцалтгүй тусламжийн орлого	-	46,504
Бусад орлого	-	56,931
Бусад орлогын дүн	58,883	280,916

26. Борлуулалт, маркетингийн зардал

Мянган төгрөгөөр	2022	2021
Зар сурталчилгааны зардал	184,650	43,389
Ивээн тэтгэлэг	26,534	-
ПР, Нийгмийн хариуцлагын зардал (1)	592,529	49,195
Борлуулалт, маркетингийн зардлын дүн	803,713	92,584

(1) Группийг олон нийтэд сурталчлах зорилгоор "Бээжин-2022" өвлийн олимп, Дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг эх орондоо шууд дамжуулахад 456,986.0 мянган төгрөг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад 116,607.0 мянган төгрөг, бусад 18,944.0 мянган төгрөгийн үйл ажиллагааг ивээн тэтгэж ажилласан байна.



345





"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийллэ)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2023.05.11
БҮРТГЭВ-03

27. Ерөнхий ба удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	2022	2021
Ажиллагсадын үндсэн цалингийн зардал	3,101,933	2,218,445
Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл	418,388	214,467
Ажилчдад төлсөн тэтгэмжийн зардал	40,728	22,300
Ашиглалтын зардал	14,056	2,741
Томилолтын зардал	123,392	46,281
Даатгалын зардал	242,853	18,238
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	9,353	1,915
Шатахууны зардал	6,309	3,849
Албан татвар төлбөр хураамжийн зардал	69,200	15,387
Элэгдэл, Хорогдлын зардал	398,781	365,591
Шуудан холбооны зардал	47,688	37,056
Бичиг хэргийн зардал	18,401	25,511
Хүлээн авалтын зардал	175,721	81,807
Зөвлөх үйлчилгээний зардал	151,899	67,934
Засварын зардал	24,380	83,410
Сургалт хөгжлийн зардал	71,556	12,958
Түрээсийн зардал	35,404	105,124
Үйл ажиллагааны бусад зардал	489,834	180,834
Ерөнхий ба удирдлагын зардлын дүн	5,439,876	3,503,848

28. Бусад зардал

Мянган төгрөгөөр	2022	2021
Найдваргүй авлагын зардал	181,650	286,568
Хандив, тусламжийн зардал	4,738	8,410
Зогсоолын төлбөр	-	2,291
Алданги, торгуулийн зардал	45,786	1,841
Бусад зардал	108,451	15,772
Бусад зардлын дүн	340,625	314,882

29. Санхүүгийн зардал болон орлого

Санхүүгийн зардал нь дараахаас бүрдэж байна.

Мянган төгрөгөөр	2022	2021
Хүүгийн зардал	470,567	-
Санхүүгийн түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	57,401	26,222
Санхүүгийн зардлын дүн	527,968	26,222

Санхүүгийн орлого нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2022	2021
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлээс олсон хүүгийн орлого	56,726	28,266
Бондын хүүгийн орлого (1)	24,923	-



346





"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

МОНГОЛЫН ХЭРЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

2022 00 14

БҮРТГЭВ-03
2022 2021

Мянган төгрөгөөр	2022	2021
Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн хүү	61,213	-
Санхүүгийн орлогын дүн	142,862	28,266
Санхүүгийн орлого (зардал)-ын дүн	(385,106)	2,044

(1) "Монложистикс ворлдвайд" ХХК нь хоёрдогч арилжаанаас дараах нөхцөлтэй бондыг 2022 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр худалдан авч 31 хоног ашиглан эргүүлэн борлуулсан байна.

Бондын нэр:	Номин
Бонд гаргасан компаний нэр:	Номин Трейдинг ХХК
Нэгж үнэ:	1,000.0 мянган төгрөг
Жилийн хүү:	10%
Хуримтлагдсан хүүгийн орлого:	15,534.2 мянган төгрөг
Ашигласан хугацааны хүүгийн орлого:	9,388.8 мянган төгрөг

30. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Мянган төгрөгөөр	2022	2021
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	6,172,141	316,731
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(4,771,129)	(358,085)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ын дүн	1,401,012	(41,354)

31. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)

Мянган төгрөгөөр	2022	2021
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	373	7,922
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(3,639)	(34,119)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)-ын дүн	(3,266)	(26,197)

32. Орлогын татварын зардал


Мянган төгрөгөөр	2022	2021
Тайлант жилийн татвар	1,570,315	685,389
Хойшлогдсон татвар (тодруулга 9-с харна уу)	88,210	622
Орлогын татварын зардлын дүн	1,658,525	686,011

Үр ашигт татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна.

Мянган төгрөгөөр	2022	2021
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	11,349,687	4,578,471
Бусдад суутгуулсан орлого	(1,154,150)	-
Бусдад олгосон зээлийн хүүгийн орлого	53,820	(23,774)
Тусгайлан хувь хэмжээтэй орлого	(215,480)	(28,266)
Татвараас хасагдахгүй зардал	720,636	1,532,329
Хойшлогдсон татварын түр зөрүүний нөлөө	(882,101)	(6,224)



347





Мянган төгрөгөөр	2022	2021
Нийт татвар ногдох орлого	9,872,412	6,052,536
Нийтлэг хувь хэмжээгээр ногдох орлогын албан татвар (2022: 10%, 25%)	1,419,687	680,185
Бусдад суутгуулсан орлогын албан татвар	127,102	-
Бусдад олгосон зээлийн хүүгийн орлогын албан татвар	14,819	2,377
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцох орлогын албан татвар (2022: 10%)	7,685	2,827
Засгийн газрын буцалтгүй тусламж	1,022	-
Хойшлогдсон орлогын албан татварын зардал	88,210	622
Орлогын албан татварын зардал	1,658,525	686,011

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн мэдээллийг тодруулга 21-с харна уу.

33. Холбоотой талын ажил гүйлгээ

Группийн холбоотой талд голлох удирдлага, хараат болон хамтын хяналттай компани, толгой болон охин компани, нэгтгэсэн хяналт дор байдаг зэрэгцээ аж ахуйн нэгжүүд хамаарна.

33.1 Хяналтын харилцаа

Группийг тус компанийн 32.11%-ийг эзэмшдэг Л.Ганзоригт хянадаг. Группийн дээд толгой компани нь Монгол улсад хуулийн этгээдээр бүртгэгдэж, Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нью Хоризонс оффис, 11 давхар, 1101 тоотод байрлах Мон Логистикс Холдинг ХХК бөгөөд санхүүгийн тайлангаа олон нийтэд зориулан гаргадаггүй байна. Группийн хяналтын эрх бүхий хамгийн дээд компани нь Мон Логистикс Холдинг ХХК юм.

33.2 Охин компанитай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацааны охин компаниудад Монложистикс Ворлдвайд ХХК, Монложистикс Тракинг ХХК, Монложистикс Транзит ХХК, Монложистикс Карго ХХК, Монложистикс Россия холдинг ХХК, Монложистикс Транс сервис ХХК, Монложистикс Экүйпмент ХХК, Монложистикс Экспресс ХХК зэрэг компаниуд багтана.

Мянган төгрөгөөр	2022	2021
Ажил, үйлчилгээний орлого	3,242,348	1,025,704
Үндсэн хөрөнгийн борлуулалт	5,909	35,078
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа	2,104	4,065,181
Олгосон зээл	1,750,000	440,000
Хүүгийн орлогын хуримтлал	9,212	23,774
Хоорондын тооцоо	3,552,971	89,144
Хувьцаа буцаан худалдан авсан	3,001,050	-

33.3 Удирдлага болон тэдний ойр дотны гэр бүлийн гишүүдтэй хийсэн ажил гүйлгээ

Голлох удирдлагад ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, тэдний гэр бүлийн гишүүд хамаарна. Голлох удирдлагын тайлант оны цалин хөлс, урамшуулал, холбогдох бусад тэтгэмжийн зардал дараах байдалтай байна. Үүнд:

Мянган төгрөгөөр	2022	2021
Цалин хөлс, урамшуулал	1,211,433	588,293
Нийгмийн даатгалын зардал	167,346	63,138

1,378,779 651,431



"Мон Ложистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



33.4 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үлдэгдэл

Мянган төгрөгөөр	2022	2021
Авлага		
Монложистикс Ворлдвайд ХХК	-	92,445
Монложистикс Транзит ХХК	-	-
Монложистикс Россия Холдинг ХХК	347,655	91,175
Монложистикс Тракинг ХХК	3,162	1,914
Монложистикс Карго ХХК	23,674	1,144
Каус Аустралис ХХК	4,400	-
Авлагын дүн	378,891	186,678
Олгосон зээлийн үлдэгдэл		
Хувьцаа эзэмшигч	593,894	-
Каус Аустралис ХХК	1,500,000	-
Монложистикс Карго ХХК	250,000	-
Охин компанийн гүйцэтгэх удирдлага	73,333	-
Олгосон зээлийн үлдэгдэл дүн	2,417,227	-
Нийт холбоотой талын авлагын дүн	2,796,118	186,678
Өглөг		
Монложистикс Ворлдвайд ХХК	3,000,000	89,713
Монложистикс Карго ХХК	787	-
Нийт холбоотой талын өглөгийн дүн	3,000,787	89,713

34. Болзошгүй өр төлбөр

Тайлант хугацаанд Группийн эсрэг хуулийн зарга маргаантай холбоотой болзошгүй өр төлбөр байхгүй байна.

35. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэглүүрийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг тодруулга 4.8-д дэлгэрэнгүй харуулсан болно.

Групп нь санхүүгийн хэрэглүүрийн идэвхтэй арилжаанд оролцдоггүй. Компанийн өртөж болох томоохон санхүүгийн эрсдэл нь доорх байдалтай байна.


35.1. Зах зээлийн эрсдэл

Групп санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.





"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)



Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжаас мөн зээлийн эрсдэл үүснэ.

35.2. Гадаад валютын эрсдэл

Группийн ихэнх гүйлгээ Монгол төгрөгөөр хийгддэг. Гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх нь анх ам.доллаароор хийгдсэн ажил гүйлгээнээс үүдэн бий болдог байна.

Валютын эрсдэлд өртөж буй гадаад валютаар хийгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дор харуулав. Доорх дүнг хаалтын ханшаар монгол төгрөг рүү хөрвүүлж удирдлагадаа тайлагнасан байна. Үүнд:

Ангилал	Ам. Доллар	Евро	Юань	Рубль	Бусад
2022 оны 12 дугаар сарын 31					
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,145,784	82,026	1,237,353	405,771	219
Дансны болон бусад авлага	10,198,622	411,985	414,131	146,550	1,046,591
Санхүүгийн өр төлбөр					
Дансны болон бусад өглөг	8,500,688	708,769	1,317,844	9,125	-
Цэвэр дүн	7,843,718	(214,758)	333,640	543,196	1,046,810
2021 оны 12 дугаар сарын 31					
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,976,111	828	4,046	27,316	-
Дансны болон бусад авлага	7,742,045	-	29,592	-	-
Санхүүгийн өр төлбөр					
Дансны болон бусад өглөг	215,774	716,215	95,237	23,675	-
Цэвэр дүн	9,502,382	(715,387)	(61,599)	3,641	-

Ам. Доллар болон бусад валютын эсрэг төгрөгийн 10% (2022: 10%) –ийн өсөлт ба бууралтад үзүүлэх Компанийн мэдрэмжийг доорх хүснэгтээр харуулав. 10% (2022: 10%) нь гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтөд өгөх удирдлагын үнэлгээг харуулдаг. Мэдрэмжийн шинжилгээнд зөвхөн одоогийн гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, гадаад валютын ханшийн 10% -ийн (2022: 10%) өөрчлөлт дэх тайлант хугацааны эцэст хийсэн нь хөрвүүлэлтийн тохируулга багтана.

Хэрэв төгрөг ам. Доллар болон бусад валютын эсрэг 10% -аар (2022: 10%) чангарвал, дараах нөлөөг үзүүлэх болно:

Мянган төгрөгөөр	Тайлант оны ашиг, алдагдал				
	Ам.доллар	Евро	Юань	Рубль	Бусад
2022 оны 12 сарын 31	784,372	(21,476)	33,364	54,320	104,681
2021 оны 12 сарын 31	950,238	(71,539)	(6,160)	364	-

35.3 Хүүгийн түвшний эрсдэл

Компанийн бодлого нь урт хугацаат зээлийн хүүгийн түвшний эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах юм. Иймээс урт хугацаат зээл нь ихэвчлэн тогтмол хүүтэй. 2022 оны 12 сарын 31-ний байдлаар компани нь хувьсах хүүтэй банкны зээлээс хамаарах хүүгийн түвшний өөрчлөлтийн эрсдэлд өртдөг. Бусад зээл нь тогтмол хүүтэй.

Доорх хүснэгтээр хувьсах хүүгийн түвшин 1 хувиар өөрчлөгдөхөд тайлант оны ашиг, алдагдал болон өмчид хэрхэн нөлөөлөхийг харуулав:





Мянган төгрөгөөр	Тайлант оны ашиг, алдагдал	
	+1%	-1%
2022 оны 12 сарын 31	28,167	28,167
2021 оны 12 сарын 31	15,000	15,000

35.4 Зээлжих эрсдэл

Зээлжих эрсдэл нь Группд санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг. Группийн хувьд энэхүү эрсдэлийн нөлөөлөл нь харилцах данс, дансны авлага, гэрээний хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалт гэх мэт өөр өөр санхүүгийн хэрэгслээс үүсдэг. Дараах санхүүгийн хэрэглүүрийн дансны үнээр хамгийн их зээлжих эрсдэлийг харуулав:

Мянган төгрөгөөр	2022 оны	2021 оны
	12 сарын 31-ний үлдэгдэл	12 сарын 31-ний үлдэгдэл
Санхүүгийн хөрөнгө дансны үнээр		
- Банкн дахь харилцах болон хугацаатай хадгаламж	14,190,667	5,806,747
- Дансны авлага	15,965,656	12,916,133

Банкан дахь харилцах болон хугацаатай хадгаламж

Банкан дахь мөнгөний зээлжих эрсдэлийг томоохон банк, санхүүгийн байгууллагад байршуулах замаар удирддаг.

Moody's Investors Service/Standard & Poor's-ийн үнэлгээгээр банкн дахь харилцах болон хугацаатай хадгаламжийн зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2022 оны	2021 оны
	12 сарын 31-ний үлдэгдэл	12 сарын 31-ний үлдэгдэл
ВЗ	14,190,649	5,806,747
Зэрэглэлгүй	18	-
Дүн	14,190,667	5,806,747

35.5 Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм.

Компанийн бодлого нь үйл ажиллагааны болон зээлийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг барагдуулахад хангалттай мөнгөн хөрөнгө болон түргэн борлогдох хөрөнгөтэй байх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

Дараах хүснэгтээр гэрээнд заасан эргэн төлөгдөх хугацаатай үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүдийг төлөх Компанийн үлдсэн гэрээний хугацааг харуулав. Компани төлөх шаардлагатай эхний өдөр санхүүгийн өр төлбөрийн дискаунтчилаагүй мөнгөн гүйлгээнд үндэслэн уг хүснэгтийг гаргасан.

2022 оны 12 сарын 31	Богино хугацаат		Урт хугацаат	
	6 сараас бага	6 сараас 12 сар	1-5 жил	5-с дээш жил
Дансны болон бусад өглөг	11,399,190	-	-	-
Богино хугацаат зээл	2,500,000	300,000-	16,667	-
Санхүүгийн түрээсийн богино хугацаат өр төлбөр	82,701	-	105,002	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	921,930	-	-
Нийт	13,981,891	1,221,930	121,669	-



"Мон Логистикс Холдинг" ХХК
 Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
 2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлвэ)



2021 оны 12 сарын 31	Богино хугацаат		Урт хугацаат	
	6 сараас бага	6 сараас 12 сар	1-5 жил	5-с дээш жил
Дансны болон бусад өглөг	6,038,333	-	-	-
Богино хугацаат зээл	750,000	-	750,000	-
Санхүүгийн түрээсийн богино хугацаат өр төлбөр	215,966	-	98,211	-
Бусад богино хугацаат өр төлбөр	333,876	-	-	-
Нийт	7,338,175	-	848,211	-

Компани нь хөрвөх чадварын эрсдэл ялангуяа мөнгөний эх үүсвэр, дансны авлагыг үнэлэх, удирдахад санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг авч үздэг. Компанийн мөнгөний эх үүсвэр, Дансны авлага нь эргэлтийн мөнгөн урсгалын шаардлагаас их байна.

36. Бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг тусдаа санхүүгийн тайланд бодит үнэ цэнийн шатлалаар гурван түвшинд ангилна. Эдгээр гурван ангиллыг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан орцуудын ач холбогдолд үндэслэнэ.

Түвшин 1: Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан тодорхойлно;

Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;

Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг.

Дараах хүснэгтээр бодит үнэ цэнийг хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн шатлалыг түвшин тус бүрээр харуулав. Үүнд:

2022 оны 12 сарын 31	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Дансны болон бусад авлага	-	19,504,042	-	19,504,042
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	14,198,308	-	14,198,308
Санхүүгийн хөрөнгийн дүн	-	33,702,350	-	33,702,350
Санхүүгийн өр төлбөр				
Дансны өглөг	-	11,399,190	-	11,399,190
Богино хугацаат зээл	-	2,816,667	-	2,816,667
Санхүүгийн түрээсийн богино хугацаат өр төлбөр	-	187,703	-	187,703
Бусад богино хугацаат өр төлбөр	-	921,930	-	921,930
Цэвэр бодит үнэ цэнэ	-	18,376,860	-	18,376,860

2021 оны 12 сарын 31	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Дансны болон бусад авлага	-	13,629,377	-	13,629,377



352



Мон Ложистикс Холдинг ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

2023-08-14
БҮРТГЭВ-03

2022 оны 12 сарын 31	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	5,815,535	-	5,815,535
Санхүүгийн хөрөнгийн дүн	-	19,444,912	-	19,444,912
Санхүүгийн өр төлбөр				
Дансны өглөг	-	6,038,333	-	6,038,333
Богино хугацаат зээл	-	750,000	-	750,000
Санхүүгийн түрээсийн богино хугацаат өр төлбөр	-	314,177	-	314,177
Бусад богино хугацаат өр төлбөр	-	333,876	-	333,876
Урт хугацаат зээл	-	750,000	-	750,000
Санхүүгийн өр төлбөрийн дүн	-	8,186,386	-	8,186,386
Цэвэр бодит үнэ цэнэ	-	11,258,526	-	11,258,526

37. Капиталын удирдлагын бодлого, журам

Группийн капиталын удирдлагын бодлогын зорилго нь компани цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадавхийг хангах юм.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компанийн капиталын шаардлагыг үнэлнэ. Групп капиталын бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг харгалзан тохируулга хийдэг. Капиталын бүтцийг бий болгож, тохируулахын тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашгийн дүнд залруулга хийж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг буцаах, шинээр хувьцаа гаргах, эвсэл өр төлбөрөө бууруулахаар хөрөнгө борлуулах зэрэг арга хэмжээ авна.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав. Үүнд:

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Нийт эздийн өмч	24,867,195	16,936,318
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14,198,308	5,815,535
Капитал	10,668,887	11,120,783
Нийт эздийн өмч	24,867,195	16,936,318
Нэмэх: Зээл	2,816,667	1,500,000
Нэмэх: Түрээсийн өр төлбөр	187,703	314,177
Бүх санхүүжилт	27,871,565	18,750,495
Капитал, санхүүжилтийн харьцаа	0.38	0.59

38. Тайлагналын үеийн дараах үйл явдал

Тайлагналын өдөр буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон энэхүү тайланг баталгаажуулсан өдөр хоорондын хугацаанд ямар нэгэн залруулагдах эвсэл үл залруулагдах томоохон гүйлгээ гараагүй болно.



353






"Мон Логистикс Холдинг" ХХК
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2022 оны 12 сарын 31-нээр дуусаар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)




39. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайланг 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр удирдлага батлав.


Г.Хишигбат
үйцэтгэх захирал




З.Шинэ-Од
Санхүү хариуцсан захирал





Монгол Улс, Улаанбаатар 14240
Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж 5, Аюуд
Тауэр, 14-р давхар, 1404 тоот
Утас/Факс +976-7747-1122
Имэйл: info@khanlex.mn
Вэб: www.khanlex.mn

2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-д

“Монложистикс Холдинг” ХХК-иас нийтэд анх удаа санал болгон гаргаж буй хувьцаатай холбоотой нэмэлт хууль зүйн дүгнэлт гаргах тухай

Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН нь “Монложистикс Холдинг” ХХК (цаашид “**Үнэт цаас гаргагч**” гэх)-иас нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах (IPO) ажиллагаатай холбогдуулан хөндлөнгийн хуулийн дүгнэлт (цаашид “**Үндсэн дүгнэлт**” гэх) бэлтгэн, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн билээ. Үндсэн дүгнэлт гарснаас хойш Үнэт цаас гаргагчийн зүгээс дараах нөхцөл байдалд өөрчлөлт орсонтой холбогдуулан энэхүү нэмэлт хуулийн дүгнэлт (цаашид “**Нэмэлт дүгнэлт**” гэх)-ийг бэлтгэн, хүргүүлж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагчийн түлхүүр ажилтнуудтай байгуулсан Колл опцион гэрээ дуусгавар болсон тухай

Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**” гэх) нь 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 23/ТУЗ/01 тоот тогтоолын дагуу ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр баталж, тус тогтоолын хоёрдугаар хавсралтад жагсаасан нийт 28 ажилтантай Колл опцион гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байдаг.

Дээрх тогтоолд заасан бүрэн эрхийн дагуу Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал нь 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр нэр бүхий 28 ажилтантай Колл опцион гэрээг байгуулсан.

Хожим Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76.1.7 дахь хэсгийг үндэслэн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 23/ТУЗ/21 тоот тогтоолоор урьд гаргасан 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 23/ТУЗ/01 тоот тогтоолыг хүчингүй болгон, нэр бүхий 28 ажилтантай байгуулсан Колл опцион гэрээг цуцлах (буюу гэрээнээс тагталзах)-



355





2023-06-14

БҮРТГЭВ-03

аар шийдвэрлэсэн байна. Энэхүү тогтоолыг үндэслэн нэг талаас Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал, нөгөө талаас ажилтан нар гэрээг цуцлан, дуусгавар болгох талаар харилцан тохиролцож, холбогдох баримтыг сайн дурын үндсэн дээр үйлдэн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

Иймд Иргэний хуулийн 240 дүгээр зүйлийн 240.1.5 дахь хэсгийн дагуу талуудын хооронд үүссэн Колл опцион гэрээний дагуух үүрэг дуусгавар болсон тул талууд харилцан шаардлага гаргах эрх зүйн үр дагавар үүсэхгүй болно.

Жич: Хэрэв Үнэт цаас гаргагч нь ирээдүйд буюу хувьцаат компани болсны дараа ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр шинээр хэрэгжүүлэх бол тухайн үед Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээд тус хөтөлбөрийг батлан, эрх бүхий байгууллагуудад бүртгүүлснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой болохыг дурдах нь зүйтэй байна.

2. Үнэт цаасны танилцуулгад орсон өөрчлөлттэй холбоотойгоор Үндсэн дүгнэлтэд тусгагдах өөрчлөлт:

Энэхүү нэмэлт дүгнэлт болон Үнэт цаасны танилцуулгын 4.9 дэх хэсэгт тусгагдсан өөрчлөлттэй холбогдуулан Үндсэн дүгнэлтийн 3.4.1.1 хэсэгт тусгагдсан “Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд ажилчдад худалдахаар” гэх хэсэг болон Хоёрдугаар хавсралтын 4.9 дэх мөр бүхэлдээ хасагдсан болно.

Дүгнэлтийн талаарх тодруулга:

Энэхүү Нэмэлт дүгнэлт гаргахдаа бид энэхүү дүгнэлтэд дурдагдсан, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичиг, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үндэслэл болгосон бөгөөд Үндсэн дүгнэлтийн 1.2 (Дүгнэлтийн хүрээ), 1.3 (Дүгнэлт боловсруулсан арга, аргачлал), 1.5 (Хязгаарлалт) болон 1.6 (Мэдэгдэл) дахь хэсэгт дурдсан нөхцөл нэгэн адил үйлчилнэ.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ӨМГӨӨЛЛИЙН “ХААНЛЕКС
ПАРТНЕРС” ХХН

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН:

Гарын үсэг: *J. Batjargal*

Нэр: Г.Батжаргал



ӨМГӨӨЛЛИЙН “ХААНЛЕКС
ПАРТНЕРС” ХХН

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН:

Гарын үсэг: *I. Uchralbayar*

Нэр: И.Учралбаяр



2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

